# ТӨРИЙН БАЙГУУЛАЛ СУДЛАЛ

№08

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан
Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлал,
Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль

§GAP
Governance, Administration, Politics
Засаглал, Удирдлага, Улс төр

Улаанбаатар
2024

KONRAD ADENAUER STIFTUNG

УЛС ТӨР СУДЛАЛ,
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА,
НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

# ТӨРИЙН БАЙГУУЛАЛ СУДЛАЛ СЭТГҮҮЛ №08

§GAP
Governance, Administration, Politics
Засаглал, Удирдлага, Улс төр


## РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ:

| | |
|---|---|
| Профессор С.Мөнхбат | МУИС-ийн УТСОУХНУС-ийн захирал |
| Профессор Ж.Төртогтох | МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч |
| Дэд Профессор Н.Бурмаа | МУИС-ийн УТСОУХНУС-ийн Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч |
| Виктор Франк | Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч |
| С.Ганзаяа | Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн хөтөлбөрийн менежер |
| Ерөнхий редактор: | Доктор П.Амаржаргал |



Зохиогчийн эрх ©Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан
Энэхүү бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул эшлэл авалгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно. Бүтээлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.



“Адмон-принт” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ ....................................................

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮН БОЛОН ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ
Д.УНДРАХ, Б.ЭРДЭНЭДАЛАЙ, Д.ТҮМЭНЖАРГАЛ..................................

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН УРИА ҮГЭНД ХИЙСЭН АНАЛИЗ
Г.ОДОНТУЯА.........................................................................................

МОНГОЛ ДАХЬ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД БОЛОН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ӨРСӨЛДӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
Д.УНДРАХ, Б.ЭРДЭНЭДАЛАЙ, Д.ТҮМЭНЖАРГАЛ.................................

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛИЙН ДҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ
Ц.ПУНЦАГ...........................................................................................

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ
Ж.ГАНТУЯА.........................................................................................

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ-ЗАСАГ ДАРГЫН ЭРХ МЭДЛИЙН ХАРИЛЦАА
М.ИНДРАБҮД.......................................................................................

ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СУУРИЛСАН ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ БА ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ХАМААРАЛ
Т.АРИУНБОЛД, Б.ЧИМЭДЛХАМ, Д.ЦЭЦЭНБИЛЭГ................................

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ
С.НОМЫНБАЯСГАЛАН..........................................................................

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ШУУД АРДЧИЛЛЫН ЭЛЕМЕНТ
Д.БАТЗАЯА..........................................................................................

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ:
ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ШИНЖИЛЖ, ЖЕНДЭРИЙН ОЛОН ТАЛТ УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ БИЙ БОЛГОХ НЬ
Д.УУГАНЖАРГАЛ, Х.АНХБИЛЭГ....................................................

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШУУД АРДЧИЛЛЫН ЭЛЕМЕНТҮҮД
П.ХАШ-ЭРДЭНЭ.......................................................................

# ӨМНӨХ ҮГ

“Төрийн байгуулал судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит 8 дахь дугаарыг Уншигч Танд тус сэтгүүлийн редакцын зөвлөлөөс өргөн барьж байна.

МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Улс төр судлалын тэнхимба Монгол Улс дахь ХБНГУ-ын Конрад Аденауэр-Сангийн суурин төлөөлөгчийн газрын харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд тус эрдэм шинжилгээний сэтгүүлийг нийгэм, улс төр судлал, төрийн захиргаа, төрийн бодлого, удирдлагын салбарын өргөн хүрээг хамарсан эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн бүхий өгүүлэл, нийтлэлийг хэвлэн нийтлэх зорилготойгоор хамтран эрхлэн гаргадаг билээ.

“Төрийн байгуулал судлал” сэтгүүлийн энэхүү ээлжит дугаарт орсон өгүүллүүд нь 2024 онд болсон орон нутгийн сонгууль сонгуулийн үр дүн, үр нөлөө зэрэгт холбогдох сэдвээр дагнан бичсэн судлаачдын өгүүллээс бүрдсэн гэдгийг онцолж байна.

Энэ удаагийн дугаарт орсон нийтлэл, өгүүллүүд нь орон нутгийн сонгуулийн үр дүн болон олон нийтийн санаа бодол, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн уриа, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын өрсөлдөөн, нутгийн өөрөө удирдах байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал ба Засаг даргын эрх мэдлийн харилцаа, иргэдийн оролцоо ба орон нутгийн сонгуулийн хамаарал, орон нутгийн сонгуулийн тогтолцоо, зохицуулалт, Иргэдийн нийтийн хурал, орон нутгийн санхүүгийн бие даасан байдал, шууд ардчилал зэрэг асуудлыг хөндсөн бөгөөд тухайн зохиогчдынхоо үзэл бодол, итгэл үнэмшил, судалгааны сонирхол, үр дүнг илэрхийлсэн гэдгийг тунгаан үзвэл зохилтой.

Бид цаашид төрийн байгууллын институтүүдийн талаарх болон нийгэм, улс төр судлал, төрийн захиргаа, удирдлагын чиглэлээрх судалгаа, шинжилгээний үр дүн бүхий эрдэм шинжилгээний өгүүллүүдийг хүлээн авч, хэвлэн нийтлэх болно.

Уншигч Таны ажил үйлст өндөр амжилт хүсэн ерөөе.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

# ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮН БОЛОН ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

**Д.Ундрах**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, дэд профессор
**Б.Эрдэнэдалай**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор
**Д.Түмэнжаргал**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

## *Удиртгал*

Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон Орон нутгийн сонгуульд оролцох сонгогчдын оролцоо 2000 оноос хойш буурсаар байна. 1992 оны орон нутгийн сонгуулийн ирцтэй харьцуулахад 2020 онд ирц 56% байсан нь 16%-аар, 2024 онд ирц 53.1% байсан нь 18.9%-аар[1] буурсан үзүүлэлттэй байна. Сонгуулийн ирц улам багасч 50%+1[2] гэсэн үндсэн шалгуурыг хангахгүй нэмэлт санал хураалт явуулах байдал 2020 он хүртэлх орон нутгийн сонгуулиудад ажиглагддаг байсан. Энэ нь орон нутгийн сонгуульд сонгогчдын санал ихээр гээгдэх, ИТХ-д ялалт байгуулсан төлөөлөгч сонгогчдын төлөөллийг хангаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлсээр байна. Гэхдээ 2020, 2024 оны орон нутгийн сонгуулийн ирцийн улсын дундаж дүн 56%, 53.1% байгаа ч, олон хэсгийн хороодод 50%-аас доош ирцтэй сонгууль болсон. Нөгөө талаараа, орон нутгийн сонгуулийг зохион байгуулах, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намуудаас орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх, орон нутгийн сонгуулийн мэдээллийг сонгогчдод хангалттай түгээх,

[1] Статистикийн үндэсний хорооны сайт дээрээс орон нутгийн сонгуулийн ирцийг авсан. www.1212.mn

[2] 2012 онд батлагдсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль"-ийн 55-р зүйл "Сонгуулийн хэсгийн хороонд явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах" гэсэн заалтын 55.1.5-д "сум, баг, хороонд тухайн сум, баг, хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн 50-аас дээш хувь нь оролцоогүй бол уг сум, баг, хорооны 50-аас дээш хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд" гэж заажээ.

мэдээлэх, цэгцтэй ойлголт өгөх зэрэг тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэхэд анхаарал хандуулдаггүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгаа юм.

### *Судалгааны арга, хамрах хүрээ, түүвэр.*

Судалгааг тоон судалгааны аргыг ашиглан Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн төлөөллийг оролцуулан судалгааны мэдээллийг цуглууллаа. Ингэхдээ 2021 оны 06 сард болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох сонгогчдын нэрсийн жагсаалтад 2,099,118 сонгогч бүртгэгдсэнийг үндэслэн 1268 иргэнийг “Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа”-нд хамруулан орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөг эсэх, оролцоо, хандлага, хүчин зүйлийн хамт судлахыг зорьсон болно.

### *Орон нутгийн сонгууль, сонгогчдын оролцоо, үйл байдлын талаарх олон улсын судалгааны тойм*

Орчин үед ардчилсан улс орнуудад үндэстэн дамнасан засгийн газрын хэрэгцээ, үүрэг өсөн нэмэгдэж, олон шатлалт засаглалын тогтолцоо хөгжиж байгаа хэдий ч орон нутгийн сонгууль, тэдгээрийн институциональ өөрчлөлт, сонгогчдын үйл байдлын талаарх нэгдсэн ойлголт, мэдээлэл хаа сайгүй хангалтгүй, хуваагдмал шинжтэй байна. Энэ чиглэлд хийгдсэн судалгааны ажлууд хийгээд хэвлэгдсэн бүтээлүүдийг шүүж үзэхэд орон нутгийн сонгуульд хандах хандлага нийтдээ адилхан хангалтгүй буюу доод түвшний сонгууль гэж үзэх хэвшмэл ойлголт тогтож, орон нутгийн сонгуулийг улс төрийн ач холбогдол багатай гэж үзсээр ирсэн болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг[3]. Сүүлийн үед Европын улсуудад орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн улс төрийг харьцуулан судлах сонирхол нэмэгдэж байгаа ба жишээлбэл, орон нутгийн бие даасан байдлын индексийн судалгаагаар орон нутгийн институциудын нөхцөл байдал болон Европ дахь төвлөрлийг сааруулах динамикийг системтэйгээр судлахыг зорьсон судалгаанууд хийгдэх болсон байна[4].

Орон нутгийн сонгууль хийгээд орон нутгийн сонгуулийн эргэн тойронд өрнөх улс төрийг судлах явдал нь төлөөллийн ардчилал, сонгуулийн

[3] Miller, W. L. (1988). Irrelevant elections? The quality of local democracy in Britain. Oxford University Press.

[4] Ladner, A., Keuffer, N., & Baldersheim, H. (2016). Measuring Local Autonomy in 39 Countries (1990–2014). Regional & Federal Studies, 26(3), 321-357.

хариуцлагын механизмыг ойлгоход онцгой чухал[5] хэмээн тэмдэглэснээс гадна орон нутгийн улс төрийн институциуд нь иргэдтэйгээ ойр байдаг бөгөөд орон нутгийн сонгуулийн тойргуудад нэг саналын үнэ цэнэ харьцангуй өндөр байдаг тул зайлшгүй судлан тодруулж, анхаарал хандуулах нь чухлыг цохон тэмдэглэсэн байдаг[6]. Оролцоо, өрсөлдөөн, сонгогчдын санал өгөлт зэрэг нь ихээхэн ялгаатай байдаг ч сонгуулийн чиг үүрэг нь үндэсний хэмжээнд биш орон нутагт илүү чухал байдаг тухай судлаач Веттер "Өрнөд Европын ардчиллын нөөц: Орон нутгийн улс төр үү?" бүтээлдээ цохон тэмдэглэжээ[7].

Орон нутгийн сонгуулийн ирц үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг бусад сонгуулиудаас ихэвчлэн бага байдаг ч ирцийн зөрүү нь улс орон болон цаг хугацаанаас хамаарч ихээхэн ялгаатай байгааг Их Британи ба Францын орон нутгийн сонгуулийн жишээн дээр хийсэн судалгаа харуулж байна[8]. Ван Хоувелингений 2017 онд хийсэн мета-шинжилгээгээр Нидерландад хотын хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр орон нутгийн сонгуулийн ирц буурч байгааг дурдаад үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулах судалгаа зайлшгүй шаардлагатай байгааг тэмдэглэсэн[9] байна.

### *Нэг. Орон нутгийн сонгуулийн ирц, оролцоонд хийсэн анализ*

1992 оноос хойш явагдсан сонгуулиудад оролцсон сонгогчдын ирц, оролцоо тогтмол буурсан. Тодруулбал, 2000-2020 оны орон нутгийн сонгуульд сонгогчдын оролцооны хувийн тархалтыг шинжлэн харвал, орон нутгийн

---

[5] Clark, A., & Krebs, T. B. (2012). Elections and policy responsiveness. In: Mossberger, K., Clarke, S. E., & John, P. (Eds.). The Oxford handbook of urban politics. Oxford University Press.

[6] Blais, A. (2000). To vote or not to vote? The merits and limits of rational choice theory. University of Pittsburgh Press.

Oliver, J. E., Ha, S. E., & Callen, Z. (2012). Local elections and the politics of small-scale democracy. Princeton University Press.

[7] Vetter, A. (2007). Local politics: a resource for democracy in Western Europe? Local autonomy, local integrative capacity, and citizens' attitudes toward politics. Lexington Books

[8] Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.

Frandsen, A. G. (2002). Size and electoral participation in local elections. Environment and Planning C: Government and Policy, 20(6), 853-869.

[9] Van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.

дийлэнх сонгуулийн дүн нийт иргэдийн 65-аас доош хувийг хамруулж үр дүнгээ танилцуулж байна.

2012 оноос хойш сонгогчдын сонгуульд оролцох оролцоо бага байгааг олон нийт шүүмжилж, сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд санаачлан сургалт хийх, сурталчлах ажлуудыг хийж байна. Гэтэл энэ нь зөвхөн сонгуулийн жил, эсвэл сонгуулийн идэвхтэй сурталчилгаа эхлэх хэсэгхэн цаг хугацаанд хийгддэг нь үр дүн муутай. Мөн эдгээр нөлөөллийн арга хэмжээг УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын үеэр идэвхтэй хийгээд, орон нутгийн сонгуулийн үеэр сонгогчид руу хандсан кампанит ажилд анхаардаггүй зэрэг нь орон нутгийн сонгуулийг үл ойшоох, саналаа өгөхгүй байх, сонгогдсон төлөөлөгчид нийт сонгогчдын тоотой харьцуулбал бага санал авч сонгогдох, санал ихээр гээгдэх зэрэг сөрөг үр дагаврууд гарахад ч нөлөөлж байна.

Мөн сонгуулийн ирц, оролцооны бууралт нь тухайн тойрогт сонгогдож байгаа төлөөлөгч нийт сонгогчдын саналыг хэр зэрэг төлөөлж, итгэл хүлээж байгаа хувь 2000 онд 39%, 2004 онд 40% байсан бол 2020 онд энэ тоо 35% болж буурсан. Цаашид орон нутгийн сонгуулийн иргэдийн сонголтыг төлөөлөх чадвар тогтмол буурсаар байвал орон нутгийн сонгуулийн төлөөллийн ардчиллын шинж алдагдана. Мөн 2020 онд орон нутгийн сонгууль хүчин төгөлдөр болох 50%+1 гэсэн ирцийн босгыг байхгүй болгосон нь дээрх байдлыг даамжруулах хүчин зүйл болсон.

2020 онд батлагдсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль"-д орон нутгийн хурлын сонгуулийн ирцийг 50%+1 сонгогч саналаа өгвөл тухайн сонгууль хүчинтэй болдог байсныг болиулсан. Эндээс тухайн сонгуульд ирж оролцсон сонгогчдын ирцээр тооцдог болсон буюу бүх тойрогт хүчинтэй сонгууль болохоор өөрчлөлт орсон. Энэ нь 1992 оноос хойших орон нутгийн сонгуулийг зохион байгуулахад гардаг байсан сонгогчдын ирц хүрэхгүй, дахин санал хураалтыг олон хэсгийн хороод дээр зохион байгуулдаг, зарим хэсгийн хороод дээр дахин санал хураалтаар ч ирц хүрдэггүй байснаас болоод нэмэлт саналт хураалт явуулах буюу өмнөх санал хураалтад оролцсон сонгогчид нэмэлт санал хураалтад оролцохгүй, харин үндсэн санал хураалтын өдөр саналаа өгөөгүй сонгогчид очиж саналаа өгдөг зохицуулалтай байв. Харин 2020 оны орон нутгийн хурлын сонгуулийн ирц дээр тухайн санал хураах өдөр сонгуулийн санал хураах байранд ирж саналаа өгсөн сонгогчдын тоогоор хүчинтэй санал

хураалт болсон гэж үзэх өөрчлөлт оруулсан нь Монгол дахь орон нутгийн сонгуулийн ач холбогдол улам буурч байгаа, сонгогчид орон нутгийн сонгуулийг тоохгүй байгааг хүлээн зөвшөөрснийг харуулж байна.

Нөгөө талаасаа, орон нутгийн сонгуулийг товлон зарлахад цаг хугацааны хувьд тухайн сонгуулийн жилийн намрын улиралд буюу 10 дугаар сард болдог. Сонгуулийн ирц тааруу болоход нөлөөлдөг хамгийн том шалтгаан бол хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор тухайн харьяа бүхий бүртгэлтэй санал хураах байранд очиж саналаа өгөхгүй байх явдал юм. Үүний зэрэгцээ цаг хугацааны хувьд УИХ-ын сонгуулийн дараахан болдог, намар хөдөө орон нутгийн оюутнууд сургуульдаа, залуучууд хот суурин газрууд руу ажилдаа явж шилжилт хөдөлгөөнд ордог, мал хуйгаа харах хүн хүч дутмаг болдог зэрэг асуудлууд нөлөөлж байдаг. Нөгөө талаасаа, орон нутгийн сонгууль нь сонгогч бүрийг тухайн аймаг, сум, хот, дүүргийн үндсэн оршин суугч байхыг, эсвэл сонгуулийн тухай хуулийн хүрээнд шилжилт хөдөлгөөнийг заавал урьдчилан хийлгэсэн байх ёстойг нарийвчлан шаарддаг. Шилжилт хөдөлгөөнийг урьдчилан хийлгэх талаар мэдээлэлгүй сонгогчид сонгуульд саналаа өгөх боломжгүй болдог. Мөн гэнэтийн ажил гарах, өөр газар байх тохиолдолд саналаа өгөх боломжгүй. Тэрчлэн гадаадад оршин суугаа сонгогчдын саналыг орон нутгийн сонгуульд авах зохицуулалт байхгүй байна. Шилжилт хөдөлгөөнөөс гадна орон нутгийн сонгуульд оролцохдоо нутгархдаг, намчирхдаг буюу тухайн намын төлөөлөл орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан бол эсрэг намын иргэдийг төрийн албанаас халдаг, ажилд авдаггүй, төрийн аливаа үйлчилгээнд хамрагдахад саад учруулдаг зэрэг олон сөрөг асуудлууд үүсдэг болсон.

Дээрхээс гадна орон нутгийн сонгуулийн үеийн сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн санал хураах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоодог тул сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд их зөрүү гардаг, эргэлзээтэй байдлыг үүсгэж сонгуулийн ирц бага байхад сөргөөр нөлөөлж байна. Шилжилт хөдөлгөөн хийлгээгүй, сонгогчийн нэрийн жагсаалтад нэр ороогүй зэргээс гадна сонгуульд оролцож чадахгүй байгаа сонгогчид бол гадаадад амьдарч буй сонгогчид бөгөөд тэд 2012, 2013, 2017 оны сонгуульд нийт гурван удаа оролцож саналаа өгч байсан. Орон нутгийн сонгуульд оролцож чадахгүй байгаа дараагийн бүлэг сонгогчид бол хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид юм. Хэдийгээр орон нутгийн сонгуулийн тухай хуульд 1996 оноос хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн саналыг авах боломжийг зааж

өгсөн ч бодит байдал дээр сонгуулийн санал хураах байрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, нялх хүүхэдтэй хүмүүст хүртээмжгүй дэд бүтэцтэй, орчныг бүрдүүлж өгөөгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид сонгуульд санал өгөхөөс татгалздаг, зайлсхийдэг нь орон нутгийн сонгуулийн ирц, оролцоонд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Сонгуулийн ирц, оролцоонд бага хувиар нөлөөлдөг зүйл бол хүчингүй санал юм. Орон нутаг болон Улаанбаатар хотын сонгогчдоос үл хамааран хүчингүй саналын хувь хэмжээ 2000-2008 онд ойролцоо байсан байна. Харин 2011 онд "Сонгуулийн автоматжуулсан системийн тухай" хууль батлагдаж сонгуулийн саналын хуудсыг автомат төхөөрөмжид уншуулж, сонгуулийн санал хураалтын дүнг гаргадаг болсноос хойш хүчингүй саналын хувь эрс багассан.

## *Хоёр. Орон нутгийн сонгууль дахь иргэдийн оролцоо, хандлага тодорхойлох судалгааны дүн*

Судалгааны энэ хэсэгт орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгч буй болон өгөхгүй байгаа иргэдийн оролцоо, хандлагыг авч үзлээ.

*Зураг 1. Сонгуульд оролцож саналаа өгөх нь чухал эсэх*




"Таны бодлоор дараах сонгуулиудад оролцож саналаа өгөх нь хэр чухал вэ?" гэсэн асуултад УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох нь "маш чухал" гэж судалгаанд оролцогчдын 64%-68% нь хариулсан бол, 59% нь орон нутгийн сонгуульд оролцох нь "маш чухал" гэж хариулсан. Тодруулбал, иргэд орон нутгийн сонгуульд бага ач холбогдол өгдөг нь харагдаж байна.

Бүх түвшний сонгууль, түүний ач холбогдлын талаар сонгогчдод таниулах үйл ажиллагаанууд жигд, хүртээмжтэй хийгдэх ёстой ч УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр энэ ажлууд илүү хийгддэг, орон нутгийн

сонгуулийн үеэр багасдаг нь сонгогчдод орон нутгийн сонгуулийг ач холбогдолгүй мэт бодох, анхаарахгүй байх суурийг бий болгодог. Нөгөө талаасаа сонгогчдын орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөхгүй байх, нэмэлт санал хураалтыг тоохгүй, саналаа өгдөггүй зэргээс шалтгаалан 2020 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд ирцийн 50%+1 босгыг байхгүй болгосон нь орон нутгийн сонгуулийн санал хураалтыг ямар ч тохиолдолд хүчинтэй байлгах заалт болсон. Гэвч энэ нь ардчилсан сонгуулийн суурь шаардлагыг хангахгүй байдалд хүргэж байна. Эндээс харахад цаашид сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх, ялангуяа орон нутгийн сонгууль, орон нутгийн сонгуулиар бүрддэг тухайн орон нутгийн ИТХ-ын эрх-үүрэг, ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага их байна.

*Хүснэгт 1. Орон нутгийн сонгуульд санал өгч оролцох ач холбогдол, бүс нутгаар*

| Байршил | Маш чухал | Ер нь чухал | Нэг их чухал биш | Огт чухал биш | Мэдэхгүй | нийт |
|---|---|---|---|---|---|---|
| Баруун бүс | 63% | 30% | 5% | 1% | 1% | 100% |
| Зүүн бүс | 64% | 26% | 3% | 3% | 3% | 100% |
| Төвийн бүс | 56% | 29% | 11% | 1% | 3% | 100% |
| Улаанбаатар | 55% | 31% | 10% | 1% | 3% | 100% |
| Хангайн бүс | 67% | 29% | 4% | 0% | 1% | 100% |
| дундаж | 59% | 30% | 8% | 1% | 2% | 100% |

Орон нутгийн сонгуульд санал өгөхийн ач холбогдлыг бүс нутгаар нь авч үзвэл, Баруун, Зүүн болон Хангайн бүс нутгийн аймгийн иргэд жигд 63%-67% нь "маш чухал" гэж үзсэн бол Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд 55%-56% нь "маш чухал" гэжээ. Харин эсрэгээрээ Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд бусад бүс нутгаасаа илүү буюу 10-11% нь орон нутгийн сонгуульд оролцох нь "нэг их чухал биш" гэсэн хариултыг өгчээ. Төв бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх нь муу байна. Энэ нь орон нутагт аймаг, сумын сонгогчид тооны хувьд цөөн, орон нутгийн иргэдийг таньдаг, сонгуулийн сурталчилгаа өрх бүрт хүрэх боломжтой зэргээр сонгогчдыг сонгуулийн ач холбогдлыг илүү ойлгоход эерэг нөлөө үзүүлж байх талтай.

*Зураг 2. Сонгуульд оролцож саналаа өгдөг эсэх*




Хэдийгээр судалгаанд оролцогчид сонгуулийн оролцоог маш чухал хэмээн үнэлсэн боловч 69% нь УИХ-ын сонгуульд, 71% нь Ерөнхийлөгчийн сонгуульд, 54% орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог хэмээн хариулсан байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн 89% нь орон нутгийн сонгуулийг чухал хэмээн үзэж байгаа ч ердөө 54% нь тус сонгуульд тогтмол оролцдог гэж хариулсан.

*Хүснэгт 2. Ажил эрхлэлтийн байдал ба орон нутгийн сонгуулийн оролцооны түвшин*

| | Тогтмол | Ихэвчлэн | Заримдаа | Саналаа өгдөггүй | Санал өгөх нас болоогүй байсан |
|---|---|---|---|---|---|
| Төрийн байгууллагад | 66% | 14% | 11% | 7% | 1% |
| Хувиараа хөдөлмөр эрхэлдэг | 59% | 20% | 12% | 9% | 1% |
| ОУБ-д | 69% | 23% | 8% | 0% | 0% |
| ТББ-д | 67% | 19% | 10% | 4% | 0% |
| Хувийн байгууллагад | 48% | 20% | 17% | 14% | 1% |
| Малчин | 61% | 24% | 12% | 2% | 0% |
| Тэтгэвэрт | 86% | 5% | 8% | 2% | 0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Групп | 47% | 33% | 13% | 7% | 0% |
| Оюутан | 34% | 18% | 17% | 11% | 20% |
| Ажил эрхлээгүй байна | 49% | 24% | 12% | 12% | 4% |

Дээрх хүснэгтэд ажил эрхлэлтийн байдал болон орон нутгийн сонгуулийн оролцоо хоорондын хамаарлыг харуулав. Тэтгэвэрт байгаа иргэдийн 86% нь орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог хэмээн хариулсан нь бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад илт давамгай өндөр байсан. Нөгөөтээгүүр, оюутнуудын ердөө 34% нь орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог гэсэн хариултыг өгсөн байна. Хувийн байгууллагад ажиллагсдын ердөө 48% нь орон нутгийн сонгуульдаа тогтмол оролцдог гэсэн бол, энэ салбарт ажиллагсад хамгийн их буюу 14% нь орон нутгийн сонгуульд саналаа өгдөггүй болохоо илэрхийлжээ. Эндээс хувийн хэвшлийнхний орон нутгийн сонгуулийн оролцоо оюутнуудтай хамгийн ойролцоо буюу хангалтгүй хэмээн дүгнэхэд хүргэж байна.

Дээрх судалгааны дүнгүүдээс харахад, орон нутгийн сонгуулийг ер нь чухал, ач холбогдолтой гэж үздэг ч тухайн сонгуульд оролцож саналаа өгөх байдал муу байгааг тодруулах, цаашид орон нутгийн сонгуулийн ирц, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй. Энэ үүднээс орон нутгийн сонгуульд оролцох нь ач холбогдолтой гэж үзсэн ч сонгуульд саналаа өгөх оролцоо муу байгаа шалтгааныг тодруулах зорилгоор дараах асуултыг судалгаанд оролцогчдоос асуусан юм.

*Хүснэгт 3. Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан*

| Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан | Хувь |
|---|---|
| Тухайн үед өөр газар байсан, шилжилт хөдөлгөөнөө урьдчилан хийлгэж чадаагүй, орон нутаг руугаа очиж саналаа өгөхөд цаг хугацаа, зардал мөнгө гарах тул орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй. | 30% |
| Намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан. | 26% |
| Орон нутгийн сонгуульд санал өгөх нь ач холбогдолгүй, үр дүнг сонирхдоггүй, надтай надгүй сонгууль болдгоороо болно. | 15.2% |

| | |
|---|---|
| Орон нутгийн сонгуульд оролцож, санал өгөх нь төвөгтэй, саналаа хэрхэн өгөх талаарх ойлголт байхгүй байсан учраас. | 11% |
| Сонгуулийн үр дүнд итгэдэггүй учраас. | 5.6% |
| Өмнө нь олон сонгогдсон төлөөлөгчид л дахин нэр дэвшдэг. | 4.6% |
| Орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан учраас. | 4.1% |
| Санал хураах байр хөгжлийн бэрхшээлтэй сонгогч надад хүртээмжгүй байсан учраас. | 1.4% |
| Намайг хэнд саналаа өгч байгааг мэдчих вий гэж бодсон учраас. | 1.2% |
| Мөнгө болон надад ашигтай зүйл өгөөгүй учраас. | 0.6% |
| Нийт | 100% |

Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан олон байсан боловч шалтгаануудыг нь багцлан харвал, шилжилт хөдөлгөөнөөс хамаарч 30% нь оролцож чадаагүй, улс төрийн шалтгаан буюу "намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан", "сонгуулийн үр дүнд итгэдэггүй, орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан учраас" гэж судалгаанд оролцогчдын 35.7% нь хариулсан байна. Харин "орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөггүй" гэсэн шалтгаанаар судалгаанд оролцогчдын 15.2% нь саналаа өгөөгүй гэж хариулжээ.

Эндээс дүгнэхэд, шилжилт хөдөлгөөнөөс болж саналаа өгөөгүй, орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөггүй гэж хариулсан иргэдээс гадна намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан, сонгуулийн үр дүнд итгэдэггүй, орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан гэсэн хариултуудыг судалгаанд оролцогчдын 35.7% нь хариулсан нь цаашид орон нутгийн сонгууль зохион байгуулалт, үр дүн гаргах тогтолцоог сонгогчдод нээлттэй, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах, нэр дэвшигчдийн өрсөлдөөнийг шударга байлгах, орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллээс гадна нэр дэвшигчдийн мэдээллийг ойлгомжтой байдлаар сонгогчдод хүргэх, дээрх асуудлуудад иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын мониторинг, хяналтыг нэмэгдүүлэх,

ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийг оролцуулан зохион байгуулах зэрэгт анхаарах шаардлагатайг харуулж байна.

Орон нутгийн сонгуульд иргэд хэр зэрэг ач холбогдол өгдөг, тухайн сонгуульд оролцож саналаа өгдөг эсэх зэргээс гадна орон нутгийн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой оролцооны олон хэлбэрүүд байдгийг судалгаанд оролцогчдод таниулах, ойлголт өгөх, тэдний оролцдог байдлыг судлах зорилгоор дараах асуултыг тодруулсан.

*Хүснэгт 4. Орон нутгийн сонгуульд оролцдог хэлбэр*

| Оролцооны хэлбэр | Байнга | Заримдаа | Огт үгүй | Энэ талаарх ойлголт байхгүй |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн сонгуульд саналаа өгч оролцдог. | 57% | 25% | 16% | 2% |
| Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж байсан. | 5% | 9% | 81% | 5% |
| Орон нутгийн сонгуулийн үеэр Фейсбүүк/Твиттер зэрэг цахим орчинд санал бодлоо илэрхийлдэг. | 12% | 39% | 46% | 4% |
| Хэвлэл мэдээллийн хэрэгслээр (сонин, сэтгүүл, радио, телевиз гэх мэт) байр сууриа илэрхийлдэг. | 7% | 21% | 68% | 4% |
| Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөг. | 16% | 28% | 51% | 5% |
| Жагсаал, цуглаанд оролцож байсан. | 8% | 28% | 60% | 4% |
| Улс төрийн намыг идэвхтэй дэмжиж оролцдог. | 14% | 25% | 57% | 4% |
| Санал хүсэлтээ бичгээр холбогдох газарт хүргүүлж оролцдог. | 9% | 20% | 66% | 5% |
| Нэр дэвшигчийн уулзалтад оролцож, саналаа илэрхийлдэг. | 12% | 29% | 55% | 4% |
| Амьдарч буй орон нутгийн удирдлагатай /Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал/ уулзаж, санал бодлоо илэрхийлдэг. | 10% | 28% | 57% | 4% |
| Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нам, нэр дэвшигчид сонгуулийн хандив өгдөг. | 6% | 15% | 74% | 6% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааны ажиглагчаар ажиллаж оролцдог. | 9% | 17% | 69% | 6% |
| Дундаж | 14% | 24% | 59% | 4% |

Орон нутгийн сонгуулийн хувьд, судалгаанд оролцогчид сонгуульд саналаа өгөхөөс бусад оролцооны хэлбэрт огт үгүй гэсэн хариултыг давамгай өгсөн байна. Тодруулбал, иргэдийн 81% нь орон нутгийн сонгуульд огт нэр дэвшиж байгаагүй, 46% нь орон нутгийн сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлдэггүй, 68% нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байр сууриа илэрхийлдэггүй, 51% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөггүй, 60% нь жагсаал, цуглаанд оролцож байгаагүй, 57% нь улс төрийн намыг идэвхтэй дэмждэггүй, 66% нь санал хүсэлтээ бичгээр холбогдох газарт хүргүүлж байгаагүй гэжээ. Харин орон нутгийн сонгуульд саналаа байнга өгдөг гэж судалгаанд оролцогчдын 57% нь хариулсан байна. Энэ хувь 1992 оноос хойш болсон орон нутгийн сонгуулиудын дундаж ирц болох 63%-аас бага байлаа. Эндээс цаашид орон нутгийн сонгууль, ИТХ-ын талаарх ойлголт, мэдээллийг иргэдэд түгээх, үр дүнтэй нөлөөллийн ажлууд хийхэд илүү анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Дээрх асуултаас сонирхол татсан хариулт бол, судалгаанд оролцогчдын 51% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөггүй, 5% нь энэ талаар ойлголт байхгүй гэж хариулсан нь орон нутгийн шийдвэрлэх нэн шаардлагатай асуудлуудад иргэд оролцдоггүй, анхаардаггүйг харуулж байгаа төдийгүй, тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий нутгийн өөрийн удирдлагын эрх, үүргийг мэдэхгүй байх талтай болох нь ажиглагдлаа. Судалгаанд оролцогчдын зөвхөн 16% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа байнга өгдөг, харин 28% нь заримдаа саналаа өгдөг гэж хариулсан нь хангалтгүй үр дүн байв.

Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, сонирхлыг авч үзэхдээ улс төр хэр сонирхдог, орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилдаг зүйлс, сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг байдал ба тухайн орон нутгаас сонгогдсон төлөөлөгчдийн таньдаг эсэх, орон нутгийн сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, нутгийн өөрийн удирдах байгууллагад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зэрэгтэй

холбоотой зарим асуудлуудын талаарх ойлголт, сонирхлыг тодруулан харахыг зорилоо.

*Зураг 3. Орон нутгийн сонгуульд саналаа өгөхөд чухалчилдаг хүчин зүйлс*




Орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхдөө юуг нь илүү чухалчилж сонголтоо хийдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 25% нь буюу 4 хүн тутмын нэг нь "мөрийн хөтөлбөрийг нь уншиж танилцан сонголтоо хийдэг" гэсэн бол 32% нь "нэр дэвшигч нь хэн байгааг чухалчилдаг" буюу хүнийг нь харж сонголт хийдэг гэсэн хариулт өндөр хувьтай байна. Тэгвэл тухайн сонгогчид сонгуульд оролцож саналаа өгөхдөө нэр дэвшигчийн хэн байгааг чухалчлан үздэг бол тухайн тойргийн сонгуульд ялалт байгуулсан төлөөлөгчдийг таньж байгаа эсэхийг асуусан юм.

*Зураг 4. Тодорхой албан тушаалтнуудыг таних эсэх*



Иргэдийн дийлэнх хувь нь тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, УИХ-ын дарга болон Ерөнхийлөгчөө таньж байсан бол ердөө 43%-44% нь өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэл, сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөө танина гэв.

Энэ нь орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид орон нутгийн сонгууль, түүний зохион байгуулалтын талаарх мэдээллийг сонгогчдод төдийлөн хүртээмжтэй хүргэж чаддаггүй, бүүр цаашилбал сонгуулийн ирц бага байсныг харуулж байна. Үүнээс гадна сонгогчдын орон нутгийн сонгуульд санал өгч оролцох оролцоо сул, орон нутгийн сонгуультай холбоотой асуудалд хайхрамжгүй ханддаг байдалтай холбоотой. Нөгөөтээгүүр, нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид сонгогдсоныхоо дараа ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдтэйгээ хамтрах, санал солилцох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ИТХ-ын үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх зэрэг ажил сул хийдгийг харуулж болох юм.

Сонгогчдын зүгээс тухайн сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилдаг зүйлийг судлахаас гадна аль ч сонгуулийн хувьд нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншиж судлан, харьцуулж сонголтоо хийх нь ардчиллын суурь зарчим байдаг. Тэгвэл судалгаанд оролцогчид орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэхийг дараах асуултад тодрууллаа.

*Зураг 5. Орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэх*




Судалгаанд оролцогчдын 59% нь орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг тодорхой хэмжээгээр уншиж судлан сонголтоо хийдэг гэж хариулсан байна. Харин 15% нь мөрийн

хөтөлбөрөөс өөр зүйлийг харгалзаж буюу нэр дэвшигчийн өөр бусад зүйлсийг хардаг, 7% нь гэр бүл ойр дотнын хүмүүсийнхээ зөвлөгөөгөөр сонголтоо хийдэг бол 18% нь энэ асуултад хариулт өгөхөөс татгалзсан. Угаас орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх нь бага, тухайн сонгуулийн өдөр саналаа өгөх боломжгүй буюу өөр газар шилжсэн байдаг, нэр дэвшигчдийн өрсөлдөөн шударга бус, ёс зүйгүй болдог зэрэг судалгааны дээрх хэсгүүдэд дурдагдсан шалтгаанууд байгаа бол орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг унших байдал бага байх нь ойлгомжтой. Харин орон нутгийн сонгуульд тогтмол, идэвхтэй оролцож байгаа иргэдийн хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншиж танилцан сонголтоо хийдэг байх магадлалтай. Уг нь сонгуулийн мөрийн хөтөлбөр гэдэг бол тухайн сонгуульд нэр дэвшигчдийн зүгээс орон нутгийг хөгжүүлэх хөгжлийн бодлогыг сонгогчдод санал болгож байгаа баримт бичиг тул сонгогчид уг мөрийн хөтөлбөрийг сайтар уншиж танилцан, харьцуулж сонголтоо хийх ёстой байтал судалгаанд оролцсон иргэдийн 40% нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаггүй, цаашилбал бүрэн уншдаггүй, ер нь уншдаггүй судалгаанд оролцогчдын хувь 65% байгаа нь орон нутгийн сонгуулийн мөн чанарын талаарх ойлголтгүй байгааг харуулж байна.

Манай улсад орон нутгийн сонгуулийг мажоритар тогтолцоогоор зохион байгуулдаг учраас тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагад ихэвчлэн 2-3 улс төрийн нам, эвсэл сонгогддог[10]. УИХ-ын сонгуульд мөн адил 2-3 улс төрийн нам, эвсэл олонх болж байсан. Эндээс судалгаанд оролцогчид орон нутгийн сонгуульд сонголт хийхэд нь УИХ-ын сонгуульд санал өгсөн байдал нөлөөлдөг эсэхийг тодруулах зорилгоор “УИХ-ын сонгуульд саналаа өгч дэмжсэн улс төрийн намыг орон нутгийн сонгуулийн үеэр дэмжин сонгож байсан уу?” гэсэн асуултыг асуулаа.

[10] Азийн сангийн дэмжлэгээр МУИС-ийн Ардчилал судлалын төвийн багш, судлаачдын гүйцэтгэсэн “Монгол Улсын 2000 оноос хойших орон нутгийн сонгуулийн үр дүнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2022

*Зураг 6. УИХ-ын сонгуульд саналаа өгч дэмжсэн улс төрийн намыг орон нутгийн сонгуулийн үеэр дэмжин сонгож байсан эсэх, бүс нутгаар*




Судалгаанд оролцогчдын хариултыг бүс нутгаар ангилж, харуулав. Хангайн бүсийн сонгогчдын хувьд УИХ-ын сонгуульд саналаа өгсөн намдаа орон нутгийн сонгуулиар дахин санал өгөх хувь (73%) харьцангуй өндөр байсан бол Улаанбаатар хотын сонгогчдын хувьд харьцангуй бага буюу (59%) байв. Эндээс орон нутгийн сонгогчид УИХ болон орон нутгийн сонгуульд нэг намын нэр дэвшигчдийг дэмжих хандлага илүү байна.

*Зураг 7. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийж байсан эсэх, бүс нутгаар*



Өмнө дурдсанчлан орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийдэггүй гэж судалгаанд оролцогчид дүгнэснийг бүс нутгаар ангилж харуулав. Баруун бүсийн иргэд энэ төрлийн мэтгэлцээн болдоггүй гэсэн бол, төвийн бүсийн иргэд харьцангуй өндөр хувьтайгаар орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийдэг, заримдаа хийдэг гэсэн хариултууд өгсөн байна.

*Хүснэгт 5. Орон нутгийн сонгуультай холбоотой зарим асуудал оновчтой эсэх*

| Үзүүлэлт | Оновчтой | Дунд зэрэг | Оновчгүй | Энэ талаарх ойлголт алга | |
|---|---|---|---|---|---|
| Орон нутгийн сонгуулийн тогтолцоо | 12% | 54% | 24% | 10% | |
| Орон нутгийн сонгууль хүчин төгөлдөр болох ИРЦийн 50%+1 гэсэн "босго" байхгүй болсон. | 15% | 38% | 28% | 19% | |
| Орон нутгийн сонгуулийн санал хураах үеэр өөр газар ажиллаж, сурч, амьдарч байгаа бол тухайн байгаа газраасаа сонгуульд оролцож саналаа өгөх | 39% | 32% | 18% | 11% | |
| Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх | 17% | 39% | 32% | 13% | |
| Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвших | 35% | 38% | 16% | 11% | 10 |

Судалгаанд оролцогчдын 78% нь орон нутгийн сонгуулийн тогтолцоог, 66% нь орон нутгийн сонгууль хүчин төгөлдөр болох ирцийн 50%+1 гэсэн “босго” байхгүй болсон, 71% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх нь “дунд зэрэг оновчтой” болон “оновчгүй” хэмээн дүгнэлээ. Мажоритар сонгуулийн тогтолцооны сул талууд болох сонгогчдын саналыг нутгийн өөрөө удирдах байгууллагад төлөөлж чадахгүй ихээр гээж байгаа, нөгөө талаас иргэд орон нутгийн сонгуулийг тоохгүй байх, саналаа өгөхгүй байгаагаас дахин болон  нэмэлт санал хураалтыг зохион байгуулдаг.

Мөн 2020 болон 2024 оны орон нутгийн сонгуульд ирцийн босгыг байхгүй болгосон нь сонгуулийн тогтолцооны сул талыг улам нэмж байна.

Судалгаанд оролцогчдын 71% нь орон нутгийн сонгуулийн санал хураах үеэр өөр газар ажиллаж, сурч, амьдарч байгаа бол тухайн байгаа газраасаа сонгуульд оролцож саналаа өгөхийг ихээр дэмжсэн байгаа нь бодлогын хувьд шийдэх хэрэгтэйг харууллаа. Харин судалгаанд оролцогчдын 73% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвшихийг “дунд зэрэг оновчтой”, “бүрэн оновчтой” гэж хариулсан нь цаашид орон нутгийн ИТХ-ыг тойрсон улс төржих, улс төрийн намаар талцах зэрэг асуудлыг шийдэх шаардлагатай байна. Уг асуултуудад “энэ талаарх ойлголт алга” гэж хариулсан судалгаанд оролцогчдын хувь энэхүү судалгааны бусад асуултын хариултуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан нь цаашид энэ талаарх ойлголтуудыг өгөх, ач холбогдлыг ойлгуулах нэн хэрэгцээтэй харуулж байлаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагад нийгмийн зарим бүлгийн төлөөлөл байх хэрэгцээ шаардлагыг иргэд хэрхэн харж буйг тодруулах зорилгоор дараах асуултуудыг асуулаа.

*Зураг 8. Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тодорхой бүлгийн төлөөллийг нэмэгдүүлэх тухай*




Судалгаанд оролцогчдын 95% нь залуучуудын төлөөллийг, 94% нь эмэгтэйчүүдийн төлөөллийг, 89% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн төлөөллийг ИТХ-д нэмэгдүүлэхийг дэмжсэн. Эндээс сонгогчид ИТХ-д тодорхой бүлгийн төлөөллийг нэмэгдүүлэх нь ач холбогдолтойг анзаарч байна. Ер нь өмнөх жилүүдийн орон нутгийн сонгуулийн үр дүнгээс харахад өнөөдрийг хүртэл ИТХ нь тодорхой бүлгийн төлөөллийг

харгалзахгүй, үүнд ач холбогдол өгөхгүй байгаа. Зөвхөн эмэгтэйчүүдийн квотыг сонгуулийн тухай хуульд тусгадаг ч сонгогдсон төлөөлөгчдийг хүйсээр ялган дүгнэлт хийх боломж Сонгуулийн ерөнхий хорооны нэгтгэгдсэн мэдээллийн санд байхгүй.

Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг хэрхэн хүлээн авдаг, тэдгээр мэдээллүүд хэр хүртээмжтэй байдаг зэргийг дараах асуултаар тодруулсан юм.

*Зураг 9. Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийн хүртээмжийн үнэлгээ*




Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг сонгогчдод түгээж байгаа нь сонгогчдод хэр зэрэг хүртээмжтэй эсэхийг үнэлэх асуултад судалгаанд оролцогчдын 31% нь сайн, 42% нь дунд, 27% нь муу, огт авдаггүй болон энэ талаарх ойлголт алга гэж хариулсан. Гэхдээ тухайн сонгогч орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг хэр зэрэг сонирхдог вэ, сонгогчийн боловсрол олгох мэдээллийг хүлээн авч байна уу, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны мэдээлэл, мөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл зэргийн алийг түлхүү хүлээн авдгийг ялгаж судлах хэрэгтэй байна. Иргэдийн мэдээлэл хүлээн авдаг суваг (зөвхөн улс төрийн бус) болон тухайн мэдээллийг ямар хэлбэрээр хүлээн авахыг хүсдэг нь мэдээллийн хүртээмжийг, мөн сонгуулийн талаарх мэдээллийг тэдэнд хүргэх, ач холбогдлыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой билээ.

### *Тухайн орон нутгийн хөгжлийн талаарх иргэдийн үнэлгээ*

Судалгааны энэ хэсэгт тухайн орон нутгийн нөхцөл байдалд иргэд хэр сэтгэл хангалуун байдгийг тодруулсан.

*Хүснэгт 6. Орон нутгийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун байдал, бүс нутгаар*

| | Баруун бүс | Зүүн бүс | Төвийн бүс | УБ | Хангайн бүс | Үндэсний дундаж |
|---|---|---|---|---|---|---|
| Орон нутгийн бодлого, төлөвлөлт | 66% | 68% | 71% | 51% | 61% | 59% |
| Орон нутгийн өрсөлдөх чадвар | 56% | 67% | 63% | 48% | 49% | 53% |
| Орон нутгийн төсөв | 49% | 53% | 52% | 41% | 42% | 45% |
| Орон нутгийн дэд бүтэц | 50% | 56% | 61% | 45% | 50% | 49% |
| Боловсролын хүртээмж | 64% | 73% | 60% | 46% | 56% | 54% |
| Эрүүл мэндийн үйлчилгээ | 52% | 46% | 55% | 44% | 44% | 47% |
| Орон нутгийн иргэдийн амьдрал, амьжиргааны түвшин | 48% | 44% | 52% | 38% | 47% | 43% |
| Ажлын байр | 49% | 42% | 42% | 36% | 40% | 40% |
| Бизнес эрхлэх таатай орчин | 47% | 43% | 46% | 35% | 42% | 40% |
| Амьдрах орчин, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал | 45% | 44% | 49% | 35% | 45% | 41% |
| Орон нутгийн удирдлагад цахимаар санал хүсэлтээ өгөх, холбогдох боломж | 46% | 45% | 48% | 37% | 49% | 43% |
| Бусад | 46% | 45% | 47% | 33% | 42% | 39% |

*мөр бүрээс хамгийн өндөр болон хамгийн бага хувийг тодруулав.

Дээрх хүснэгтэд иргэдийн орон нутгийн нөхцөл байдлын талаарх сэтгэл хангалуун байдлыг бүс нутгаар ангилж харуулсан. Улаанбаатар хотын нөхцөл байдал (бизнес эрхлэх орчин, хүртээмж, амьжиргааны түвшин зэрэг)-д сэтгэл хангалуун иргэдийн хувь бусад аймгуудтай харьцуулахад бүх үзүүлэлтээр хамгийн доогуур байлаа. Тухайлбал, орон нутгийн төлөвлөлтийн талаар төвийн бүсээс судалгаанд оролцсон иргэдийн 71% нь маш сэтгэл хангалуун болон зарим талаар сэтгэл хангалуун гэсэн хариултыг өгчээ. Харин Улаанбаатар хотын хувьд тухайн хэмжээ 51% болон буурсан байна.

## ДҮГНЭЛТ

Орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөх, бүр тодруулбал нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт маш чухал нөлөөтэй бөгөөд тухайн амьдарч буй орон нутгийн иргэдэд тулгарч буй асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор, иргэдийн өөрсдийнх нь саналаар шийдэх тогтолцоо юм. Гэтэл орон нутгийн төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд оролцдоггүй, анхаарч үздэггүй зэрэг нь орон нутгийн сонгуульд саналаа өгөхгүй байгаатай адил болсон. Эндээс харахад, орон нутгийн сонгууль дахь сонгогчдын ирц, оролцоо хангалтгүй, хязгаарлагдмал байна. Цаашид орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт тодорхойлох, сонгогчдын хэрэгцээ шаардлага, үйл байдлыг, орон нутгийн сонгуульд саналаа өгөхөд тулгамдаж буй асуудлуудыг нарийн судлах, судалгааны үр дүнд үндэслэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох, олон нийтэд орон нутгийн сонгуулийн талаарх зөв, цэгцтэй мэдээллийг өгөх, нөлөөллийн ажлуудыг хийх боломжтой.

Иймээс Сонгуулийн ерөнхий хороо, төрийн болон төрийн бус байгууллагууд, улс төрийн нам, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн удирдлага, багш, судлаачид сонгогчдыг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцоход ашиглах боломж нээлттэй байгаа зэргийг бүрэн ашиглаж сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах, идэвхжүүлэх, заах, үлгэрлэх зэргээр ажиллах нэн шаардлагатай байна.

## САНАЛ

***Хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд:***

- Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Намын тухай хууль зэрэг хуулиудад сонгогчдын улс төрийн эрх, үүрэг болон сонгуульд оролцох оролцоотой холбоотой бүхий л асуудлыг нарийн тусгаж, сонгогчдын улс төрийн идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зүйл заалтуудыг тусгаж өгөх.
- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтэд таниулах ухуулга сурталчилгааг зөвхөн иргэний нийгмийн байгууллага гэхгүйгээр төрийн байгууллагууд, улс төрийн намууд санаачилдаг, зохион байгуулдаг зохицуулалт бий болгох.

***Бүтэц, зохион байгуулалтын асуудлын хүрээнд:***

- Орон нутгийн сонгуулийг зохион байгуулах, уг сонгуультай холбоотой мэдээллийг түгээх, сонгуульд өрсөлдөх гэж байгаа нэр дэвшигчдийг бүртгэх зэрэг асуудлыг технологийн дэвшлийг ашиглах, цахим байдлаар зохион байгуулах.

- Гадаадад оршин суугаа, бүртгэлтэй хаяг дээрээ амьдраагүй, ковид зэргээс шалтгаалсан олон нийтийг хамарсан хөл хорионы улмаас саналаа өгч чадахгүй байгаа иргэдийн саналыг авах дэвшилтэт аргуудыг орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанд яаралтай нэвтрүүлэх. Тухайлбал, мэйлээр, онлайнаар саналаа өгөх зэрэг аргуудыг хэрэглэх. Ингэхдээ нууцлал, аюулгүй байдлыг сайтар хангах.
- Тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас санал хураах байр бүрд байх, санал авах байр тэргэнцэртэй сонгогчид чөлөөтэй нэвтрэх боломжтой байх, мөн хэл, ярианы бэрхшээлтэй сонгогчдод өгсөн заавар бүхий контентуудыг сонгогчдод ээлттэй түгээх. Тухайн нөхцөл байдлыг бодит байдал дээр хүртээмжтэй байгаа эсэхэд хяналт, мониторинг хийж алдаатай, дутуу зүйлсийг засах, яаралтай шийдвэрлэдэг байхыг тухайн хэсгийн хороодод үүрэг болгох.
- Орон нутгийн сонгуулиар дамжуулан иргэдийн төлөөлөгчдийн хуралд нийгмийн тодорхой бүлгийн буюу залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгааг улс төрийн нам, нэр дэвшигчид анхаарах, тэднийг чадавхжуулах хөтөлбөр бий болгох.

***Орон нутгийн сонгуулийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх ажлын хүрээнд:***

- Орон нутгийн сонгуулийн ач холбогдол, санал өгөхөд анхаарах зүйлсийн талаарх ойлголт, мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар сонгогчдод хүргэх.
- ИТХ-ын талаарх ойлголт бага учраас орон нутгийн сонгуулийг иргэд үл тоомсорлох, саналаа өгөхгүй байх хандлага судалгааны хүрээнд ажиглагдсан. Иймээс орон нутгийн сонгуулиар бүрддэг буюу иргэдэд хамгийн ойр шийдвэр гаргадаг төлөөллийн байгууллага болох ИТХ-ийн талаарх ойлголт, мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хялбар байдлаар, тогтмол хүргэж хэвших.
- Иргэдийн сонгуулийн оролцоог зөвхөн санал өгөх хязгаарлагдмал хүрээнд авч үзэлгүй улс төрийн нам, бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй танилцах, уулзалтад очих, үзэл бодлоо илэрхийлэх, хандив өгөх, өөрөө нэр дэвших, холбогдох газарт санал хүсэлт гаргах зэрэг өргөн хүрээнд сурталчлан таниулах.
- Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, биелэлтийг тухайн орон нутгийн иргэд хянах, сонгогчдод мэдээлэх, хэлэлцэх. Ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийн дунд цахим ээлттэй талбаруудыг нээн тогтмол ажиллуулах.

- Орон нутгийн сонгуульд сонгогчдын оролцоо хандлагыг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөллийн ажлыг сонгууль зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагууд сонгогчид, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, улс төрийн намуудын дэмжлэгтэйгээр тогтмол зохион байгуулж хэвших. Ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийг оролцуулан зохион байгуулахыг анхаарах.

## НОМ ЗҮЙ


- Blais, A. (2000). To vote or not to vote? The merits and limits of rational choice theory. University of Pittsburgh Press.
- Clark, A., & Krebs, T. B. (2012). Elections and policy responsiveness. In: Mossberger, K., Clarke, S. E., & John, P. (Eds.). The Oxford handbook of urban politics. Oxford University Press.
- Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.
- Ladner, A., Keuffer, N., & Baldersheim, H. (2016). Measuring Local Autonomy in 39 Countries (1990–2014). Regional & Federal Studies, 26(3), 321-357.
- Marschall, M. (2010). The Study of Local Elections in American Politics. J. Leighley (Ed.) The Oxford Handbook of American Elections and Political Behavior. Oxford University Press.
- Miller, W. L. (1988). Irrelevant elections? The quality of local democracy in Britain. Oxford University Press.
- Oliver, J. E., Ha, S. E., & Callen, Z. (2012). Local elections and the politics of small-scale democracy. Princeton University Press.
- Van der Kolk, H. (2007). Local electoral systems in Western Europe. Local Government Studies, 33(2), 159-180.
- Van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.
- Vetter, A. (2007). Local politics: a resource for democracy in Western Europe? Local autonomy, local integrative capacity, and citizens' attitudes toward politics. Lexington

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН УРИА ҮГЭНД ХИЙСЭН АНАЛИЗ

Г.Одонтуяа

*Хураангуй:* Энэхүү судалгааны ажлын хүрээнд 1993 оноос 2021 он хүртэлх хугацаанд нийтдээ найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн 23 нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны цөм хэсэг болох "Сонгуулийн уриа"-д дүн шинжилгээ хийхийг зорьсон. Сонгуульд нэр дэвшигч улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн уриа үгийг задлан судалсан судалгаа элбэг биш бөгөөд дэвшүүлсэн уриа нь оновчтой, олон нийтийн анхаарлын татсан сонирхолтой эсэхэд хийсэн ажиглалт, шинжилгээний үр дүнгээс танилцуулна.

*Түлхүүр үг:* Ерөнхийлөгчийн сонгууль, нэр дэвшигч, уриа, сурталчилгаа, нам эвсэл

## *Оршил:*

Ардчилалаас хойшхи 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн найман удаагийн сонгууль болж, зургаан Ерөнхийлөгч сонгогджээ. 1993 онд П.Очирбат, 1997, 2001 онд Н.Багабанди, 2005 онд Н.Энхбаяр, 2009 болон 2013 оны сонгуульд Ц.Элбэгдорж, 2017 онд Х.Баттулга, 2021 оны сонгуульд У.Хүрэлсүх ялалт байгуулан Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон[1].

Монгол Улсад зохион байгуулагдсан нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг эргэн харвал аль ч сонгуульд улс төрийн хоёр гол том нам болох МАН/МАХН болон АН-ын нэр дэвшигчид ялалт байгуулсаар иржээ. Сонгогдсон бүх нэр дэвшигч нь эрэгтэй байсан ба нийт 23 нэр дэвшигчийн дунд нэг л эмэгтэй нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн байна. Нийт найман удаагийн сонгуулийн хоёрт нь хоёр нэр дэвшигч, тавд нь гурван нэр дэвшигч, 2005 оны сонгуульд дөрвөн нэр дэвшигч тус тус өрсөлджээ.

[1] Э.Гэрэлт-Од, (2021). Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах” гэж заасан байдаг.[2]

Найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д суудалтай нам, эвслийг төлөөлсөн 23 хүн нэр дэвшсэн бөгөөд сонгуулийн сурталчилгаандаа бүгд уриа үг ашиглажээ.

Сонгуулийн сурталчилгаа нь нэр дэвшигчийн байр суурь, бодит нөхцөл байдлын талаар сонгогчдод хүртээмжтэй мэдээлэл хүргэхэд чиглэдэг.[3]

Хуульд заасан энэ хугацаанд нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө сонгогчдод энгийн ойлгомжтой, товч тодорхой танилцуулах, хоногшуулах эхний алхам бол “Сонгуулийн уриа”.

Нэр дэвшигчдийн сонгуулийн уриа нь хэр оновчтой, онцлогтой, содон, сонирхолтой, алсын хараа, зорилгоо яаж шингээсэн зэргийг задалж судлах нь энэ салбарт шинэлэг судалгаа болох юм.

*Судалгааны зорилго:*

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны урианы шинж чанар, утга агуулга, онцлог зэргийг судалж сонгуулийн сурталчилгааны оновчтой агуулга бүхий уриаг тодорхойлох нь энэхүү судалгааны зорилго юм.

*Судалгааны арга:*

Судалгаанд чанарын судалгааны аргыг түлхүү ашиглан баримт материалыг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашигласан.

*Онолын ойлголт:*

Англи хэлний “Slogan” гэдэг үг нь Монгол хэлэнд “уриа, лоозон” гэж орчуулагддаг.

Англи хэлний Оксфордын толь бичигт уриа гэдэг үгийг "сурталчилгаанд ашигласан богино, мартагдашгүй, гайхалтай зохицол бүхий үг хэллэг, өгүүлбэр" хэмээн тайлбарлажээ.[4] Өөрөөр хэлбэл, нэр дэвшигч нь өөрийн давуу

[2] Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хууль, 2020 он, 34 дүгээр бүлэг

[3] Gelman A & King G. (1993) Why American Presidential Election Polls So Variable When Votes are So Predictable? British Journal of Political Science 23 (3): 409

[4] Оксфорд толь бичиг.
H HYPERLINK "https://www.oxfordreference.com/display/10.1093/acref/9780199590230.001.0001/acref-9780199590230-e-1663"ttps://www.oxfordreference.com/display/10.1093/acref/9780199590230.001.0001/acref-9780199590230-e-1663

талыг, алсын хараа, хүрэх үр дүнг товчоор ойлгуулах, олонд зэргээр танигдахын тулд уриа үгийг ашигладаг.

Уг сэдэвт хамаатуулан тайлбарлах гол онол бол “Хоёр үе шаттай мэдээллийн урсгалын онол” юм. Е.Катц энэхүү онолын таамаглалыг дэвшүүлэхдээ дараах үндсэн шинжийг зайлшгүй байх ёстой хэмээн дэвшүүлсэн. Үүнд: хувийн нөлөөний хүч, хувийн нөлөөллийн чиглэл, үзэл санааны лидер болон хэвлэл мэдээллийн харилцан хамаарал зэрэг юм.[5] Энэ нь хэвлэл мэдээллийн сурталчилгаанаас илүүтэй уриа үгээр дамжуулан өндөр нөлөө үзүүлж болох юм.

Түүнчлэн улс төрчид олон нийтийн санаа бодлыг өөрт ашигтай байдлаар өөрчлөх эргүүлэх буюу манипуляци хийх явдал нь улс төрд эртнээс бий болсон. Манипуляци нь нийгэм-сэтгэл зүйн үзэгдэл бөгөөд бусдын санаа бодлыг өөрчлөхийн тулд сэтгэл хөдлөл буюу эмоци дээр тулгуурладаг онцлогтой. Атаархах, бахархах, бишрэн шүтэх, айх, үзэн ядах, жигшин зэвүүцэх, зэрэг хөдлөлийн мэдрэмжүүдэд тулгуурлан манипуляцийг гардан хийгчид буюу манипуляторууд өөрийн байр суурь, стереотипийг олон нийтийн санаа бодолд бий болгодогт манипуляцийн гол мөн чанар оршино. Манипуляцийг хүргэх гол суваг нь олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд байдаг. Мөн ухуулга сурталчилгааны бусад бүх хэлбэрийг ашиглаж болдог.[6]

АНУ-ын Georgia College & State University судлаач Кайл Ньюсоме “The Use of Slogans in Political Rhetoric” буюу “Улс төрийн үг хэллэгт уриа лоозон ашиглах нь” судалгаандаа “Сайн уриа лоозон нь сэтгэл хөдлөл, шалтгаан, итгэл үнэмшил зэрэгт тулгуурлан үзэгчдийн сэтгэлийг хөдөлгөхөөр, үнэмшилтэй байдаг. Уриа лоозон, үг хэллэгийг улс төрчид, улс төрийн намууд, цэргийнхэн, идэвхтнүүд, жагсагчид тодорхой итгэл үнэмшил, үйлдлийг илэрхийлэх, дэмжих зорилгоор ашигладаг”[7] гэсэн дүгнэлтийг гаргасан нь Ардчилсан улсад хамгийн томирох тодорхойлолт юм.

---

[5] Katz and Lazarsfeld (1995) Personal Influence. New York: Free Press
Elihu (1957) The Two-Step Flow of Communication: An Up-To-Date Report on a Hypothesis. Public Opinion Quarterly. Oxford University Press. Pp.61-78.

[6] Д.Мөнхцэцэг (2006) Шинэ толь сэтгүүл 55, х-5

[7] https://kb.gcsu.edu/cgi/viewcontent.cgi?article=1203 HYPERLINK "https://kb.gcsu.edu/cgi/viewcontent.cgi?article=1203&context=thecorinthian"& HYPERLINK "https://kb.gcsu.edu/cgi/viewcontent.cgi?article=1203&context=thecorinthian"context=thecorinthian

*Түүхийн улбаа:*

Дэлхийд тэргүүлэх гүрнүүдийн түүхэн хөгжилд дайн тулаан тодорхой үүрэг гүйцэтгэсэн нь ойлгомжтой. Эрт дээр үеэс дайн байлдаанд цэргүүдээ зоригжуулах шаардлага зүй ёсоор үүссэн байх. Зүгээр л дув дуугай байлдах нэг хэрэг, ямар нэг ид шидэт, өөрсдийнхөө омог зоригийг бадраах, дайсныхаа сүр сүлдийг үхүүлэх дайчин уриатай орох нь огт өөр хэрэг.[8]

*Орон орны сүр хүчээ илэрхийлдэг уриа, уухайны утга:*

1. Уухай - Монгол

Монголчууд “Уухай!” хэмээн хашгирч тулаанд ордог билээ. Энэ нь ерөнхийдөө "Мөнх хөх тэнгэр ивээх болтугай" гэсэн итгэл үнэмшлийн утгатай аж. Мөн дайн тулаан биш чухал үйл явдал баяр ёслолын үед ч муу муухайг зайлуулах, сайн сайхныг авчрах үүднээс уухай буюу хурай хэмээх нь бий.

2. Montjoie Saint Denis (Монжуа сан дени) - Франц

Montjoie Saint Denis! Энэ бол Францын Вант улсын байлдааны уриа байв. Энэ нь домогт Карл хааны сүлд болох "Montjoie"-ийг магтан дуулж буй утгатай аж. Тус сүлдийг Гэгээн Денисийн сүм хийдэд хадгалагдаж байгаа гэж үздэг учраас нэрийг нь цуг хэлдэг байна.

3. Алала - Грек

Эрт цагт грекчүүд ἀλαλάζω буюу "Алала" хэмээн тулаанд ордог байв. Энэ нь дайны охин тэнгэр Афиныг өөр нэг нэр аж. Грекийн дайчид Алала буюу Афин нэрийг хэлж байгаа цэргүүдийг ивээн ялалт авч ирнэ гэж итгэдэг байжээ.

4. Аллах Акбар - Исламын шашинт орнууд

Аллах Акбар буюу "Allāhu akbar" нь "Бурхан бол агуу" гэсэн утгатай араб үг юм. Ерөнхийдөө Исламын шашинтай бүх орнуудад ашигладаг. Энэ үгийг уулга алдах, баяр хүргэх, залбирах гэх мэт олон хэлбэрээр ашигладаг ч дайчдын уриа гэдгээрээ хамгийн алдартай болсон байна.

5. Ура - ЗХУ, ОХУ

"Ура" нь Оросын цэргүүд хаант засгийн үеэс хэрэглэгддэг байсан үг юм. Үнэхээр ч тэд “Ура” үгийнхээ ачаар мөн ч олон гавъяа байгуулсныг түүхийн баримт батална. Ялангуяа Дэлхийн 2-р дайныг үед "Ура" хэмээн хашгирах Зөвлөлтийн цэргүүдгүйгээр төсөөлөхийн аргагүй.

6. Лхаржялоо! (Хоржийлоо) - Төвд

[8] Д.Ганхуяг. https://gankhuyag.com/2010/08/22/lksflkh/

Төвд, тангад ард түмэн эртнээс аливаа эр зориг шаардсан үйлийг хийх, дайн байлдаанд орохдоо "Лхаржялоо!" хэмээн хашхирдаг байжээ. "Тэнгэр дийллээ" гэх утгатай энэ урианд мэдээж Бурхны шашны нөлөө орсон тул зөвхөн дайн байлдаан биш, овоо шүтээнийг тайх, гороо хийхдээ хэлж болдог.

Монгол хэлэнд энэ үг "Хоржийлоо!" болон орж ирсэн бөгөөд наадмын үеэр морьд эргэхэд голчлон хэлдэг болсон билээ.

7. Tenno Heika Banzai - Япон

“Эзэн хаан урт наслаг” гэж орчуулагддаг энэ үгийг Японы цэргүүд (мөн энгийн иргэд баяр ёслолын үеэр) хашгирдаг юм. Дэлхийн 2-р дайны Номхон далайн тулалдааны үеэр Япон цэргүүд амиа золиослосон дайралт хийхдээ "Банзай" гэж орилдог байсан нь мөн түүхэнд бичигдсэн билээ.

8. Dieu et Mon Droit - Англи

Англи Францын хооронд өрнөсөн Зуун жилийн дайны шийдвэрлэх гурван тулалдааны нэг болох 1346 оны Кресийн тулалдаанд Английн Хаан III Эдвард орохдоо францаар "Dieu et Mon Droit" буюу "Бурхан ба эрх чөлөө" гэж хашгирсан байдаг. Энэ тулалдаанд явган цэргүүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн тул язгуурт хүлэг баатрууд бус энгийн цэргүүдийг хөгжүүлэх тал дээр европын орнууд анхаарч эхэлсэн юм. “Dieu et Mon Droit” нь өдгөө Английн хааны гэр бүлийн уриа болж, Хааны сүлд дээр бичигдсэн байна. [9]

[9] Saak.mn https://www.caak.mn/post/view/253373

*Хүснэгт 1. 1993-2021 он хүртэлх Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид, саналын тоо, дэвшүүлсэн уриа*

| № | Нэр дэвшигч | Нам, эвсэл | Хүн амын тоо | Сонгуулийн насны хүний тоо | Нэрсийн жагсаалтад бичигдсэн сонгогч | Нийт санал өгсөн сонгогчийн тоо | Санал өгсөн сонгогчийн хувь | Авсан саналын хувь | Сонгуулийн уриа | Нэг хүнд ногдох ДНБ | Ядуурлын түвшин |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1993 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | Л.Түдэв | МАХН | 2 199 570 | 1 159 173 | 1 106 403 | 1 025 970 | 92,73 | 38,7 | Өрх бүр үйлдвэр, хүн бүр үйлдвэрлэгч болох ёстой. | 345 | - |
| 2 | **П.Очирбат** | МҮАН, МСДХ | | | | | | 57,8 | Шилжилтийн үеийг цэглэнэ, амьдралын доройтлыг арилгана | | |
| **1997 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | **Н.Багабанди** | МАХН | 2 245 492 | 1 241 819 | 1 155 228 | 982 640 | 85,06 | 60,81 | Таны итгэл бидний зүтгэл | 515 | - |
| 2 | П.Очирбат | МҮАН, МСДН-ын | | | | | | 29,81 | “Хээгүй Ерөнхийлөгч” | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ардчилсан холбоо эвсэл | | | | | | | | | |
| 3 | Ж.Гомбожав | МҮНН | | | | | | 6,64 | "Тусгаар тогтнол, Шударга ёс, Эгэл борчуудын төлөө | | |
| **2001 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | **П. Багабанди** | МАХН | 2 388 163 | 1 398 219 | 1 205 885 | 1 000 125 | 82,94 | 58,13 | "Төрийг тогтворжуулна","Төрийн хэрэг иргэдээсээ, иргэний хэрэг төрөөсөө" | 531 | 2002 онд 36.1 |
| 2 | Р. Гончигдорж | АН | | | | | | 36,53 | "Төрийг тэнцвэржүүлнэ" | | |
| 3 | Л. Дашням | ИЗН | | | | | | 3,54 | Чадварлаг төр, хүчирхэг эдийн засаг, | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хангалуун амьдрал | | |
| **2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | П. Энхбаяр | МАХН | 2 533 552 | 1 578 967 | 1 241 268 | 930 921 | 75,00 | 53.44 | Монголчууд Эвтэй байхдаа хүчтэй Төрөө хямралаас гаргая, түмнээ ядуурлаас аваръя. | 1015 | 2006 онд 32.2 |
| 2 | М. Энхсайхан | Эх орон-Ардчилал эвсэл | | | | | | 20.05 | "Авлигачдыг цээрлүүлнэ" | | |
| 3 | Б. Эрдэнэбат | Эх орон нам | | | | | | 11.33 | Эрх чөлөөт, чинээлэг иргэдтэй Эрх зүйт, шударга төртэй болохын төлөө | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Б.Жаргалсайхан | БНН | | | | | | 13.83 | Төрд хяналт хариуцлага, Түмэнд ажил, орлого | | |
| **2009 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | Н. Энхбаяр | МАХН | 2 616 631 | 1 642 567 | 1 493 217 | 1 098 875 | 73,59% | 47.41 | "Эвийн хүчийг бэхжүүлнэ. Эх орны хишгийг өгүүлнэ" | 1759 | 31.7 |
| 2 | **Ц. Элбэгдорж** | АН | | | | | | 51.21 | Шударга л байцгаая Эх орны хишиг иргэн бүрд | | |
| **2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | Б. Бат-Эрдэнэ | МАН | 2 870 407 | 1 998 586 | 1 864 273 | 1 239 784 | 66,50 | 41.97 | Эвийг эрхэмлэнэ, Зөвийг дэмжинэ, | 4501 | 2012 онд 27.4 |
| 2 | **Ц. Элбэгдорж** | АН | | | | | | 50.23 | Ерөнхийлөгчөө дэмжье | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Н. Удвал | МАХН | | | | | | 6.5 | Шударга байхдаа хүчтэй, шударга бусыг өөрчилнө | | |
| **2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| 1 | М. Энхболд | МАН | 3 132 405 | 2 032 022 | 1 988 891<br>1 990 797* | 1 357 788<br>1 207 787* | 68,27<br>60,67* | 30.32<br>41.16* | Эвтэй Монгол, Эелтэй төр | 3705 | 2016 онд 29.6 |
| 2 | **Х. Баттулга** | АН | | | | | | 38.11<br>50,61* | Монгол ялна | | |
| 3 | С. Ганбаатар | МАХН | | | | | | 30.19 хасагдсан * | Монголоо сонгоё. “Өөр гарц байна, бидэнд иттэ | | |
| **2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль** | | | | | | | | | | | |
| | **У.Хүрэлсүх** | МАН | 3 393 437 | 2 160 549 | 2 049 379 | 1 215 063 | 59,29 | 67.69 | Баялагтаа эзэн Монгол байгалийн баялаг ард түмний өмч” гэсэн концепц | 4657 | 28.4 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | С.Эрдэнэ | АН | | | | | | 5.99 | Дарангуйлалгүй Монгол-Ардчилсан Монгол | | |
| | Д.Энхбат | “Зөв хүн электорат” эвсэл | | | | | | 20.31 | Монгол чадна /Намын төлөө бус нийт олныхоо төлөө/ | | |

**1993/ Л.Түдэв: Өрх бүр үйлдвэр, хүн бүр үйлдвэрлэгч болох ёстой.**

1993 оны хамгийн анхны Ерөнхийлөгчийн сонгуулийн үед улс төр, нийгэм, эдийн засгийн байдал гээд улс орон бүхэлдээ хүнд байсан үе. Нэгээс нөгөө нийгэмд дөнгөж шилжиж улс орон бүхэлдээ хөлөө олж эхлээгүй, шинэ улс төрийн тогтолцоо бүрэн төлөвшиж амжаагүй, эдийн засаг хямарсан, ард түмэн үймсэн гайхсан, байдалтай байсан. 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Монгол телевиз, одоогийн МҮОНТВ анх удаа нэр дэвшигчдийн халз мэтгэлцээнийг зохион байгуулжээ. П.Очирбат ард түмэнд тохируулж, тэдэнд таалагдах үгийг л сонгож хэлж байсан бол Л.Түдэв ард түмнээсээ түрүүлсэн, хэтийдсэн зүйлсийг ярьж байв. Тухайлбал, тухайн үед нар салхи, усны хүчийг ашиглах тухай ярьсан нь тэр цагт үлгэр шиг л сонсогдож байлаа. Мөн өрх бүр үйлдвэр, хүн бүр үйлдвэрлэгч гэх мэт хачин жигтэй үгүүд хэлж, “Би сонгогдвол импортыг хязгаарлаж, монголчууд бүсээ чангална. Ингэж л бид өөрсдөө үйлдвэрлэгч болно” гэж ярьсан нь олон нийтэд үнэхээрийн таалагдахгүй байлаа. Халз мэтгэлцээний өмнөх судалгаа, тандалтаар Л.Түдэв 60 гаруй хувиар илүү явж байсан бол мэтгэлцээний дараа сонгогчдын санаа бодол эргэжээ.[10] Тэр үед ард түмэн бүсээ чангалах тухай сонсохыг ч хүсээгүй хэрэг.

**П.Очирбат: Шилжилтийн үеийг цэглэнэ, амьдралын доройтлыг арилгана**

МАХН-ын гишүүн байсан П.Очирбат тухайн үед намаас нь нэр дэвшүүлээгүй тул МҮАН, МСДХ-ноос нэр дэвшихдээ ард түмэн юу хүсч байгааг маш сайн мэдэрч чадсан нь сонгуулийн ялалтыг авчирсан гэж үздэг байна. Нийгэм солигдоод удаагүй ороо бусгаа цагийг цэглэж, дутагдаж гачигдахын дээс хоолойд нь тулж ирсэн ард түмэнд тэр алт, эд баялаг, элбэг дэлбэгийг амласан.

**1997/ Н.Багабанди: Таны итгэл бидний зүтгэл**

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд гэвэл, 1996 оны УИХ-ын сонгуульд АХ эвсэл ялалт байгуулж Засгийн эрх барьж байсан үе. Харин ялалт байгуулсны дараа явуулж байсан бодлого, үйл ажиллагаа иргэдийн итгэсэн итгэл хүлээлтээс тэс өөр байсан. Өөрөөр хэлбэл 1997 оны Ерөнхийлөгчийн сонгууль хүртэлх 10 сарын хугацаанд улс оронд ажилгүйдэл ихсэж, ядуурал улам нэмэгдэж, иргэдийн амьдралын түвшин дордож улс орны нийгэм эдийн засгийн байдал нэлээд хүндэрсэн. Жишээ нь: 1996 оны сүүлчийн хагаст бараа үйлчилгээний үнэ тариф 40 хувь нэмэгдэж, хүн амын бодит орлого 32 хувь

[10] Д.Дамдинжав (2018), Сийлүү дардаг бажгар нийтлэлдээ дурдсан байдаг.

буурсан байна. Тухайн үед дэвшүүлсэн уриа нь тодорхой бус, бэлэгдлийн шинжтэй байсан ч ялалт байгуулсан.

**П.Очирбат: Хээгүй Ерөнхийлөгч**

Монголчууд хээгүй, гүндүүгүй гэж ярьдаг. Монгол хэлний их тайлбар тольд "Эрээ цээргүй, хамаа намаагүй, энгийн: хээгүй эр" гэж тайлбарлажээ.

Тэгэхээр сонгуулийн уриа үгэнд нь өнгөрсөн 4 жилд ажилласан амжилт, алсын хараа, ирээдүйн зорилго, мөрийн хөтөлбөрийн агуулга, үзэл санаа аль аль нь багтаагүй, хувь хүний онцлогийг илэрхийлсэн хээгүй гэсэн тодотгол наажээ.

**Ж.Гомбожав: Тусгаар тогтнол, Шударга ёс, Эгэл борчуудын төлөө**

Тусгаар тогтнол, шударга ёс гэсэн түгээмэл тунхаглалыг оруулж ирсэн атлаа эгэл борчуудын төлөө гэсэн нь зөрчилтэй уриа байна.

Үндсэн хуулинд "хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалт байдаг ч эгэл борчууд гэсэн ангилал гаргасан нь ёсзүйн зөрчил агуулжээ.

**2001/ Н.Багабанди: Төрийг тогтворжуулна**

Дахин нэр дэвшихдээ "Төрийг тогтворжуулна" гэсэн уриа дэвшүүлсэн нь "Титэм үг"-ээрээ алдартай улс төрчийн хувьд хамгийн оновчгүй үг гэж дүгнэлт хийжээ. Өмнөх 4 жилд нь төрийн тэргүүнээр ажиллахдаа төрийг тогтворжуулж чадаагүй учир дахин сонгогдож, яг тогтворжуулна гэх агуулгатай. Энэхүү уриа нь бүхэлдээ хамгийн муу сонголт хэдий ч дахин сонгогдсон.

**Р.Гончигдорж: Төрийг тэнцвэржүүлнэ**

Түүний нэр дэвшсэн жилд эдийн засаг хямралд орсон, ядуурал дээд цэгтээ хүрсэн. Үүний бурууг 1996-2000 онд Засгийн эрх авсан "Ардчилсан холбоо" эвсэл улс төрийн тогтворгүй байдал үүсгэсэн гэж дүгнэжээ. Мөн ард иргэд Р.Гончигдоржийг асуудалд бөөрөнхий ханддаг, худлаа ярьдаг гэж шүүмжилсэн байна. Сонгуулийн уриа нь МАХН-аас нэр дэвшигч Н.Багабанди нэр дэвшигчийн уриа үгнээс ондоошиж чадаагүй нь үр дүнд нөлөөлсөн гэж үздэг.

**Л.Дашням: Чадварлаг төр, хүчирхэг эдийн засаг, хангалуун амьдрал**

ИЗН-аас нэр дэвшигч Л.Дашням Санкт-Петербургийн Олон улсын харилцааны сургуульд суралцсан, СГЗ, эрдэмтэн, зохиолч, доктор профессор. "Чадварлаг төр, хүчирхэг эдийн засаг, хангалуун амьдрал" гэсэн хөтөлбөр уриатай Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон. Сонгуулийн насныхан дунд

явуулсан судалгаагаар иргэд Л.Дашнямыг "сайн мэдэхгүй" гэж хариулжээ. Сонгуулийн уриа нь нэг зүйлд фокуслагдаагүй, олон утгыг гаргасан, хэт урт уриа юм.

**2005/ Н.Энхбаяр: Төрөө хямралаас гаргая, Түмнээ ядуурлаас аваръя**

2005 онд Монгол Улсын гуравдах Ерөнхийлөгчөөр Намбарын Энхбаяр сонгогдож байлаа. Тэрбээр Ардчилсан намаас нэр дэвшигч М.Энхсайхан, Эх орон намаас нэр дэвшсэн Бадарчийн Эрдэнэбат, Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн Базарсадын Жаргалсайхан нартай өрсөлдөж, нийт сонгогчдын 53.44 хувийн санал авч, "Төрөө хямралаас гаргая, түмнээ ядуурлаас аваръя" уриатай ялж байсан юм.

МАХН-ын дарга Н.Энхбаярын парламентын танхимд ороод анх удаа хэлсэн үг нь "Монгол Улсын Засгийн газрыг огцруулах" тухай байв. Энэ үгнээс төрийн хямрал эхэлсэн. Гэхдээ тэр эхлүүлсэн хямралаа эмчлэгчийн дүрээр төрийн толгойд гарч, улмаар Үндэсний удирдагчийн хэмжээнд өөрийгөө өргөмжлүүлж чадсан юм.[11]

**М.Энхсайхан: Авлигачдыг цээрлүүлнэ**

Хамгийн сайн дэвшүүлсэн уриа гарцаагүй энэ юм. Харамсалтай нь түүний уриа цаг үеэсээ түрүүлчихжээ. Монголчууд тэр үед авлигын хор хөнөөлийг өнөөдрийнх шиг амьдралаараа ойлгоогүй байсан юм. Хэрэв ЖиДҮ, концессын луйвар цэцэглэсэн 2017 онд М.Энхсайхан гарч ирээд "Авлигачдыг цээрлүүлнэ" гэсэн бол "Монгол ялна" уриатай Х.Баттулгаас ч илүү санал авах боломжтой байв. Нэг хараад ойлгохоор, утга учир нь бүрэн дүүрэн, тогтооход хялбар, тухайн үеийн иргэдийг хүслийг шингээсэн ч ялагдал хүлээжээ.

АН хоёр ч даргатай болсон нь нэр дэвшигч М.Энхсайханыг сонгуульд амжилтгүй оролцох суурь болсон. Нэг эвсэлд байсан Б.Эрдэнэбат АН-ын нэр дэвшигчийн саналаас хуваалцахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэжээ.

**Б.Эрдэнэбат: Эрх чөлөөт, чинээлэг иргэдтэй, Эрх зүйт шударга төртэй болохын төлөө**

"Миний бие нийгмийг хамарсан хямралт байдлыг шинжлэн дүгнэж, ард түмнийхээ хүсэл эрмэлзлийг удирдлага болгон "Эрх чөлөөт чинээлэг иргэдтэй, Эрхзүйт шударга төртэй болохын төлөө" гэсэн уриатай төр, нийгмийн эрс

[11] Б.Баяраа (2021), Маргааш дахин нар мандана нийтлэл
http://www.baabar.mn/article/margaash-dakhin-nar-mandana

шинэчлэлийн хөтөлбөрийг сонгогч түмэндээ өргөн толилуулж байна" гэж тухайн үеийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулж байжээ.

Сонгуулийн уриа нь тогтооход хэцүү, ойлгоход бэрх, урт үгтэй уриаг сонгожээ. Агуулгын хувьд оновчгүй. Тухайлбал "Эрх чөлөөт, чинээлэг иргэдтэй" гэсэн нь иргэдийг эрх чөлөөгүй, ядуу байна гэсэн эсрэг ойлголтоор ойлгогдож байгаа юм.

**Б.Жаргалсайхан: Төрд хяналт хариуцлага, Түмэнд ажил орлого**

Сонгуулийн сурталчилгааны үеэр иргэд Бүгд Найрамдах намаас нэр дэвшсэн Б.Жаргалсайханыг дэмжих хандлага ажиглагдсан. "Түмэнд ажил орлого. Би бүтээж чадна" уриатай нэр дэвшсэн Б.Жаргалсайханы сонгуулийн штабаас иргэдэд ноос ноолууран бүтээгдэхүүн, цаг зэргийг тарааж байжээ. Сонгуулийн уриа үг нь толгой холбож шүлэглэсэн, сонсоход ойлгомжтой хэдий ч хувь хүний олонд танигдсан имиджд тохирохгүй уриа гэж үздэг байна.

**2009/ Ц.Элбэгдорж: Эх орны хишиг иргэн бүрт, Шударга л байцгаая**

Тухайн үед МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаяртай өрсөлдөж, нийт сонгогчдын 51.21 хувийн саналаар "Эх орны хишиг иргэн бүрт" гэсэн уриатай ялж байв. Уг уриа нь шууд утгаараа мөнгө амлаж, иргэдийн саналыг татах оролдлого байсан нь амжилттай хэрэгжсэн. Байгалийн баялгийн тэгш хувиарлалт хэмээх баялгийн хараал болсон ойлголтыг АН-ынхан бодож олж, иргэн бүрт 1 сая төгрөгийн хувьцаа өгөх санаачилга гаргасан нь мөнгө амлах амлалтуудын эхлэл байв.

**Н.Энхбаяр: Эвийн хүчийг бэхжүүлнэ. Эх орны хишгийг өгүүлнэ**

Дахин дэвшихдээ АН-ын гаргасан санааг атган авч, мөнгөний дүнг 1,5 болгон нэмэгдүүлэх уриаг УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд ашиглаж, УИХ-д олон суудал авахад хэрэгжсэн. Үндсэндээ эх орны хишиг нэрийдлээр 2 том намын нэр дэвшигчид шууд мөнгө өгөх амлалтаар луйвар хийсэн нэр дэвшигчдийн уриа үгний хамгийн муу жишээ юм.

**2013/ Б.Бат-Эрдэнэ: Эвийг эрхэмлэнэ, Зөвийг дэмжинэ**

Монгол төрийн ондоошил, үндэсний хэв маягийг шингээсэн үндэсний бөхийн их аваргыг намаасаа нэр дэвшүүлсэн нь намын лидертээ бус, хувь хүний буюу олонд хүндлэгдсэн их аваргын нэр хүндэд итгэж сойсон хэрэг.

Хувь хүний олонд танигдсан имиджээрээ ч Эвийг эрхэмлэж, зөвийг дэмжихийг уриалжээ. Тус уриа нь намчирхал талцалыг зогсоож, үндэсний эв

нэгдлийг сэргээж эв эеийг эрхэмлэн хөгжих ёстой, улс орондоо хэрэгтэй зөв бүхнийг дэмжинэ гэсэн агуулга байсан болов уу.[12]

Нөгөө талаар “Миний нэр цэвэр, миний гар цэвэр, миний сэтгэл цэвэр” хэмээх мессеж нь тухайн үед олны анхаарал татсан мессеж болсон билээ.

**Ц.Элбэгдорж: Ерөнхийлөгчөө дэмжье**

Өнгөрсөн 4 жилд нь төрийн тэргүүн байсан тэрбээр хоёр нэр дэвшигчээс давуу тал болох ерөнхийлөгч гэдэг статусаа ашигласан. “Ерөнхийлөгч” гэдэг гол үгийг өөр дээрээ шууд нааж, хамаатуулах хүчтэй өнцөг хэрэглэсэн юм. Өөрөөр хэлбэл өнгөрсөн 4 жилд хийсэн ажлаа үргэлжлүүлэн хийх агуулгаар өрсөлдөн ялалт байгуулсан.

**Н.Удвал: Шударга байхдаа хүчтэй, шударга бусыг өөрчилнө**

МАХН-аас нэр дэвшсэн, Монголын хүн амын тэн хагасын төлөөлөл болсон анхны эмэгтэй нэр дэвшигч Н.Удвал “Шударга байхдаа хүчтэй, Шударга бусыг өөрчилцгөөе” гэсэн ойлгоход хэцүүхэн уриа дэвшүүлжээ. Анхны эмэгтэй нэр дэвшигчийн уриа нь экс төрийн тэргүүний “Эвтэй байхдаа хүчтэй” урианы үргэлжлэл бөгөөд Н.Энхбаяр Ерөнхийлөгчийн агуулга, үзэл санаа нэвт шингэсэн гэж тухайн үед шүүмжлэгдэж байжээ.

**2017/Х.Баттулга: Монгол ялна**

Хэт үндсэрхэг эсвэл жинхэнэ утгаараа эх оронч, нөгөө талаас хэт популист мэт сэтгэгдэл төрүүлэх “Монгол ялна” уриа иргэд, сонгогчдын хамгийн их мэддэг уриа юм. Тухайн үед сайн уриа, муу уриа гэдэгт судлаачид олон нийт талцаж, үгэн дээр нь цохилт өгч мэтгэлцэж байсан. Нөгөө талаар 2027 оны сонгуулийн пи-ар бүхэлдээ нэр дэвшигчдээ цэвэр цустай биш, Хятадын эрлийз зэргээр "харлуулах" өрсөлдөөнийг тооцоолж уриагаа сонгосон биз. Шууд утгаараа би Монгол, өрсөлдөгч Хятад цустай гэсэн далд утга шингээсэн 2 үг хамгийн анхаарал татсан, содон уриа болсон юм.

**М.Энхболд: Эвтэй Монгол, Ээлтэй төр**

Х.Баттулгын уриа үгийг дарах, эсрэг байх “Эвтэй” гэдэг үг оруулсан нь тухайн үед мөн л эерэг хандлагыг өгч байсан ч ялагдал хүлээсэн. Сонгуулийн сурталчилгааны үеэр “Хагарч бутарч сууснаас бид улс орон ард иргэдийнхээ аж амьдрал нөхцөл байдлыг хэрхэн яаж доройтуулсныг мартах учиргүй. Тиймээс Монголын төр эвтэй байж энэ нөхцөл байдлын ард гарах ёстой. Монголын төр тогтвортой нэгэн зүгт харж улс үндэстнээрээ эв нэгдэлтэй байж чадвал цаашид

[12] Sonin.mn https://sonin.mn/news/peconomy/22876

тогтвортой хөгжиж цэцэглэх үндэс суурь бүрдэнэ гэж би бодож байна.” хэмээн ухуулж байжээ. Сонгуулийн дараа сошиал орчинд болон судлаачид М.Энхболдын ялагдлын шалтгааныг сонгуулийн дүн шинжилгээнд 60 тэрбумын бичлэг задарсан, нам дотроо хагарч бутарсантай холбон тайлбарласан байна. [13]

**2021/ У.Хүрэлсүх: Баялагтаа эзэн Монгол**

Ардын нам өнгөрсөн 4 жилд иргэдийн сэтгэл зүйг бэлдсэн зүйл дээрээ “тоглох”-ыг илүүд үзэв. “Баялагтаа эзэн Монгол” гэх уриаг Ардын намд гэхээсээ илүүтэй У.Хүрэлсүх хэмээх хувь хүнд “зориулсан” гээд шулуухан хэлчихэж болох юм. Учир нь тэрбээр 2017 оноос хойш байгалийн баялгийн талаар хамгийн их ярьсан хүн. Мөн газрын доорх баялаг бол бидний өмч мөн гэдэг агуулгыг МАН “шигтгэсэн”. Ерөнхий сайдаар томилогдон чуулганд орохдоо л “Байгалийн баялагийг тэгш хуваарилна, нэг айл 34 лиценз эзэмшиж болохгүй. Газрын доорх баялаг бол ард түмний өмч. Төр ард түмний өмчийг эргүүлж авна” гэх зэргээр иргэдэд таалагдах зүйлсийг "чулуудаж" эхэлсэн. Түүний Засгийн газар Эрдэнэтийн 49 хувийг буцааж авах, Оюутолгойн гэрээ хэлэлцээрт өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлж, татварын акт тавьсан. Мөн Асгатын мөнгөний ордныг Хятадуудаас тусгай байгууллагуудын хүчээр “булааж” авсан гээд байгалийн баялагтай холбоотой олон “ажил” хийсэн. Тиймээс энэ сонгуульд баялагтаа эзэн байх талаар ярьж орох нь өнгөрсөн хугацаанд хийсэн ажлуудаа эхнээс нь дуустал ярих боломжийг түүнд олгоно. Нөгөө талаас Монголчууд байгалийн баялаг гэдэг үгэнд ихэд акцент өгч ханддаг. Байгалийн баялгаа харийнханд алдахаас үхтлээ айдаг. Хэн нэгнээс “Баялгийн эзэн, таны юм” гэх үгсийг сонсох туйлын кайфтай улс. Эдийн засаг, улс орны хөгжлийг бодохоос илүүтэйгээр газар, шороо эх орондоо илүү санаа зовдог төрөлх натуртай ард түмэн. Мөн У.Хүрэлсүхийн урианаас халамж нэвт “үнэртэж” буйг хэлэх нь зүйтэй. Угаасаа МАН зүүн төвийн үзэлтэй нам учраас ийм өнгө аяс цухалзуулах нь ойлгомжтой. Тодруулбал, 2001 оноос хойшхи Ерөнхийлөгчийн сонгуулиуд МАН-аас нэр дэвшигч эвийн хүч, эсвэл баялагийн хүч гэсэн хоёрхон агуулга дээр л “тоглож” ирлээ.[14]

[13] О.Эрдэнэчимэг (2021), *Ерөнхийлөгчийн сонгууль: 1993-2013 лавлагаа, дүн шинжилгээ*

[14] Ubn.mn https://ubn.mn/p/14230

**С.Эрдэнэ: Дарангуйлалгүй Монгол-Ардчилсан Монгол**

"Дарангуйлалгүй Монгол" бол Ардчилсан намаас нэр дэвшигч С.Эрдэнийн бодож олсон сонгуулийн уриа үг. Нэг намын эсвэл нэг хүний дарангуйлал гэх агуулгыг АН-ынхан сүүлийн нэг жилийн турш давтаж байгаа. Монголчууд нэг хүнд эсвэл нэг намыг хэт хүчтэй байхыг тэвчдэггүй. Ялагдаж байгаа нэгнийг дэмждэг сонин өрөвч хүмүүс. Үг агуулгын хувьд идэвхтэй харагдаж байна. Ямар нэгэн зүйлд уриалан дуудсан шинжийг агуулжээ. Харин улс төрийн агуулгын хувьд сөрөг хүчнээс барьж болох л хувилбарыг дэвшүүллээ. Соц нийгэмд нэг нам, нэг хүний эрх мэдэл дор 70 жилийг туулсан монголчуудын хувьд. Мөн ардчилсан нийгэмд шилжээд 30 жилийг үдсэн ард түмний хувьд дарангуйлалд яс махнаасаа дургүй.

Өөрөөр хэлбэл, АН-ын энэ сонгуулийн арга тактик нь нэг намд УИХ, Засгийн газар, орон нутаг гээд төрийн бүхий л эрх мэдэл "хураагдсан". Дээр нь нэмж Ерөнхийлөгчийн институтийг өгөхгүй байцгаая л гэдэг агуулга. Товчоор хэлбэл, том агуулга нь явцуу байж болох ч яг өнөөдрийн нөхцөл байдалд өрсөлдөж буй хамгийн хүчтэй нөхөртөө “цохилт” өгөх гэсэн шууд зорилготой. Ямар ч байсан 2016 оноос хойш УИХ-д дараалан хэт олонх болж, сөрөг хүчиндээ зүү орох ч зай үлдээлгүй дөрвөн Засгийн газрыг байгуулсан өрсөлдөгчөө “баалсан” өнгө аяс С.Эрдэнийн урианаас үнэртэж эхэллээ. Энэ урианы гол зорилтод бүлэг нь нийслэл хотын хөвөгч масс руу л чиглэсэн мэт миний хувьд “уншигдаж” байна.

**Д.Энхбат: Монгол чадна**

Ерөнхийлөгч Х.Баттулгын “Монгол ялна” гэдгийн бараг л муужруулсан хувилбар мэт санагдав. Магадгүй Д.Энхбат нэр дэвшигчийн сонгуулийн “гараа” олон хүний хүлээлтэд хүрсэнгүй. Сул эхлээд яваандаа боолтоо чангалах тактик байхыг ч үгүйсгэхгүй. Аль ч сонгууль эхлэхэд хамгийн сайн ранктай байсан хүн сонгуулийн явцад хүссэн, хүсээгүй доошилдог. Харин дор байсан хүн нь өсдөг бичигдээгүй хуультай.

"Монгол чадна" гэх сонгуулийн уриа нь үг агуулгын хувьд идэвхтэй. Ямар нэгэн зүйлд уриалан дуудсан. Хийж бүтээхэд чиглэсэн мэт уншигдаж байна. Магадгүй тус эвслийн гол хүч ХҮН-ын хөдөлмөр гэдэг агуулгатай шууд холбож ойлгох нь зөв байх.

Улс төрийн агуулгын хувьд уг нь чадна гэдэг үгээрээ том агуулгыг харуулахыг хичээсэн бололтой. Гэхдээ өнгөрсөн сонгуулиар “Монгол ялна” гэдэгт хөөсөрч саналаа өгсөн ихэнх масс иймэрхүү агуулгаас татгалзах

мэдрэмжтэй байгаа. Мөн яагаад ч бүү мэд, Х.Баттулгын "үргэлжлэл" ч юм шиг сэтгэгдэл төрүүлээд байх юм. Дээрээс нь ямар нэгэн амлалт, чадна гэдэг үг улс төрчдөд олон жил хууртсаар ирсэн монголчуудад нэг л наалдахгүй байх вий дээ. Ямар сайндаа л "Би чадна" гэдэг "сервис"-ээр аливаа худлаа, асуудалтай, бүтэхгүй зүйл дээр жишээ авч хошигноод удсан.

***Дүгнэлт***

1993 оноос 2021 оны хооронд болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн найман удаагийн сонгуульд өрсөлдсөн 23 нэр дэвшигчдийн сонгуулийн уриа үгэнд анализ хийлээ. Найман удаагийн сонгуульд улс төрийн хоёр томоохон нам болох Ардчилсан нам-4, Ардын нам /МАХН/ 4 удаагийн ялалт байгуулжээ.

1993 оноос 2000 оны эхэн хүртэлх сонгуульд бэлэгдлийн утга агуулгатай уриа лоозонгоор өрсөлддөг байсан бол 2005 оноос эхлэн авлига, төрийн хяналт зэрэг үгнүүдийг оруулж эхэлсэн нь иргэдийн хүлээлтэд хүрэх, санаанд нийцэх тоглолт болж эхэлжээ.

2009 оны сонгуульд нэр дэвшигчид иргэдийн саналыг амлалтаар худалдан авах оролдлогыг шууд утгаар хийж, эх орны хишиг нэрийдлээр иргэн бүрт мөнгө өгөх агуулгыг шингээсэн нь хамгийн муу уриатай өрсөлдөөн юм.

Яван явсаар сүүлийн сонгуулиуд хамгийн хар пиар давамгалсан өрсөлдөгчөө илтэд доромжлох агуулгаар өрсөлдөөн хийсэн нь сонгуулийн тоглолтыг соёлгүй болгосон хэрэг юм.

# МОНГОЛ ДАХЬ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД БОЛОН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ӨРСӨЛДӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

**Б.Эрдэнэдалай**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор
**Д.Ундрах**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,
дэд профессор
**Д.Түмэнжаргал**
МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

**Удиртгал**

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш УИХ-ын, орон нутгийн тус бүр 9 удаагийн, Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгуулийг зохион байгуулсан. Сонгуулиас сонгууль бүрт сонгогчдын ирц, оролцоо буурах, сонгуулийг үл тоох хандлага нэмэгдэх болсон. Ялангуяа орон нутгийн сонгуулийн ирц хүрэхгүй байх явдал давтагддаг, дахин сонгуулийг олон удаа хийх явдал гарах болсон. Мөн сонгууль, сонгуулийн тогтолцоо, сонгогчдын үйл байдлын судалгааг хийхдээ ихэвчлэн УИХ болон ерөнхийлөгчийн сонгуулийг судалдаг, орон нутгийн сонгуулийн талаарх мэдээлэл, судалгаа ховор байдаг зэрэг нь энэхүү судалгааг хийхэд хүргэсэн юм.

Улс төрийн нам сонгуульд оролцоод ялалт байгуулбал засгийн газрыг байгуулж, улс орныг удирдах бодлого шийдвэрүүдийг гаргана. Орон нутгийн сонгуулиар бүрдэж байгаа ИТХ мөн адил тухайн орон нутагт дагаж мөрдөх шийдвэрүүдийг гаргаж, тухайн орон нутгийн иргэдийн төлөө ажиллах үүрэгтэй. Энэхүү өгүүлэлд орон нутгийн сонгуульд оролцож байгаа улс төрийн намуудын өрсөлдөөн, тэдгээрийн сонгуулийн үр дүнд хэрхэн нөлөөлж буйд шинжилгээ хийлээ.

УИХ-ын сонгуульд МАН 7 удаа, АН 2 удаа, Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН тус бүр 4 удаа ялалт байгуулсан байна. Орон нутгийн сонгуулийн (аймаг, нийслэл, сум, дүүрэг нэгтгэсэн тоон мэдээлэл) 1992 болон 1996 оны дүн олдоогүй, гэхдээ 2000 оноос хойших сонгуулиудад МАН олонх болж байжээ.

## Орон нутгийн сонгуулийн талаарх ойлголт, судалгаа

Судлаач Маршалл Их Британид орон нутгийн сонгууль хийгээд санал хураалтын талаарх харьцуулсан судалгаа төдийлөн хөгжөөгүй хэвээр байгааг "орон нутгийн сонгуулийн судалгаа байдаг гэж хэлэх нь дэгсдүүлсэн явдал болно" хэмээн тэмдэглэсэн нь бий[1]. Харин сүүлийн үед Европын улсуудад орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн улс төрийг харьцуулан судлах сонирхол нэмэгдэж байгаа ба жишээлбэл, Орон нутгийн бие даасан байдлын индексийн судалгаагаар орон нутгийн институциудын нөхцөл байдал болон Европ дахь төвлөрлийг сааруулах динамикийг системтэйгээр судлахыг зорьсон судалгаанууд хийгдэх болсон байна[2]. Мөн орон нутгийн сонгуулийн ирц үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг бусад сонгуулиудаас ихэвчлэн бага байдаг ч ирцийн зөрүү нь улс орон болон цаг хугацаанаас хамаарч ихээхэн ялгаатай байгааг Их Британи ба Францын орон нутгийн сонгуулийн жишээн дээр хийсэн судалгаа харуулж байна[3].

Ван Хоувелингений 2017 онд хийсэн мета-шинжилгээгээр Нидерландад хотын хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр орон нутгийн сонгуулийн ирц буурч байгааг дурдаад үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулах судалгаа зайлшгүй шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна[4]. Өрнөдийн орнуудад хийгдэж буй орон нутгийн сонгуулийн талаарх судалгаанууд хэдийгээр хэсэгчилсэн, цогц бус боловч сонгуулийн талаарх хууль дүрэм, нэр дэвшигчдийн санхүү хангамж, сонгогчдын ирц, сонголтын тухайд орон нутгийн болон үндэсний түвшний сонгуулиудад олон чухал ялгаа байгааг судлан тогтоожээ.

### *Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцож буй зарим улсын жишээ*

---

[1] Marschall, M. (2010). The Study of Local Elections in American Politics. J. Leighley (Ed.) The Oxford Handbook of American Elections and Political Behavior. Oxford University Press. (2010: 471)

[2] Ladner, A., Keuffer, N., & Baldersheim, H. (2016). Measuring Local Autonomy in 39 Countries (1990–2014). Regional & Federal Studies, 26(3), 321-357.

[3] Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.

Frandsen, A. G. (2002). Size and electoral participation in local elections. Environment and Planning C: Government and Policy, 20(6), 853-869.

[4] van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.

***Канад Улс:*** Канадад "Сонгуулийн менежментийн байгууллага" гэж байх ба нутгийн сонгуулийг орон нутгийн "Сонгуулийн менежментийн байгууллага" хариуцан зохион байгуулдаг байна. Намууд нь төв, орон нутгийн салбаруудад хуваагддаг. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлдэг байна.

Олон намын тогтолцоонд суурилсан Сонгуулийн менежментийн байгууллагын гишүүд улс төрийн намуудын төлөөлөгчдийн үүрэг гүйцэтгэхийнхээ зэрэгцээ сонгуулийн үйл явцыг төвийг сахих зарчмын дагуу явуулж, өөрийг нь томилсон намын эрх ашгийг хамгаална. Тэд өөрсдийг нь томилсон намын эрх ашгийг хамгаалахаас гадна өөрийнхөөсөө бусад намын эрх ашгийг давуу байлгахгүйн төлөө ажиллана. Намаас сонгогдсон Сонгуулийн менежментийн байгууллагын гишүүд тодорхой хугацаанд алба хаших бөгөөд үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бололцоогүй болсон, эсвэл өөрийг нь томилсон эрх баригчид ажлаас нь халахаас бусад тохиолдолд албан тушаал нь өөрчлөгддөггүй.

***Чили Улс:*** Чили бол 15 регион, 51 провинц, 346 муниципалитет, коммунаас бүрдсэн нэгдмэл улс юм. Чили улсын Үндсэн Хууль, Сонгуулийн тогтолцооны органик хууль-18.556 (1986), Орон нутгийн органик хууль-18.695 (2006), Улс төрийн намуудын тухай хууль-18.603 /1987/ зэрэг хуулиудаар орон нутгийн сонгуулийн процедурыг зохицуулна. Парламентын болон орон нутгийн аль алиных нь сонгуульд нам, эвсэл, бие даагчдын зүгээс тойрог бүрт дээд тал нь хоёр хүний нэр дэвшүүлсэн жагсаалтыг гаргаж өгдөг байна. Сонгогчид өөрсдийн шилж сонгосон нэр дэвшигчийнхээ төлөө санал өгдөг. Эхний суудлыг нийт дүнгээр хамгийн олон санал авсан жагсаалтад багтсан нэр дэвшигчдэд өгдөг. Нэг тойргийн хоёр суудлын хоёуланг авахын тулд хамгийн амжилттай өрсөлдөгчдийн санал нь хоёр дахь жагсаалтад өгсөн саналаас хоёр дахин их байх ёстой. Энэ тогтолцоонд тавьдаг босго маш өндөр учраас намууд сонгуульд эвсэл болон оролцох шаардлагатай болдог байна. Ихэвчлэн эвсэл бүр нэг суудал авдаг учраас жинхэнэ өрсөлдөөн хоёр сөргөлдөгч эвсэл ба тэдний намуудын хооронд явагдахын оронд нэг эвслийн гишүүн намуудын хооронд явагддаг байна. Энэхүү маргаан нь эвслийн эв нэгдэл, тогтвортой байдалд эрсдэл учруулж байдаг.

***Франц Улс:*** Францын улс төрийн намууд нь зохион байгуулалтын үндэсний хэмжээний буюу төв, орон нутгийн хэмжээний буюу салбаруудад

хуваагдана. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлнэ.

***Испани Улс:*** Улс төрийн намууд, холбоо эвслүүд орон нутгийн сонгуульд оролцохоор бол Сонгуулийн Зөвлөлд сонгууль зарласнаас хойших 9 дэх өдрөөс өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, 15-20 хоногт нэр дэвшигчдийг танилцуулна. Улс төрийн нам нь дангаараа болон бусад улс төрийн намуудтай эвсэл байгуулан оролцож болно. Тухайн улс төрийн нам, намуудын эвсэл болон холбоодоос ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалт дахь нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан байх ёстой бөгөөд энэ нь 3000-аас доош хүн амтай орон нутагт хамаардаггүй. Тус улсын иргэд, тухайн орон нутагт амьдарч буй Европын Холбооны иргэд болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн иргэд сонгууль өгөх эрхтэй. Тус улс дахь улс төрийн намууд төвийг сахих зарчим, мэргэжлийн ур чадварын өндөр стандартыг хангах зорилгоор Сонгуулийн менежментийн байгууллагад өндөр нэр хүндтэй хүмүүсийг томилдог бөгөөд ийм тохиолдолд гишүүд намуудын төлөөлөгч маягаар ажилладаггүй. Мөн түүнчлэн улс төрийн намуудтай харилцах харилцаагаа хялбаршуулахын тулд сонгуулийн эхний үеэс улс төрийн нам бүрээс Сонгуулийн төв зөвлөл, доод шатны сонгуулийн зөвлөлтэй харилцах ерөнхий төлөөлөгчийг томилуулж, улс төрийн намууд болон Сонгуулийн зөвлөлийн хооронд холбоо барих үүрэгтэйгээр ажиллуулдаг байна.

***Монгол Улс:*** Нам, эвслийг төлөөлж тухайн бүс дэх салбар нь орон нутгийн сонгуульд оролцох хүсэлтээ санал авах өдрөөс 60 хоногийн өмнө тухай шатны сонгуулийн хороонд хүргэнэ. Нам, эвсэл сонгуульд орон нутгийн оролцохдоо “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай” хуулийн тавдугаар бүлэгт заасан бичиг, баримтыг бүрдүүлэн хуулийг баримтлан хэрэгжүүлнэ.

*Хүснэгт 1. Орон нутгийн сонгууль дахь улс төрийн намуудын болон орон нутгийн хурлын байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намуудын оролцоо*[5]

| | Үзүүлэлт | Испани улс | ХБНГУ | Англи | Ирланд | Дани |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хуулийн нэр | "Орон нутгийн засаг захиргааны үндсэн хууль". 1979 онд энэ хуулиар ардчилсан орон нутгийн сонгуулийг явуулсан. | Дэлхийн 2-р дайны дараагаас орон нутгийн сонгуулиа "Орон нутгийн засаг захиргааны хууль"- иар явуулдаг болсон. | 2000 онд парламентаар батлагдсан "Орон нутгийн засаг захиргааны акт"-аар орон нутгийн сонгуулийг зохицуулдаг. | 1898 онд "Орон нутгийн захиргааны Ирландын акт"-ыг батлан гаргасан. | 1953 оны "Үндсэн хуулийн акт"-аар орон нутгийн сонгуулийг зохицуулдаг. |

[5] Дани-Франц-Герман-Ирланд-Испани-Англи-улсуудын-орон-нутгийн-сонгуулийн-тогтолцооны-зарим-зохицуулалтын-онцлог-2011.pdf

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Орон нутгийн сонгууль дахь улс төрийн намуудын оролцооны эрх зүйн зохицуулалт | Орон нутгийн зөвлөлтэй. Зөвлөлийн гишүүдийг улс төрийн нам санал болгож, иргэдээс сонгодог. Гишүүн нас барсан тохиолдолд сонгууль явуулахгүй сонгуульд орсон санал авсан нэрсийн жагсаалтаар дараагийн хүнийг шууд сонгодог. Олонхи суудал авсан намын гишүүдээс зөвлөлийн даргыг томилдог | Улс төрийн намаас нэр дэвшсэн гишүүдтэй зөвлөл орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлдэг. | Улс төрийн намын харьяалалтай гишүүдээр дамжуулан тухайн орон нутгийн зөвлөлд намын бодлогоо хэрэгжүүлдэг. | Орон нутгийн зөвлөлтэй байна. Зөвлөл нь пропорциональ системээр бүрддэг. Зөвлөл нь гол улс төрийн намаас хамааралтай. | Орон нутгийн зөвлөл нь улс төрийн намуудаас нэр дэвшүүлж, сонгогдсон төлөөллөөс бүрдэнэ. |
| 3 | Орон нутгийн хурлын байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намуудын оролцоо | Олонх болсон намын санал болгож томилуулсан Зөвлөлийн дарга нь орон нутгийн захиргааны бүх томилгоог хийдэг. Энэхүү томилгоогоороо дамжуулан нам нь улс төрийн бодлогоо хэрэгжүүлдэг. | Мужийн орон нутгийн зөвлөлийн гишүүдийн дундаас захирагчийг сонгодог. | Мужийн зөвлөлийг иргэдээс шууд сонгогдсон захирагч удирддаг. | Орон нутгийн зөвлөлийг гол улс төрийн намаас нэр дэвшүүлж, сонгогдсон захирагч удирдана. | |

### *Монгол Улс дахь нөхцөл байдлын шинжилгээ*

Энэхүү өгүүллийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос авсан 2000 оноос хойших орон нутгийн сонгуулийн тоон өгөгдөл, мэдээлэл нь тухайн сонгуулиудад нэр дэвшсэн бүх улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мэдээлэл бус зөвхөн ялалт байгуулсан төлөөлөгчдийн мэдээлэл байсан нь судалгааны хамрах хүрээ, шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байсан ч боломжит өгөгдөл дээр суурилан шинжилгээ хийлээ. 2000-2020 онд болсон нийт 5 удаагийн орон нутгийн сонгуульд 2-11 улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид ялалт байгуулсан байна. Энэхүү судалгааг боловсруулах явцад 2024 оны орон нутгийн сонгуулийн дүн гарсан хэдий ч, албан ёсоор ашиглах дата нийтэд мэдээлэгдээгүй тул дүнг харьцуулан ашиглаж чадаагүй, оруулаагүй болно.

### Орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчийн авсан саналын хувь, үнэлгээ

Дараах зурагт ялсан нэр дэвшигчийн авсан саналын хувийн давтамжийг харуууллаа. Үүнд аймаг болон дүүргийн сонгуулийн тойргуудын дэлгэрэнгүй тоон мэдээллүүдийг хамруулсан. Ялсан нэр дэвшигчдийн авсан саналын хувь хугацааны туршид харьцангүй тогтвортой буюу 50%-55% орчим төвлөрсөн байсан байна. Хэдийгээр ялалтын хувь тогтвортой байгаа ч Зураг 1-т дурдсанчлан сонгуулийн ирц, оролцоо буурч, 65%-аас доош хэсэгт төвлөрч эхэлсэн. Өөрөөр хэлбэл, ИТХ-ын хуралд ялалт байгуулсан нэр дэвшигчийн нийт иргэдийг төлөөлөх чадвар 32.5%-35.8%-тай байна.

*Зураг 1. Ялсан нэр дэвшигчийн авсан саналын хувь: Хугацааны өөрчлөлтөөр*






ИТХ-ын сонгуулийн хувьд улс төрийн намын харьяалал нэр дэвшигчийн авсан саналд хүчтэй нөлөө үзүүлдэг бөгөөд тус нөлөөлөл хугацааны туршид өссөн, нийслэл болон дүүргийн саналд илүү хүчтэй байдаг гэсэн хамаарал ажиглагдлаа[6]. Дараах хүснэгтэд тус хамаарлын дэлгэрэнгүй үр дүнг харуулав. Нийт түүврийн хувьд 2000 оны байдлаар МАН-ын нэр дэвшигч байсан тохиолдолд бусад намтай харьцуулахад дунджаар 8.86%-аар өндөр санал авахаар байлаа. АН-ын хувьд тус нөлөө ажиглагдаагүй, ач холбогдолгүй байсан. Харин 2020 оны байдлаар дундаж ялалтын хувь буурч, намуудын нөлөө огцом нэмэгджээ. Тодруулбал, МАН-ын нэр дэвшигч бусад нэр дэвшигчидтэй харьцуулахад дунджаар 17.06%, АН-ын нэр дэвшигч бусад нэр дэвшигчидтэй харьцуулахад дунджаар 14.1%-аар илүү санал авч, ялалт байгуулсан байна.

Сонирхолтой нь энэхүү нөлөөг орон нутаг болон нийслэл, дүүргээр ангилбал АН-ын нөлөө орон нутагт сөрөг байв. Өөрөөр хэлбэл, АН-ын нэр дэвшигч бусадтай харьцуулахад -2.45%-аар бага дүнгээр санал авч, ялалт байгуулж байв. Түүнчлэн нийслэл болон дүүргийн сонгуулийн хувьд намын нөлөө харьцангуй давамгай байдаг ажээ.

[6] Шинжилгээний түүвэр нь зөвхөн ялалтын хувь болон ялалт байгуулсан нэр дэвшигчдийн намыг хамарсан.

*Хүснэгт 2. Сонгуульд авсан саналын үнэлгээ: Ялалт байгуулсан хувийн шинжилгээ*

| | Улсын | | | Орон нутгийн | | | Нийслэл болон дүүргийн | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дундаж | МАН | АН | Дундаж | МАН | АН | Дундаж | МАН | АН |
| **2000** | 52.48*** | 8.86*** | 2.52 | 60.32*** | 0.82*** | -2.39*** | 51.7*** | 6.86*** | 0.82 |
| **2004** | 61*** | 2.93*** | 1.35*** | 60.19*** | 0.94*** | -2.27*** | 60.92*** | 1.91*** | -1.04** |
| **2008** | 54.46*** | 0.81 | -1.91* | 60.32*** | 0.55** | -2.69*** | 53.25*** | 3.57*** | -0.14 |
| **2012** | 50.04*** | -0.85 | 0 | 60.33*** | 0.77*** | -2.57*** | 49.79*** | 6.59*** | 2.59 |
| **2016** | 33.68*** | 21.38*** | 20.8*** | 60.33*** | 0.8*** | -2.43*** | 49.11*** | 6.3*** | 4.26*** |
| **2020** | 42.27*** | 17.06*** | 14.1*** | 60.27*** | 0.83*** | -2.45*** | 49.44*** | 8.91*** | 6.21*** |

*Энд: ***-99%, **-95%, *-90%-ийн итгэх түвшинг тус тус илэрхийлнэ.*

Нийт 6 сонгуулийн хувьд (2000-2020), УИХ-ын сонгуулийн суудлын хувь ИТХ-ын суудлын хувьд нөлөөлдөг эсэхийг үнэлэв. Ингэхэд АН УИХ-ын сонгуульд 1%-аар олонх болоход ИТХ-ын суудлын хувь (АН-ын суудал/нийт суудал) 0.37%*-аар, МАН УИХ-ын сонгуульд 1%-аар олонх болоход ИТХ-ын суудлын хувь 0.32%**-аар тус тус нэмэгддэг байна. Тэгвэл орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчид өрсөлдөж байгаа учраас монгол дахь улс төрийн намын гишүүд тухайн сонгуульд нэр дэвших боломж, нам доторх өрсөлдөөн хэр зэрэг байдгийг дараах хэсэгт шинжиллээ.

**Орон нутгийн сонгууль - улс төрийн намын дотоод ардчилал**

Улс төрийн нам доторх өрсөлдөөн бол намын дотоод ардчиллыг хэмжих гол үзүүлэлт бөгөөд бүх шатны сонгуулиудад нэр дэвших боломж намын гишүүдэд нээлттэй байх ёстой. 2018 онд Азийн сангийн дэмжлэгээр Дэфакто институтийн гүйцэтгэсэн “Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын

индекс" судалгаанд[7] улс төрийн намын гишүүдээс авсан судалгаанд оролцогчид "намаас орон нутгийн сонгуульд өрсөлдөх эрх авах боломж гишүүдэд нээлттэй юу" гэсэн 4 онооны асуултад 3-3.6 оноо өгсөн бол УИХ-ын сонгуулийн хувьд 1.7-3.3 оноо, Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд 1.3-2.8 оноо өгсөн байна.

*Зураг 2. Тухайн шатны сонгуульд өрсөлдөх боломж улс төрийн намын гишүүдэд нээлттэй эсэх*[8]




МАН, АН-ын хувьд олон тооны гишүүдтэй учраас бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх намын гишүүдэд нээлттэй бус, нэр дэвшигчдэд тавигдах босго шалгуур өндөр буюу намдаа өгч буй дэнчингээс хамааралтай болдог байна. Харин жижиг улс төрийн намуудын хувьд бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх харьцангуй нээлттэй, нэр дэвшигчдэд тавигдах шалгуур харьцангуй бага байдаг байна.

[7] Азийн сан, Дефакто институт. "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс-2018" судалгаа. 2018. 22 дахь тал

[8] Азийн сан, Дэфакто институт. "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс-2018" судалгаа. 2018. 24-25 дахь тал

2019 онд Дэфакто институтийн гүйцэтгэсэн "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс" судалгаанд[9] дурдсанаар, МАН, АН орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжүүдийн тоогоор тэргүүлж, МАХН (МАН-д нэгдсэн) орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжийн тоогоор гуравдугаарт орж байв. Эндээс парламентад суудалтай улс төрийн намууд, тэдгээрийн гишүүдийн тоо олон учраас УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших, нам дотроо өрсөлдөөн их. Харин орон нутгийн сонгуульд тухайн намын гишүүд нэр дэвшин өрсөлдөх боломж нэмэгддэг. Тэгвэл парламентад суудалгүй улс төрийн намуудын хувьд орон нутгийн сонгуулийн тойрог бүрт гишүүдээ нэр дэвшүүлэх хүний нөөц хязгаарлагдмал.

Улс төрийн намууд орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх процесс нь өөрөө намын гишүүдийн зүгээс намын дотоод ардчилалд оролцох боломжийг олгодог. Гэтэл энэ нь зарим талаараа улс төрийн санхүүжилтийн асуудалтай холбогдоно. Хэдийгээр орон нутгийн сонгуулийн тойрог хуваарилалт бага хэмжээтэй боловч тухайн сонгуульд нэр дэвшигч сонгуулийн кампанит ажлаа үр бүтээлтэй ажиллуулахын тулд хөрөнгө, санхүүжилт хэрэгтэй. Үндэсний аудитын газраас орон нутгийн сонгуулийн 1 тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг баталж өгдөг ч эргээд сонгуульд зарцуулсан зардлын тайланг хариуцлагатайгаар хүлээн авдаггүй нь ИТХ-ын сонгуулийн ач холбогдлыг, нам доторх шударга өрсөлдөөн, хариуцлагыг бууруулж байна.

Эмэгтэйчүүд болон залуучуудыг орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх өрсөлдүүлэх асуудлыг квотын аргаар шийдвэрлэдэг. Эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд сонгогдон ажилласнаар олон эерэг үр дагавартай гэж үздэг. Мөн адил залуучууд орон нутгийг хөгжүүлэх бодлого боловсруулах, залуучуудад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих сайн талуудтай.

Эмэгтэйчүүд болон залуучууд орон нутгийн сонгуульд хэр зэрэг нэр дэвшдэг, хэдэн хувьд нь ялалт байгуулсан зэрэг мэдээллийг шалгаж үзэх хэрэгтэй ч судалгааны хүрээнд ашиглаж байгаа 2000 оноос хойших орон нутгийн сонгуульд авсан санал (ялалт байгуулсан хувь)-д нөлөөлөгч хүчин зүйлсийг боломжит тоон мэдээлэлд үндэслэн тодруулахыг зорилоо. Сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчийн дундаж санал 61.72%, МАН-аас нэр дэвшигч

[9] Азийн сан, Дэфакто институт. "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс-2019" судалгаа. 2019. 27 дахь тал

тохиолдолд 2.33%-аар нэмэгддэг бол эмэгтэй нэр дэвшигч тохиолдолд санал -0.71%-аар буурдаг гэх үр дүн гарсныг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 3. Сонгуульд ялалт байгуулахад нөлөөлөгч хүчин зүйлс*

| Нөлөөлөгч хүчин зүйлс | Тоон үзүүлэлт |
|---|---|
| Дундаж | 61.72%*** |
| МАН-ын нэр дэвшигч эсэх | 2.33%*** |
| АН-ын нэр дэвшигч эсэх | -0.21 |
| Хүйс | -0.71%** |
| Нас | -0.02% |

*Энд: ***-99%, **-95%, *-90%-ийн итгэх түвшинг тус тус илэрхийлнэ.*

Ялалт байгуулсан нэр дэвшигчдийн дийлэнх буюу 73 орчим хувь нь 30-49 насны нэр дэвшигчид байжээ. Түүнчлэн ИТХ-д ялсан нэр дэвшигчдийн 74% нь эрэгтэй, 26% нь эмэгтэй байв (Тоон мэдээллийн олдоцоос хамааран боломжит мэдээллийг хамруулсныг анхаарна уу).

*Зураг 3. Ялсан нэр дэвшигчдийн нас: 2000-2008*




*Зураг 4. Ялсан нэр дэвшигчдийн хүйс: 2000-2008*




Дээрх мэдээллийг шалгахад 2000-2008 оны орон нутгийн сонгуулиудын дунд шинжилгээ хийхэд боломжтой тоон мэдээлэл байсан. Ялсан нэр дэвшигчдийн нас 40-49 насныхан 42%, 30-39 насныхан 31%, 50-59 насныхан 17%, 20-29 насныхан 7%, 60-69 насныхан 2%-тай байв. Харин хүйсийн хувьд 74% нь эрэгтэй төлөөлөгч, 26% нь эмэгтэй төлөөлөлч ялалт байгуулсан байна. Гэхдээ энд зөвхөн 3 удаагийн орон нутгийн сонгуулийн дунд шинжилгээ хийснийг анхаарна уу.

*Зураг 5. Нэг нэр дэвшигч дахин сонгогдсон байдал: 2016-2020 он*




Орон нутгийн сонгуулийн үеэр нам доторх нэр дэвшигчдийн өрсөлдөөнийг ажиглахад, тухайн нэр дэвшигчийн легитим байдал буюу хэдэн удаа ИТХ-д дахин сонгогдон ажиллаж байгааг харж болно. Өвөрхангай, Хөвсгөл, Төв аймгуудын хувьд 2016 оны ИТХ-ын сонгуульд ялалт байгуулсан төлөөлөгч дахин сонгогдсон нь түгээмэл байлаа (Зураг 1). Харин Орхон, Говьсүмбэр аймагт дахин сонгогдсон явдал харьцангуй бага байсан нь нам доторх өрсөлдөөн ихтэй, сонгуулийн кампанит ажлын онцлогтой холбоотой байж болох юм.

*Хүснэгт 4. Нэр дэвшигчдийн дахин сонгогдсон давтамж, аймгаар: 2016-2020 он*

| | Дахин сонгогдсон давтамж | Дахин сонгогдсон байдлын эрэмбэ |
|---|---|---|
| Аймгууд | | |
| Архангай | 27 | 6 |
| Баян-Өлгий | 12 | 19 |
| Баянхонгор | 28 | 5 |
| Булган | 21 | 9 |
| Говь-Алтай | 19 | 13 |
| Говьсүмбэр | 3 | 26 |
| Дархан-Уул | 14 | 17 |
| Дорноговь | 20 | 11 |

| | | |
|---|---|---|
| Дорнод | 18 | 14 |
| Дундговь | 20 | 11 |
| Завхан | 12 | 19 |
| Орхон | 8 | 21 |
| Өвөрхангай | 44 | 1 |
| Өмнөговь | 22 | 8 |
| Сүхбаатар | 18 | 14 |
| Сэлэнгэ | 17 | 16 |
| Төв аймаг | 38 | 3 |
| Увс | 13 | 18 |
| Ховд | 26 | 7 |
| Хөвсгөл | 43 | 2 |
| Хэнтий | 29 | 4 |
| Дүүргүүд | | |
| Багануур | 2 | 28 |
| Багахангай | 1 | 30 |
| Баянгол | 6 | 24 |
| Баянзүрх | 2 | 28 |
| Налайх | 3 | 26 |
| Сонгинохайрхан | 21 | 9 |
| Сүхбаатар | 8 | 21 |
| Хан-Уул | 4 | 25 |
| Чингэлтэй | 7 | 23 |

Хэдийгээр олон удаагийн сонгуулийн үр дүнг харьцуулах боломжгүй байсан ч хоёр удаагийн орон нутгийн сонгуульд тухайн нэр дэвшигч дахин сонгогдсон байдал орон нутагт их, нийслэлд илт бага байна. Хөдөө орон нутагт ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллах хугацаа, тухайн төлөөлөгч аль улс төрийн намын гишүүн байх, тухайн орон нутагтаа оршин суудаг эсэх, нэр дэвшигчийн танил, ах дүү хамаатан, найз нөхөд тухайн орон нутагт амьдардаг байх зэрэг нь дахин сонгогдох магадлалыг нэмэгдүүлдэг байх талтай.

*Хүснэгт 5. Нэр дэвшигчдийн дахин сонгогдсон давтамж, төрлөөр: 2016-2020 он*

| Төрөл | Дахин сонгогдсон төлөөлөгчдийн тоо | Дахин сонгогдоогүй төлөөлөгчдийн тоо | Нийт | ДС* Хувь |
|---|---|---|---|---|
| Аймаг, сумдын | 459 | 2817 | 3276 | 14.0% |
| Нийслэл, дүүргийн | 54 | 219 | 273 | 19.8% |

**ДС – Дахин сонгогдсон*

Дээрх хоёр хүснэгт дэх мэдээллийг зөвхөн аймаг, сум болон нийслэл, дүүргээр ангилж харвал, нийслэл болон дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчид дахин сонгогдох хувь харьцангуй өндөр байв. Түүнчлэн дахин сонгогдсон байдлыг улс төрийн намаар ангилан авч үзвэл, МАН-ын гишүүд 295 удаа буюу 65.4%, АН-ын гишүүд 156 удаа дахин сонгогдсон буюу 34.6%-ийг тус тус эзэлж байгаа нь тухайн төлөөлөгч дахин сонгогдох магадлалыг аль улс төрийн намаас нэр дэвшиж буй нь нэмэгдүүлдэг байх магадлалтай байна. Хэрвээ цаашид орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн бүрэн мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд нэгтгэдэг болвол, зөвхөн улс төрийн намаас нэр дэвшиж сонгогдсон төлөөлөгчдийг бус бие даан нэр дэвшигчид, эмэгтэйчүүд, залуучууд, нийгмийн бүлгүүдийн төлөөллийн дахин сонгогдсон байдлыг ажиглах, шинжлэх боломж бүрдэнэ.

Бид үндэсний хэмжээнд “орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн санаа бодлын судалгаа”-г 2022 онд хийсэн бөгөөд тэрхүү судалгаанд оролцогчдоос дараах асуултыг асуусан юм.

Хүснэгт 6. Орон нутгийн сонгуульд намаас болон иргэд өөрсдөө нэр дэвших асуудалд

| Асуулт | Оновчтой | Дунд зэрэг | Оновчгүй | Энэ талаарх ойлголт алга |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх | 17% | 39% | 32% | 13% |
| Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвших | 35% | 38% | 16% | 11% |

Судалгаанд оролцогчдын 73% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвшихийг "дунд зэрэг оновчтой", "бүрэн оновчтой" гэж хариулсан нь цаашид орон нутгийн ИТХ-ыг тойрсон улс төржих, улс төрийн намаар талцах зэрэг асуудлыг шийдэх шаардлагатай байгааг харуулав. Уг асуултуудад "энэ талаарх ойлголт алга" гэж хариулсан судалгаанд оролцогчдын хувь дээрх судалгааны бусад асуултын хариултуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан нь цаашид энэ талаарх ойлголтуудыг өгөх, ач холбогдлыг ойлгуулах нэн хэрэгцээтэйг харуулж байлаа.

Дээрх судалгааны хүрээнд дараах асуултыг мөн асуусан юм. "Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх" талаар иргэдийн үнэлэмжийг ухуулагчаар ажиллаж байсан эсэхээс хамааруулан харуулж байна. Сонгуулийн кампанит ажилд ухуулагчаар ажиллаж байсан судалгаанд оролцогчдын 67.8% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигч дэвшүүлэхийг оновчтой эсвэл дунд зэрэг оновчтой гэж дүгнэсэн бол ухуулагчаар ажиллаж байгаагүй иргэдийн ердөө 51.5% нь тус хариултыг өгсөн.

*Зураг 6. Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх оновчтой эсэх, нийгэм, улс төрийн статусаар*




"Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх" нь оновчтой эсэх хариултыг улс төрийн статусаар ангилж харууллаа. ИТХ-ын сонгуульд улс төрийн намаас нэр дэвшүүлэхийг улс төрийн намын гишүүн иргэдийн 73%, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын

гишүүн иргэдийн 61%, ямар нэгэн статусгүй иргэдийн 52% нь оновчтой болон дунд зэрэг гэж дүгнэжээ.

Дээрх хоёр асуултын хариултаас харахад орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх асуудлыг сонгуулийн кампанит ажилд ухуулагчаар ажиллаж байсан болон нийгэм, улс төрийн статустай судалгаанд оролцогчид түлхүү дэмжсэн байна. Оновчгүй болон энэ талаарх ойлголт байхгүй гэж хариулсан хувь ухуулагчаар ажиллаж байгаагүй болон нийгэм, улс төрийн статустай судалгаанд оролцогчдод өндөр байсан юм.

## ДҮГНЭЛТ

Орон нутгийн сонгуулийн үр дүнтэй холбоотой тоон өгөгдөл УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнтэй холбоотой тоон өгөгдөлтэй харьцуулахад баялаг, дүн шинжилгээ хийх боломж их боловч нэгдсэн өгөгдлийн сан, стандарт байхгүй, сонгууль бүрийн тоон мэдээлэл өөр өөр формат бүхий, нээлттэй өгөгдөл биш зурган файлаар байдаг, судалгааны хүрээнд нэгтгэх, харьцуулах боломжгүй байсан нь энэхүү судалгааны явцад том хүндрэлийг үүсгэсэн. Мөн орон нутгийн сонгуулийн оролцоо, сонгогчдын үйл байдалд нөлөөлж буй хүчин зүйлс, орон нутгийн сонгуулийн нөхцөл байдал, нэр дэвшигчдийн авч буй санал, үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар хийгдсэн судалгаа байхгүй нь энэ чиглэлд цаашид онцгой анхаарах шаардлагатайг харууллаа.

***Судалгааны эхний хэсэгт***, орон нутгийн сонгуульд оролцож байгаа улс төрийн намуудын өрсөлдөөн, тэдгээрийн сонгуулийн үр дүнд хэрхэн нөлөөлж буйг шинжлэхэд дараах үр дүнгүүд гарав.

Улс төрийн нам доторх өрсөлдөөн бол намын дотоод ардчиллыг хэмжих гол үзүүлэлт бөгөөд бүх шатны сонгуулиудад нэр дэвших боломж намын гишүүдэд нээлттэй байх ёстой. МАН, АН-ын хувьд олон тооны гишүүдтэй учраас бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх намын гишүүдэд нээлттэй бус, нэр дэвшигчдэд тавигдах босго шалгуур өндөр буюу намдаа өгч буй дэнчингээс хамааралтай болдог байна. Харин жижиг улс төрийн намуудын хувьд бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх харьцангуй нээлттэй, нэр дэвшигчдэд тавигдах шалгуур харьцангуй бага байдаг байна.

Монгол Улсад орон нутгийн сонгууль мажоритар тогтолцоо голлож зохион байгуулагдаж байсан учраас МАН орон нутгийн ихэнх сонгуульд ялалт

байгуулж олонх болж байсан. МАН, АН орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжүүдийн тоогоор тэргүүлж, МАХН (МАН-д нэгдсэн) орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжийн тоогоор гуравдугаарт орж байв. Орон нутгийн сонгуульд тухайн намын гишүүд нэр дэвшин өрсөлдөх боломж нэмэгддэг. Тэгвэл парламентад суудалгүй улс төрийн намуудын хувьд орон нутгийн сонгуулийн тойрог бүрт гишүүдээ нэр дэвшүүлэх хүний нөөц хязгаарлагдмал байна. Эмэгтэйчүүд болон залуучуудыг орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх өрсөлдүүлэх асуудлыг квотын аргаар шийдвэрлэдэг ч шинжилгээ хийсэн онуудын мэдээлэлд ялалт байгуулсан нэр дэвшигчдийг хүйс, насаар ангилсан мэдээлэл дутмаг байсан.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийн легитим байдал буюу хэдэн удаа ИТХ-д дахин сонгогдон ажиллаж байгааг олон удаагийн сонгуулийн үр дүнг харьцуулах боломжгүй байсан ч хоёр удаагийн орон нутгийн сонгуульд тухайн нэр дэвшигч дахин сонгогдсон байдал орон нутагт их, нийслэлд бага байв. Хөдөө орон нутагт ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллах, тухайн төлөөлөгч аль улс төрийн намын гишүүн байх, тухайн орон нутагтаа оршин суудаг эсэх, нэр дэвшигчийн танил, ах дүү хамаатан, найз нөхөд тухайн орон нутагт амьдардаг байх зэрэг нь дахин сонгогдох магадлалыг нэмэгдүүлдэг байх талтай. Түүнчлэн дахин сонгогдсон байдлыг улс төрийн намаар ангилан авч үзвэл, МАН-ын гишүүд 295 удаа буюу 65.4%, АН-ын гишүүд 156 удаа дахин сонгогдсон буюу 34.6%-ийг тус тус эзэлж байгаа нь тухайн төлөөлөгч дахин сонгогдох магадлалыг аль улс төрийн намаас нэр дэвшиж буй нь нэмэгдүүлдэг байх магадлалтай байна. Хэрвээ цаашид орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн бүрэн мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд нэгтгэдэг болбол дээрх мэдээлэлд бүрэн анализ хийх боломжтой болно.

***Судалгааны төгсгөл хэсэгт,*** Үндэсний хэмжээнд хийсэн "Орон нутгийн сонгуулийн талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа"-нд оролцогчдын 73% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвшихийг "дунд зэрэг оновчтой", "бүрэн оновчтой" гэж хариулсан нь цаашид орон нутгийн ИТХ-ыг тойрсон улс төржих, улс төрийн намаар талцах зэрэг асуудлыг шийдэх шаардлагатайг харуулж байлаа. Мөн дээрх асуултыг сонгуулийн ухуулагчаар ажиллаж байсан болон нийгэм, улс төрийн статустай судалгаанд оролцогчдын хувьд салгаж харахад орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх асуудлыг сонгуулийн кампанит ажилд ухуулагчаар ажиллаж байсан болон нийгэм, улс төрийн

статустай судалгаанд оролцогчид түлхүү дэмжсэн байна. Оновчгүй болон энэ талаарх ойлголт байхгүй гэж хариулсан хувь ухуулагчаар ажиллаж байгаагүй болон нийгэм, улс төрийн статустай судалгаанд оролцогчдод өндөр байлаа.

## САНАЛ

*Хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд:*

- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтэд таниулах ухуулга сурталчилгааг төрийн байгууллагууд, улс төрийн намууд зохион байгуулдаг зохицуулалт бий болгох.
- Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс нэр дэвшигчдийн бүрэн мэдээлэл, сонгуулийн ирц, ялалт байгуулсан нэр дэвшигчийн талаарх зэрэг мэдээллүүдийг нэгдсэн форматаар өгөгдлийг цуглуулж хэвших.
- Сонгуулийн ерөнхий хорооны бүтцэд орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийг нэгтгэх, олон нийтэд нээлттэй мэдээлэх тогтолцоог бэлтгэх, ажилтнуудыг чадавхжуулах.
- Орон нутгийн сонгуульд оролцож буй улс төрийн намын нөлөө буюу намчирхах, нутгархдаг байдлыг багасгах, засаг дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагад ялалт байгуулсан эсвэл ялалт байгуулаагүй нам, намын гишүүд, иргэдийн харилцаанд үүсдэг улс төржилтийг багасгах боломжит зохицуулалтуудыг яаралтай хийх.
- Нас, хүйс, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл бүхий нэр дэвшигчид орон нутгийн сонгуульд өрсөлдөхөд нээлттэй байх боломжийг олгох, төрийн санхүүжилтийг энэ чиглэл рүү олгох хувилбарыг санал болгох.

*Бүтэц, зохион байгуулалтын асуудлын хүрээнд:*

- УИХ болон ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд сонгогчдын мэдээллийг илүү дэлгэрэнгүй авах зөвлөмж гардаг бол орон нутгийн сонгуулийн хувьд сонгогчдын мэдээлэл дээр нэмээд нэр дэвшигчдийн бүрэн мэдээллийг дэлгэрэнгүй авах шаардлагатай.
- Орон нутгийн сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны сайт болон бусад холбогдох төрийн байгууллагуудын сайтууд дээр нээлттэй өгөгдөл байдлаар тогтмол байлгах, арилгахгүй байх. Өгөгдлийн нэгдсэн сан үүсгэх.
- Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрт нэр дэвшигчдийн овог, нэр (хэрвээ сонгуульд дахин нэр дэвшиж байгаа бол түүнийг тэмдэглэх, овог нэр

дээр өөр тэмдэглэгээ хийхгүй байх зэргийг анхаарах), нас, хүйс, нэр дэвшүүлж буй улс төрийн нам эсвэл бие даагч эсэх гэх мэт мэдээллүүд нэгдсэн форматын дагуу байх.

- Нэр дэвшигчдэд "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль"-ийн талаарх ойлголт, орон нутгийн сонгуульд нэр дэвших, түүнтэй холбоотой бүхий л мэдээллийг өгөх сургалтыг урьдчилан зохион байгуулах, танилцуулга видео хичээл Сонгуулийн ерөнхий хорооны сайт дээр байршуулах, гарын авлага гаргах, нутгийн өөрөө удирдах байгууллагад хүргүүлэх.
- Орон нутгийн сонгуулийг зохион байгуулах, уг сонгуультай холбоотой мэдээллийг түгээх, сонгуульд өрсөлдөх гэж байгаа нэр дэвшигчдийг бүртгэх зэрэг асуудлыг технологийн дэвшил, цахим байдлаар зохион байгуулах.

## НОМ ЗҮЙ


- Азийн сан, Дэфакто институт. (2018). "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс-2018" судалгаа.
- Азийн сан, Дэфакто институт. (2019). "Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс-2019" судалгаа.
- Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.
- Kuhlmann, S., & Bouckaert, G. (eds.) (2016). Local Public Sector Reforms in Times of Crisis. Palgrave.
- Marschall, M. (2010). The Study of Local Elections in American Politics. J. Leighley (Ed.) The Oxford Handbook of American Elections and Political Behavior. Oxford University Press.
- Van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.

# НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛИЙН ДҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Ц.Пунцаг

## НЭГ. ОРШИЛ

Ардчилсан сонгууль бол иргэд сонгогчдын хувьд Үндсэн хуульд заасан засгийн эрх ард түмний гарт байх үндсэн эрхээ хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл, түүний үр дүнд байгуулагдсан институцүүдийн эх үндрага гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл, төр-иргэний улс төрийн харилцааны үндсэн арга хэрэгсэл болох бүх нийтийн чөлөөт сонгууль нь иргэд улс орноо өөрөө удирдах хүсэл зоригоос үүдэлтэй өөрийн итгэл үнэмшлээр төлөөллийн байгууллагаа байгуулах хариуцлагатай сонголт бөгөөд нэг талаас иргэд сайн дураараа оролцож байгаа иргэний оролцоо, нөгөө талаас үйл ажиллагаандаа иргэдийг татан оролцуулж байгаа төрийн албан ёсны үйл ажиллагаа юм.

Аливаа улс орны сонгуулийн тогтолцооны мөн чанар, онцлог нь тухайн улс орны соёл иргэншил, түүх соёлын өвөрмөц байдал, нийгэм эдийн хөгжлийн түвшин, ялангуяа улс төрийн дэглэм, төрт ёсны түүхэн уламжлал, иргэдийн улс төрийн боловсрол, сэтгэлгээ, сэтгэл зүйн онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байдаг байна.[1]

Монгол Улс 1990 оноос нийгмийн цоо шинэ тогтолцоонд шилжиж, 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу олон улсын жишгээр бүх нийтийн чөлөөт сонгуулийг бүх шатанд зохион байгуулж ирлээ.

Манай орны хувьд 1990 оноос өмнөх үе буюу социализмын үеийн сонгуулийн процедур, санал өгөх механизм хийгээд төлөөллийн засаглал зэрэг олон нийтийн оролцоог зайлшгүй шаардсан систем үйлчилж ирсэнийг үгүйсгэх аргагүй ч 1990 оноос хойш явагдсан бүх шатны сонгуулиуд нь жинхэнэ утгаараа ардчилсан засаглал, төлөөллийн байгууллагыг байгуулах үндсэн арга хэрэгсэл болж чадсан юм.

Нэг үгээр хэлбэл, сонгогчдынх нь өөрсдийнх нь улс төр, хууль эрх зүйн ухамсар, соёл, туршлага, сэтгэл зүйн түвшин, зан төлөвийн шинж төрхийг илэрхийлсэн томоохон шалгуур болж ирлээ.

---

[1] Н.Цолмонтуяа. Засаглалд сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөө 2012 он.19 дэх тал.

Манай орны эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад сонгууль, сонгуулийн тогтолцоо, түүний үр дагаврын талаар чамгүй олон судалгаа хийгдэж, энэ чиглэлээр судалгааны олон ном, бүтээл олны хүртээл болгосон юм.

Тухайлбал: Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн удирдлага дор Нийгмийн бодлого, хөгжил судлалын хүрээлэнгээс явуулсан "Сонгуулийн дараах олон нийтийн нийтийн санал бодлын тандалт судалгаа", Конрад Аденауэр сан, Удирдлагын академи хамтран 2016 онд явуулсан "Залуучуудын улс төрийн оролцоо" судалгаа, МУИС-ийн орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн явуулсан "Монгол дахь сонгогчдын боловсрол" төслийн судалгаа, Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн удирдлага дор Нийгмийн бодлого, хөгжил судалгааны хүрээлэнгээс Улаанбаатар хот, 13 аймгийн 18-аас дээш насны 5000 иргэний дунд 2016 оны 3,8-р сард явуулсан "Сонгуулийн өмнөх болон дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа" зэргийг нэрлэж болох юм. Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн удирдлага дор Нийгмийн бодлого, хөгжил судалгааны хүрээлэнгээс Улаанбаатар хот, 13 аймгийн 18-аас дээш насны 5000 иргэний дунд 2016 оны 3,8-р сард явуулсан "Сонгуулийн өмнөх болон дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа"-ны тайлангаас үзэхэд "Сонгуульд санал өгөх нь улс орны талаар шийдвэр гаргахад нөлөөлөх боломжийг надад өгдөг гэдэгтэй та хэр зэрэг санал нийлдэг вэ? " гэсэн асуултад 37% нь бүрэн санал нийлдэг, 43% нь ерөнхийдөө санал нийлдэг гэж хариулсан нь иргэдийн дийлэнх олонх нь шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтойг харуулсаны зэрэгцээ Монголын сонгогчдын дүр төрх харьцангуй өөрчлөгдөж, тэдний нийгэм, сэтгэл зүй, үйл байдал сонгуулиас сонгуульд дасан зохицож, тэдгээрийг ойлгон хүлээн авах болсон байна гэж үзэж болох юм.

Миний бие иргэдэд хамгийн ойр, өөрсдийнх нь аж төрж буй нутаг дэвсгэрийн хамтын удирдлагын хэлбэр болох нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын /Цаашид Орон нутгийн сонгууль гэх/ сонгуулийн дунд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэн судлахад анхаарлаа хандуулж байна.

Учир нь Орон нутгийн сонгууль бол нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах үндсэн арга хэрэгсэл, тухайн орон нутагтаа нийтийн засаглалыг бий болгох үйл ажиллагаа болохын хувьд сонгогчдын өөрсдийнх нь улс төр, хууль эрх зүйн ухамсар, соёл, туршлага, сэтгэл зүйн түвшин, шинж төрхийг

илэрхийлэх боломж илүүтэй байдаг тул нэр дэвшигчдийн улс төрийн технологи, амьдарч буй орчноос үүдэлтэй нийгмийн сэтгэл зүйн нөлөөлөл орон нутгийн сонгуулийн хувьд хүчтэй байх магадлалтай.

Хэдийгээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгууль нь сонгогчдын саналаа өгөх үйл явц, хэлбэрийн хувьд адил төстэй талууд байх боловч Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар "...аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн"[2] тул хуулиар олгогдсон эрх мэдэл, эрх хэмжээний цар хүрээ, иргэдэд үзүүлэх үр нөлөөний тухайд агуулгын талаасаа ялгаатай тул тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

Энэ утгаараа удирдлагын бусад институциудээс хэд хэдэн онцлог шинжүүдийг өөртөө агуулж байдаг.

1. Хүний нийгмийн харилцааг зохицуулах анхдагч институци гэж хэлж болно. Анхны хүй нэгдлийн үеийн нийгэмшиж эхлэх эхний алхам нь нутгийн өөрөө удирдах ёс байж байж магадгүй[3] тухай зарим судлаачид тэмдэглэсэн байдаг.

2. Нийгмийн удирдлагын бусад институциудтэй харьцуулахад тухайн нутаг дэвсгэрт оршин амьдарч буй иргэдэд хамгийн ойр, тэдний өмнө тулгамдаж буй асуудлуудыг богино хугацаанд судлан үр нөлөөтэй шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх хамгийн боломжтой байгууллага

3. Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн хурал, нэр дэвшин томилогдсон Засаг даргын бодлого, үйл ажиллагаа иргэдэд илүү ил тод, ойр дөхөм байдаг тул оновчтой сонголт хийх боломжтой.

Ийм учраас сонгуулийн үр дүнд ямар нэр дэвшигч ялалт байгуулсан гэдгээс илүүтэйгээр эдгээр сонгуулиудад иргэд, сонгогчид хувийн эрх ашгийн үүднээс сонголт хийж байна уу?, сэтгэл хөдлөлд автсан патримон хандлагаар оролцож байна уу? эсвэл нийтийн эрх ашгийн үүднээс ухамсартайгаар рациональ сонголт хийж байна уу?, эцсийн дүндээ засгийн эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулиар олгогдсон эрхээ ухамсартайгаар эдэлж, иргэд хөндлөнгийн аливаа хүчин зүйл, нөлөөнд автахгүйгээр саналаа илэрхийлж чадаж байна уу?, нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн дүн

[2] Монгол Улсын Үндсэн хуулийн /Тавин наймдугаар зүйл. 1992 он./

[3] Ц.Санжаа. Орон нутгийн удирдлагын орчин үеийн онол, арга зүй, үндсэн зарчим. 50 дахь тал.

нутгийн өөрөө ёсны хөгжил, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын төлөвшил, чадамжид хэрхэн нөлөөлж байна вэ гэдэгт дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгөх шаардлага тулгарч байна.

Учир нь орон нутгийн сонгуулийг Улсын Их хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуультай харьцуулахад сонгуулийн зохион байгуулалт, сонгогчид саналаа илэрхийлэх, дүнг гаргах үйл явцын хувьд адил төстэй талууд байх боловч дараах ялгаатай талууд бий. Үүнд:

1.Нэг нэр дэвшигчид ноогдох сонгогчийн тоо цөөн байгаа тул тухайн нэр дэвшигч сонгогч бүрт хүрч ажиллах боломж илүү байх магадлалтай.

2.Одоогийн сонгуулийн хуулиар дийлэнхдээ улс төрийн намаас нэр дэвшиж байгаа боловч нэр дэвшигчид ихэнх тохиолдолд сонгогчдын танил хүмүүс байдаг тул тэднийг харьцуулан үнэлж, сонголтоо хийх бололцоотой.

3. Цаг хугацааны хувьд Улсын Их Хурлын сонгуулийн дараа шинэ Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх хэрэгжиж эхэлж байгаа тэр цаг үед явагддаг тул сонгуулийн үр дүнд өөр хүчин зүйлс нөлөөлөх боломжтой.

Өөр нэг анхаарал татаж байгаа үйл явц нь орон нутгийн сонгуулийн сонгогчдын ирц, оролцооны тухай асуудал юм.

Өвөрхангай аймгийн тухайд 2024 оны орон нутгийн сонгуулийн ирцийг 1996 оны орон нутгийн сонгуулийн ирцтэй харьцуулахад 16.2 хувиар буурсан төдийгүй 1996 оноос хойш явагдсан удаа дараагийн орон нутгийн сонгуулийн ирц тухайн онд явагдсан Улсын Их Хурлын сонгуулийн ирцийн хувиас 10.9-20.2 хувиар доогуур байна.

Хэдийгээр цаг үеийн болон цаг агаарын нөхцөл байдлаас үүдэлтэй янз бүрийн шалтгаан байж болох боловч өөрсдийн амьдран суугаа орон нутгийн удирдлагын байгууллагыг сонгох сонгуульд иргэд идэвх муутай оролцож байгаагийн гол үндсэн шалтгааныг олж илрүүлэн дүгнэлт гаргах шаардлагатай байна.

Нөгөө талаар сонгуульд оролцож байгаа иргэдийн байр суурь, тэдний сонголтод нөлөөлж буй хүчин зүйлүүд, саналаа өгч байгаа болон сонгуульд оролцохгүй байгаагийн учир шалтгааныг сайтар шинжлэн судлах хэрэгцээ үүсэж байна.

Нөгөө талаар ардчиллын замыг сонгож аваад дөнгөж 30 гаруй жил болж буй манай орны иргэдийн хувьд инстутитэжсэн тогтолцоо дахь эрхээ мэддэггүй, улс төрийн оролцооны механизмаа ашиглаж чаддаггүйгээс тэмцлийн буруу буюу нийцгүй оролцооны хэлбэрийг ашиглах гэдэг, эсвэл

дуугүй, хүлцэнгүй ханддаг байдалд шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийж, дүгнэлт өгөх шаардлага тулгарч байна.

Хүмүүсийн харилцааны явцад оюун санааны тэгш бус, адилгүй чадамж, авьяас билэг, үнэлэмж, байр суурийн ялгаанаас болж, тэдний хооронд эрх ашиг сонирхлын ихээхэн ялгаа бий болж байгааг хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнээс харж болно. Түүнээс үүсвэрлэсэн бэрхшээлтэй, төвөгтэй олон асуудал нүдэнд үл үзэгдэх боловч сөрөг үр дагавар ихтэй учраас тэдгээрээс урьдчилан сэргийлэх, иргэд, сонгогчдод зөв сонголт хийхэд тус дөхөм үзүүлэх явдал чухал юм.

Энэ бүхнээс үзэхэд орон нутгийн сонгуулийн үр дүн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзэхдээ, сонгуулийн үйл явц, орон нутгийн иргэдийн түүх, соёл, нийгэм сэтгэл зүйн уламжлал, онцлог, өнөөгийн байдлыг эрх зүй, улс төр болон нийгэм судлалын хүрээнд цогцоор нь шинжлэн судалж, дүгнэлт гаргах зайлшгүй хэрэгцээ үүсч байна.

## ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ДҮН, СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУДАЛГАА

**1. Өвөрхангай аймагт 1992-2024 онд явагдсан Орон нутгийн сонгуулийн тухай товч хураангуй.** Монгол улсын Шинэ үндсэн хуулийн дагуу 1992 онд явагдсан аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны сонгууль нэлээд өвөрмөц хэлбэрээр явагдсан байдаг. Монгол улсын Үндсэн хуулийн агуулгад нийцүүлэн 1992 онд батлан гаргасан Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу сум, дүүргийн хуралд баг, хороо бүрээс 5 төлөөлөгч, аймгийн хуралд сум бүрээс 3 /10000-аас дээш хүн амтай сумаас 5/ төлөөлөгч, нийслэлийн хуралд дүүрэг бүрээс 8 /10000 хүртэл хүн амтай дүүргээс 2/ сонгосон нь хуучин нийгмийн тогтолцооны эхэн үед /1924-1931 он/ хэрэглэж байсан төлөөллийн зарчимтай төстэй байв.

Өөрөөр хэлбэл 1923 онд Ардын Засгийн газраас гаргасан “Нутгийн захиргааны дүрэм”-д тусгагдаж, улмаар анхдугаар Үндсэн хуульд баталгаажсан “...баг, сум, аймаг, улсын Засгийн газар хүртэл ардын төлөөлөгчдийн хурлыг байгуулан төлөөлөгч сонгодог журам”-ыг шинэ нөхцөлд уламжлан авсан явдал гэж үзэж болно

Өвөрхангай аймгийн Ардын Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан 112 багийн Иргэдийн нийтийн хурлыг 9 дүгээр сарын 10-18-ны өдрүүдэд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг 9 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Ингэхдээ "Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Арвайхээр, Хархорин сумаас тус бүр-5, бусад сумаас тус бүр -3 төлөөлөгчийг шууд бус сонгуулийн зарчмаар нууцаар санал хурааж, бүгд 61 хүнийг төлөөлөгчөөр сонгожээ.

Түүнээс хойш 1996, 2012 онуудад хосолсон зарчмаар буюу нэг мандаттай нутаг дэвсгэрийн нэгжээр болон намын жагсаалтаар /гэхдээ хоорондоо зарчмын ялгаатай/, 2000, 2004 онуудад мажоритори тогтолцоогоор буюу нэг мандаттай нутаг дэвсгэрийн нэгжээр, 2008, 2016, 2020, 2024 онуудад олон мандаттай томсгосон мажоритори тогтолцоогоор, нутаг дэвсгэрийн нэгжээр тус явагдсан.

1996 онд явагдсан орон нутгийн сонгууль нь Улсын Их Хурлын сонгуулийн дараа шинээр батлагдан гарсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай" хуулийн дагуу иргэд анх удаа нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд зарчмаар орон нутгийн Төлөөлөгчдөө сонгосон анхны "Орон нутгийн сонгууль" байв.

Нөгөө талаар аймгийн ИТХ-д 35 төлөөлөгч сонгогдохоос мажоритари тогтолцоогоор буюу сум бүрийг төлөөлсөн-19, пропорцианал тогтолцоогоор буюу намын жагсаалтаар-16 төлөөлөгч сонгогдсон холимог тогтолцоотой сонгууль болсон.

Тухайн шатны ИТХ-д улс төрийн намын дараалалд орсон нэрсийн жагсаалтаас нутаг дэвсгэрийн нэгжид нэр дэвшсэн болон жагсаалтаар нэр дэвшсэн гэсэн хоёр хэлбэрээр нам эвслээс суудал авах боловч авсан суудлын нийт дүн нь нам эвслийнх нь авсан нийт саналд хувь тэнцсэн байх зарчим хуульд тусгагдсан байлаа. Нэг үгээр хэлбэл жагсаалтын дараалалд нэр дэвшсэн нэр дэвшигч тойрогт ялалт байгуулж чадаагүй ч дараалалд дээгүүр бичигдсэн бол төлөөлөгчөөр сонгогдох боломжтой байхаар хуульчлагдсан байв. [4]

Энэ байдлыг 2012 оны хуулиар өөрчилж, тойрог болон жагсаалтанд нэгэн зэрэг нэр дэвших явдлыг зогсоосон байна.

[4] Жишээ нь: Өлзийт сумын тойрогт ялсан, ялагдсан хоёр нэр дэвшигч хоёулаа төлөөлөгч болжээ.

Тухайн үед батлагдан гарсан хуулийн дагуу 2000, 2004 оны сонгууль нэг мандаттай мажоритори тогтолцоогоор, 2008, 2016, 2020, 2024 оны сонгууль олон мандаттай мажоритори тогтолцоогоор тус тус явагджээ.

Ийнхүү 1992 оноос хойш явагдсан Орон нутгийн сонгуулиуд удаа дараа өөрчлөгдөн батлагдсан хуулийн дагуу сонгуулийн өөр өөр тогтолцоогоор явагдаж, сонгуулийн дүн харилцан адилгүй гарсан байна.

## 2. Сонгуульд нэр дэвшигчдийн намын харьяалалын судалгаа







1992 оноос хойш Өвөрхангай аймгийн ИТХ-ын сонгуульд нийтдээ 728 нэр дэвшигч өрсөлдсөнөөс улс төрийн голлох хоёр нам болох МАН / МАХН/, АН /Эвсэл/-аас нэр дэвшигчид дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд бусад намуудын хувьд тухайн цаг үеийн улс төрийн намуудын идэвхижлээс шалтгаалан орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн байдал анзаарагдаж байна. Тухайлбал, 2000 оны сонгуульд Эх орон- МАШСНам, 2012 онд "Шударга ёс" эвсэл, 2024 оны сонгуульд ХҮН, Иргэний хөдөлгөөний намаас нэр дэвшигчид харьцангуй олон байжээ. Харин 2008 оны сонгуулиас хойш аймгийн ИТХ-ын сонгуульд нэг ч бие даагч нэр дэвшээгүй байна.

## 3. Аймгийн ИТХ-ын сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдийн намын харьяаллын судалгаа






Өнгөрсөн хугацаанд явагдсан 9 удаагийн сонгуульд Өвөрхангай аймгийн тухайд авч үзэхэд МАН/МАХН/ нэг ч удаа ялагдал хүлээлгүй дийлэнх олонхийн санал авчээ. Харин холимог системээр явагдсан 1996, 2012 оны сонгуульд голлох хоёр намын суудлын харьцаа нэлээд ойртсон /45,7:45.7,58.5:39.0/ байна. Нөгөөтэйгүүр өнгөрсөн 32 жилийн хугацаанд улс төрийн бусад намаас нэр дэвшигчдээс ердөө 4 нэр дэвшигч ялалт байгуулжээ. Мөн 1996 оны сонгуульд 3 бие даагч төлөөлөгчөөр сонгогдсон явдал нь тухайн сонгуулийн системийн онцлогт тохируулсан эрх баригч намын тактик байв. Учир нь сонгуулийн хуулиар намын нэр дэвшигчид нэрсийн жагсаалтаас тойрогт нэр дэвшиж байгаа тул сонгуулийн эцсийн дүн голлох хоёр намын хувьд тун ойролцоо гарах магадлалтайг харгалзан тэр үеийн эрх баригч МАХН тухайн тойрогт өөрийн намаас нэр дэвшүүлэлгүй бие даагчийг бодлогоор дэмжин өрсөлдүүлсэн байна. Иймээс 1996 оны сонгуулийн дүн МАХН-16, Ардчилсан холбоо эвсэл-16, бие даагч -3 нийт 35 төлөөлөгч сонгогджээ.

## 4. Төлөөлөгчдийн боловсролын байдлын судалгаа







1992 оны сонгуулиар бага боловсролтой таван төлөөлөгч сонгогдсон нь нэг талаас тухайн үеийн боловсролын системийн онцлог, нөгөө талаас нийгмийн зарим бүлгүүдийн төлөөлөл / малчин, ажилчин/ төлөөлөгчөөр сонгогдсонтой холбоотой байв. Түүнээс хойш улс орон зах эдийн засгийн харилцаанд шилжиж, дээд сургуулиудын тоо олширсон тул тэдгээрт суралцаж, төгсөгчдийн тоо өссөн нь сонгогдсон Төлөөлөгчдийн боловсролын байдалд нөлөөлсөн байна. Нөгөөтэйгүүр сонгуулийн тогтолцооноос шалтгаалан нийгмийн зарим бүлгүүдийн төлөөлөл нэр дэвшигдэн сонгогдох магадлал багассантай ч холбоотой байж болох юм.

## 5. Төлөөлөгчдийн мэргэжлийн байдлын судалгаа







1992 оны сонгуульд огт мэргэжилгүй төлөөлөгчдийн эзлэх хувийн жин 19.7%-ийг эзэлж байсан нь тухайн сонгуульд малчин, ажилчин зэрэг нийгмийн төлөөлөл нэр дэвшигдэн сонгогдож байсантай холбоотой байв. Мэргэжлийн онцлогоос шалтгаалан инженер, эдийн засагчдын төлөөлөл аймгийн ИТХ-д харьцангуй олноор сонгогдож иржээ. Харин 2004 оноос эхлэн аймгийн ИТХ-д эрх зүйч - хуульчдийн төлөөлөл сонгогдох болсон нь сонирхол татаж байгаа бөгөөд ИТХ-д сонгогдох магадлал өндөр, олны танил мэргэжил болох багш, эмч нарын төлөөлөлүүдийн удаа дараагийн сонгуулиудад эзлэх хувь нь харьцангуй тогтвортой байна.

## 6. Төлөөлөгчдийн насны ангилал.







Өнгөрсөн хугацаанд явагдсан сонгуулийн дүнгээс ажиглахад 30 хүртэлх насны залуучуудын эзлэх хувь харьцангуй доогуур байгаа бол 31-45 насны хүмүүсийн эзлэх хувь 2000 оноос өсч, 50-иас илүү хувийг эзлэх болсон байна.

Харин 45-аас насныхны эзлэх хувь 1992 оныг 2024 онтой харьцуулахад 7,7%-иар буурсан байна. Энэ байдалд тухайн үеийн сонгуулийн тогтолцоо, улс төрийн намуудын арга тактик нөлөөлсөн байж болох юм.

## 7. Сонгогдсон Төлөөлөгчдийн жендерийн судалгаа







2000 оноос өмнөх сонгуульд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 10% хүрэхгүй байв. Харин түүнээс хойш мэдэгдэхүйц нэмэгдэж, 2024 оны сонгуульд нийт 10 төлөөлөгч буюу 24.4%-д хүрсэн нь томоохон дэвшил юм. Орон нутгийн ИТХ-аар хэлэлцэж буй асуудлуудын дийлэнх нь тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын өдөр тутмын амьдралтай холбоотой амин чухал асуудлууд байдаг тул  эмэгтэйчүүдийн оролцоог цаашид ч нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## 8. Албан тушаалын ангилал.







Дээрх статистикаас харахад сонгогдсон төлөөлөгчдийн дийлэнх хувийг төр, хувийн хэвшлийн удирдах албан тушаалтнууд эзэлж байна. Энэ нь тухайн нэр дэвшигчдийн хувийн нэр хүнд, нийгэм улс төрийн амьдралд эзлэх байр

суурь, сонгуульд оролцож буй улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Харин төлөөлөгчөөр сонгогдсон зарим гүйцэтгэх албан тушаалтнууд удирдах албан тушаалд томилогдох үзэгдэл сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон.

## 9. Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн сонгогдсон байдал







Өнгөрсөн хугацаанд явагдсан сонгуулийн дүнгээс ажиглахад улс төрийн намууд нэг талаас сонгуулиас сонгуульд өөрсдийн нэр дэвшигчиддээ олон талаас нь судалж нэр дэвшүүлдэг, нөгөө талаас зарим төлөөлөгчид сонгогчдын итгэлийг тэр бүр дааж ажиллаж чаддаггүйтэй холбоотой нь 9 удаагийн сонгуулиар сонгогдсон нийт 365 төлөөлөгчийн 83.3% нь зөвхөн нэг удаа сонгогдсон үзүүлэлтээс харагдаж байна. Харин зарим нэр дэвшигчдийн хувийн нэр хүнд, ойрын хүрээллийн нөлөө, манлайлах чадвар өндөр байдгаас шалтгаалан 2 ба түүнээс дээш удаа сонгогджээ. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Өвөрхангай аймагт удаа дараа 4 ба түүнээс дээш сонгогдсон дөрвөн иргэн байгаагийн дээр 6 удаа сонгогдсон буюу 24 жилийн хугацаанд аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр ажилласан нэг хүн байна.

**10. Сонгуулийн ирцийн байдал.**




Судалгаанаас үзэхэд иргэдийн оролцооны гол илэрхийлэл болох энэ жилийн буюу 2024 оны сонгогчдын ирцийг 1992 онтэй харьцуулахад 16.2%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна. Харин 2016 онд явагдсан сонгуулийн сонгогчдын ирц-76.3%-тай байсан нь аймгийн ИТХ-ын сонгуулийг УИХ-ын сонгуультай нэгэн зэрэг явуулсантай холбоотой байв. Бусад тохиолдолд Монгол улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуултай харьцуулахад Орон нутгийн сонгуульд сонгогчдын ирц харьцангуй доогуур /1.7-6.2%/ байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн хувьд 2024 оны явагдсан Орон нутгийн сонгуулийн ирц, тухайн онд явагдсан УИХ-ын сонгуулийг ирцээс 7.8 %-иар доогуур байна. Орон нутгийн сонгуульд сонгогчдыг идэвхи оролцоо хангалтгүй ялангуяа залуучуудын ирц доогуур байгаагийн учир шалтгааныг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

# ГУРАВ.СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Орон нутгийн сонгуулийн үр дүнд дараах хүчин зүйлүүд багагүй нөлөө үзүүлдэг байдал ажиглагдаж байна.

**<u>1. Сонгуулийн тогтолцооны нөлөөлөл:</u>** 1992 оноос хойш явагдсан найман удаагийн орон нутгийн сонгуульд тухайн үедээ батлагдан гарсан хуулийг дагуу дөрвөн өөр системээр явагдахад Өвөрхангай аймгийн хувьд сонгуулийн дүн, улс төрийн намын харьцаа өөр өөр байна. Сонгуулийн дүнгээс үзэхэд үүнд олон хүчин зүйл нөлөөлж болох боловч сонгуулийн тогтолцоо шийдвэрлэх нөлөөтэй байгаа нь илэрхий байна.

1992 оны ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох үйл явц нь хэдийгээр тогтолцоо, зохион байгуулалтын хувьд шууд бус сонгуулийн хэлбэрээр өрсөлдөөн багатай явагдсан боловч багийн Иргэдийн нийтийн хурлаас сумын ИТХ-ын төлөөлөгчдийг, сумын ИТХ-аас аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгосон нь улс төрөөс харьцангуй хараат бусаар явагдах нөхцлийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

Харин холимог системээр явагдсан 1996, 2012 оны сонгуульд голлох хоёр намын суудлын харьцаа нэлээд ойртсон /45,7:45.7,58.5:39.0/ байхад сонгуулийн мажоритари тогтолцоогоор явагдсан бусад сонгуульд голлох хоёр намын саналын зөрүү 49.6-85.2% байгаа нь орон нутгийн ИТХ-ын сонгуульд сонгуулийн тогтолцоо ямар нэг хэмжээгээр нөлөөлж байгааг харуулж байна.

2<u>. Улс төрийн хүчин зүйл:</u> Сонгуулийн дүнд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж болох юм. Үүнд:

- ❖ **Улс төрийн намын хатуу гишүүнчлэл.** Өнөөгийн мөрдөгдөж буй Орон нутгийн сонгуулийн хуулиар нэр дэвшигчдийн дийлэнх нь улс төрийн намаас нэр дэвшиж байгаа тул хатуу гишүүнчлэлтэй намуудын нөлөө хүчтэй байна. Хэдийгээр тухайн нутаг дэвсгэртээ танигдсан, харьцангуй ойрын хүрээлэл сайтай байх магадлалтай боловч бие даан нэр дэвшигчид ялах магадлал тун бага байдаг нь сонгуулийн дүнгээс харагдаж байна. 1992 оны Орон нутгийн сонгууль шууд бус сонгуулийн системээр явагдсан учраас төлөөлөгчдийн 23% нь нам бус төлөөлөгчид байжээ. Гэтэл түүнээс хойш явагдсан сонгуулиудад сонгогдсон төлөөлөгчдөд бие даагч болон улс төрийн гуравдагч хүчний эзлэх хувийн жин 3% ч хүрэхгүй байна. 1996 оноос хойших орон нутгийн сонгуулийн хуулиар тухайн шатны ИТХ-ын сонгуульд улс төрийн намуудын оролцоо илт давамгайлах болсонтой

холбоотойгоор удирдах албан тушаалтнуудаас бусад нийгмийн бүлгийн төлөөлөл хязгаарлагдмал болсон байна. 1992 оны сонгуулиас хойш улс төрийн намын харьяалалгүй нэг ч иргэн сонгогдоогүй байна.

- **Улс төрийн намуудын бодлого үйл ажиллагааны нөлөө.** Сонгуулийн холимог системээр явагдсан 1996, 2012 оны сонгуулиас бусдад нь МАН/МАХН/- 74.2-92.7% буюу илт давамгай ялалт байгуулжээ. Тухайн намаас нэр дэвшигчдийн хувьд орон нутгийн болон ойрын хүрээллийн нөлөө байгаа боловч тус намын хийж, хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлын үр дүн сонгогчдын олонход итгэл төрүүлсэн байдал анзаарагдаж байна.Үүнээс үзэхэд сонгуульд саналаа илэрхийлж буй иргэдийн сонголтод улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагаа нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй.
- **Улс төрийн намуудын сонгуулийн кампанит ажлын арга технологийн нөлөө:** Сонгуулийг шударга, ардчилсан байдлаар явуулах гол нөхцөл нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах арга технологийн хэлбэрээс их зүйл хамаардаг юм байна. Улс төрийн зарим субьект, нам, хүчин сонгууль зохион байгуулах арга технологийг чамбай эзэмшиж, улс төрийн шинэлэг арга хэрэгсэл туршин хэрэглэх болсон байна. Сүүлийн үед улс төрийн мэдээлэл харилцааны салбарт мэргэшсэн, сонгуулийн ухуулга сурталчилгаа явуулах талаар тодорхой туршлага хуримтлуулсан байгууллага, PR агентлаг, хууль зүйн товчоо зэрэг нь улс төрийн бодлогын шинжилгээ, улс төрчдийн рейтинг тогтоох, олон түмний санаа бодлыг судалж, дүгнэлт зөвлөмж өгөх нь нэмэгдэж, судалгааны баг болон хувь хүмүүс сонгуулийн кампани удирдан зохион байгуулахад идэвхитэй оролцох болсон, сонгуулийн үйл явцад олон янзын арга технологи хэрэглэж буй зэрэг нь бодит байдлыг судлах өргөн боломжийг нээж байна. Нөгөө талаар манай оронд болсон удаа дараагийн сонгуулийн явцад сонгуулийн "бохир технологи" буюу "деструктив технологи" харьцангуй илүүтэй хэрэглэгдэж, сонгууль их төлөв булхайтай, шударга бус болох хандлага хандлага нэмэгдэх болсон талаар олонтаа ярьж бичдэг. Тийм болохоор өнөөдөр сонгуулийн үйл ажиллагааны арга технологийн асуудал, сонгуулийн үр дүнд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судалж, дүгнэлт гаргах нь улс төрийн шинжлэх ухааны чухал судлагдахуун болжээ.

**3. Хууль зүйн хүчин зүйл:** Одоогийн мөрдөгдөж буй Орон нутгийн сонгуулийн хууль түүнийг дагалдаж гарсан бусад эрх зүйн актууд зэрэг

болон сөрөг нөлөө үзүүлж байна. Анх 1996 онд Орон нутгийн сонгуулийн хуулийг батлан мөрдөж эхэлснээс хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсаны дотор 2012 он, 2020 онд Орон нутгийн сонгуулийн хуулийг шинэчлэн баталж, мөрдсөн байна. Уг өөрчлөлтүүдээр дээр дурьдсан сонгуулийн тогтолцооны өөрчлөлтөөс гадна, төрийн жинхэнэ албан хаагчдыг орон нутгийн сонгуульд нэр дэвшихийг хязгаарласан, сонгуулийн сурталчилгааны хугацаанд өөрчлөлт оруулсан, сонгогчдын ирцийн босго тавьдаг байсныг өөрчилсөн зэрэг нь сонгуулийн үр дүнд эерэг сөрөг алин боловч мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна. Тухайлбал: хамгийн сүүлд явагдсан 2020 оны Өвөрхангай аймгийн ИТХ-ын сонгуульд сонгогдсон төлөөлөгчдийн дийлэнх нь улс төрийн албан тушаалтан, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн удирдах албан тушаалтнууд байна.

**4. Нутаг дэвсгэр, ойрын хүрээллийн нөлөө** Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуульд нэр дэвшигчид ихэнх тохиолдолд ялангуяа хөдөө орон нутагт байнгын оршин суугчид, нутаг орны хүмүүс байдаг тул нэр дэвшигчийн хувийн нэр хүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Ялангуяа хөдөө орон нутагт аав ээж, ах дүү, төрөл садан, найз нөхөд, бизнесийн холбоо хамаарлын нөлөө илүү хүчтэй байх тал ажиглагдаж байгааг дээрх судалгаа харуулж байна. Иймучраас улс төрийн намууд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахдаа тухайн хүний хувийн нэр хүнд, танил тал, ойрын хүрээллийн нөлөөг чухалчлан авч үздэг нь өнгөрсөн сонгуулиудын дүнд хийсэн судалгаанаас ажиглагдаж байна.

**5. Хэвлэл мэдээлийн байгууллага, нийгмийн сүлжээний нөлөө:** Одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд дараах тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

| № | ХМХ-ийн нэрс | Тоо |
|---|---|---|
| 1. | Телевиз | 115 |
| 2. | Сонин | 59 |
| 3. | Сэтгүүл | 43 |
| 4. | Сайт | 59 |
| 5. | Радио | 46 |
| 6. | News | 59 |
| 7. | WWW | 188 |
| Бүгд | | 510 |

Гэхдээ бусад сонгуулиудтай харьцуулахад үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд орон нутгийн сонгуульд үзүүлэх нөлөө харьцангуй бага байх тал бий. Төвийн хэвлэл мэдээлийн хэрэгслүүд орон нутгийн сонгуультай холбоотой мэдээллийг түгээхгүйгээс гадна улс төрийн намуудын сурталчилгааны материалуудаас өөр мэдээллийн хэрэгслүүд орон нутагт цөөн тоотой байдаг. Өвөрхангай аймгийн тухайд орон нутгийн телевиз-2 ажилладаг боловч тэдгээр нь зөвхөн Арвайхээр хотод цацагддаг тул бусад сумдын тухайд хүртээл багатай.

Харин нийгмийн сүлжээ бол байгууллага эсвэл хувь хүн нэг ба түүнээс дээш тооны харилцан хамаарал бүхий үерхэл нөхөрлөл, дайсагнаж хонзогнох болон цаашлаад санхүүгийн арилцаа, наймаа, итгэл үнэмшлийн /улс төр, шашны/ харилцаа, мэдлэг болон нэр төр, амбиц зэрэг дээр тулгуурласан интернет орчин дахь асар том цогц харилцааны төвлөрөл зангилаа тул орон нутгийн сонгогчдод илүүтэй нөлөө үзүүлэх магадлалтай юм.

Манай улсын хувьд 2.2 сая иргэн нийгмийн сүлжээнд оролцож, өдөрт дунджаар 77 минут зарцуулдаг гэх мэдээлэл байгаа нь үүнийг нотолж байна. Энэ чиглэлээр тус аймагт үйл ажиллагаа явуулдаг хоёр LIVE TV нийгмийн сүлжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

**6. Сонгогчдын ирц, оролцооны нөлөө:** 2020 оны орон нутгийн сонгуулийн ирцийг 1996 оны орон нутгийн сонгуулийн ирцтэй харьцуулахад 18.4 хувиар буурсан төдийгүй сонгуулиас сонгуульд улам буурсаар 2024 оны орон нутгийн сонгуульд нэрсийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын 59.5 хувь нь сонгуульд оролцож, саналаа өгсөн нь тухайн онд явагдсан УИХ-ын сонгуулиас 7,8 %-иар доогуур байна. 1996 оноос хойш явагдсан удаа дараагийн орон нутгийн сонгуулийн ирц тухайн онд явагдсан Улсын Их Хурлын сонгуулийн ирцийн хувиас 10.9-20.2 хувиар доогуур байгаа нь энэ бүхнийг илтгэжбуй бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах сонирхолтой судлагдахуун юм.

## ДӨРӨВ. САНАЛ.

1. **Улс төр судлалын хүрээнд:** Миний бие энэ удаагийн өгүүлэлдээ нутгийн өөрөө байгууллагын сонгуульд нөлөөлж буй хүчин зүйлсийг

институтициональ хандлагаар буюу баримт бичгийн судалгааны аргаар авч үзсэн болно. Цаашид энэ сэдвийг бихевиорист арга буюу сонгогчдын сонгуульд оролцож саналаа өгөх сэдэл, зан үйл, сэтгэл зүй, улс төрийн ухамсар, соёлын түвшинтэй холбон судлах ажлыг үргэлжлүүлж байгаа бөгөөд энэ чиглэлээр цуврал өгүүлэлүүдийг бичиж эхлээд байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагын бусад институцүүдээс ялгарах өөрийнх нь онцлог шинжүүдтэй холбоотойгоор орон нутгийн сонгуулийн өвөрмөц шинж чанарууд урган гарч ирж байна. Ялангуяа уг сонгуульд саналаа илэрхийлэн оролцож буй иргэдийн сэдэл, сэтгэл зүй,зан үйлийн талаас нь судлан явдал чухал байна. Ийм учраас энэ чиглэлээр бусад олон судлаачид анхаарлаа хандуулахыг хүсч байна.

2. **Хууль зүйн хүрээнд :**

❖ Юуны өмнө нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангасан, улс төрийн намуудаас харьцангуй хараат бус сонгуулийн эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. Монгол Үндсэн хуульд: “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.”[5] хэмээн заасан. Иймд орон нутгийн өөрөө удирдах байгууллагад улс төрийн нөлөө бүрэн арилах боломжгүй. Харин орон нутгийн сонгуульд оролцох субьектүүдыг өргөжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой мэт бодогдож байна.

❖ Улс орны хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулан 2024 онд Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын гишүүдийн тоог 126 болгон өргөжүүлсэн. Ийм учраас орон ИТХ-ын төлөөлөгчдийн тоог ч эргэн харах нь зүйтэй. Ялангуяа сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн тоо хэтэрхий цөөн байгаагаас шалтгаалан хэт талцал хуваагдал үүсэх, ИТХ-ын даргыг сонгох, Засаг даргыг нэр дэвшүүлэх асуудлаас гадна орон нутгийн тулгамдсан асуудлуудыг явцуу хүрээнд хөнгөн гоомой шийдвэрлэх байдал ажиглагдаж байна.

❖ 1999 оноос эхлэн Үндсэн хуульд гурван удаа өөрчлөлт оруулахдаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай заалтуудыг огт хөндөөгүй. Харин суулийн үед улс орныг бүсчилэн хөгжүүлэх үзэл

[5] Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг /УБ хот 1992 он/

баримтлал эрчимтэй яригдаж, бодит ажил хэрэг болж эхэллээ. Үүний нэг нотолгоо нь энэ жилийн УИХ-ын сонгуулийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан явдал. Тийм болохоор Бүсчилсэн хөгжлийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн өөрийн удирдлага ямар дүр төрхтэй баймааж хөгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байна

3. **Улс төрийн нам эвслүүдийн тухайд:** Өнгөрсөн хугацаанд явагдсан сонгуулийн дүнд судалгаа хийх явцад ажиглагдсан нэг зүйл нь улс төрийн нам эвслүүд өөрийн хүмүүсээ сонгуульд нэр дэвшүүлэхдээ хэнийг тухайн тойрог, орон нутагт хэн ялах вэ гэдэгт анхаарлаа хэт төвлөрүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн шинж чанар болох нийгмийн бүх төлөөллийг хангасан байх суурь нөхцлийг бүрдүүлэх явдлыг орхигдуулж иржээ. Үүний улмаас 2020 оны Өвөрхангай аймгийн ИТХ-ын сонгуульд сонгогдсон төлөөлөгчдийн 90,2%-ийг төр, хувийн  хэвшлийн удирдах албан тушаалтнууд буюу “дарга” нар бүрдүүлж байсан нь үүний нэг нотолгоо юм. Харин 2024 оны аймгийн ИТХ-ын сонгуульд МАН болон АН хөгжлийн бүрхшээлтэй тус бүр нэг иргэнийг аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэн өрсөлдүүлсөн нь нийгмийн төлөөллийг хангах цаг үеийн шаардлагын зөв мэдэрч эхэлсэний нэг жишээ юм.

Улс төрийн намууд энэ онд батлагдан гарсан “Улс төрийн намуудын тухай” хуулийн үзэл баримталд нийцүүлэн хатуу гишүүнчлэлийг аль болохоор зөөллөн бодлогын нам болон төлөвших асуудлыг анхаарах шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд доктор, профессор Я.Долгоржавын нэгэнтээ дурьдсан“... Орон нутагт өөрсдөө сонгож байгуулдаг өөрийн удирдлага бүхий хүй элгэний”[6]-ний байгууллага болох нутгийн өөрөө удирдах байгууллагын хөгжил, төлөвшлийн асуудалд төр, засаг, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн, судлаачид  анхаарлаа  төвлөрүүлэх цаг нэгэнт болжээ.

[6] Долгоржав.Я. Төрийн захиргаа. 2024. УБ. 188 дахь тал.

# ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Ж.Гантуяа

Юуны өмнө “Орон нутгийн засаг захиргаа” гэх ухагдахууныг тайлбарлан толилуулж ирсэн судлаачдын байр суурьтай уялдуулан энэ тухай өөрийн илэрхийллийг хүргэе. “Орон нутгийн засаг захиргаа” гэх ойлголт нь муж, улс доторх засаг захиргааны тодорхой нэгж бөгөөд уг нэгжээр дамжуулан тухайн орон нутгийн иргэдэд нийтийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй байдлаар үзүүлэх, тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүс нутгийн хэмжээнд төсөв, татвар хураамж, дэд бүтэц, хот төлөвлөлт, байгуулалт, нийтийн тээвэр, цэвэр, бохир ус, инженерийн шугам сүлжээ зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгэм соёлын цогцолбор юм.

Орон нутгийн засаг захиргаа нь тодорхой түвшинд бие даасан байдлаар ажилладаг бөгөөд тэдгээрийн бүтэц, эрх мэдэл нь улс орон, бүс нутгаас хамааран харилцан адилгүй байж болно. Ерөнхийд нь нутгийн удирдлагын зарим үндсэн шинж чанар, чиг үүргийг энд дурдвал:

- Орон нутгийн засаг захиргаа нь хотын захиргаа, хошуу, хот суурин, тосгон зэрэг янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд эдгээр нь зөвлөл, хурал, комисс гэх мэт өөр, өөр удирдлагын бүтэцтэй.
- Энд ихэвчлэн хотын дарга, захирагч, зөвлөлийн гишүүд, хянагч зэрэг сонгогдсон албан тушаалтнууд нийтийн эрх ашгийг төлөөлж, орон нутгийн асуудлаар шийдвэр гаргадаг.
- Нийтийн аюулгүй байдлыг хамгаалах тодруулбал, цагдаа, гал түймэр, онцгой байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авах алба болон вакцинжуулалт, эрүүл мэндийн боловсрол, хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлдэг нийгмийн эрүүл мэндийн газар, хэлтсүүдээр дамжуулан хүн амд шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ. Мөн сургуулийн өмнөх болон ерөнхий суурь, мэргэшлийн, тусгай боловсролын байгууллагаар дамжуулан иргэдэд боловсрол олгоно.
- Хурал, зөвлөл гэх мэт бүтцээр дамжуулан орон нутгийн түвшинд тулгарч буй зам, нийтийн тээвэр, цэвэр, бохир ус зэрэг инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, орон сууцжуулалт, хот

төлөвлөлт, төсөв, татвар хураамж зэрэг асуудлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан шийдвэрлэж нийтийн хэрэгцээг хангадаг онцлогтой. Энэ дотроо төсөв, санхүүгийн менежмент нь орон нутгийн засаг захиргааны гол хөшүүрэг юм.

Эндээс харахад Орон нутгийн засаг захиргаа нь иргэдийн өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэж, зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжих, төрийн бодлого, шийдвэрт төлөөллөөрөө дамжуулан иргэдийнхээ оролцоог хангах, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн арга хэмжээг зохион байгуулах нэгж юм. Хамгийн товчоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гэдэг нь аймаг, нийслэл, сум дүүргийн харьяа хүн ам, нутаг дэвсгэр, удирдлагыг багтаасан ойлголт юм.[1]

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдаж байгаа бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. Өнөөдрийн байдлаар Монгол Улс 21 аймаг, 9 дүүрэг, 204 хороо, 330 сум, 1570 баг [2] т хуваагдсан байна.

Нутгийн удирдлагын эрх зүйн гол үндэс нь 1992 онд батлагдсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль юм.[3] Үүнээс хойш Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг 2006, 2020 онд тус тус 2 удаа шинэчилсэн найруулжээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй нэгжийн хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг, эдийн засгийн үндэс, нэгжийг өөрчлөх үндэслэл журмыг тодорхойлж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх **өөрийн** болон **төрийн удирдлагын** тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, зохион байгуулалт, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, нутгийн удирдлагаас бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулж байна.

[1] Ш.Цогтоо. Монгол Улсын Захиргааны эрх зүй. 2021 он. УБ хот. Хуудас-28.

[2] Нийслэлийн статистикийн газар, http://www.ubstat.mn/AimagNiislelCode.aspx /тайлбар баг, хорооны тоо 1-3 хооронд зөрж магадгүй./

[3] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. 2021 он. УБ хот. хуудас-393.

Мөн хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг тодруулбал, орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, дэд бүтэц, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал уг асуудлыг шийдвэрлэнэ. Ингэхдээ улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, уг хотуудын үндсэн нэгжид шилжүүлэх чиг үүргийг тус тусад нь ялгасан байх бөгөөд эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төр олгохоор хуульчилсан нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд нэмэртэй санагдлаа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс нь тухайн нэгжид хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг, орон нутгийн өмч, бүх төрлийн өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хураамжаас орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ. **Нутгийн өөрөө удирдах** ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн.[4] Судлаачдын дээрх байр суурь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дараах чиг үүрэг, бүрэн эрхтэй салшгүй холбоотой юм. Үүнд:

- хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал;
- хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;
- тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;
- тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;
- тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;
- тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;
- хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих;

[4] Мөн тэнд.

- нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;
- хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;
- орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;
- орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;
- энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;
- хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;
- Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;
- худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;
- хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт иргэдийг татан оролцуулах, саналыг нэгтгэн хууль санаачлагчид уламжлах;

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг баримтлан ажиллахаар хуульчлагдсан.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас бүрэлдэж байна.

Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог хүн амын байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дор дурдсанаар тогтоох бөгөөд тэдгээрийг сонгох журмыг хуулиар тогтооно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд:

- аймгийн хүн амын тоо нь 50 000 хүртэл бол 25;
- аймгийн хүн амын тоо нь 50 001-70 000 хүртэл бол 29;
- аймгийн хүн амын тоо нь 70 001-90 000 хүртэл бол 35;
- аймгийн хүн амын тоо нь 90 001-ээс дээш бол 41.

Сумын иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын хувьд:

- сумын хүн амын тоо нь 2 000 хүртэл бол 15;
- сумын хүн амын тоо нь 2 001-5 000 хүртэл бол 21;
- сумын хүн амын тоо нь 5 001-9 000 хүртэл бол 25;
- сумын хүн амын тоо нь 9 001 ба түүнээс дээш бол 29.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд:

- дүүргийн хүн амын тоо нь 100 000 хүртэл бол 25;
- дүүргийн хүн амын тоо нь 100 001-200 000 хүртэл бол 35;
- дүүргийн хүн амын тоо нь 200 001-300 000 хүртэл бол 41;
- дүүргийн хүн амын тоо нь 300 001 ба түүнээс дээш бол 43.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд төлөөлөгчийн тоо 45[5] байна.

Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд энэ нь ээлжит бус сонгуулиар байгуулагдсан Хуралд хамаарахгүй. Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь

[5] Төлөөлөгчдийн тоон мэдээллийг https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль.

хуралдаан бай бөгөөд ээлжит хуралдааныг улиралд нэг удаа, ээлжит бус хуралдааныг нийт төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүйн саналаар, эсхүл Хурлын Зөвлөл, Хурлын даргын санаачилгаар хуралдуулна.[6] Хуралдааны процесстой холбоотой асуудлыг холбогдох хуулиас илүү тодруулах боломжтой.

Энэ хүрээд 2024.10.11-ний өдөр улс орон даяар зохион байгуулагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ес дэх удаагийн сонгуультай холбоотой анхаарал татсан зарим асуудлыг жишээ баримттайгаар хүргэхийг зорилоо. Онцлон дурдахад орон нутгийн 2024 оны сонгуулийн үеэр улс төрийн нам, нэр дэвшигчээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэлд тулгуурлан жишээ баримтуудыг сонгон авсан боловч одоогоор тухайн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт ямар явцтай байгаа талаар мэдээлэл дутмаг байна. Өнөөдрийн байдлаар /2024.11.07/ СЕХ болон бусад байгууллагаас орон нутгийн сонгуулиудын үр дүнг харьцуулах байдлаар дэлгэрэнгүй гаргасан судалгаа, мэдээлэл ховор байна. Гэхдээ СЕХ-ны албан ёсны цахим хуудсанд Сонгууль-2024 гэсэн талбар байгаа бөгөөд энэ холбоосоор https://report.m-election.mn/home# ороход тодорхой мэдээлэл гарч ирж байсан. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй "Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд бүтээгдсэн "Монгол Улсын сонгууль 1992-2021" эмхэтгэлийн 4-р бүлэгт хамаарах Монгол Улсын орон нутгийн сонгууль гэх судалгааны хэсэгт цухас дурдсан байна.

Эрх зүйн орчны хүрээнд Орон нутгийн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой дараах хуулиудыг батлаж мөрдүүлсэн байжээ. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль /1996 он /
- Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, /2007 он/
- Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, /2012 он/
- Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, /2012 он/
- Сонгуулийн тухай хууль, /2015 он. Тайлбар, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх

[6] Мөн хуульд.

журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн энэ хуулийн Орон нутгийн Хурлын сонгуультай холбогдсон бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцсон. /

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль /2020 он/

Сонирхуулахад орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд 2395 тойрог, 8031 мандатын төлөө 10 нам, 1 эвслээс 17010, бие даан нэр дэвшигч 268, нийт 17278 нэр дэвшигч шат, шатны сонгуулийн хороодоос нэр дэвшигчийн үнэмлэхээ авч, хуулийн хугацаанд сурталчилгаагаа хийж дуусгасан байна. Хүйсийн хувьд нэр дэвшигчдийн 5582 буюу 32.3 хувь нь эмэгтэй, 11696 буюу 67.7 хувь нь эрэгтэй байсан бол насны хувьд 31-50 насныхан зонхилж байна.[7]

Тохиолдол 1: Х аймгийн Д сумын сонгуулийн хороо 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Д сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 1 дүгээр тойрогт А намаас нэр дэвшигч Б.Г, 4 дүгээр тойрогт нэр дэвшигч П.Б нарыг МАН-ын гишүүнчлэлтэй нь тогтоогдсон тул нэр дэвшигчээс хасаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байсан. Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д "Намын гишүүн хэдийд ч өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр намаас гарах эрхтэй. Намын гишүүн намаас гарах тухай өргөдөл гаргаснаар түүнийг намаас гарсанд тооцно." гэж заасны дагуу дээр нэр дэвшигчид нь 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр МАН-ын гишүүнчлэлээс гарах өргөдлөө холбогдох намын хороонд хүргүүлсэн байдаг.[8]

Энэ тохиолдолд дараах 2 асуудал анхаарал татаж байна.

1. Сонгуулийн хороо нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэлтэй гэж үзвэл тухайн нам, эвсэлд өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх боломжийг олгох ёстой. Тодруулбал, 2024.09.05-ны өдрийн дотор нам, эвсэл нэр дэвшигчдийн баримт бичгийг сонгуулийн хороонд хүргүүлэх бөгөөд хороо холбогдох материалыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор буюу 2024.09.12-ны өдрийн дотор бүртгэх эсхүл бүртгэхээс татгалзах шийдвэрээ гаргахаар байна. Гэтэл сонгуулийн хороо нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг нөхөн нэр дэвшүүлэх хуулийн хугацаа өнгөрсний дараа буюу

[7] https://m-election.mn/wp/ajmag-nijslel-sum-duurgijn-irgedijn-toloologchdijn-hurlyn-eelzhit-songuulijn-zohion-bajguulaltyn-talaar-medeelel-hijlee/ холбоосоор орж Сонгуулийн Ерөнхий хорооны албан ёсны мэдээлэлээс авлаа.

[8] Тус тохиолдлыг нь сонгуулийн үеэр улс төрийн нам, нэр дэвшигчээс гаргасан өргөдлөөс авав.

2024.09.25-ны өдөр гаргажээ. Шалтгаан нь магадгүй тухайн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд аль нэг улс төрийн намын шугамаар ажил албанд томилогдсон албан тушаалтнууд олонхи болж байгаа тохиолдолд хараат бусаар ажиллаж чадахгүйд хүрч байна. Үүнээс гадна Улсын Их хурлын 2024 оны сонгуулийн үеэр байгуулагдсан сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг орон нутгийн сонгуулийн үеэр өөрчлөөгүйтэй холбоотой байж болох юм. Тодруулбал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын даргаар ихэвчлэн тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч нар бүрэлдэхүүнд нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төлөөлөл, цагдаагийн болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын дарга зэрэг төрийн алба хаагчид байсан нь зарим талаар иймэрхүү улс төрийн ашиг сонирхолтой шийдвэр гаргахад хүргэжээ. Уг нь сонгуулийн хороод сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдаас бүрдэх бөгөөд эдгээр нь ашиг сонирхлоос ангид байж тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгуулийг өндөр хариуцлага, зохион байгуулалттай зохион байгуулах чиг үүрэгтэй бүтэц юм.

2. Хуулиар 18 нас хүрсэн, ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй байхаар хуульчилсан. Хуулийн дээрх заалтын хүрээнд А нам нэр дэвшигчээ тодруулж тухайн шатны сонгуулийн хороонд бүртгүүлэхээр хандахад нэр дэвшигчийг нь өөр намын гишүүнчлэлтэй гэж үзээд бүртгэж аваагүй байна. Дээр дурдсанаар Б.Г, П.Б нар 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр МАН-ын гишүүнчлэлээс гарах өргөдлөө холбогдох намын хороонд хүргүүлээд дараа А намаас нэр дэвшиж байгаа холбогдох хуулиудад нийцэж байна. Ер нь иргэд өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр намаас гарах эрхтэй бөгөөд намын гишүүн намаас гарах тухай өргөдөл гаргаснаар түүнийг намаас гарсанд тооцох зохицуулалт үйлчилж байна.

<u>Тохиолдол 2:</u> О аймгийн ...намын хороо орон нутгийн сонгуульд нэр дэвшигчээ хуульд заасан хугацаа хэтрүүлэн буюу 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр тодруулсан тухай зарим улс төрийн намаас олон нийтэд мэдээлж байсан.

Энэ тохиолдолд орон нутгийн хурлын сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам,эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө /2024.08.27-ны өдрөөс/ эхлүүлж, долоо хоногийн /2024.09.02-ны өдрийг дуустал/ хугацаанд дуусгах бөгөөд уг хугацааг хэтрүүлсэн бол нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзана.

Тохиолдол 3: А аймгийн нэмэлт санал хураалтад оролцохоор явж байсан сонгогчдын тээврийн хэрэгсэл, унааг шалгах нэрийн дор саатуулж зорчиж явсан сонгогчдын сонгууль өгөх эрхэд халдсан.

Энэ тохиолдолд сонгогчдын санал өгөх эрхэд халдсан байж болзошгүй байна. Учир нь хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн бол адил санал авсан нэр дэвшигчдийн дунд нэмэлт санал хураалт явуулах бөгөөд уг санал хураалтад эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч оролцож, саналаа өгөхөөр хуульчилсан. Ингээд нэмэлт санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоог эхний санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоон дээр нэмж тооцсоноор тухайн тойргийн санал хураалтын дүнг гаргах ёстой.

Тохиолдол 4: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд МАН-ын намаас нэр дэвшигч Хотын дарга гэх Х.Н нь **2024.09.07**-ны өдөр "Сүүлийн үед сонгууль дөхсөн залуу "Женкочид" А намаас, баахан лайв хийдэг хүмүүс нэр дэвшиж байна. Болсон болоогүй энд, тэнд очиж лайв хийдэг хэдэн шизотой бацаанууд бий. Үүн дээр мэргэжлийнхэн өөрсдөө дуугарцгаа. Ерөөсөө энэ Ажил огт хийж үзээгүй, хүүхэд байхаасаа хойш энд тэнд шантааж хийж, лайв хийдэг хүний хөлсөөр шантаажилдаг бараг 20-30 нөхдүүдийг нэр дэвшүүлсэн байна лээ. Энэ хүмүүс бол ерөөсөө л луйвар, шантааж хийдэг хэдэн бацаан нийлцэн нийслэлийн иргэдийн хуралд нэр дэвших гээд явж байна. Өөрсдөө юу ч хийдэггүй дандаа хулгай хийдэг" гэх илт худал мэдээллийг олон нийтийн цахим хуудас ашиглан цацсан.

Энэ тохиолдол нь Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг болон Эрүүгийн хуулийн тусгай ангийн ангийн 14.8 дугаар зүйлийн 1-д "Сонгуульд оролцогч улс төрийн нам, .., нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан..." гэх гэмт хэргийн шинжийг агуулж байгаа нь илт байна. Хуулиар нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно гэж заасан. Мөн ээлжит

сонгуулийн жил буюу 2024.01.01-ний өдрөөс эхлэн хойш бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, ийм агуулга бүхий мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараасан болох нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэлтэй. Хуулийн дээрх заалтаар нэр хүндэд халдсан үйл баримт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдоход богино биш хугацаа ордгийг зарим нэг увайгүй, ёс суртахуунгүй зальжин нөхдүүд сонгуулийн хар пи-ар болгон ашиглаж өрсөлдөгчөө харлуулж ирсэн. Иймэрхүү гэмт хэрэг зөрчлийн шинжтэй үйлдлүүд УИХ болон орон нутгийн сонгуулийн үеэр ч нилээдгүй гарсан.




Зураг-1.

Эх сурвалж: /Зургийг нэгэнт нийтэд ил болсон мэдээллээс авсан болно.

https://www.facebook.com/Ulsturch.mn/videos/384799334473406

<u>Тохиолдол 5: </u>Орон нутгийн сонгуулийн дараа зарим нэг ИТХ-ын төлөөлөгчид Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэхэд саналаа зарж /тухайн нэгжээсээ хамаараад 20, 30 гэх мэт өөр өөр дүн яригддаг төлөөлөгчийн ярианаас/ байгаа үзэгдэл сүүлийн сонгуулиудаар ажиглагдах болсон.

Энэ нь сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн хороо тухайн Хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулах бөгөөд уг хурлаар Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгодогтой холбоотой. Тодруулбал, ИТХ-ын төлөөлөгч болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэг дангаараа буюу хамтарч хуульд заасан шаардлага хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэхээр санал гаргахдаа олонхи болсон төлөөлөгчийн саналыг урвуулах, худалдан авах /нийгэмд түгээд байгаа нэршил/ явдал юм. Угтаа Засаг дарга нь хурлынхаа шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьялах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцаж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хурлын шийдвэрт хориг тавих эрх эдлэх чухал субъект билээ.

Тохиолдол 6: Орон сууцны СӨХ-р дамжуулан оршин суугчдад мөнгө, эд зүйл тараах зэргээр хууль бус сурталчилгаа зохион байгуулах тохиолдол байна. Тодруулбал, Манай СӨХ-ийн дарга үүрээр хаалга тогшоод 100.000 /нэг зуун мянган төгрөг/ өгсөн гэх оёдолчин эмэгтэй яриаг оруулаа. Мөн СӨХ-ын дарга нар СӨХ-ийн группээр дамжуулан манай хороонд нэр дэвшиж байгаа төлөөлөгч хорооллын гаднах замыг янзалж байгаа гэх мэт нэр дэвшигчийн зураг хөргийг оруулан сонгуулийн сурталчилгаа хийх явдал байна. Угтаа бол сонгуулийн сурталчилгаа хийх этгээд албан ёсоор сонгуулийн хороонд бүртгүүлж үнэмлэх авах ёстой.

Нийтлэлийнхээ энэ хэсэгт ИТХ-ын 2024 оны сонгуулийн дүнг нэгтгэж, анализ хийсэн нэгэн судлаачийн судалгааны хэсгээс харахад МАН, АН-с нэр дэвшигчдийн ялалтын зөрүү маш бага байна.

Хүснэгт-1.

| Д/д | УТН-ын нэрс | Аймгийн ИТХ-ын сонгууль | Сумын ИТХ-ын сонгууль |
|---|---|---|---|
| | | квот: 751 | квот:6924 |
| 2. | МАН-с нэр дэвшигч | 410 | 3629 |
| 3. | АН-с нэр дэвшигч | 333 | 3174 |
| 4. | Бусад | 8 | 118 |

Эх сурвалж /Улс төр судлаачийн судалгаанаас зөвшөөрөл авч нийтлэв./

Сонгогчид яагаад сонгуульд оролцдоггүй талаар товч судалгааг танилцуулъя.

Зураг-2.




Эх сурвалж: /АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээгдсэн “Монгол Улсын сонгууль 1992-2021” эмхэтгэл. 2023 он. УБ хот./.

<u>Цаашид анхаарах асуудал:</u>

-Сонгуулийн хороонд сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулах зохицуулалтын хүрээнд Орон нутгийн хурлын сонгуулийн үеэр уг сонгуулийг зохион байгуулах хороог шинэчлэн байгуулах.

-Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг чадавхжуулах, тэднийг нэгдсэн удирдлага мэдээллээр хангах, тэдэнд арга зүйн зөвлөм өгөх хараат бусаар ажиллах ёстойг анхааруулах. Сонгуулийн хорооны бүрэлдэхүүний ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх.

-Сонгуулийн төв байгууллага нь сонгуулийн үеэр сонгуулийн бүх шатны хороодын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах; аймаг, сум, Дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг шалган зааварлах гэх мэт чиг үүргээ шуурхай хэрэгжүүлж ажиллах Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан

Ардчилсан нийгмийн гол шинж нь болсон чөлөөт, шударга сонгуулийн зарчмыг хангах, иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэхэд чухал байгааг анхаарах.

-Нэг сонгогч олон дахин санал өгөх явдалд хяналт тавих боломжгүй байгаатай холбогдуулан сонгогч саналаа өгснийг илэрхийлэх аливаа тэмдэг, тэмдэглэгээ хийхийг хуульчлах. Энэ үзэгдэл хотын захын хүн ам олноор суурьшсан Баянзүрх /43 хороотой/ Сонгинохайрхан /43 хороотой/ гэх мэт томоохон дүүргүүдэд сонгогчдыг зохион байгуулалттайгаар зөөж санал өгүүлдэг тухай тухай яриа өнөөдрийг хүртэл байсаар байгааг анхаарах.

-Аймаг орон нутгийн хэмжээнд 2024 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг 2024.09.28-ны өдрөөс мөн оны 10.08-ны өдрийн хооронд буюу орон нутгийн хурлын сонгуулийн сурталчилгааны цаг үетэй давхцуулан зохион байгуулсан учир дутагдалтай байсан. Учир нь Цэрэг татлагын товчоог аймаг, нийслэлийн засаг даргын захирамжаар байгуулж бүрэлдэхүүнд нь цагдаагийн газрын алба хаагчид, нэгдсэн эмнэлгийн эмч, удирдлагууд зэрэг төрийн захиргааны албан хаагчдыг оруулдаг. Товчооны зүгээс цэрэг татлага нэрийн дор 18-25 насны эрэгтэйчүүдийг буюу санал өгөх насны залуучуудыг цуглуулж эмчийн үзлэгт хамруулах, хяналт, шалгалт хийх зэргээр 18-25 насны сонгуульд санал өгөх залуусын сонгуульд шууд ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргах үндсэн эрхэд нөлөөлөх бодитой нөхцөл үүссэн. Иймд Сонгуулийн үетэй давхцуулан цэрэг татлага гэх мэт ажлыг зохион байгуулахгүй байхад анхаарах.

-Орон нутгийн тэр тусмаа нийслэл, дүүргийн иргэдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хувьд нийгэм, олон нийтэд хэр танигдсан байх нь сонгуулийн үр дүнд нөлөөлж байна. Тодруулбал, өмнө нь сонгогдсон төлөөлөгч нь нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тойргийн сонгогчдодоо ажлын тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт, болон хуулиар хориглоогүй арга хэмжээг зохион байгуулж байгаа тэдэнд давуу тал болж байгаа тул энэ заалтыг хуулиас хасах.

-Орон нутгийн сонгуулийн ирц оролцоог нэмэгдүүлэх уг сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийн оновчтой зөв шийдлийг нэвтрүүлж хүний оролцоог багасгах.

-Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй орон нутгийн сонгуулийн хуульд сонгогчдын ирцийн босго байхгүй болохоор магадгүй сонгогчдын идэвх, оролцоо сул байж болох юм. Тиймээс үүнтэй холбоотой тусгайлан санал асуулга хийж судалгаа хийх.

-Орон нутгийн сонгуулийн үеэр гардаг өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх талаар хуульчид, хууль хэрэгжүүлэгч субъектүүдийн дунд тусгайлан хэлэлцүүлэг зохион байгуулах.

**Эх сурвалж:**


1. Ш.Цогтоо. Монгол Улсын Захиргааны эрх зүй. 2021 он. УБ хот.

2.Ж.Болдбаатар,

2. Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрхзүйн түүхэн уламжлал. 2021 он. УБ хот.

3. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/

4. Улс төрийн намын тухай хууль /2023 он/

4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2020/

5. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль /2020 он/

6. http://www.ubstat.mn/AimagNiislelCode.aspx Нийслэлийн статистикийн газар,

7. https://m-election.mn/wp/ajmag-nijslel-sum-duurgijn-irgedijn-toloologchdijn-hurlyn-eelzhit-songuulijn-zohion-bajguulaltyn-talaar-medeelel-hijlee/ Сонгуулийн Ерөнхий хороо,

8. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй "Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд бүтээгдсэн "Монгол Улсын сонгууль 1992-2021" эмхэтгэл. 2023 он. УБ хот.

9. Нэрээ нууцлахыг хүссэн судлаачийн судалгааны ажлаас /2024 он/

10. https://www.facebook.com/Ulsturch.mn/videos/384799334473406

# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ-ЗАСАГ ДАРГЫН ЭРХ МЭДЛИЙН ХАРИЛЦАА

М.Индрабүд

**Хураангуй.** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана. Сонгогдсон төлөөлөгчид нь иргэд, иргэний нийгмийн байгууллага, бизнесийн бүлгийн дуу хоолой болж, доороос гарч байгаа саналыг орон нутгийн шийдвэр, төлөвлөлт, төсөвт үр нөлөөтэй, шударгаар тусгах, төрийн үйлчилгээ, нутгийн захиргааны ажлын үр дүнгийн талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх замаар ил тод байдлыг хангах, иргэдийн өмнө хариуцан тайлагнахад чухал үүрэгтэй байна. Тиймээс Засаг дарга ба Хурлын харилцаа, эдгээрийн хоорондын хяналт-тэнцвэр, нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар санал зөвлөмж боловсруулахад оршино.
**ТҮЛХҮҮР ҮГ.** Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Төлөөлөгчид, Хурлын бүрэн эрх, Засаг даргын бүрэн эрх, Эрх мэдэл

## ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ" хэмээн заасан. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, хурлын тэргүүлэгчид, хурлын төлөөлөгч нь тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэх эрх бүхий субьект билээ. Тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг шийдвэрлэх бодлого, шийдвэр гарган ажиллаж буйн хувьд иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарч буй шийдвэрийн чанар чухал. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас чанартай, хэрэгжих боломжтой, бодитой

шийдвэр гаргахын тул иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нь иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж буй шийдвэрийн төсөлд дүн шинжилгээ хийх, санал боловсруулах мэдлэг чадвартай байх шаардлага тавигдаж байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нь иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж буй шийдвэрийн төсөлд дүн шинжилгээ хийх, үндэслэлтэй санал боловсруулахын тулд хэлэлцэгдэж буй шийдвэрийн төслийн төрлөөс шалтгаалан тухайн шийдвэрийн төсөлд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг холбогдох эрх зүйн болон бусад баримт бичгээс олж тодорхойлох бөгөөд нөгөө талдаа Засаг дарга ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын харилцаа, эдгээрийн хоорондын хяналт-тэнцвэрийг хангах асуудал чухал юм. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд зааснаар: “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна” хэмээн тодорхойлсон байдаг.

## ҮНДСЭН ХЭСЭГ

***Иргэдийн төлөөлөгчдийн хурал***

Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага мөн. Орон нутгийн сонгуулийн дүнгээр төлөөлөгчдийн дөрөвний гурваас доошгүй төлөөлөгч сонгогдож, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол гарсан бол тухайн Хурлыг бүрэн эрхээ

хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно. Хурлын бүрэн эрх нь дөрвөн жил байна.[1]

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь юм. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хамтын шийдвэр гаргадаг этгээд болохынхоо хувьд хуралдах нь түүний шийдвэрээ гаргах үндсэн арга бөгөөд нийт төлөөлөгчдийн олонх нь хуралдаанд оролцсоноор хүчин төгөлдөр болж шийдвэрээ гаргадаг байна. Анхдугаар хуралдааныг тухайн Хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь даргалах учиртай. Иргэдийн төлөөлөгчийн Анхдугаар хурлаар төлөөлөгч болон Иргэдийн төлөөлөгчийн хурлын даргаа сонгодог. Тус анхдугаар хуралдаанаар харьяа засаг даргыг нэр дэвшүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд зааснаар аймаг, нийслэл, сум, Монгол Улсын Үндсэн хууль ба бусад хуулийн дагуу авч үзвэл аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн зохион байгуулалтын 5 хэлбэрийг ашиглан явуулна. Эдгээр нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг иргэдийн эрх ашигт нийцсэн хэрэгжих үндэслэлтэй байлгахад чиглэсэн.

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо.* Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана. Хороо нь Хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрхлэх асуудлаараа иргэдийн санаа бодлыг судалж хэлэлцэх, дүгнэлт гаргах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэргээр Хурлын шийдвэрийг үндэслэлтэй, хэргэжих магадлалтай гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа эрхлэн явуулна.

Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно. Хороог байгуулахдаа анхаарах нэг зүйл нь иргэдийн төлөөлөгчдийн хурал нь бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож, тэр чиглэлээрээ хороод байгуулан ажиллах. Ингэснээр хороодын үйл ажиллагааны уялдаа сайжрах ба хороодын дунд хариуцан ажиллах асуудлын давхцал, хийдэгдэл гарахгүй байх магадлал нэмэгдэх юм. Зайлшгүй байх хороодод төсөв санхүүгийн, нутгийн

---

[1] М.Сандаг-очир "Нутгийн удирдлага" УБ.,2003 он

захиргааны асуудал эрхэлсэн хороодыг нэрлэж болох ба харин нийгмийн бодлогын болон хөдөө аж ахуйн бодлогын асуудлаар тус тус хэд хэдэн хороо байгуулж болох юм. Тухайлбал, тухайн Хурлын бүрэн эрхийн хугацаанд тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо нийгмийн халамжийн асуудлаар, эсвэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гэх мэтчилэн нийгмийн бодлогын тодорхой асуудлаар дагнасан хороо байгуулж ажиллуулж болно Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

*Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зохион байгуулалтын хэлбэр*




*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл.* Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий таваас долоо хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал батална.[2]

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба.* Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын албатай байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно. Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна. Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана. Ажлын албаны үндсэн чиг үүрэгт:

1. ИТХ-ын дарга, төлөөлөгчдийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах;
2. ИТХ-ын төсөв санхүүг захиран зарцуулах;

[2] Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. 2020 он

3. ИТХ-ын шийдвэрийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх,
4. Хууль эрх зүйн лавлагаа гаргах, нийгэм, эдийн засгийн тооцоо гаргах;
5. ИТХ-ын архив, албан хэргийг хөтлөн явуулах;
6. ИТХ-ын шийдвэрийг түгээх, сурталчлах, нийтэд мэдээлэх, хэрэгжилтийг тооцох ажлын зохион байгуулах;
7. ИТХ-ын нэрийн өмнөөс байгууллага, албан тушаалтан, ирээдүй харилцах, мэдээлэл гүйцээх, цуглуулах, боловсруулалт хийх;
8. ИТХ-д хуулиар ногдуулсан бусад үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;
9. Иргэдийн санаа бодлыг судлах ажлын зохион байгуулах, тэдгээрийг нэгтгэн боловсруулах, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ба төлөөлөгчдөд дүнг танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах ажлын зохион байгуулах зэрэг ажил хамаарна.

*Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч.* Улс төр, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг эрхэмлэн баримтлагч юм. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нь иргэдийнхээ санал хүсэлтийг судалж, хийж байгаа ажлаа тогтмол мэдээлдэг,хуулиа дээдэлдэг, ёс зүйтэй байх зэрэг наад захын ёс зүйтэй. Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог.

*Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн эрх хэмжээ:*

- Асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох
- Хурлын хороонд харьяалагдах
- Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асууж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах
- Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах
- Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, санал гаргах
- Хурлын шийдвэрийг сонгогчдодоо тайлбарлан таниулах;
- Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой

асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих;

- Сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах;
- Үйл ажиллагаагаа жилд нэг удаа сонгогчдод тайлагнах.
- Хурлын төлөөлөгч эрх, үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана.
- Хурлын төлөөлөгч нь хуралдааны чөлөөт цагт Хурлын хорооны үйл ажиллагаанд оролцож, төлөөлөгчийн хувьд хийсэн ажлынхаа талаарх мэдээллийг Хурлын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр сонгогчдод мэдээлнэ.

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох, эргүүлэн татах.* Тус төлөөлөгч нас барсан, хүндэтгэн үзэх шалтгаантай/өөрийн хүсэлтээр чөлөөлөх хүсэлт гаргасан/, тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоогдсон, тус орон нутгаас шилжсэн, ёс зүйн дүрмийг удаа дараа ноцтой зөрчсөн, төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон тохиолдолд бүрэн эрх нь дуусгавар болдог. Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эргүүлэн татна.

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл.* Төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах;

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хүлээлгэх хариуцлага.* Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, Хурлын дэг зөрчсөн, эсхүл үйл ажиллагаагаа хуульд заасны дагуу тайлагнаагүй бол, сануулах, хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах, санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах, асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурал батална. Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална. Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Улс төрийн нам, бусад байгууллага төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.[3]

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд:

- 36 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонх нь тухайн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж санал оруулсан бол Хурлын нийт төлөөлөгчийн гуравны хоёроос доошгүйн саналаар тухайн Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан бол;
- Анхдугаар хуралдааныг товлон зарласнаас хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдааныг хуралдуулж Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй, хуульд заасан хугацаанд төсвөө батлаагүй, түүнчлэн хуралдаан зарлаж товлосон хугацаанаас хойш хуралдахгүй 60-аас дээш хоног өнгөрсөн бол тухайн Хурлыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал оруулснаар Засгийн газар тараах шийдвэр гаргасан бол.
- Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд сонгуулийг 30 хоногийн дотор холбогдох хуульд заасны дагуу товлон зарлана.

40 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

Төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах;

---

[3] Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн манлайлал сургалтын гарын авлага. УБ.,2020 он




***Засаг дарга***

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулинд зааснаар Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч юм.

- Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ.
- Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

Засаг даргад нэр дэвшүүлэх ажиллагааг дараах журмаар явуулна:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэг, түүнчлэн иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч

энэ хуулийн 56.3, 56.4-т заасан шаардлага хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэхээр санал гаргана; /Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

- Тус хуулийн 56.5.1-д заасан хүний талаар санал хураалт явуулж, Хуралд оролцсон иргэдийн, түүнчлэн нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэх;
- Засаг даргын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

Засаг дарга харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах;
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
4. Төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;
6. Өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, нийслэлийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;
7. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах
8. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх;
9. Хууль тогтоомжид заасан журмын дагуу гадаад улсын зохих шатны нэгжтэй харилцаж, хамтран ажиллах;

10. Татварын албаны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
11. Засаг даргаас олгосон газар эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
12. Засаг даргын орлогч, тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;
13. Энэ хуульд заасан үндэслэлээр нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах;
14. Төрийн дээд шагналд тодорхойлох;
15. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

***Иргэдийн төлөөлөгчдийн хурал ба Засаг даргын хоорондын харилцаа.***

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аливаа төлөөллийн ардчиллын байгууллагуудын нэгэн адил шийдвэрийг нь хэрэгжүүлэх үүрэгтэй, өөрт нь ажлаа хариуцан тайлагнадаг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай байдаг нь нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга юм. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засаг даргын үйл ажиллагааг чиглүүлж, явц, үр дүнд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх үүргийг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн шатныхаа Засаг даргатай харилцах, хамтран ажиллах ёстой. Засаг дарга бол төр, засгийг төлөөлж, төрийн хууль тогтоомжийг сурталчилж хэрэгжүүлэхийн зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн хурлынхаа шийдвэрийг биелүүлж байх үүрэгтэй. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Засаг даргад нэр дэвшүүлэн, мөрийн хөтөлбөрийг нь батлан, биелэлт үр дүнг сонсож, үнэлгээ дүгнэлт өгнө. Засаг даргаас өргөн барьсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл Засаг даргыг огцруулах санал тавина. Гэвч энэхүү харилцааны асуудал нь тэр бүр хуулиар зохицуулахад хялбар биш, төвөгтэй, хувь хүмүүсийн харилцаа, боловсрол, хүмүүжил, ёс суртахууны түвшингээс хамааралдай нилээд эмзэг асуудал юм. Энэ нь харилцан тэнцүү эрх бүхий нутгийн удирдлагын хоёр субьектын харилцаа юм. Тэгэхээр Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нар санаа нэгдэн ажиллах, хуулиар олгосон чиг үүргээ туушгай хэрэгжүүлэх учиртай юм. Харин тус бүрийнхээ хуулиар заасан чиг үүргийн заагаас хальж, өдөр тутмын ажилд нь хөндлөнгөөс оролцох нь зохимжгүй. Үйл

ажиллагааны хүрээ, зорилго, мөрдөж хэрэгжүүлэх хууль, ажиллах обьект нь нэг учраас иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга хоёрын үйл ажиллагаа нэгдмэл байх ёстой. Гэхдээ хуулиар тус тусад нь олгосон чиг үүрэг бий.

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, тухайн нутаг дэвсгэрийн хэрэгжүүлэх чиглэлээр батлагдсан урт, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг зөрчөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд, иргэдийн санал, шүүмжлэлийн мөрөөр авч байгаа арга хэмжээний үр дүнг тухай бүр Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаараа авч хэлэлцэн, газар дээр нь үзэж танилцах ажлыг зохион байгуулна. Ийнхүү тогтоосон хэм хэмжээний хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Засаг даргын үйл ажиллагааг хянах үүргээ үндсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тайлан, сонсголыг хэлэлцэх;
- Ажлын хэсэг, комисс томилон ажиллуулан хяналт шалгалт явуулна.

Тайлан: тайлан бол Засаг даргын тодорхой хугацаанд гүйцэтгэсэн ажлын өөрийн үнэлгээ юм. Өөрөөр хэлбэл, энэ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэл юм. Тайланг жил бүр болон 4 жилээр зөвхөн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэнэ. Хуралдаанаас өмнө Төлөөлөгчид, хороо болон Намын бүлгүүд хэлэлцэн, санал дүгнэлтээ боловсруулна.

Сонсгол: Энэ нь нэг буюу хэд хэдэн үйлдэл эс үйлдлийн талаар бэлтгэсэн тайлбар, дүгнэлт юм. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэг эсвэл хэд хэдэн төлөөлөгчийн асуулгын хариу болон ѝодорхой үйлдэл эс үйлдлийнхээ талаар ИТХ-д сонсгох нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд оруулж буй мэдээлэл гэсэн хоёр хэлбэртэй ѓайдаã. Энэхүү асуудлаар Иргэдийн төлөөлөгчдийн хурал заавал тогтоол гаргах албагүй бөгөөд тогтоол гаргах эсэхийг хуралдааны дэгийн дауу санал хураaж шийдвэрлэнэ.

| Иргэдийн төлөөлөгчдийн хурал ба Засаг даргын хоорондын харилцаа | |
|---|---|
| *Иргэдийн төлөөлөгчдийн хурал* | *Засаг дарга* |
| 1. Засаг даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах талаар санал гаргана.<br>2. Засаг даргын тайлан сонсголыг хэлэлцэн, үйл ажиллагааг үнэлнэ. | 1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас үүрэг даалгавар өгнө. Заавал биелүүлэх үүрэгтэй.<br>2. Иргэдийн төлөөлөгчдийн хуралд асуудал санаачлан оруулж хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна. |

# СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2016 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хуралд нийт 8099 төлөөлөгч сонгогдон ажиллаж байсны дотор эмэгтэй төлөөлөгчид 26.7, дээд боловсролтой 62.5, анх удаа сонгогдсон төлөөлөгч 57.2, 35 хүртэлх насны залуучууд 28.9 хувийг эзэлж байна.[4]

| Төлөөлөгчдийн эзлэх хувь | Аймаг | Сум | Нийслэл | Дүүрэг | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Төлөөлөгчдийн тоо | 762 | 7001 | 45 | 291 | 8099 |
| Анх удаа сонгогдсон төлөөлөгчдийн эзлэх хувь | 60.1 | 56.6 | 64.4 | 61.8 | 57.2 |
| Дээд боловсролтой төлөөлөгчдийн эзлэх хувь | 97.5 | 57.0 | 100 | 97.9 | 62.5 |
| Эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 15.7 | 27.9 | 22.2 | 28.2 | 26.7 |
| 35 хүртэл насны залуучуудын эзлэх хувь | 18.8 | 29.6 | 20 | 35.4 | 28.9 |
| Тэргүүлэгчдийн тоо | 219 | 2232 | 9 | 63 | 2523 |

*Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2019 он*

Жендэрийн үндэсний хороо 2020 оноос эхлэн Үндэсний статисикийн хорооноос баталсан маягт, зааврийн дагуу "Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ"-г нэгтгэн гаргадаг болсон ба 2023 оны мэдээгээр нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн 16.3% нь эмэгтэй, 83.7% нь эрэгтэй, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн 29.2% нь эмэгтэй, 70.8% нь эрэгтэй төлөөлөгч сонгогдсон байдаг.

2024 оны аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулиар нийслэлд 45 төлөөлөгч сонгогдсон. Үүнээс:

- Анх удаа сонгогдсон-27
- Хоёр дахь удаагаа-13
- Гурав дахь удаагаа-14

[4] Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ. УБ.,2019 он

- Дөрөв дэх удаагаа сонгогдсон-1 төлөөлөгч байв.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн дундаж нас 40.8, бөгөөд 10 нь буюу 22.8% нь эмэгтэйчүүд сонгогдсон. Улсын хэмжээнд сонгогдсон төлөөлөгчдийн 28.1% нь эмэгтэй, 71.9%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

2024 оны сонгуулийн үр дүнг өмнөх оны мэдээтэй харьцуулахад аймаг, нийслэлийн түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл 11.2%-иар нэмэгдэж, сум, дүүргийн түвшинд 1.1%-иар буурсан гэсэн мэдээ гарсан байдаг.

*Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарын хүйсийн байдал*







| № | Нас | 2022 он | 2023 он | Нас | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /Эрэгтэй/ | | | | Ирэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /Эрэгтэй/ | | |
| 1 | 18-24 | 0 | 0 | Эрэгтэй | 5218 | 5193 |
| 2 | 25-34 | 53 | 46 | 18-24 | 21 | 6 |
| 3 | 35-44 | 105 | 112 | 25-34 | 1006 | 874 |
| 4 | 45-54 | 99 | 93 | 35-44 | 1933 | 1966 |
| 5 | 55, түүнээс дээш | 33 | 38 | 45-54 | 1641 | 1650 |
| Нийт | | 290 | 289 | 55, түүнээс дээш | 617 | 697 |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /Эмэгтэй/ | | | | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /Эмэгтэй/ | | |
| 1 | 18-24 | 0 | 0 | Эмэгтэй | 2089 | 2081 |
| 2 | 25-34 | 2 | 1 | 18-24 | 1 | 0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | 35-44 | 10 | 11 | 25-34 | 234 | 190 |
| 4 | 45-54 | 31 | 28 | 35-44 | 695 | 679 |
| 5 | 55, түүнээс дээш | 6 | 10 | 45-54 | 808 | 807 |
| Нийт | | 49 | 50 | 55, түүнээс дээш | 351 | 405 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

*Засаг дарга, Засаг даргын орлогч нарын хүйсийн байдал*

| № | Албан тушаал | Хүйс | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Засаг дарга /аймаг, нийслэл/ | Эрэгтэй | 0 | 0 | 0 | 0 |
| | | Эмэгтэй | 22 | 22 | 21 | 20 |
| Нийт | | | 22 | 22 | 21 | 20 |
| 2 | Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/ | Эрэгтэй | 34 | 34 | 23 | 20 |
| | | Эмэгтэй | 8 | 8 | 5 | 4 |
| Нийт | | | 42 | 42 | 28 | 24 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

*Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөлгчид, Засаг дарга гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын чиг үүрэг*

| Бодлогын чиглэл | ИТХ-ын төлөөлөгчид | Хамтарсан чиг үүрэг | ИТХ-ын ажлын алба | Засаг дарга /ЗДТГ/ |
|---|---|---|---|---|
| Хүрээлэн буй орчны бохирдол Хог хаягдлын менежмент | Асуудал дэвшүүлэх Хуралд санал оруулах Лоббидох Шийдвэр гаргах Сурталчлах Хяналт тавих Үр дүнг тооцож үнэлэх | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах Хэлэлцүүлэг зохион байгуулж оролцох Хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг нэгтгэж боловсруулах гарсан | Мэдээлэл цуглуулах Мэдээллийн боловсруулалтыг хурлын хороогоор хэлэлцүүлэх Эрх зүйн туслалцаа үзүүлэх Хуралдаанд бэлтгэх Шийдвэрийн төслийг | Саналыг судалж, шаардлагатай тооцоо судалгаа, мэдээллийг боловсруулах Мэргэжлийн байгууллагаар санал, дүгнэлт гаргуулах Шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шийдвэрийн биелэлтэд хяналт тавих | боловсруулах | ажиллах Байгууллагын өмчид бүртгэж, эзэнтэй болгох Хувьсах зардлын асуудлыг хариуцах |

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Нутгийн удирдлагын хослуулах загвар нь шийдвэр гаргах, гүйцэтгэх байгууллагын хооронд хяналт-тэнцвэр хэрхэн бий болгож байгааг дүгнэвэл, Хуралд Засаг даргын мөрийн хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэнд нь үнэлэлт өгөх, орон нутгийн төсөв батлахаас эхлээд, орон нутгийн өмч хөрөнгөтэй холбоотой бүх шийдвэрийг гаргах, Засаг даргыг огцруулах хүртэл гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих хангалттай эрх байна. Харин Засаг дарга Хурлын шийдвэрт хориг тавих тавих эрхтэй боловч уг хоригийг хүлээн авахгүй байх эрх Хуралд хадгалагддаг. Засаг даргыг огцруулах эрхийг Хуралд олгосон хэрнээ Хурлыг тараах шийдвэрийг Хурал зөвхөн өөрөө гаргадаг нь нэг талын урсгалт харилцаа гэж дүгнэж болно. Нөгөө талаас, орон нутгийн шийдвэр гаргахад төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй, төвөөс томилогдсон Засаг дарга ихээхэн нөлөөтэй байдаг. Энэ тогтолцоонд Хурлын үүрэг, үр нөлөө нь төдийлөн хангалтгүй байна.

Хослуулах зарчмын нэг чухал элемент болох нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд төв засгаас тавих хяналт, шалгалт, үзүүлэх тусламж дэмжлэг хуулийн зохицуулалтын талаасаа ч практик талаасаа ч хангалтүй байна. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн нутгийн удирдлагын байгууллага шийдвэрлэсэн асуудлыг төв засгийн зүгээс хуульд нийцсэн байдлаар залруулах боломжгүй буюу засгийн газрын зүгээс нэгдмэл улсын ашиг сонирхлын үүднээс шийдвэр гаргахад бэрхшээл учрах болсон. Нөгөө талаас, нутгийн өөрөө удирдах байгууллагад Засгийн газраас үзүүлж байгаа дэмжлэг, туслалцаа хангалтгүй байна.

Хурлын бүрэн эрх нь харьцангуй цөөн, ерөнхий, ихэнхдээ тодорхой асуудлаар тухайн шатны нутаг дэвсгэрийн бодлогыг тодорхойлох, түүнийхээ хэрэгжилтэнд хяналт тавих гэсэн тунхагийн шинжтэй бол Засаг даргын бүрэн эрх нь дэлгэрэнгүй, гэхдээ тодорхой эрх, үүргийг хэрхэн яаж хэрэгжүүлэх нь тэр болгон тодорхой бус, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизм дутагдалтай, агуулгын хувьд бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг илүү хүлээсэн шинжтэй байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод үйл ажиллагаа нь зорилго, чиг үүргээ хэрхэн амжилттай биелүүлж байна, ямар өөрчлөлтүүд гарч байгааг үзүүлэлтүүдэд тулгуурлан хэмжиж болно. Үүнд: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн чанар, нийгэм эдийн засгийн үр нөлөө, ил тод нээлттэй байдал, засаг дарга болон Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж буй байдал, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн сургалт, хөтөлбөр, иргэдийг мэдээллээр хангах, нийтийн сонсгол зохион байгуулах, иргэдийн оролцоо, санал санаачлагыг дэмжсэн байдал зэрэгт шалгуур үзүүлэлтийн өөрчлөлтийг шинжлэх нь чухал юм. Иймд энэхүү дүгнэлтэнд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

***Санал***

1. Олон улсын жишигт нийцүүлэн /Жишээ нь: Финлянд, Литва, Португаль, Испани/ төв ба орон нутгийн хамтын ажиллагааны зарчмыг баримтлах
2. Хурал болон Засаг дарга нарыг чадавхижуулахад засаг захиргааны байгууллагууд шийдвэр боловсруулж ажиллах
3. Хурал болон Засаг даргын хүлээх эрх, үүрэг хариуцлагыг тэнцвэртэй болгох
4. Засгийн газраас нутгийн удирдлагын байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах менежментийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

## НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль.1992 он
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. 2020 он

3. Р.Драго “Административная наука” М.,1982 год
4. М.Сандаг-очир “Нутгийн удирдлага” УБ.,2003 он
5. Н.Э.Шишкина “Местное управление в зарубежных странах” .,Иркутск,1995 год
6. А.Токвиль.Демократия в Америке.УБ.,1989 он
7. С.Төмөр.Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй . УБ.,2004 он
8. Ё.Мюллер.ХБНГУ-ын захиргааны тухай товч тойм . Берлин.,1996 он
9. Ш.Цогтоо.Засаг захиргаа. УБ.,2007 он
10. Д.Дондог,О.Тунгалаг.Нутгийн удирдлагын шинэчлэл. УБ.,2007 он
11. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн манлайлал сургалтын гарын авлага. УБ.,2020 он
12. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд хийсэн дүн шинжилгээ. УБ.,2019 он
13. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хяналт-шинжилгээ үнэлгээ сургалтын гарын авлага. УБ.,2018 он

# ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СУУРИЛСАН ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ БА ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ХАМААРАЛ

Т.Ариунболд, Б.Чимэдлхам, Д.Цэцэнбилэг

**Удиртгал:**

Төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран аливаа тусгаар улсад Төв, Орон нутаг гэсэн ойлголт байдаг бөгөөд газар нутаг хүн ардаа удирдан зохион байгуулахдаа засаг захиргааны нэгжид хуваан авч үздэг.

Нөгөө талаас тусгаар улс нь газар нутаг засаг захиргааны нэгжээс бүрддэг.

-Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

-Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгж/аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо буюу орон нутаг/ -д хуваагдана (хууль М.-ы. Ү., 1992)

Иймээс манай улсад нутаг дэвсгэрийн нэгж буюу орон нутгийн удирдлагыг

-Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

-Нутгийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлдэг байна. (Б.Чимид, 2002)

Нутгийн өөрөө удирдах ёс буюу нутгийн удирдлага хэмээх ойлголт нь “орон нутаг хэмээх ойлголттой нягт уялдаатай бөгөөд орон нутаг гэдэг нь улс орны удирдлага Засаг захиргааны удирдлагын шатлалтай холбоотой юм. “Орон нутаг” бол газарзүйн байршлыг бус эрх мэдэл, эрх хэмжээний хүрээ хязгаарыг илэрхийлдэг төр-хууль зүйн тухайлсан нэр томьёо юм. Тухайлбал улсын хэмжээнд ажиллах эрх хэмжээтэй байгууллагыг “Төв байгууллага” харин аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгждэг, түүнээс хальж гарах ёсгүй эрх хэмжээтэй байгууллагыг “орон нутгийн” гэж ангилдаг. Энэ нь хотод ч байдаг.

-Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар гэж хэлж болох юм. Энэ нь:

**А/** Иргэдийн Төлөөллийн байгууллага

-Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

**Б/** Өөрийн удирдлагын байгууллага

-Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал юм.

Манай улсын хувьд нутгийн өөрөө удирдах ёсны зарчим анх албан ёсоор хуульчлагдсан хэлбэрээр бус ч зан заншлын хэлбэрээр эрт үеэс хөдөө орон нутагт үйлчилж байсан гэж үзэх үндэстэй. Энэ нь эхэн үедээ цусан болон ураг төрлийн харилцаанд цаашдаа шашин, зан заншил, орон нутгийн аж ахуй эрхлэх буюу хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах зэргээр соёл, уламжлал, аж ахуйн нийлээд өргөн нийтлэгт тулгуурласан нэгэн нутаг усны хүмүүс хамтын зохион байгуулалтад орж өөрсдийн эрх ашигт нийцүүлэн, өөрсдийн хүчээр үйл хэргээ явуулах зайлшгүй шаардлагаар нөхцөлдөж шууд утгаараа “ Өөрөө удирдах ёс” буюу иргэдийн оролцоо хэрэгжиж байжээ.

## 1. Иргэдийн оролцоо

Иргэдийн оролцоо тэр тусмаа нийтийн үйл хэрэгт оролцох оролцооны асуудал нь эртний Грек, Ромын ардчилалалаас эхтэй бөгөөд аливаа шийдвэрийг олонхийн эрх ашигт нийцүүлэх үндсэн арга хэлбэр гэж хэлж болох юм. Судлаач Стив Мартин “Иргэд болон сонирхогч бусад талын оролцоог хангах нь” бүтээлдээ иргэдийн оролцооны ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлжээ. (Г.Чулуунбаатар, 2021)

1. Мэдээллийн өргөн эх сурвалж, асуудлыг шийдэх олон хувилбаруудаас ашиглах боломжыг засгийн газарт олгож бодлого боловсруулах явцыг чанартай болгох

2. Төр иргэдийн хоорондын харилцаа холбоог хөнгөвчлөх

3. Хариуцлага, шилэн байдлыг нэмэгдүүлэх

4. Төлөөллийн зарчим олон нийтийн итгэлийг бэхжүүлэх хэмээгээд оролцооны хүрээг:

-Мэдээллэх

-Зөвлөлдөх

-Хамтран бүтээх гэсэн бүрдэл хэсгээр тодорхойлжээ.

**2. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага иргэдийн оролцооны байгууллага болох нь.**

-Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар гэж хэлж болох юм.

**А/** Иргэдийн Төлөөллийн байгууллага

-Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

Б/ Өөрийн удирдлагын байгууллага

-Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал.

Өөрөөр хэлбэл бүх шатны хурлын байгууллага нь иргэдийн оролцооны байгууллага болж байгаа ба үүнээс баг, хорооны иргэдийн нийтийн хурал нь иргэдийн шууд оролцооны байгууллага болж байна.

**3. Иргэдийн оролцоонд суурилсан орон нутгийн шийдвэр гаргалт**

Нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь бодлогын шийдвэр гаргагчийн хувьд судалгаанд үндэслэн, иргэдийн нэгдмэл санааг тусган, төлөвлөгөөний дагуу хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах үүрэг хүлээдэг. Үүний тулд иргэдийнхээ өмнө үйл ажиллагаагаа ил тод явуулдаг, хариуцан тайлагнадаг байх явдал чухал юм. Ингэснээр иргэдийн тусын тулд хамгийн ашигтай, хамгийн эрх тэгш шийдвэр гаргах боломжтой. Үүнийг холбогдох хуулиудад дараах байдлаар зохицуулж өгчээ.

-Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ (хууль, 1992).

-Иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. (хууль, 16.9, 1992)

- "Нутгийн өөрийн удирдлага" гэж иргэд шууд, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ (хууль М. У., 2020)

-Иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шууд

болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй. (хууль М. У., 2020)

-Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй. (хууль М. У., 2020)

-Сум, баг, дүүрэг, хорооны тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй. (хууль М. У., 2020)

-Энэ хуулийн 31.1-д заасны дагуу гаргасан санал, зөвлөмжийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэх үүрэгтэй. (хууль М. У., 2020)

-Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй. (хууль М. У., 2020)

Дээр дурьдагдсан эрх хэмжээний хүрээнд иргэд орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явц болон төрийн үйлчилгээг сайжруулахад оролцох дараах нийтлэг хэлбэрүүд байна.

**Оролцооны хэлбэрүүд**

➢ Олон нийтийн цуглаан, хэлэлцүүлэгт оролцох:

- Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2014 онд Монгол Улсын бүх сум, дүүргүүдэд Иргэний танхим байгуулах тухай зөвлөмж өгсөн. Иргэний танхим нь ихэвчлэн тухайн сум, дүүргийнхээ төв хэсэгт байрладаг, иргэд цуглан уулзаж, асуудлаа хэлэлцдэг газар бөгөөд зарим үед Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурлуудыг энд зохион байгуулдаг. Түүнчлэн орон нутгийн засаг захиргаа нь сум, орон нутагтаа тулгамдаж буй асуудлаар иргэдийнхээ дунд хэлэлцүүлэг зохион байгуулдаг болсон.

➢ Судалгаанд оролцох:

- 2013 оноос мөрдөгдөж эхэлсэн Төсвийн тухай хуульд бүх өрх, оршин суугаа орон нутагтаа нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төслүүдийн судалгаанд оролцож, саналаа өгөх эрхтэй болсон. Энэ судалгааны маягтыг жил бүрийн хавар буюу 3-5 дугаар сарын хооронд баг, хорооны Засаг дарга нар айл өрхүүдэд тараадаг. Харин иргэн судалгааны маягтыг бөглөж, сум, хорооны захиргаанд буцааж өгөх хэрэгтэй. Иргэдийн санал шийдвэр гаргах түвшинд хүрсэн эсэхийг тухайн иргэн өөрөө нягтлах боломжтой. ОНХС-ийн хөрөнгийг юунд зарцуулах тухай шийдвэр гаргахад иргэдийн өгсөн санал чухал ач холбогдолтой. Үүнээс гадна жил бүрийн 6-7 дугаар саруудын аль нэгэнд баг, хороонд болдог ОНХС-ийн төсөлд санал авах хэлэлцүүлэгийг зохион байгуулдаг.

➢ Худалдан авах үйл ажиллагаанд оролцох:

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төслүүдийг иргэд өөрсдөө бүлэг зохион байгуулан хэрэгжүүлж, гүйцэтгэх боломжтой. Нийт төсөвт өртөг нь 20 сая төгрөгөөс бага хэмжээтэй төслүүдийн хувьд сум, дүүргийн Засаг дарга иргэдийн бүлгүүдтэй шууд гэрээ байгуулж болдог. ОНХС ба төрийн худалдан авах үйл ажиллагааны талаар судлах нь зүйтэй. Түүнчлэн хэсэг иргэд хамтран хоршоолол, аж ахуйн нэгж байгуулахыг хүсвэл энэ талаар баг, хороонызхоо Засаг даргад хандан, шаардлагатай дэмжлэг авч болно.

**-Зарим орон нутгийн ИТХ-аас иргэдийн оролцоог хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил 2020-2023 он**

**Багахангай дүүрэг ИТХ:**

**2020 он:** X

**2021 он:** 57 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 3 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

**2022 он:** 44 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 3 заалтад уулзалт, сургалт зохион байгуулах, **төсвийн хяналтад иргэдийг оролцуулахаар** төлөвлөж тайлагнасан

**2023 он:** 56 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 2 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

**Багануур дүүрэг ИТХ:**

**2020 он:** X

**2021 он:** X

**2022 он:** 42 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 8 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах, хяналт хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах гэх мэт арга хэмжээ төлөвлөж тайлагнасан:

**2023 он:** 43 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 4 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах, хяналт хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах гэх мэт арга хэмжээ төлөвлөж тайлагнасан

**Баянзүрх дүүрэг ИТХ**

**2020 он:** X

**2021 он:** 11 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 5 заалтад сурталчлах, түгээх, соён гэгээрүүлэх арга хэмжээ төлөвлөж тайлагнасан

**2022 он:** X

**2023 он:** 33 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 5 заалтад сурталчлах, түгээх арга хэмжээ төлөвлөж тайлагнасан

**Налайх дүүрэг ИТХ**

**2020 он:** 15 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 4 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

**2021 он:** X

**2022 он:** X

**2023 он:** X

**Сүхбаатар дүүрэг ИТХ**

**2020 он:** 51 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 4 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

**2021 он:** X

**2022 он:** X

**2023 он:** X

**Чингэлтэй дүүрэг ИТХ**

**2020 он:** X

**2021 он:** X

**2022 он:** X

**2023 он:** X

**Нийслэлийн ИТХ**

**2020 он:** X

**2021 он:** X

**2022 он:** Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд хэлэлцүүлэг, нээлттэй сонсгол зэрэг ажил зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан
**2023 он:** Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд хэлэлцүүлэг, нээлттэй сонсгол зэрэг ажил зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

**Нийслэлийн төсвийн төсөлд иргэдийн саналыг тусгасан байдал**

**Хүснэгт: 1**

| Огноо | Оролцсон иргэд | Ирсэн санал | Шаардагдах хөрөнгө |
|---|---|---|---|
| 2023 | 300 | 455 | 112632,2 сая |
| 2024 | 230 | 637 | 947,9 тэрбум |

(НЗДТГ, 2022, 2023)

Дээрх тайлангуудаас харахад нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах асуудал хангалтгүй байгаа бөгөөд

Оролцооны байдал нь МЭДЭЭЛЭХ түвшинд түлхүү зарим тохиолдолд ЗӨВЛӨЛДӨХ төдий байгаа бөгөөд ХАМТРАН БҮТЭЭХ оролцоо огт хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байгаа бөгөөд Төрийн удирдлагын болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын зүгээс иргэдийг мэдээллээр хангасан ажлаа оролцоог хангасан гэж тайлагнасаар байна. Иймээс шийдвэрлэвэл зохих тодорхой асуудлууд үүсчээ

## 4. Иргэдийн оролцоо ба орон нутгийн сонгууль

Манай улсын хувьд 1924 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд Улсын их, бага хурал, ба нутгийн хурлуудад төлөөлөгчийг сонгох бөгөөд сонгогдох эрхийг

1. Тус улсын харъяат 18 нас хүрсэн өөрийн хүчийг үнэлэх буюу хувийн ажил хийж амьдрагчид
2. Ардын хувьсгалт цэрэг эдлэхээр (Бүгд найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, 1924) зааснаар иргэд улс орны удирдлагад оролцох оролцоог хуулийн хүрээнд/нэр төдий хэдий ч/ хүлээн зөвшөөрчээ.

Улмаар 1992 онд 4 дэх шинэ Үндсэн хууль батлагдсанаар Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмаар хэрэгжүүлэх болж (хууль М.-ы. Ү., 1992) ИТХ-ын сонгуулийг 4 жил тутам зохион байгуулах болсон. Энэ үеэс хуулийн хүрээнд иргэдийн

оролцооны эрхийг бүрэн хүлээн зөвшөөрөх болсон гэж үзэж болох юм. Тухайлбал:

-Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ (хууль, 1992).

-Иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. (хууль, 16.9, 1992)

1992 оноос хойшхи 8 удаагийн чөлөөт ардчилсан сонгууль болсон ба иргэдийн оролцоо ямар хэмжээнд байсныг санал өгсөн сонгогчдын ирцийн мэдээнээс харж болох бөгөөд дараах байдалтай байна.

2012 он 52,9 %

2016 он 60.4 %

2020 он 55,9 %

2024 он 53.1 %

**2024 оны Аймаг,Нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд иргэд оролцсон байдал**

| 2024-10-11 20:00: | 53.1% |
|---|---|

1,119,881 / 2,107,290

| Эрэгтэй 50.2%<br>502,513 / 1,000,637 | Нас | Эмэгтэй 56.0%<br>617,368 / 1,101,951 |
|---|---|---|
| 35.7% | 18-19 | 33.1% |
| 31.2% | 20-24 | 31.3% |
| 35.4% | 25-29 | 39.9% |
| 42.2% | 30-34 | 49.0% |
| 47.0% | 35-39 | 54.8% |
| 52.3% | 40-44 | 60.2% |
| 56.5% | 45-49 | 63.6% |
| 60.0% | 50-54 | 65.4% |
| 63.9% | 55-59 | 67.5% |
| 69.1% | 60-64 | 71.4% |
| 74.7% | 65-69 | 74.8% |
| 76.9% | 70+ | 71.3% |

| Дүүрэг | | |
|---|---|---|
| Дүүрэг | Саналаа өгсөн | Хувь |
| Багахангай | 2,057 | 73% |
| Налайх | 13,356 | 53% |
| Багануур | 9,450 | 51.2% |
| Сүхбаатар | 41,212 | 44% |
| Баянгол | 64,082 | 42.7% |
| Хан-Уул | 69,809 | 42.3% |
| Сонгино хайрхан | 85,051 | 41.6% |
| Баянзүрх | 102,879 | 40.7% |
| Чингэлтэй | 37,385 | 40.4% |

| Аймаг | | |
|---|---|---|
| Нэр | Саналаа өгсөн | Хувь |
| Баян-Өлгий | 48,722 | 76.3% |
| Сүхбаатар | 29,725 | 72.8% |
| Завхан | 33,005 | 71.8% |
| Говьсүмбэр | 7,420 | 70.1% |
| Ховд | 37,732 | 69.2% |
| Говь-Алтай | 25,062 | 68.4% |
| Архангай | 39,787 | 67.2% |
| Увс | 35,093 | 67.1% |
| Баянхонгор | 36,826 | 66.7% |
| Дундговь | 19,505 | 66.2% |
| Өмнөговь | 31,591 | 66% |
| Төв | 38,776 | 64.3% |
| Булган | 25,222 | 64.2% |
| Хэнтий | 31,197 | 62.3% |
| Сэлэнгэ | 40,972 | 60.4% |
| Өвөрхангай | 43,625 | 59.7% |
| Дорнод | 30,426 | 59.5% |
| Хөвсгөл | 51,056 | 59.2% |
| Дорноговь | 25,549 | 57.8% |
| Орхон | 33,031 | 48.7% |
| Дархан-Уул | 30,277 | 46% |
| Улаанбаатар | 425,282 | 42.3% |

Нийслэлийн нийт сонгогч: 1.100.437 (icon.mn, 2024)

## 5.Тулгарч буй бэрхшээл

### 5.1 Иргэдийн шууд оролцооны хувьд:

5.1.1 Өмнөх жилүүдэд иргэд харьяа баг, хорооны Иргэний танхимын ажилтанд хандаж, иргэний танхимдаа хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжөө орон нутгийн засаг захиргааны сонорт хүргэх боломжтой байдаг байсан.

Иргэний танхимын ажилтан байснаар ИНХ-ын бэлтгэл ажил, ИНХ-ын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, архив, бичиг хэргийн ажлууд эмх цэгцтэй, нэг журамд орж байсан юм. 2021 оноос ИТХ-ын Ажлын алба хороодын иргэний танхимын ажилтны орон тоог хасаж жигдэрч байсан ажил зогссон байна.

5.1.2 ЗЗНДНТУТХ-д нэмэлт өөрчлөлт орж Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал /32 дугаар зүйл/ заалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөн ажиллаж байна. Одоог хүртэл Иргэдийн нийтийн хурал хуралдааагүй хуралдсан ч зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын асуудал хэлэлцсэн үүрэг гүйцэтгэгч Засаг даргатай хороод цөөнгүй байна. Энэ нь иргэдийн шууд оролцоог хаагдуулж байна.

5.1.3 2020 оны хууль батлагдсанаар өмнө байсан ИНХ-ын Тэргүүлэгчид, ИНХ-ын дарга хэмээх статус байхгүй болсон нь иргэдэд тэр бүү хэл зарим хороодын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч нар ч ИНХ гэж байхгүй болсон гэж ойлгоход хүргэжээ

### 5.2 Иргэдийн төлөөллийн оролцооны хувьд:

5.2.1 Төлөөллийн оролцоо нь Төлөөлөгчөө сонгохоос эхэлдэг. 2024 оны орон нутгийн сонгуульд иргэд саналаа өгсөн байдлыг харахад 3 аймаг, нийслэл, нийслэлийн 6 дүүрэгт сонгогчийн ирц 50% хүрээгүй байгаа бөгөөд сонгуулийн үр дүнд иргэдийн цөөнхийн төлөөлөл олонхийн өмнөөс шийдвэр гаргах болсон нь ардчилалын үндсэн зарчмыг гажуудуулж байна. Тэр тусмаа хүн амын талаас илүү хувь оршин суудаг нийслэлийн ИТХ-д төлөөлөлгүй үлдсэн улс төрийн хүчний төлөөллийн бухимдлыг төрүүлээд байна. Тухайлбал:

*-ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга П. Ганзориг-*

*400 орчим хүн нэр дэвшүүлж 310000 орчим хүний санал авсан. Нийслэлд суудлын 90 орчим хувийн санал авсан МАН нийт сонгогчдын 50 хувийн санал*

*авсан. Ирц 42 хувьтай ахин 3 хувиар буурсан бол МАН дангаар сонгогдох байсан. Энэ бол Мажоритар тогтолцооны гажиг.*
*-ХҮН намын нийслэлийн намын хорооны дарга Э.Золзаяа-*
*Саналын 51 орчим хувийг МАН, 34 орчим хувийг АН 15 орчим хувийг ХҮН авсан. Бид сонгуульд шударгаар өрсөлдөх зарчмаар оролцож түүндээ тохирсон саналаа авлаа* гэж мэдэгджээ.

**6. Санал дүгнэлт**

**1. Иргэдийн шууд оролцооны хувьд**

Шинэчлэн батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 54.2-т ИТХ-ын Ажлын албаны бүтэц орон тооны хязгаарыг Монгол Улсын Засгийн газраас тогтоож өгөхөөр тусгаж Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор баталгаажуулснаар хурлууд бүрэн эрхийн хүрээнд шинэ бүтэц хийхдээ хороо бүр дээр байсан Иргэний танхим хариуцсан ажилтанаа ЗДТГ-т шилжүүлсэнээр иргэний оролцоог хангах асуудалд цалгар хандах болсон байна,

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулахаар хуульчилсан ч тодорхой хугацаа заагаагүй нь үүрэг гүйцэтгэгч хорооны Засаг даргын хувьд ИНХ хуралдуулахгүй байх нь бүрэн эрхээ хадгалж үлдэх нэг боломж учраас энэ асуудалд цалгар хандаж байна.

Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлтэй байх болж энэ нь иргэдийн төлөөллөөс гадна баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч нараас бүрдэх бөгөөд гагцхүү иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дараагийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах үүрэг хүлээжээ. Зөвлөлийн хурлыг Хуралдааны дарга тэргүүлэхээр зохицуулсан ч зарим хороонд Хорооны Засаг даргаа Зөвлөлийн даргаар сонгосон тохиолдол байна

Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлэхээр зохицуулсан ч иргэд энэ эрхийн талаар ойлголтгүй байна.

Иймээс:

1.ИНХ-ын хурлын анхдугаар хуралдааныг сум, дүүргийн ИТХ-аас зарлан хуралдуулдаг зохицуулалт хийх

2.ИНХ-ын анхдугаар хуралдаан зарлах хугацааг тогтоож өгөх

3.Иргэдийн оролцоог хангах ажлыг ИТХ-ын чиг үүрэгт тусгаж өгөх /одоогийн мөрдөгдөж буй хуульд зарчим хэлбэрээр байгаа (хууль М. У., 2020)/ шаардлагатай байна.

**2. Орон нутгийн сонгууль, иргэдийн төлөөллийн оролцооны хувьд**

2020 онд батлагдсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай" хуулийн 4.8-д "Орон нутгийн Хурлын сонгууль олонхын /мажоритар/ тогтолцоотой байна" гэж заажээ. Сонгуулийн мажоритар тогтолцоо бол энгийн олонх буюу 50+ хувийн зарчим юм. Гэтэл орон нутгийн ИТХ-ын сонгуулийн дахин санал хураалтыг зөвхөн "нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцсэн тохиолдолд" явуулна гэж хуульд оруулсан байна. Мөн хуулийн 4.9.1-д "нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцсэн тохиолдолд нэмэлт санал хураалт" явуулна гэжээ.

"Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай" хуулийн 73.1-д "Тухайн шатны сонгуулийн хороо санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана" гэжээ. Ингээд мөн хуулийн 73.2-д "Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно" гэж тусгажээ.

2024 оны орон нутгийн сонгуульд иргэд саналаа өгсөн байдлыг харахад 3 аймаг, нийслэл, нийслэлийн 6 дүүрэгт сонгогчийн ирц 50% хүрээгүй байгаа бөгөөд Нийслэлийн хувьд 2020 онд 47 % байсан ирц 2024 онд 42% болж 7 % буурчээ. Түүх сөхөн үзвэл 2008 онд нийслэлийн ИТХ-ын сонгууль 47% ирцтэй буюу ирцийн босго даваагүй учир дахин зохион байгуулагдаж байжээ.

Орон нутгийн ИТХ-ын сонгуульд "ирцийн босго" байхгүй болсноор нэг талаас холбогдох төрийн байгууллагууд ч иргэдийн сонгуулийн оролцоо, идэвхэд анхаарахгүй болсон нөгөө талаас энэ нь эрх баригчдын зүгээс өөрсөддөө давуу байдал бий болгох хуулийн цоорхой гэж харагдаж байна. Тухайлбал:

1.2024 оны орон нутгийн сонгуулийг яагаад Баасан гаригт зохион байгуулахаар шийдвэрлэв? Сонгуулийн өдөрөөр ажилдаггүй. Залгаад амралтын өдрүүд

таарах нь Нийслэлчүүдийн хувьд хотоос гарч явах сэдлийг төрүүлдэгийг хэн бүхэн мэднэ

2.Нэгэнтээ сонгогчийн ирцийн хувь босго байхгүй тул олон гишүүнтэй томоохон улс төрийн хүчний хувьд өөрийн гишүүд+дэмжигчдийг сонгуульд оролцуулах замаар ялалт байгуулах боломжийг бүрдүүлж байгаа харагдаж байна. Тухайлбал: Нийслэлийн сонгогч 2024 онд 2107 мянга. НИТХ-д олонхи болсон Нийслэлийн МАН 78340 гишүүнтэй (хуудас, 2024.11.07). Гишүүн гэр бүлтэй, насанд хүрсэн 1 хүүхэдтэй гэж бодоход л 235020 буюу нийт сонгогчийн 10%+. Гэтэл сонгуулийн ирц 42% тохиолдолд нийт сонггогчдийн 25% санал авахадл олонхи болох боломжтой байна.

3.Сонгуулийн үр дүнд олонхи болсон буюу эрх мэдэл хэрэгжүүлэх эрх авсан улс төрийн нам мөрийн хөтөлбөртөө тусгасан заалтуудаа сонгуулийн маргаашаас мартдаг нь (Д.Энхтүвшин) иргэдийн итгэлийг үгүй хийж хэдхэн төгрөгөөр саналаа худалдах эс чадвал саналаа өгөхгүй үлдэх алхам руу түлхэж байна

4.Эдгээр нөхцөл байдлаас харахад олон гишүүнтэй томоохон улс төрийн хүчин гишүүд дэмжигчид дээрээ сонгогчдийн цөөхөн хувийн /10-15%/ санал худалдаж авхад/орон нутгийн сонгуулийн сурталчилгааны үед сонгогчдын саналыг багцлан зарах оролдлоготой таарч байв/ л орон нутгийн сонгуульд ялалт байгуулах боломж харагдаж байна. Иймээс орон нутгийн сонгуульд ирцийн босгыг 50 буюу түүнээс дээш хувьтай байхаар хуулиар тогтоож өгөх нь "Чөлөөт ардчилсан сонгууль"-ийн зарчимд нийцэхээр байна. Эс тэгвээс иргэдийн цөөнхийн дэмжлэгээр төлөөллийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх авсан Улс төрийн хүчний үйл ажиллагаа олонхид бус өөрсдийгөө дэмжсэн цөөнхөд чиглэснээр олонхи бухимдах дургүйцэх явдал ихсэж байгаа ба цаашид сонгуулиар төрийн бодлогод нөлөөлөх, өөрчлөх итгэл үнэмшил алдарч, магадгүй өөр арга хэлбэр эрэлхийлэхэд хүргэж болзошгүйг нийгэмд өрнөөд байгаа үйл явдлууд, олон нийтийн хандлага (гишүүн, 2024.11.06) харуулж байна.

## ЭХ СУРВАЛЖЫН ЖАГСААЛТ

Монгол Улсын Үндсэн хууль (1992).

Захиргааны ерөнхий хууль (2015).

Төсвийн тухай хууль (2011).

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. (2006, 2020).

Төрийн албаны тухай хууль (2017).

Шилэн дансны тухай хууль (2014).

Нутгийн удирдлагын практик. Баттүвшин.Б. (2017). Улаанбаатар

Нутгийн өөрөө удирдах ёс. Долгоржав, Я. (2000). Улаанбаатар

Монгол Улсад нутгийн өөрийн удирдлагыг төлөвшүүлэх тулгамдсан асуудал /Докторын бүтээл/ Нармандах. С (2002). Улаанбаатар

Монгол Улсад нутгийн өөрийн удирдлагыг шинжлэхүй. Нармандах. С (2010) Улаанбаатар

Нутгийн удирдлага. Сандаг-Очир, М. (2003). Улаанбаатар.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ.

“Монгол Улсад төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ажилласан экспертийн баг. (2019). Улаанбаатар

Монголын ардчилал. “Конрад Аденаурын сан, Г.Чулуунбаатар, Ш.Батсүх, Б.Ганцоож. (2021). Улаанбаатар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь./судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж.

“Конрад Аденаурын сан, Монгол Улсын Их сургууль. (2019). Улаанбаатар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ/судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж.

“УИХ Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (2019). Улаанбаатар

ИТХ-ын төлөөлөгчдийн сургалтын гарын авлага.

“Нутгийн өөрийн удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь төслийн нэгж. (2016). Улаанбаатар

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай. УИХ-ын тогтоол (1997). Улаанбаатар

icon.mn. (2024). *орон нутгийн сонгууль.*

Б.Чимид. (2002). *Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй.* Улаанбаатар.

*Бүгд найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль.* (1924).

Г.Чулуунбаатар, Ш. Б. (2021). *Монголын ардчилал.*
Д.Энхтүвшин, У. г. (огноо байхгүй). *2024.11.06.*
дарга, У. з. (2024).
НЗДТГ. (2022, 2023). *Үйл ажиллагааны тайлан.*
Т.Ариунболд. (2024).
хуудас, Н. М. (2024.11.07).
хууль, М. У. (2020). *12 р зүйл.*
хууль, М.-ы. Ү. (1992). *2-р зүйл.*
хууль, Ү. (1992). *Үндсэн хуулийн 3,1.* Улаанбаатар: 3,1.
хууль, Ү. (1992). *16.9.*

Нийслэл, дүүргийн ИТХ-ын Ажлын албаны бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай.
ЗГ-ын тогтоол 2021
Дүрэм батлах тухай
ЗГ-ын тогтоол 2021

# ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

С.Номынбаясгалан

***Товч агуулга***: *Энэхүү нийтлэлийн сэдвийг "Орон нутгийн хурлын сонгуулийн тогтолцоо, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал" гэж томьёолон, агуулгыг Орон нутгийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр хязгаарлав.*
***Түлхүүр үгс***: Сонгуулийн эрх зүй, олонхийн тогтолцоо, хувь тэнцүүлэх тогтолцоо,

## I.Удиртгал

БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан бөгөөд тус хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "**Улсын Их Хурал нь нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна**"[1] гэж анхны эхэд заасныг Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр "**Улсын Их Хурал нэг танхимтай, зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно**"[2] гэж өөрчлөн найруулсан. Энэхүү өөрчлөлт нь 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд түүнд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг[3] Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн дагуу оруулсан.[4] Ийнхүү Үндсэн хууль тогтоогчийн анхдагч үзэл санааг нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн хууль тогтоогч дээрхи байдлаар өөрчилсөн. Үүнийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны

[1] https://legalinfo.mn/mn/detail?lawId=367 [Сүүлд үзсэн: 2024.11.05]
[2] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759482929681&showType=1 [Сүүлд үзсэн: 2024.11.05]
[3] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760298587161&showType=1 [Сүүлд үзсэн: 2024.11.05]
[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759483116721 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

ээлжит сонгуулийг товлон,[5] тогтоосон сонгуулийн тойрог,[6] түүнд ногдох мандатын хүрээнд[7] сонгуулийн холимог тогтолцоогоор явуулж, Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар тус тус сонгон[8] бүрдүүлсэн гэдгээрээ онцлогтой.

Үүнтэй уялдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно" гэсний ". . . **журмыг хуулиар тогтооно**" гэсний дагуу Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан.[9] Уг хуулийн 4 дүгээр зүйл (Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль)-ийн 4.8 дахь хэсэгт "**Орон нутгийн Хурлын сонгууль олонхын /мажоритар/ тогтолцоотой байна**" гэж заасан. Үүнээс гадна Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог тогтоосон[10] бөгөөд үүнийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө гэж хуульчлан тайлбарласан. Үүний дагуу орон нутгийн Хурлын сонгуулиар төлөөлөгчдийг сонгосон.[11] Хэдий тийм болovч "**Монгол Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсантай адилаар орон нутгийн Хурлын сонгуулийг мөн холимог тогтолцоогоор явуулсан бол илүү үр дүнтэй байсан**" байж болох юм. Энэ байдлыг харгалзан энэхүү нийтлэлээр орон нутгийн Хурлын сонгуулийг сонгуулийн тогтолцооны аль аргаар явуулах нь цаашид үр дүнтэй болохыг авч

[5] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17047864363581 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[6] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960708774791 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[7] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960708868361&showType=1 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[8] Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн "*Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцох тухай*" 191 дүгээр тогтоолын 1 болон 2 дугаар хавсралт

[9] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15125 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[10] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[11] Энэхүү нийтлэлийн хавсралт хэсгээс орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнг үзнэ үү.

үзэхийг гол зорилгоо болгов. Энэ нийтлэлээр орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгийн хүрээнд авч үзэв.

Учир нь сонгуулийн эцсийн зорилт нь "**хэн засаглалыг тогтоох**" явдал юм.[12] Энэ ч үүднээс ардчилсан нийгэмд төрийн эрх мэдлийн хүлээн зөвшөөрөгдөх чанар нь "хууль ёсны дагуу ардчилсан сонгуулиар төрийн тогтолцоог бүрдүүлэх" замаар эхэлнэ[13] гэж үздэг. Түүхэн талаасаа, сонгуулийн ардчилсан тогтолцооны хэлбэр бүхэн улс төрийн амьдралын хүрээнд өөр өөрсдийн өвөрмөц үр дагаврыг бий болгодог бөгөөд сонгуулийн тогтолцоог сонгож авах нь цэвэр техникийн шинж чанартай шийдвэр биш (*Сонгуулийн ямар тогтолцоог сонгох вэ гэдэг нь аливаа ардчилсан орны улс төрийн институцийн хувьд хамгийн чухал шийдвэрийн нэгд тооцогддог*). Энэ нь улс төрийн системийн ажиллагаанд эерэг болоод сөрөг үр дагавартай байж болно.[14] Тиймээс сонгуулийн тогтолцоог өөрчлөх эсэх асуудал хөндөгдөхөд улс төрийн намууд их ач холбогдол өгдгийн учир нь сонгуулийн тогтолцооны сонголт нь улс төрийн намуудад шууд нөлөөлөхүйц үр дагавартай. Улс төрийн намууд сонгуулийн тогтолцоог өөрчилснөөр "**ардчиллыг хэрэгжүүлэх тоглоомын дүрмийг зохиох**" боломжтой болно.[15] Иймээс сонгуулийн тогтолцооны шийдвэр гаргахад аль тогтолцоо хамгийн үр дүнтэй вэ гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөхийн өмнө улс төрийн тодорхой ямар нөхцөл байдалд аль шалгуур нь хамгийн чухал вэ гэдгийг нарийвчлан судалж тогтоох хэрэгтэй гэж үзэх нь бий.[16] Тэгээд ч сонгуулийн ямар тогтолцоог хэрэглэх нь илүү ашигтай

---

[12] Лоуренс Ленүк., Ричард Ниэми., Пиппа Норрис., Ардчилалуудыг харьцуулахуй: Сонгууль ба санал өгөлт глобаль түвшинд, (Орчуулсан: Мөнх–Эрдэнэ Д.), 2008, Уб., 58 дахь тал (Цаашид "Лоуренс Ленүк., Ричард Ниэми., Пиппа Норрис., Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

[13] Н.Лүндэндорж, Төрийн онол // Theory of State, (Нэмж засварласан хоёр дахь хэвлэл), Уб., 2005, 58 дахь тал (Цаашид " Н.Лүндэндорж., Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

[14] Лоуренс Ленүк., Ричард Ниэми., Пиппа Норрис., Дурдсан бүтээл, 37 дахь тал

[15] Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал // Constitutional law: State structure, principles and policies, Уб., 2019, 196 дахь тал тал (Цаашид "Гангабаатар Д., Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

[16] Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт // Electoral System Design: The New International IDEA Handbook, (Орчуулсан: Батбаяр Г.), Уб., 2010, 11 дэх тал http://forum.mn/res_mat/2019/ElectoralSystem.pdf?fbclid=IwAR0B72O-ymL5P5WT5SThTRkGys6bdTtTcQ-fEX-WVJy5UGVc68DHTur9zXQ [Сүүлд үзсэн: 2024.11.05] (Цаашид "Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

вэ гэсэн асуултын хариу, тэр дундаа сонгууль тойрсон маргаан нь эцсийн эцэст орон нутгийн Хурлын байгууллагад сонгогдсон орон нутгийн Хурлын төлөөлөгч хэний эрх ашиг, ашиг сонирхлыг илэрхийлэх вэ гэдэгт оршдог. Өөр үгээр бол, төлөөллийн ардчиллын үндсэн шинж нь ард түмнээс сонгогдсон төлөөлөгч тэдний ашиг сонирхлын үүднээс ажиллах учиртай бөгөөд тухайн төлөөлөгчийг ийнхүү ажиллуулахын тулд юу хийх нь чухал вэ гэдгийг сонгох эрх чөлөө нь ард түмэнд мөн хадгалагдаж үлддэгт оршино.[17]

## II.Орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоог хууль зүйн үүднээс тодорхойлох боломж

Энгийнээр өгүүлэхэд "**сонгуулийн тогтолцоо**" нь аливаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам, нэр дэвшигчдийн авах суудлын тоонд шилжүүлэх арга замыг хэлдэг. Үүнийг тодорхойлдог гол хувьсагчид нь сонгуулийн тогтолцооны хувилбар, суудал хуваарилах томъёо (*олонхийн, хувь тэнцүүлсэн, холимог эсвэл өөр ямар тогтолцоо ашиглаж байгаа, суудлын хуваарилалтыг ямар математик томъёо ашиглан тооцоолох гэх мэт*), саналын хуудасны бүтэц (*сонгогч нам эсвэл нэр дэвшигчийн алинд санал өгч байна, зөвхөн нэг сонголт хийх үү эсвэл хэд хэдэн сонголт хийх боломжтой юу*), сонгуулийн тойргийн цар хүрээ (*тухайн тойрог хэдэн сонгогчтой байгаагаар биш, тойргоос хууль тогтоох байгууллагад хэдэн төлөөлөгч сонгогдож байгаагаар илэрхийлэгдэнэ*) зэрэг юм.[18] Энэ утгаараа, Сонгуулийн ямар тогтолцоог сонгосноос хамаарч сонгогчид улс төрийн намд санал өгөх эсвэл нэр дэвшигчид саналаа өгөх, сонгогчдын саналыг ямар аргачлалаар парламентын суудал хуваарилах, сонгуулийн тойргийг хэрхэн тогтоох, тойрог бүрээс хэдэн төлөөлөгч сонгох гээд олон асуудал тодорхой болдог[19] гэж үздэг. Тиймээс сонгуулийн эрх зүйн тохируулагч үүрэг, тухайн үед хэрэглэсэн тогтолцооны үр нөлөө хэр зэрэг байна вэ гэдэг нь эцсийн дүнд уг үйл явцад сонгогчид хэр зэрэг санаа тавьж оролцсон, тухайн сонгуулийн үр дүнд иргэдийн сэтгэл ханамж ямар түвшинд байна вэ гэдгээр илэрдэг. Өөрөөр хэлбэл, иргэдийн оролцоо бол сонгуулийн эрх зүй, тогтолцооны үр дүнгийн гол шалгуур гэж үздэг.[20] Сонгуулийн

[17] Хүний эрх, үр нөлөөтэй удирдлага: Сурвалж бичиг, Дурдсан бүтээл, 46 дахь тал
[18] Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, Дурдсан бүтээл, 7 дахь тал
[19] Д.Гангабаатар, Дурдсан бүтээл, 195–196 дахь тал
[20] Б.Чимид, Дурдсан бүтээл, 44 дэх тал

тогтолцооны төлөвшилтийн өөр нэг чухал асуудал нь сонгуулийн зохион байгуулалтын асуудал юм.[21] Мөн түүнчлэн сонгуулийн тогтолцооны ач холбогдлыг орхигдуулж болохгүй.[22] Иймд дурдаж байгаа энэ бүх зүйлүүд сонгуулийн тогтолцоо хэмээн ойлголтын агуулгад багтдаг.

Тийм ч учраас сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах "**амин**" хэрэгцээнээс үүдэлтэй.[23] Ийнхүү сонгуулийг улс төрийн байгууллаас салдаггүй, ёстой л орхиж болдоггүй дагуул мэт. Түүний гол учир шалтгаан юу вэ гэвэл ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагаас нь "**шууд**" урган гардагт оршиж байна.[24] Тиймээс Монгол Улсын иргэн бүр биечлэн буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй бөгөөд ийнхүү оролцох хамгийн тодорхой хэлбэр нь "**сонгууль**" юм. Улсын Их Хурлын эсхүл орон нутгийн Хурлын сонгууль уу гэдгээс үл хамааран сонгууль нь ард түмний хүсэл эрмэлзлээ илэрхийлэх нийтлэг агаад бодитой арга төдийгүй олон улсын жишигт нийцүүлэн явуулсан цагт хүний улс төрийн "**үндсэн**" эрхийг хангадаг эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн чухал үйл явдал[25] эргэлзээгүй болно. Тэгээд ч сонгууль "**зайлшгүй**" байх олон улсын эрх зүйн зарчимтай. Сонгуулийн ардчилсан шинж чанар, нийгэм-улс төрийн үр өгөөж, гүйцэтгэх үүрэг нь түүнийг зохицуулан тодорхойлох эрх зүйн зохицуулалтаас багагүй шалтгаална. Эрх зүйн зохицуулалтын улс төрийн агуулга, утга учир нь нийгмийн ямар бүлгийн төлөөлөгчийг хэнээр, хэрхэн сонгуулах вэ, түүнийг яаж хуульчлан баталгаажуулах вэ гэдэгт оршино. Засаглалын эрх мэдэл ард түмний мэдэлд байж, ард түмнээс эх үүсэлтэй байдгийн хувьд сонгууль нь мөн ард олны хүсэл зориг, эрх ашгийн илэрхийлэл, хэрэгжилт байх ёстой.[26] Энэ нь Улсын Их

---

[21] http://www.gec.gov.mn/details/887 [Сүүлд үзсэн: 2024.11.05]

[22] Жишээлбэл, Сонгуулийн тогтолцоо нь засгийн газрын кабинетыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Гангабаатар Д., Дурдсан бүтээл, 197 дахь тал

[23] Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 27 дахь тал

[24] Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 28 дахь тал

[25] Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), Уб., 2009, 82 дахь тал

[26] Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо: Улс төр судлалын шинжилгээ, (Редактор

Хурлын гэлтгүй орон нутгийн Хурлын сонгуулийн эрх зүйн зохицуулалтын тулгуур гэж үзэж болох юм.

**1.Орон нутгийн Хурлын тухай хууль органик хууль болох нь**

Н.Лүндэндорж *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар* хэмээх (2022) бүтээлд "**"Хуулиар тогтооно**" гэдгийг тухайн харилцааг хуулиас өөр төрлийн акт зохицуулахгүй гэж ойлгохоос гадна үндсэн хуулиар гол тулгуур асуудал, зарчмыг тодорхойлсон хэм хэмжээнд нийцүүлэн органик болон бусад хуулиар нарийвчлан зохицуулах эрхийг хууль тогтоох дээд байгууллагад шилжүүлсэн гэж ойлгоно. Түүнээс гадна хуулиар зохицуулах ёстой харилцааны эрх зүйн эх сурвалжыг бий болгох процессыг "хүндрүүлж", нарийсгаснаараа хялбар дөхмөөр уг асуудлыг дур зоргоор шийдэхгүй гэсэн хориглон хязгаарласан утгыг бас агуулж буй болно. Хууль тогтоох ажиллагаа нь нарийн зохицуулсан процесстой, хяналт шүүлтүүрийн механизмтай, нүсэр том хариуцлагатай ажил учраас Үндсэн хуулийг тогтоогч "**хуулиар тогтооно**" гэсэн институцыг мөн хэрэглэсэн буй за"[27] гэж органик хууль батлан гаргах асуудлыг оновчтой бичсэн байна. Тэгвэл гадаад орнуудын хувьд органик хуулийг тогтоохдоо хоёр хандлагаар тогтоож байна. Хэдийгээр уг хоёр арга өөр хоорондоо ялгаатай мэт боловч ийнхүү ялгаатай болж буй гол хүчин зүйл нь эрх зүйн хэм хэмжээ тогтоох техник юм. Эхнийх нь (1) **органик хууль, түүний агуулгыг тогтоох замаар бий болгох хандлага**. Уг хандлагын дагуу органик хуулиар зохицуулах харилцааны агуулгыг тогтоохдоо шинжээр дамжуулан тогтооно.[28] Жишээ болгон Испани улсын Үндсэн хуулийн 81 дүгээр зүйл зэргийг дурдаж болох юм. Удаах нь (2) **органик хуульд хамаарах хууль бүрийг тогтоох буюу жагсаах хандлага**. Энэхүү арга нь органик хуулийн хэрэглээг нэг бүрчлэн нэрлэх буюу жагсаалт үүсгэх замаар тогтоох байдлаар хэрэгжиж байна. Ингэхдээ уг жагсаалт нь үндсэн хуульд тусгайлан хуулиар зохицуулахаар заасан хууль болон ердийн хуулиас тусгаар шинжтэй байдаг. Хэдийгээр ийнхүү нэрлэх замаар жагсаалт үүсгэх нь хууль тогтоогчид уг хуулийн бусад хуулиас ялгахад хялбар боловч уг жагсаалтад багтаагүй болон

---

Жамбал А.), Уб., 2000, 27-28 дахь тал (Цаашид "Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Дурдсан бүтээл" гэж товчилно. С.Н.)

[27] Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль*, (Шинжлэх ухааны тайлбар), Уб., Адмон принтинг, 2022, 141 дэх тал.

[28] А.Бямбажаргал, "Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: Органик хууль ба түүнийг тогтоох эрх зүйн боломж", Эрх зүй, (2014), №4, 168 дахь тал.

шинээр жагсаалт бий болгоход бэрхшээл үүсдэг.[29] Үүнд, Эстони улсын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйл гэх мэт. Энэ утгаар авч үзвэл, удиртгалд дурдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг нь органик хууль болох нь харагдаж байна.

**2.Орон нутгийн Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж байсан нь**

Үндсэн хуульд нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх, орон нутагт бүрэн засаглах эрх зүйн баталгааг бүрдүүлсэн.[30] Үүнийг хэрэгжүүлэх нутгийн өөрөө удирдах байгууллага бол "**иргэдийн Хурал**" бөгөөд юуны өмнө Үндсэн хуулиар статус нь тодорхойлогдсон. Иргэд нийтээрээ цугларч, эсхүл иргэдээс сонгогдох замаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах бөгөөд байгуулах арга нь орон нутгийн Хурлын сонгууль юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь "мандат өвөртлөгч" сонгогдсон төлөөлөгч нараас бүрддэг байгууллага юм.[31] Иргэдийн Төлөөлөгчийн Хурал иргэдээ төлөөлөх байгууллага зэргийг нь бодолцвол манай орны нөхцөлд улс төрийн намаас хол, мажоритар тогтолцоогоор явуулах нь зохистой мэт. Хувийн ашиг сонирхлоос ангид тэгш, шударга, хариуцлагатай, олон нийтийн итгэл даах байдлыг хангаж ажиллах эсэх нь иргэдээ төлөөлөх гэж сонгогдож буй төлөөлөгчийн хүсэл зоригоос шууд хамааралтай.[32] Түүнчлэн өмнөх орон нутгийн Хурлын сонгуулиудын заримд нь сонгуулийн холимог тогтолцоог ашиглаж байсан боловч зарим нэг сөрөг эрсдэлүүд үүсч байсан учраас эргээд мажоритар тогтолцоонд шилжсэн байна.[33]

## III.Орон нутгийн Хурлын сонгуулийн үр дүнд хийсэн шинжилгээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйл (Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төлөөлөгчдийн

---

[29] А.Бямбажаргал, "Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: Органик хууль ба түүнийг тогтоох эрх зүйн боломж", Эрх зүй, (2014), №4, 169 дэх тал.

[30] О.Тунгалаг, Орон нутгийн хурал, Уб., 2000, 6 дахь тал

[31] Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга, хэрэгжилт), Уб., 2017, 273 дахь тал

[32] Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга, хэрэгжилт), Уб., 2017, 274 дэх тал

[33] Хамтын бүтээл, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Уб., 2016,170 дахь тал

Хурлын сонгууль)–ийн 4.1 дэх хэсэгт "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль /цаашид "**орон нутгийн Хурлын сонгууль**" гэх/ . . ." гэж заасны дагуу энэ хэсэгт орон нутгийн Хурлын сонгууль гэсэн нэр томьёог хэрэглэв. Энэхүү хэсэг нь аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын болон сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн судалгаа гэсэн дэд хэсгээс бүрдэх[34] бөгөөд эцэст нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнг (мажоритар тогтолцоогоор явагдсан сонгуулийн үр дүнтэй) Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнтэй (сонгуулийн холимог тогтолцоогоор явагдсан сонгуулийн үр дүнтэй) харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх болно.

**1.Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн судалгаа**

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон Аймаг, нийслэлийн иргэдийн төлөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн судалгаанаас авч үзвэл,[35] МАН нь Архангай (28), Баянхонгор (23), Булган (15), Говьсүмбэр (11), Дархан – Уул (24), Дорноговь (27), Дорнод (19), Дундговь (16), Завхан (19), Орхон (21), Өвөрхангай (29), Сэлэнгэ (21), Увс (18), Хөвсгөл (26) гэсэн нэр бүхий **14 аймагт төдийгүй нийслэлд (40) олонхи болсон буюу нийт 796 мандатын 449** байна. Харин АН нь Баян – Өлгий (23), Говь – Алтай (18), Өмнөговь (21), Сүхбаатар (20), Төв (21), Ховд (27), Хэнтий (18) гэсэн нэр бүхий 7 **аймагт олонхи болсон буюу нийт 796 мандатын 340** байна. Үүнээс гадна ХҮН нь Архангай (1), Дорнод (1), Сэлэнгэ (1) гэсэн нэр бүхий 3 аймагт 3 мандат авсан.

**2.Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн судалгаа**

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон Сум, дүүргийн иргэдийн төлөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн судалгаанаас авч үзвэл,[36] МАН нь **Архангай аймгийн** Цэнхэр (17), Булган (17), Чулуут (18), Хангай (12), Цахир (19), Өндөр – Улаан (17), Эрдэнэмандал (20), Жаргалант (14), Өлзийт (16), Хотонт (18), Эрдэнэбулган (17) зэрэг **11 суманд нийт 423 мандатын 238 нь; Баян – Өлгий аймгийн**

[34] Энэхүү нийтлэлийн хавсралт хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.
[35] Энэ талаар нийтлэлийн хавсралт №1 –ээс дэлгэрүүлж үзнэ үү.
[36] Энэ талаар нийтлэлийн хавсралт №2 –оос дэлгэрүүлж үзнэ үү.

Алтанцөгц (14), Баяннуур (13), Бугат (14), Булган (17), Ногооннуур (14), Толбо (11), Улаанхус (19), Цэнгэл (22), Өлгий (17) зэрэг **9 суманд нийт 317 мандатын 180 нь**; **Баянхонгор аймгийн** Баянговь (17), Баянлиг (11), Баян – Өндөр (17), Богд (12), Бууцагаан (11), Гурванбулаг (16), Жаргалант (14), Заг (18), Хүрээмарал (11), Эрдэнэцогт (18) зэрэг **10 суманд нийт 416 мандатын 204 нь**; **Булган аймгийн** Баяннуур (10), Булган (24), Бүрэгхангай (14), Гурванбулаг (19), Орхон (15), Могод (15), Тэшиг (18), Сэлэнгэ (16), Хангал (15), Хутаг – Өндөр (14) зэрэг **10 суманд нийт 338 мандатын 189 нь**; **Говь – Алтай аймгийн** Алтай (10), Баян – Уул (14), Бигэр (18), Бугат (11), Дэлгэр (10), Тайшир (14), Тонхил (12), Төгрөг (14), Халиун (16), Хөхморьт (12), Цээл (18), Чандмань (17), Эрдэнэ (19) зэрэг **13 суманд нийт 356 мандатын 209 нь**; **Говьсүмбэр аймгийн** Сүмбэр (22), Шивээговь (18), Баянтал (9) зэрэг **3 сумад нийт 65 мандатын 49 нь**; **Дархан – Уул аймгийн** Дархан (22), Орхон (17), Хонгор (20) зэрэг **3 суманд нийт 100 мандатын 70 нь**; **Дорноговь аймгийн** Замын – Үүд (22), Сайншанд (15), Сайхандулаан (28), Хатанбулаг (10), Эрдэнэ (11), Өргөн (20) зэрэг **6 суманд нийт 274 мандатын 163 нь**; Дорнод аймгийн Баянтүмэн (11), Гурванзагал (11), Матад (13), Сэргэлэн (18), Халхгол (13), Хөлөнбуйр (11), Цагаа – Овоо (14), Чулуунхороот (12) зэрэг **8 суманд нийт 284 мандатын 141 нь**; **Дундговь аймгийн** Адаацаг (21), Баянжаргалан (9), Говь – Угтаал (9), Дэрэн (11), Өндөршил (10), Хулд (16), Цагаандэлгэр (12), Эрдэнэдалай (13) зэрэг **8 суманд нийт 291 мандатын 146 нь**; **Завхан аймгийн** Отгон (12), Сантмаргац (8), Сонгино (8), Тэс (11), Улиастай (17), Цагаанчулуут (14), Цэцэн – Уул (10), Шилүүстэй (8), Эрдэнэхайрхан (8) зэрэг **9 суманд нийт 440 мандатын 193 нь**; **Орхон аймгийн** Баян – Өндөр (16), Жаргалант (20) зэрэг **2 суманд нийт 50 мандатын 36 нь**; **Өвөрхангай аймгийн** Баруунбаян – Улаан (13), Бат – Өлзий (20), Богд (17), Гучин – Ус (17), Зүүнбаян – Улаан (11), Сант (17), Уянга (16), Хайрхандулаан (13), Хужирт (17) зэрэг **9 суманд нийт 435 мандатын 247 нь**; **Өмнөговь аймгийн** Номгон (14), Ханхонгор (14), Хүрмэн (10) зэрэг **3 суманд нийт 291 мандатын 107 нь**; Сүхбаатар аймгийн Онгон (17), Түвшинширээ (19), Халзан (13) зэрэг **3 суманд нийт 271 мандатын 118 нь**; Сэлэнгэ аймгийн Алтанбулаг (12), Баянгол (15), Баруунбүрэн (11), Зүүнбүрэн (13), Мандал (21), Орхон (15), Сант (20), Сүхбаатар (19), Хүдэр (12), Хушаат (17), Цагааннуур (11), Шаамар (12) зэрэг **12 суманд нийт 383 мандатын 211 нь**; **Төв аймгийн** Алтанбулаг (12), Баянжаргалан (13), Баян – Өнжүүл (16), Баянчандмань (9), Борнуур (14), Дэлгэрхаан (10), Өндөрширээт (14), Угтаалцайдам (15), Эрдэнэ

(14) зэрэг **9 суманд нийт 527 мандатын 235 нь; Увс аймгийн** Баруунтуруун (8), Бөхмөрөн (17), Зүүнговь (14), Зүүнхангай (15), Малчин (12), Өлгий (17), Өмнөговь (16), Өндөрхангай (11), Сагил (18), Тэс (15), Улаангом (19) зэрэг **11 суманд нийт 399 мандатын 224 нь; Ховд аймгийн** Алтай (15), Булган (19), Буянт (12), Дуут (10), Мөнххайрхан (14), Мөст (10), Ховд (14), Чандмань (11) зэрэг **8 суманд нийт 367 мандатын 161 нь; Хөвсгөл аймгийн** Арбулаг (15), Галт (21), Их – Уул (17), Мөрөн (19), Рашаант (17), Рэнчинлхүмбэ (16), Тариалан (18), Тосонцэнгэл (17), Түнэл (14), Улаан – Уул (16), Ханх (18), Цагаан – Үүр (19), Цэцэрлэг (12), Шинэ – Идэр (21) зэрэг **14 суманд нийт 511 мандатын 313 нь; Хэнтий аймгийн** Дадал (11), Цэнхэрмандал (16), Баянхутаг (13), Норовлин (17), Биндэр (17), Баян – Адарга (12), Баян – Овоо (11), Бор – Өндөр (18) зэрэг **8 суманд нийт 384 мандатын 195 нь** буюу нийт 7235 мандатын 3879 байна. Харин МАН нийслэлийн Баянзүрх (38), Баянгол (39), Чингэлтэй (33), Сонгинохайрхан (43), Хан – Уул (30), Налайх (23), Багануур (13), Багахангай (19) зэрэг **8 дүүрэгт нийт 313 мандатын 250** байна.

Дээрхээс авч үзвэл, МАН нь **Завхан, Өмнгөговь, Сүхбаатар, Төв, Ховд зэрэг аймгаас бусад аймагт олонхи болсон** бөгөөд **эдгээр аймагт АН нь олонхи болсон** буюу нийт 7235 мандатын 3231 байна. Мөн түүнчлэн нийслэлийн **Сүхбаатар дүүрэгт олонхи болсон** буюу нийт 313 мандатын 55 байна. Үүнээс гадна **ХҮН нь нийслэлийн Баянгол дүүрэгт 2 мандат авсан** байна.

### 3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээс авч үзвэл,[37] Нэгдүгээр тойргоос (Архангай, Баянхонгор, Өвөрхангай) нийт 9 мандатын МАН нь 2 байхад АН нь 7; Хоёрдугаар тойргоос (Говь – Алтай, Завхан, Увс, Ховьд) нийт 10 мандатын МАН нь 6 байхад АН нь 4; Гуравдугаарт тойргоос (Баян – Өлгий) нийт 3 мандатын МАН нь 2 байхад АН нь 1; Дөрөвдүгээр тойргоос (Булган, Орхон, Хөвсгөл) нийт 8 мандатын МАН нь 7 байхад АН нь 1; Тавдугаар тойргоос (Дархан – Уул, Сэлэнгэ, Төв) нийт 10 мандатын МАН нь

[37] Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 6 дугаар сарын 30 –ны өдрийн 191 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаас дэлгэрүүлж үзнэ үү.

7 байхад АН нь 3; Зургадугаар тойргоос (Дорнод, Сүхбаатар, Хэнтий) нийт 7 мандатын МАН нь 6 байхад АН нь 1; Долдугаар тойргоос (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) нийт 7 мандатын МАН нь 2 байхад АН нь 5; Наймдугаар тойргоос (Баянзүрх) нийт 5 мандатын МАН нь 4 байхад ХҮН нь 1; Есдүгээр тойргоос (Баянгол) нийт 3 мандатын МАН 2 байхад ХҮН нь 1; Аравдугаар тойргоос (Сүхбаатар, Чингэлтэй) нийт 6 мандатын МАН нь 4 байхад АН нь 2; Арван нэгдүгээр тойргоос (Сонгинохайрхан) нийт 5 мандатын МАН нь 4 байхад АН нь 1; Арван хоёрдугаар тойргоос (Хан – Уул) нийт 3 мандатын МАН нь 2 байхад АН нь 1; Арван гуравдугаар тойргоос (Багануур, Багахангай, Налайх) нийт 2 мандатын МАН нь 2 гэх зэргийг тус тус авсан. Дээрхээс авч үзвэл, МАН нь нэгдүгээр болон долдугаар тойргуудаас бусад тойргуудад олонхи болсон бөгөөд эдгээр тойрогт буюу **Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь гэсэн нэр бүхий 7 аймагт АН нь олонхи болсон** байна. Үүнээс гадна наймдугаар болон есдүгээр тойргуудад буюу **нийслэлийн Баянзүрх, Баянгол дүүрэгт АН мандат аваагүй байхад ХҮН мандат авсан** байна.

Өмнө дурдагдсан орон нутгийн Хурлын болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл, Монгол Улсын Их Хурлын сонгуульд АН нь **Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь гэсэн нэр бүхий 7 аймагт АН нь олонхи болж, мандат авсан** байхад орон нутгийн Хурлын (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын) сонгуульд **эдгээр аймгаас Өмнөговь аймгаас бусад аймагт нь олонхи болоогүй** байна. Хэдий тийм болович АН нь **Баян – Өлгий, Говь – Алтай, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий гэсэн нэр бүхий 7 аймагт олонхи болсон** байна. Үүний зэрэгцээ орон нутгийн Хурлын (Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын) сонгуульд АН нь **Завхан, Өмнгөговь, Сүхбаатар, Төв, Ховд зэрэг аймагт,** нийслэлийн **Сүхбаатар дүүрэгт олонхи болсон** байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлын сонгуульд ХҮН нь **нийслэлийн Баянзүрх, Баянгол дүүрэгт мандат авсан** хэдий ч орон нутгийн Хурлын (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын) сонгуульд **ХҮН нь Архангай, Дорнод, Сэлэнгэ гэсэн нэр бүхий аймагт мандат авсан** байна. Харин орон нутгийн Хурлын (Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын) сонгуульд ХҮН нь **нийслэлийн Баянгол дүүрэгт мандат авсан** байна.

## IV.Дүгнэлт, санал

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсад засгийн эрх ард түмний мэдэлд байх, ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх талаарх үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх, иргэний сонгуулийн эрхийг хангах гол нөхцөл бол холбогдох хуулиар сонгуулийн тогтолцоог зөв ойлгон тодорхойлох[38] асуудалд холбогдох юм. Тиймээс *үндсэн хуулиар нэгэнт орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоог шууд тодорхойлоогүй учраас сонгуулийн ямар тогтолцоотой байхыг Улсын Их Хурал шийдвэрлэх бүрэн эрхтэй*[39] эсэхэд хариулт өгөхөд чиглэв. Үүнд л энэ нийтлэлийн гол утга учир оршино. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно" гэсний ". . . **журмыг хуулиар тогтооно**" гэсний дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан байх уг хууль органик хуулийн шинжийг агуулж байна. Энэ утгаар, үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоо ямар байх, хэрхэн тодорхойлох асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх эрхтэй гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны өөрчлөлтийн сонгуулийн холимог тогтолцоо гэх үзэл санаатай уялдуулан авч үзэх орон нутгийн Хурлын цөөнгүй эрх зүйн зохицуулалтын асуудлууд байсан байна.

Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиуд явагдаж дууссан хэдий ч "**Монгол Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсантай адилаар орон нутгийн Хурлын сонгуулийг мөн холимог тогтолцоогоор явуулсан бол илүү үр дүнтэй байх**" байсан гэж үзэж байна. Энэ нь орон нутгийн Хурлын сонгуулийн үр дүнг (**мажоритар тогтолцоогоор явагдсан сонгуулийн үр дүнтэй**) Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнтэй (**сонгуулийн холимог тогтолцоогоор**

---

[38] Н.Жанцан, Үндсэн хуулийн цэц иргэдийн улс төрийн эрхийн баталгаа болох нь // Constitutional Court (tsets) as the guarantee of citizens' political rights, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга зүй, хэрэгжилт) Уб., 2017, 38 дахь тал

[39] О.Мөнхсайхан, Дурдсан бүтээл, 23 дахь тал

**явагдсан сонгуулийн үр дүнтэй)** товчхон харьцуулж үзэхэд харагдаж байна. Энэ байдлыг харгалзан дараахь цөөнх хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

**Нэгд**, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоотой орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоог уялдуулан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийн "**Орон нутгийн Хурлын сонгууль олонхын /мажоритар/ тогтолцоотой байна**" гэснийг "**Орон нутгийн Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна**" гэж өөрчлөн найруулах;

**Хоёрт**, Орон нутгийн Хурлын сонгуулийн "сонгуулийн холимог тогтолцоо" гэх үзэл санаатай уялдуулан нам, эвсэлд хэрхэн мандат хуваарилах зэрэг асуудлыг хуульд нэмэлтээр оруулах гэх зэрэг.

## Ашигласан материал

Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011

Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт // Electoral System Design: The New International IDEA Handbook, (Орчуулсан: Батбаяр Г.), Уб., 2010

Лоуренс Денүк., Ричард Ниэми., Пиппа Норрис., Ардчилалуудыг харьцуулахуй: Сонгууль ба санал өгөлт глобаль төвшинд, (Орчуулсан: Мөнх-Эрдэнэ Д.), Уб., 2008

Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл, Уб., 2019

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), Уб., 2009

# Хавсралт[40]

## Хавсралт – 1

/Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн судалгаа/

| № | Аймаг, нийслэл | Мандат | Нам, эвсэл, бие даагч | | | | | | | | | | | | Сонгогдсон төлөөлөгч | Үүнээс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Ардын нам | | | Ардчилсан нам | | | ХҮН | | | Бие даагч | | | | Эмэгтэй | Хувь |
| | | | пийт | эм | хувь | пийт | эм | хувь | пийт | эм | хувь | пийт | эм | хувь | | | |
| 1 | Архангай | 41 | 28 | 3 | 10.7 | 12 | 3 | 25.0 | 1 | | 0.0 | | | | 41 | 6 | 14.6 |
| 2 | Баян – Өлгий | 41 | 18 | 3 | 16.7 | 23 | 2 | 8.7 | | | | | | | 41 | 5 | 12.2 |
| 3 | Баянхонгор | 35 | 23 | 4 | 17.4 | 12 | 2 | 16.7 | | | | | | | 35 | 6 | 17.1 |
| 4 | Булган | 29 | 15 | 6 | 40.0 | 14 | 3 | 21.4 | | | | | | | 29 | 9 | 31.0 |
| 5 | Говь – Алтай | 29 | 11 | 1 | 9.1 | 18 | 5 | 27.8 | | | | | | | 29 | 6 | 20.7 |
| 6 | Говьсүмбэр | 25 | 21 | 6 | 28.6 | 4 | 0 | 0.0 | | | | | | | 25 | 6 | 24.0 |
| 7 | Дархан – Уул | 41 | 24 | 3 | 12.5 | 16 | 0 | 0.0 | | | | 1 | 1 | 100.0 | 41 | 4 | 9.8 |
| 8 | Дорноговь | 35 | 27 | 5 | 18.5 | 8 | 1 | 12.5 | | | | | | | 35 | 6 | 17.1 |
| 9 | Дорнод | 35 | 19 | 3 | 15.8 | 15 | 0 | 0.0 | 1 | | 0.0 | | | | 35 | 3 | 8.6 |

[40] Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвөөс дээрхи судалгаар purevsuren@gec.gov.mn 2024 оны. 11 дүгээр сарын 04–ний өдөр цахим хэлбэрээр авсан болно.

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | **Дундговь** | 25 | **16** | 5 | 31.3 | **9** | 2 | 22.2 | | | | | | | 25 | 7 | 28.0 |
| 11 | **Завхан** | **35** | **19** | 3 | 15.8 | **16** | 3 | 18.8 | | | | | | | 35 | 6 | 17.1 |
| 12 | **Орхон** | **41** | 21 | 4 | 19.0 | **20** | 4 | 20.0 | | | | | | | **41** | 8 | 19.5 |
| 13 | **Өвөрхангай** | **41** | 29 | 8 | 27.6 | **12** | 2 | 16.7 | | | | | | | **41** | 10 | 24.4 |
| 14 | **Өмнөговь** | **35** | **13** | 2 | 15.4 | 21 | 2 | 9.5 | | | | 1 | | 0.0 | 35 | 4 | 11.4 |
| 15 | **Сүхбаатар** | 29 | **9** | 2 | 22.2 | **20** | 4 | 20.0 | | | | | | | 29 | 6 | 20.7 |
| 16 | **Сэлэнгэ** | **41** | 21 | 4 | 19.0 | **19** | 2 | 10.5 | 1 | | 0.0 | | | | **41** | 6 | 14.6 |
| 17 | **Төв** | **41** | 20 | 4 | 20.0 | 21 | 4 | 19.0 | | | | | | | **41** | 8 | 19.5 |
| 18 | **Увс** | **35** | **18** | 1 | 5.6 | **15** | 1 | 6.7 | | | | 2 | | 0.0 | 35 | 2 | 5.7 |
| 19 | **Ховд** | **41** | **14** | 3 | 21.4 | 27 | 4 | 14.8 | | | | | | | **41** | 7 | 17.1 |
| 20 | **Хөвсгөл** | **41** | 26 | 9 | 34.6 | **15** | 2 | 13.3 | | | | | | | **41** | 11 | 26.8 |
| 21 | **Хэнтий** | **35** | **17** | 4 | 23.5 | **18** | 3 | 16.7 | | | | | | | 35 | 7 | 20.0 |
| 22 | **Нийслэл** | **45** | 40 | 9 | 22.5 | 5 | 1 | 20.0 | | | | | | | **45** | 10 | 22.2 |
| | **НИЙТ ДҮН** | **796** | **449** | **92** | **20.5** | **340** | **50** | **14.7** | **3** | **0** | **0.0** | **4** | **1** | **25.0** | **796** | **143** | **18.0** |

**Хавсралт 2**

| № | М/д | Аймаг, нийслэл | Сум, дүүрэг | Мандат | Нам, эвсэл, бие даагч | | | | | | | | | Ни |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Ардын нам | Ардчилсан нам | Үндэсний эвсэл | ИЗНН | Иргэний хөдөлгөөний нам | ХҮН | Үнэн ба зөв нам | Иргэдийн оролцооны нэгдэл нам | Бие даагч | |
| | УЛСЫН ДҮН | | 339 | 7,235 | 3,879 | 3,231 | 5 | 4 | 23 | 5 | 1 | 1 | 86 | 7,23 |
| 1 | 1 | АРХАНГАЙ | Цэнхэр | 25 | 17 | 8 | | | | | | | | 25 |
| 2 | 2 | | Булган | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 3 | 3 | | Ихтамир | 25 | 8 | 17 | | | | | | | | 25 |
| 4 | 4 | | Чулуут | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 5 | 5 | | Хангай | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 6 | 6 | | Цахир | 21 | 19 | 2 | | | | | | | | 21 |
| 7 | 7 | | Тариат | 21 | 3 | 18 | | | | | | | | 21 |
| 8 | 8 | | Өндөр-Улаан | 25 | 17 | 8 | | | | | | | | 25 |
| 9 | 9 | | Эрдэнэмандал | 25 | 20 | 5 | | | | | | | | 25 |
| 10 | 10 | | Жаргалант | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 11 | 11 | | Цэцэрлэг | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 12 | 12 | | Хайрхан | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 13 | 13 | | Өлзийт | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 14 | 14 | | Батцэнгэл | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 15 | 15 | | Өгийнуур | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 16 | 16 | | Хашаат | 21 | 4 | 17 | | | | | | | | 21 |
| 17 | 17 | | Хотонт | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 18 | | Төвшрүүлэх | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 19 | 19 | | Эрдэнэбулган | 29 | 17 | 12 | | | | | | | | 29 |
| | | **Дүн** | **19** | **423** | **238** | **185** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **423** |
| 20 | 1 | БАЯН-ӨЛГИЙ | Алтай | 21 | 9 | 11 | | | | | | | 1 | 21 |
| 21 | 2 | | Алтанцөгц | 21 | 14 | 7 | | | | | | | 0 | 21 |
| 22 | 3 | | Баяннуур | 25 | 13 | 12 | | | | | | | 0 | 25 |
| 23 | 4 | | Бугат | 21 | 14 | 7 | | | | | | | 0 | 21 |
| 24 | 5 | | Булган | 25 | 17 | 8 | | | | | | | 0 | 25 |
| 25 | 6 | | Буянт | 21 | 10 | 10 | | | | | | | 1 | 21 |
| 26 | 7 | | Дэлүүн | 25 | 9 | 16 | | | | | | | 0 | 25 |
| 27 | 8 | | Ногооннуур | 25 | 14 | 11 | | | | | | | 0 | 25 |
| 28 | 9 | | Сагсай | 25 | 11 | 14 | | | | | | | 0 | 25 |
| 29 | 10 | | Толбо | 21 | 11 | 10 | | | | | | | 0 | 21 |
| 30 | 11 | | Улаанхус | 29 | 19 | 10 | | | | | | | 0 | 29 |
| 31 | 12 | | Цэнгэл | 29 | 22 | 7 | | | | | | | 0 | 29 |
| 32 | 13 | | Өлгий | 29 | 17 | 12 | | | | | | | 0 | 29 |
| | | **Дүн** | **13** | **317** | **180** | **135** | | | | | **0** | | **2** | **317** |
| 33 | 1 | БАЯНХОНГОР | Баянхонгор | 29 | 13 | 16 | | | | | | | | 29 |
| 34 | 2 | | Баацагаан | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 35 | 3 | | Баянбулаг | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 36 | 4 | | Баянговь | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 37 | 5 | | Баянлиг | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 38 | 6 | | Баян-Овоо | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 39 | 7 | | Баян-Өндөр | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 40 | 8 | | Баянцагаан | 21 | 1 | 20 | | | | | | | | 21 |
| 41 | 9 | | Богд | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 42 | 10 | | Бөмбөгөр | 21 | 2 | 19 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 11 | | Буунцагаан | 21 | 11 | 10 | | | | | | | | | 21 |
| 44 | 12 | | Галуут | 21 | 2 | 19 | | | | | | | | | 21 |
| 45 | 13 | | Гурванбулаг | 21 | 16 | 5 | | | | | | | | | 21 |
| 46 | 14 | | Жаргалант | 21 | 14 | 7 | | | | | | | | | 21 |
| 47 | 15 | | Жинст | 21 | 9 | 11 | | | 1 | | | | | | 21 |
| 48 | 16 | | Заг | 21 | 18 | 3 | | | | | | | | | 21 |
| 49 | 17 | | Өлзийт | 21 | 4 | 17 | | | | | | | | | 21 |
| 50 | 18 | | Хүрээмарал | 15 | 11 | 4 | | | | | | | | | 15 |
| 51 | 19 | | Шинэжинст | 21 | 6 | 15 | | | | | | | | | 21 |
| 52 | 20 | | Эрдэнэцогт | 21 | 18 | 3 | | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **20** | **416** | **204** | **211** | **0** | **0** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **416** |
| 53 | 1 | БУЛГАН | Баян-Агт | 21 | 1 | 4 | | | 12 | | | | 4 | 21 |
| 54 | 2 | | Баяннуур | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 55 | 3 | | Булган | 29 | 24 | 5 | | | | | | | | 29 |
| 56 | 4 | | Бугат | 21 | 1 | 18 | | | 2 | | | | | 21 |
| 57 | 5 | | Бүрэгхангай | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 58 | 6 | | Дашинчилэн | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 59 | 7 | | Гурванбулаг | 21 | 19 | 2 | | | | | | | | 21 |
| 60 | 8 | | Орхон | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 61 | 9 | | Могод | 21 | 15 | 5 | | | | | | | 1 | 21 |
| 62 | 10 | | Рашаант | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 63 | 11 | | Тэшиг | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 64 | 12 | | Сайхан | 21 | 3 | 18 | | | | | | | | 21 |
| 65 | 13 | | Сэлэнгэ | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 66 | 14 | | Хангал | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 67 | 15 | | Хутаг-Өндөр | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 68 | 16 | | Хишиг-Өндөр | 21 | 6 | 15 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Дүн** | **16** | **338** | **189** | **130** | **0** | **0** | **14** | **0** | **0** | **0** | **5** | **338** |
| 69 | 1 | ГОВЬ-АЛТАЙ | Есөнбулаг | 29 | 6 | 23 | | | | | | | | 29 |
| 70 | 2 | | Алтай | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 71 | 3 | | Баян-Уул | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 72 | 4 | | Бигэр | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 73 | 5 | | Бугат | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 74 | 6 | | Дарив | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 75 | 7 | | Дэлгэр | 21 | 10 | 9 | | | 2 | | | | | 21 |
| 76 | 8 | | Жаргалан | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 77 | 9 | | Тайшир | 15 | 14 | 1 | | | | | | | | 15 |
| 78 | 10 | | Тонхил | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 79 | 11 | | Төгрөг | 15 | 14 | 1 | | | | | | | | 15 |
| 80 | 12 | | Халиун | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 81 | 13 | | Хөхморьт | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 82 | 14 | | Цогт | 21 | 0 | 21 | | | | | | | | 21 |
| 83 | 15 | | Цээл | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 84 | 16 | | Чандмань | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 85 | 17 | | Шарга | 21 | 5 | 16 | | | | | | | | 21 |
| 86 | 18 | | Эрдэнэ | 21 | 19 | 2 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **18** | **356** | **209** | **145** | **0** | | **2** | | **0** | | **0** | **356** |
| 87 | 1 | ГОВЬСҮМБЭР | Сүмбэр | 29 | 22 | 7 | | | | | | | | 29 |
| 88 | 2 | | Шивээговь | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 89 | 3 | | Баянтал | 15 | 9 | 6 | | | | | | | | 15 |
| | | **Дүн** | **3** | **65** | **49** | **16** | **0** | | **0** | | **0** | | **0** | **65** |
| 90 | 1 | ДАРХАН-УУЛ | Дархан | 29 | 22 | 7 | | | | | 0 | | 0 | 29 |
| 91 | 2 | | Орхон | 21 | 17 | 4 | | | | | 0 | | 0 | 21 |
| 92 | 3 | | Хонгор | 25 | 20 | 5 | | | | | 0 | | 0 | 25 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 93 | 4 | | Шарынгол | 25 | 11 | 14 | | | | | 0 | | 0 | 25 |
| | | **Дүн** | **4** | **100** | **70** | **30** | **0** | | **0** | | **0** | | **0** | 100 |
| 94 | 1 | ДОРНОГОВЬ | Айраг | 21 | 1 | 20 | | | | | | | | 21 |
| 95 | 2 | | Алтанширээ | 15 | 9 | 6 | | | | | | | | 15 |
| 96 | 3 | | Даланжаргалан | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 97 | 4 | | Дэлгэрэх | 15 | 8 | 7 | | | | | | | | 15 |
| 98 | 5 | | Замын-Үүд | 29 | 22 | 7 | | | | | | | | 29 |
| 99 | 6 | | Иххэт | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 100 | 7 | | Мандах | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 101 | 8 | | Сайншанд | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 102 | 9 | | Сайхандулаан | 29 | 28 | 1 | | | | | | | | 29 |
| 103 | 10 | | Улаанбадрах | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 104 | 11 | | Хатанбулаг | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 105 | 12 | | Хөвсгөл | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 106 | 13 | | Эрдэнэ | 15 | 11 | 4 | | | | | | | | 15 |
| 107 | 14 | | Өргөн | 21 | 20 | 1 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **14** | **274** | **163** | **111** | **0** | | **0** | | **0** | | **0** | **274** |
| 108 | 1 | ДОРНОД | Хэрлэн | 29 | 12 | 16 | | | | | | | 1 | 29 |
| 109 | 2 | | Баяндун | 21 | 3 | 18 | | | | | | | | 21 |
| 110 | 3 | | Баянтүмэн | 21 | 11 | 5 | | | | | | | 5 | 21 |
| 111 | 4 | | Баян-Уул | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 112 | 5 | | Булган | 21 | 5 | 16 | | | | | | | | 21 |
| 113 | 6 | | Гурванзагал | 15 | 11 | 4 | | | | | | | | 15 |
| 114 | 7 | | Дашбалбар | 21 | 5 | 16 | | | | | | | | 21 |
| 115 | 8 | | Матад | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |
| 116 | 9 | | Сэргэлэн | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 117 | 10 | | Халхгол | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 118 | 11 | | Хөлөнбуйр | 15 | 11 | 1 | 3 | | | | | | | | 15 |
| 119 | 12 | | Цагаан-Овоо | 21 | 14 | 6 | | | 1 | | | | | | 21 |
| 120 | 13 | | Чойбалсан | 21 | 6 | 8 | | | | | | | | 7 | 21 |
| 121 | 14 | | Чулуунхороот | 15 | 12 | 3 | | | | | | | | | 15 |
| | | **Дүн** | **14** | **284** | **141** | **126** | **3** | | **1** | | **0** | | | **13** | **284** |
| 122 | 1 | ДУНДГОВЬ | Сайнцагаан | 29 | 12 | 17 | | | | | | | | | 29 |
| 123 | 2 | | Адаацаг | 21 | 21 | 0 | | | | | | | | | 21 |
| 124 | 3 | | Баянжаргалан | 15 | 9 | 6 | | | | | | | | | 15 |
| 125 | 4 | | Говь-Угтаал | 15 | 9 | 6 | | | | | | | | | 15 |
| 126 | 5 | | Гурвансайхан | 21 | 0 | 21 | | | | | | | | | 21 |
| 127 | 6 | | Дэлгэрхангай | 21 | 8 | 13 | | | | | | | | | 21 |
| 128 | 7 | | Дэрэн | 21 | 11 | 10 | | | | | | | | | 21 |
| 129 | 8 | | Дэлгэрцогт | 15 | 7 | 8 | | | | | | | | | 15 |
| 130 | 9 | | Луус | 15 | 4 | 11 | | | | | | | | | 15 |
| 131 | 10 | | Өлзийт | 21 | 6 | 15 | | | | | | | | | 21 |
| 132 | 11 | | Өндөршил | 15 | 10 | 5 | | | | | | | | | 15 |
| 133 | 12 | | Сайхан-Овоо | 21 | 8 | 11 | | | | | | | | 2 | 21 |
| 134 | 13 | | Хулд | 21 | 16 | 5 | | | | | | | | | 21 |
| 135 | 14 | | Цагаандэлгэр | 15 | 12 | 3 | | | | | | | | | 15 |
| 136 | 15 | | Эрдэнэдалай | 25 | 13 | 12 | | | | | | | | | 25 |
| | | **Дүн** | **15** | **291** | **146** | **143** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | | **2** | **291** |
| 137 | 1 | ЗАВХАН | Алдархаан | 21 | 10 | 11 | | | | | | | | | 21 |
| 138 | 2 | | Асгат | 15 | 4 | 11 | | | | | | | | | 15 |
| 139 | 3 | | Баянтэс | 21 | 10 | 11 | | | | | | | | | 21 |
| 140 | 4 | | Баянхайрхан | 15 | 3 | 12 | | | | | | | | | 15 |
| 141 | 5 | | Дөрвөлжин | 21 | 4 | 17 | | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 142 | 6 | | Завханмандал | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 143 | 7 | | Идэр | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 144 | 8 | | Их-Уул | 25 | 10 | 14 | | | | | | | 1 | 25 |
| 145 | 9 | | Нөмрөг | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 146 | 10 | | Отгон | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 147 | 11 | | Сантмаргац | 15 | 8 | 7 | | | | | | | | 15 |
| 148 | 12 | | Сонгино | 15 | 8 | 7 | | | | | | | | 15 |
| 149 | 13 | | Тосонцэнгэл | 29 | 11 | 18 | | | | | | | | 29 |
| 150 | 14 | | Түдэвтэй | 15 | 3 | 12 | | | | | | | | 15 |
| 151 | 15 | | Тэлмэн | 21 | 5 | 16 | | | | | | | | 21 |
| 152 | 16 | | Тэс | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 153 | 17 | | Ургамал | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 154 | 18 | | Улиастай | 29 | 17 | 12 | | | | | | | | 29 |
| 155 | 19 | | Цагаанчулуут | 15 | 14 | 1 | | | | | | | | 15 |
| 156 | 20 | | Цагаанхайрхан | 15 | 3 | 12 | | | | | | | | 15 |
| 157 | 21 | | Цэцэн-Уул | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 158 | 22 | | Шилүүстэй | 15 | 8 | 7 | | | | | | | | 15 |
| 159 | 23 | | Эрдэнэхайрхан | 15 | 8 | 7 | | | | | | | | 15 |
| 160 | 24 | | Яруу | 15 | 4 | 11 | | | | | | | | 15 |
| | | **Дүн** | **24** | **440** | **193** | **246** | **0** | **0** | **0** | | **0** | | **1** | 440 |
| 161 | 1 | ОРХОН | Баян-Өндөр | 29 | 16 | 13 | | | | | | | | 29 |
| 162 | 2 | | Жаргалант | 21 | 20 | 1 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **2** | **50** | **36** | **14** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | 50 |
| 163 | 1 | ӨВӨРХАНГАЙ | Арвайхээр | 29 | 26 | 3 | | | | | | | | 29 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 164 | 2 | | Баруунбаян-Улаан | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |
| 165 | 3 | | Бат-Өлзий | 25 | 20 | 5 | | | | | | | | 25 |
| 166 | 4 | | Баянгол | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 167 | 5 | | Баян-Өндөр | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 168 | 6 | | Богд | 25 | 17 | 8 | | | | | | | | 25 |
| 169 | 7 | | Бүрд | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 170 | 8 | | Гучин-Ус | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 171 | 9 | | Есөнзүйл | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 172 | 10 | | Зүүнбаян-Улаан | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 173 | 11 | | Нарийнтээл | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 174 | 12 | | Өлзийт | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 175 | 13 | | Сант | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 176 | 14 | | Тарагт | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 177 | 15 | | Төгрөг | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 178 | 16 | | Уянга | 29 | 16 | 13 | | | | | | | | 29 |
| 179 | 17 | | Хайрхандулаан | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |
| 180 | 18 | | Хархорин | 29 | 11 | 18 | | | | | | | | 29 |
| 181 | 19 | | Хужирт | 25 | 17 | 8 | | | | | | | | 25 |
| | | **Дүн** | **19** | **435** | **247** | **188** | **0** | **0** | **0** | | **0** | | **0** | **435** |
| 182 | 1 | ӨМНӨГОВЬ | Баяндалай | 21 | 7 | 12 | | | | | | | 2 | 21 |
| 183 | 2 | | Баян-овоо | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 184 | 3 | | Булган | 15 | 9 | 6 | | | | | | | | 15 |
| 185 | 4 | | Гурвантэс | 25 | 8 | 17 | | | | | | | | 25 |
| 186 | 5 | | Даланзадгад | 29 | 3 | 26 | | | | | | | | 29 |
| 187 | 6 | | Мандал-Овоо | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 188 | 7 | | Манлай сум | 21 | 5 | 16 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 189 | 8 | | Поён | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 190 | 9 | | Помгон | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 191 | 10 | | Сэврэй сум | 15 | 2 | 13 | | | | | | | | 15 |
| 192 | 11 | | Ханбогд | 25 | 10 | 15 | | | | | | | | 25 |
| 193 | 12 | | Ханхонгор | 15 | 14 | 1 | | | | | | | | 15 |
| 194 | 13 | | Хүрмэн | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 195 | 14 | | Цогт-Овоо | 15 | 1 | 14 | | | | | | | | 15 |
| 196 | 15 | | Цогтцэций | 29 | 6 | 22 | | | | | 1 | | | 29 |
| | | **Дүн** | **15** | **291** | **107** | **181** | **0** | **0** | **0** | | **1** | | **2** | **291** |
| 197 | 1 | СҮХБААТАР | Баруун-Урт | 29 | 4 | 25 | | | | | | | | 29 |
| 198 | 2 | | Асгат | 15 | 4 | 11 | | | | | | | | 15 |
| 199 | 3 | | Баяндэлгэр | 25 | 12 | 13 | | | | | | | | 25 |
| 200 | 4 | | Дарьганга | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 201 | 5 | | Мөнххаан | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 202 | 6 | | Онгон сум | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 203 | 7 | | Наран | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 204 | 8 | | Сүхбаатар | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 205 | 9 | | Түмэнцогт | 21 | 0 | 21 | | | | | | | | 21 |
| 206 | 10 | | Түвшинширээ | 21 | 19 | 2 | | | | | | | | 21 |
| 207 | 11 | | Уулбаян | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 208 | 12 | | Халзан сум | 15 | 13 | 2 | | | | | | | | 15 |
| 209 | 13 | | Эрдэнэцагаан | 25 | 6 | 19 | | | | | | | | 25 |
| | | **Дүн** | **13** | **271** | **118** | **153** | **0** | | **0** | | **0** | | **0** | **271** |
| 210 | 1 | СЭЛЭНГЭ | Алтанбулаг | 21 | 12 | 7 | | | 2 | | | | | 21 |
| 211 | 2 | | Баянгол | 25 | 15 | 10 | | | | | | | | 25 |
| 212 | 3 | | Баруунбүрэн | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 213 | 4 | | Ерөө | 25 | 9 | 15 | | | 1 | | | | | 25 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 214 | 5 | | Жавхлант | 21 | 2 | 19 | | | | | | | | 21 |
| 215 | 6 | | Зүүнбүрэн | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |
| 216 | 7 | | Мандал | 29 | 21 | 7 | | | | | | | 1 | 29 |
| 217 | 8 | | Орхон | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 218 | 9 | | Орхонтуул | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 219 | 10 | | Сант | 21 | 20 | 1 | | | | | | | | 21 |
| 220 | 11 | | Сайхан | 29 | 10 | 19 | | | | | | | | 29 |
| 221 | 12 | | Сүхбаатар | 29 | 19 | 10 | | | | | | | | 29 |
| 222 | 13 | | Хүдэр | 21 | 12 | 8 | | | | | | | 1 | 21 |
| 223 | 14 | | Хушаат | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 224 | 15 | | Түшиг | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 225 | 16 | | Цагааннуур | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 226 | 17 | | Шаамар | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **17** | **383** | **211** | **167** | **0** | **0** | **3** | **0** | **0** | **0** | **2** | 383 |
| 227 | 1 | ТӨВ | Зуунмод | 29 | 10 | 19 | | | | | | | | 29 |
| 228 | 2 | | Алтанбулаг | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 229 | 3 | | Аргалант | 15 | 4 | 11 | | | | | | | | 15 |
| 230 | 4 | | Архуст | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 231 | 5 | | Батсүмбэр | 25 | 9 | 16 | | | | | | | | 25 |
| 232 | 6 | | Баян | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 233 | 7 | | Баяндэлгэр | 15 | 2 | 13 | | | | | | | | 15 |
| 234 | 8 | | Баянжаргалан | 15 | 13 | 2 | | | | | | | | 15 |
| 235 | 9 | | Баян-Өнжүүл | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 236 | 10 | | Баянхангай | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 237 | 11 | | Баянцагаан | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 238 | 12 | | Баянцогт | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 239 | 13 | | Баянчандмань | 21 | 9 | 8 | | 4 | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 240 | 14 | | Борнуур | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 241 | 15 | | Бүрэн | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 242 | 16 | | Дэлгэрхаан | 15 | 10 | 5 | | | | | | | | 15 |
| 243 | 17 | | Жаргалант | 25 | 3 | 22 | | | | | | | | 25 |
| 244 | 18 | | Заамар | 25 | 9 | 16 | | | | | | | | 25 |
| 245 | 19 | | Лүн | 21 | 2 | 19 | | | | | | | | 21 |
| 246 | 20 | | Мөнгөнморьт | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 247 | 21 | | Өндөрширээт | 15 | 14 | 1 | | | | | | | | 15 |
| 248 | 22 | | Сүмбэр | 15 | 5 | 10 | | | | | | | | 15 |
| 249 | 23 | | Сэргэлэн | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 250 | 24 | | Угтаалцайдам | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 251 | 25 | | Цээл | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 252 | 26 | | Эрдэнэ | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 253 | 27 | | Эрдэнэсант | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **27** | **527** | **235** | **288** | **0** | **4** | **0** | | **0** | | **0** | 527 |
| 254 | 1 | УВС | Баруунтуруун | 21 | 8 | 5 | | | | | | | 8 | 21 |
| 255 | 2 | | Бөхмөрөн | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 256 | 3 | | Давст | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 257 | 4 | | Завхан | 15 | 6 | 9 | | | | | | | | 15 |
| 258 | 5 | | Зүүнговь | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 259 | 6 | | Зүүнхангай | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 260 | 7 | | Малчин | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 261 | 8 | | Наранбулаг | 21 | 4 | 17 | | | | | | | | 21 |
| 262 | 9 | | Өлгий | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 263 | 10 | | Өмнөговь | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 264 | 11 | | Өндөрхангай | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 265 | 12 | | Сагил | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 266 | 13 | | Тариалан | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 267 | 14 | | Түргэн | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 268 | 15 | | Тэс | 25 | 15 | 10 | | | | | | | | 25 |
| 269 | 16 | | Ховд | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 270 | 17 | | Хяргас | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 271 | 18 | | Цагаанхайрхан | 21 | 9 | 12 | | | | | | | | 21 |
| 272 | 19 | | Улаангом | 29 | 19 | 10 | | | | | | | | 29 |
| | | **Дүн** | **19** | **399** | **224** | **167** | **0** | **0** | **0** | | **0** | | **8** | **399** |
| 273 | 1 | ХОВД | Жаргалант | 29 | 6 | 23 | | | 0 | | | | 0 | 29 |
| 274 | 2 | | Алтай | 21 | 15 | 6 | | | 0 | | | | 0 | 21 |
| 275 | 3 | | Булган | 29 | 19 | 3 | | | 0 | | | | 7 | 29 |
| 276 | 4 | | Буянт | 21 | 12 | 9 | | | 0 | | | | 0 | 21 |
| 277 | 5 | | Дарви | 21 | 7 | 14 | | | 0 | | | | 0 | 21 |
| 278 | 6 | | Дуут | 15 | 10 | 5 | | | 0 | | | | 0 | 15 |
| 279 | 7 | | Дөргөн | 21 | 7 | 14 | | | 0 | | | | 0 | 21 |
| 280 | 8 | | Зэрэг | 21 | 4 | 17 | | | 0 | | | | 0 | 21 |
| 281 | 9 | | Манхан | 21 | 4 | 17 | | | 0 | | | | 0 | 21 |
| 282 | 10 | | Мянгад | 21 | 8 | 13 | | | 0 | | | | 0 | 21 |
| 283 | 11 | | Мөнххайрхан | 21 | 14 | 7 | | | 0 | | | | 0 | 21 |
| 284 | 12 | | Мөст | 21 | 10 | 9 | | | 2 | | | | 0 | 21 |
| 285 | 13 | | Ховд | 21 | 14 | 7 | | | 0 | | | | 0 | 21 |
| 286 | 14 | | Цэцэг | 21 | 4 | 17 | | | 0 | | | | 0 | 21 |
| 287 | 15 | | Чандмань | 21 | 11 | 10 | | | 0 | | | | 0 | 21 |
| 288 | 16 | | Үенч | 21 | 8 | 13 | | | 0 | | | | 0 | 21 |
| 289 | 17 | | Эрдэнэбүрэн | 21 | 8 | 13 | | | 0 | | | | 0 | 21 |
| | | **Дүн** | **17** | **367** | **161** | **197** | **0** | | **2** | | **0** | | **7** | **367** |
| 290 | 1 | ХӨВСГӨЛ | Алаг-Эрдэнэ | 25 | 7 | 18 | | | | | | | | 25 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 291 | 2 | | Арбулаг | 21 | 15 | 6 | | | | | | | | 21 |
| 292 | 3 | | Баянзүрх | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 293 | 4 | | Бүрэнтогтох | 21 | 9 | | | | | | | | 12 | 21 |
| 294 | 5 | | Галт | 25 | 21 | 4 | | | | | | | | 25 |
| 295 | 6 | | Жаргалант | 25 | 10 | | | | | | | | 15 | 25 |
| 296 | 7 | | Их-Уул | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 297 | 8 | | Мөрөн | 29 | 19 | 10 | | | | | | | | 29 |
| 298 | 9 | | Рашаант | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 299 | 10 | | Рэнчинлхүмбэ | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 300 | 11 | | Тариалан | 25 | 18 | 7 | | | | | | | | 25 |
| 301 | 12 | | Тосонцэнгэл | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 302 | 13 | | Төмөрбулаг | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 303 | 14 | | Түнэл | 21 | 14 | 7 | | | | | | | | 21 |
| 304 | 15 | | Улаан-Уул | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 305 | 16 | | Ханх | 21 | 18 | 3 | | | | | | | | 21 |
| 306 | 17 | | Цагааннуур | 21 | 10 | 11 | | | | | | | | 21 |
| 307 | 18 | | Цагаан-Уул | 25 | 9 | 16 | | | | | | | | 25 |
| 308 | 19 | | Цагаан-Үүр | 21 | 19 | 2 | | | | | | | | 21 |
| 309 | 20 | | Цэцэрлэг | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 310 | 21 | | Чандмань-Өндөр | 21 | 4 | | | | | | | | 17 | 21 |
| 311 | 22 | | Шинэ-Идэр | 21 | 21 | 0 | | | | | | | | 21 |
| 312 | 23 | | Эрдэнэбулган | 21 | 4 | 17 | | | | | | | | 21 |
| | | **Дүн** | **23** | **511** | **313** | **154** | **0** | | **0** | | **0** | | **44** | **511** |
| 313 | 1 | ХЭНТИЙ | Жаргалтхаан | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 314 | 2 | | Хэрлэн | 29 | 14 | 15 | | | | | | | | 29 |
| 315 | 3 | | Өмнөдэлгэр | 25 | 6 | 19 | | | | | | | | 25 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 316 | 4 | | Дархан | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 317 | 5 | | Галшар | 21 | 8 | 13 | | | | | | | | 21 |
| 318 | 6 | | Батноров | 25 | 11 | 14 | | | | | | | | 25 |
| 319 | 7 | | Дадал сум | 21 | 11 | 10 | | | | | | | | 21 |
| 320 | 8 | | Батширээт | 21 | 3 | 18 | | | | | | | | 21 |
| 321 | 9 | | Дэлгэрхаан | 21 | 7 | 14 | | | | | | | | 21 |
| 322 | 10 | | Баянмөнх | 15 | 7 | 8 | | | | | | | | 15 |
| 323 | 11 | | Цэнхэрмандал | 21 | 16 | 5 | | | | | | | | 21 |
| 324 | 12 | | Мөрөн | 15 | 9 | 6 | | | | | | | | 15 |
| 325 | 13 | | Баянхутаг | 21 | 13 | 8 | | | | | | | | 21 |
| 326 | 14 | | Норовлин | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 327 | 15 | | Биндэр | 21 | 17 | 4 | | | | | | | | 21 |
| 328 | 16 | | Баян-Адарга | 21 | 12 | 9 | | | | | | | | 21 |
| 329 | 17 | | Баян-Овоо | 15 | 11 | 4 | | | | | | | | 15 |
| 330 | 18 | | Бор-Өндөр | 29 | 18 | 11 | | | | | | | | 29 |
| | | **Дүн** | **18** | **384** | **195** | **189** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **384** |
| 331 | 1 | УЛААНБААТАР | Баянзүрх | 43 | 38 | 5 | | | | | | | | 43 |
| 332 | 2 | | Баянгол | 41 | 39 | | 2 | | | | | | | 41 |
| 333 | 3 | | Чингэлтэй | 35 | 33 | 2 | | | | | | | | 35 |
| 334 | 4 | | Сүхбаатар | 35 | 12 | 23 | | | | | | | | 35 |
| 335 | 5 | | Сонгинохайрхан | 43 | 43 | 0 | | | | | | | | 43 |
| 336 | 6 | | Хан-Уул | 41 | 30 | 9 | | | | 1 | | 1 | | 41 |
| 337 | 7 | | Налайх | 25 | 23 | 2 | | | | | | | | 25 |
| 338 | 8 | | Багануур | 25 | 13 | 8 | | | | 4 | | | | 25 |
| 339 | 9 | | Багахангай | 25 | 19 | 6 | | | | | | | | 25 |
| | | **Дүн** | **9** | **313** | **250** | **55** | **2** | **0** | **0** | **5** | **0** | **1** | **0** | **313** |

# ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ШУУД АРДЧИЛЛЫН ЭЛЕМЕНТ

Д.Батзаяа

Өнөөгийн хүний амьдралын амьдрах бодит эрх зүйн орчин, түүний хангалттай байдал улам бүр хумигдсаар... Хүмүүсийн дунд үүссэн тэгш бус байдал, ашиг сонирхлын зөрчил зэрэг хувь хүний хүчин зүйлсээс гадна орон нутгийг дээрээс хэт төвлөрүүлэн удирдаж буй явдал, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын бие даасан байдал, хангагдаагүй байдал зэрэг ч нөлөөлж байгаа билээ. Засаглалын харилцаанд оролцох иргэдийн оролцоог дээшлүүлж, төр засгаас хэрэгжүүлж буй бодлогод жирийн иргэдийн санаа, бодлыг илүүтэй тусгаж, хүмүүсийг идэвхитэй татан оролцуулах, зохион байгуулалтын хэлбэрүүдийг дэмжих хэрэгтэй байна.[1]

Тодорхой улс үндэстний хүрээнд хөгжиж буй ардчилалд нөлөөлөх хүчин зүйлсийн тухай асуудлыг тухайн ард түмний сэтгэлгээ, шашин, соёл, иргэншил, төрт ёсны үндэсний онцлогоос ангид авч үзэх боломжгүй юм. Үүнийг нэг талаас тухайн ард түмний ардчилсан үзэл санааны уламжлалыг тээгчдийн орон зай, нөгөө талаас ардчиллын хөгжилд нөлөөлөх макросоциаль хүчин зүйлсийн тогтолцоо гэж үзэж болно. Сэтгэлгээ, шашин, соёл, иргэншил, төрт ёс бол нэг орон зайд буюу байгаль-газар зүйн орчинд, нэг төрлийн угсаа, гарал бүхий хүмүүсийн дунд цаг хугацааны тодорхой дараалалгүйгээр нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж, харилцан шүтэлцээтэйгээр үүсэж хөгждөг, үзэгдэл, үйл явцууд билээ.

Монгол Улс ардчиллын замаар хөгжсөн онцлогийг төрүүлж буй суурь хүчин зүйл нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, нийгэм, иргэншлийн үндэсний хөрс суурь, шашин, соёл, сэтгэлгээний өвөрмөц байдалтай холбоотой билээ. Зохиогчид эл бүтээлийг “Монголын ардчилал: уламжлал ба судалгааны арга зүйд холбогдох зарим асуудал”, “Төлөөллийн ардчиллын сул тал, бэрхшээлийг шууд ардчиллын хэлбэрүүдээр даван туулах боломж, түүнийг ашиглах оролдлогын шинжилгээ” гэсэн үндсэн гурван бүлэгт хувааж

[1] “Хүний хөгжил” УБ, 2006 он

шинжлэхдээ дээр дурдсан үндсэн ойлголтууд болон үзэл баримтлалынхаа чиг шугамыг гол ноён нуруу болгохыг хичээсэн болно.[2]

Дэлхийн улс, орнуудын дийлэнхи нь ардчилсан үзэл баримтлалтай байгаа. Улсаа удирдаж буй төр нь шат, дараалалтайгаар иргэдээ захиран, хариуцдаг. Бүтцийн хувьд мэдээж өөр, өөр. Монгол улс маань ч гэсэн үе, шаттайгаар оршин тогтнодог. Үе, шатуудын нэг болох Орон нутгийн удирдлага гэдэгт нийслэл, аймаг, дүүрэг, сум, хороо, багийн удирдлагууд ордог. Иргэдтэй харьцангуй ойр ажиллах төрийн удирдлагууд болох үүрэг, хариуцлагатай албадууд. Манайхны зүйр үг оргүй байдаггүй. Хаанаасаа хаалгач нь хэмээж өөрсдөд тулгарсан асуудлаа тухайн хүмүүст эхлэн тавьдаг.

Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нийслэл хот, 21 аймагт, нийслэл хот нь 9 дүүрэг, дүүргүүд нь 152 хороонд, 21 аймаг нь 330 сум, сумд нь 1592 багт хуваагдаж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь томорч нэгжийн шат өсөх тусам сум, дүүрэг, аймаг, нийслэлийн эрхлэх асуудлыг иргэд нийтээр хуралдан шийдвэрлэх боломжгүй болдог. Иим учраас иргэд сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан засаглалын үйл ажиллагаанд оролцох "төлөөлөх байгууллага" шаардлагатай байдаг бөгөөд үүнийг төлөөллийн ардчилал ч гэж нэрлэдэг. Үндсэн хуульд "Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал" хэмээн тодорхойлжээ.[3]

Аймаг, нийслэл, сум, дүүрэгт Иргэдийн төлөөлөгчид ажиллахдаа хурал хийж байх бөгөөд жилд хоёроос доошгүй удаа хуралдах ёстой. Иргэдийн нийтийн хурал нь баг, хорооны хувьд байдаг бөгөөд жилд 3-аас доошгүй удаа хуралдах ёстой хэмээн хуульд заасан байдаг. ИТХ, ИНХ хуралдаагүй үед тэдгээрийн Тэргүүлэгчид нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд өөрсдөд хамаарах асуудлыг шийдвэр гаргах эрхтэйгээр заасан. Тухайн төлөөлөл болж сонгогдсон хүмүүсийн хувьд дараах зүйлсийг цогцоор нь хийж, бүтээж явах ёстой. Үүнд:

- Өөрсдийн хамтарсан хуралдааныг хийх, дараагийн хүмүүсийг хэрхэн сонгох, хяналт хариуцлага тавих, хийхээр шийдсэн ажлын төсөв батлах

[2] "Монголын ардчилал" УБ, 2021 он

[3] "Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаархи иргэдийн иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааны тайлан" УБ, 2015 он

- Хариуцсан газар, нутгийнхаа хэмжээнд иргэдэд зориулан хийх ажил болох ирээдүйн хөгжлийн гарц, үр шимийг хэрхэн бий болгох, салбар бүрээр ангилан авч үзэх
- Орон нутгийн хэмжээнд байх өмчийг хэрхэн нийтэд зөв, ашигтайгаар захиран, зарцуулах үүрэг, хариуцлагаа үүрэх
- Хуульд заасан байдлаар ажил, үүргээ гүйцэтгэх явдал юм.

Гэвч өнөөгийн Монгол улсын хувьд аль ч салбарын хууль бүрэн зааснаараа хэрэгжихгүй дэгэн, догон гэсэн байдалтай байгаад нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Иргэдийн оршин, амьдарч буй орчинд асуудлууд гарсаар байгаа. Заавал шүүмж бичих чухал биш. Гэхдээ хэн ч ирээдүйгээ бодож бодлого гаргаж, түүнийгээ хэрэгжүүлж хөгжиж дэвшиж байхыг илүүд үзнэ. Үе тэнгийн найз, нөхөд болох залуусын дийлэнхи нь хотын иргэн болж төрж, өссөн. Тэд нартай ярилцаж суухдаа Иргэдийн нийтийн хуралд сууж үзсэн үү гэхэд бүгд үгүй хэмээж байна.

Тухайн хариуцан ажиллах газар, нутгийн хүрээнд оршин суугаа иргэдтэйгээ байнгын ажиллаж, ажлын байран дээрээ ихэнхи цаг хугацаагаа өнгөрөөх хүмүүс. Цалингүй байж болно гэж өөрсдөө иргэд дотроосоо сонгогдсон төлөөлөл болох хүн. Хөндлөнгөөс харахад хороо, баг, сумын ажилчиддаа надад мэдээлэл ирвэл аваад байж байгаарай гээд гараад алга болж буй мэт бодогдоно. Муухан асуудал гарвал өөрсдөд нь хариуцлага цуг тооцохоор. Гэхдээ байнга ажиллаж байгаа ажлын байран дээрхи ажилчид нь л үүрч байна. Иргэддээ хурлаа зарлаж, хийх асуудлаа хамтдаа ярилцаж, шийдвэрлэж суувал илүү үр дүн гарах алба.

Олон нийтээр хуралдах, чуулах үедээ төрийн засаглал дахь иргэдийн оролцооны асуудал, улс дотроо тэр тал дээр хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн орчин, төсвийн талаар иш татан дурьддаг. Хуралдаанд оролцож буй хүмүүстэй хэлэлцээр байдлаар ярилцах нь мэдээж. Гэхдээ иргэдийн бодит дуу хоолой, санал шүүмж гарах нь ховор. Өөрсдийнх нь эрх чөлөөг хангах чадварыг дээшлүүлж явж байна, нээлттэй байна хэмээдэг ч бусад улстай энэ асуудлаар харьцуулж үзвэл 1996 оноос хойш ахицтай өсөлт гараагүй дүгнэгдсэн байрандаа байсаар байна.

Улсын хөгжил иргэнээс хамаарна. Хөгжлийн индекс чухал. Иргэнээ хэр зэрэг хөгжүүлж чадсан байна гэдэг тухайн улсын төрөөс явуулж буй бодлогоос харагдана. Ээлжлэн нар мандаж, жаргаж буй мэт эргэх нэгэн тойрог цикл үйл ажиллагаа. Хариуцан ажиллаж буй орон нутгийнхаа иргэдээс нээлттэйгээр

санал асуулга авч, харилцан ажиллаж байж сайн ажлын үр дүн, чанар харагдах биз ээ. Гарсан үр дүнгээ ч гэсэн тогтмол нийтэд мэдээллэж байх нь тухайн хамт олны чадавхи. Энэ бүхнээс ардчилал гэх үзэлтэй төр бодитоор төлөвшиж, хөгжих болно.

Ардчилсан эрх зүйт төрийг бүрдүүлэх үнэхээр амаргүй байх. Нийт иргэдийн хувьд тэдний амьдрал, амьжиргаатай холбоотой чухал асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргахад оролцох оролцоог хангахад орон нутгийн ардчилсан институц, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагын манлайлал гэх мэт талуудын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Иргэдийн оролцоонд ач холбогдол өгөх нь иргэдэд мэдээлэлд суурилсан ухамсартай сонголт хийхэд ч чухал.

Хүн, хүний бодол, үзэл өөр ч гэсэн нэгэн зүгт, зорилго, зорилттойгоор хөдлөх нь хамт олны, багийн ажиллагаа болох болно. Нэгнийгээ хүлээцтэй сонсож, харах өнцгийг нь шууд үгүйсгэлгүй бусдын оронд өөрийгөө тавьж үзэх илүүдэхгүй. Оролцогчдын санал бодлоос нь авах зүйл ч бий, хаях зүйл ч бий. Иргэдийн төлөөллөө сонгон, өөрсдөд тулгарсан асуудлаа шийдэхийн тулд явуулж буй ИТХ-ын сонгууль нь ил тод, нээлттэй байдалтай байж, хамрах хүрээ өргөнтэй, оролцоо нь ч тэгш эрхтэй байх зарчим дээр суурилж, хэнийг ч хаалганы гадна үлдээлгүй явагдвал гарах үр дүн ч сайн болж, дүгнэхэд ч хялбар болно биз ээ.

Иргэний нийгмийн оролцоогүйгээр ардчилсан нийгмийг төсөөлөх аргагүй хэмээдэг. Төрийн зүгээс иргэнийхээ үгийг сонсдог байх ёстой. Тэдэнд шуурхай, ил тод, нээлттэй байдалтайгаар явуулдаг байхын төлөө ажиллаж байх нь ардчиллын чухал зарчмуудад ордог.

Зөвхөн хуулинд шууд ардчилалаа заахгүй, хийх бодлого, үйл ажиллагаануудад хүртэл оруулдаг. Жишээ нь:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр \2013-2017\-т гэхэд:

  1.5.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороонд шууд ардчилал иргэдийн оролцоог дэмжих нийтийн өмгөөллийн тогтолцоо сүлжээг бий болгох

  1.5.5. Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн талаархи хууль эрх зүйн шинэтгэлийг хийж, шууд ардчилал, иргэдийн оролцооны тогтолцоог бүрдүүлнэ.

2.1.2. Шууд ардчилал иргэдийн оролцоогоор дамжуулан төсвийн төвлөрлийг сааруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр \2017-2021\-т гэхэд:

  2.1.4.Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, шат дамжлагагүй хүргэх зорилгоор олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, онлайн хэлбэрт шилжүүлэх, шууд ардчилал, иргэний оролцооны сайн туршлагуудыг үргэлжлүүлэн төлөвшүүлэхийг дэмжин ажиллана.[4] хэмээн заасан байдаг.

Мөн “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг” хүртэл нээлттэйгээр 2021 оны 02 дугаар сарын 22-нд явуулжээ.




Аймгийн ИТХ-ын ажлын алба, Эрх зүй, нутгийн удирдлагын хорооноос Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд иргэд, олон нийтийн санал авах хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчид, Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нар, Аймгийн ИТХ-ын үе үеийн дарга, нарийн бичгийн дарга, Үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутатууд, нам, олон нийтийн байгууллага, эрдэмтэд, төрийн байгууллагын төлөөлөл оролцлоо.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагалдан 30 орчим хуульд нэмэлт, өөрчлөлт орно. Үүний дагуу Хот тосгоны эрх зүйн

4 http://www.legalinfo.mn/

байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэнэ. Хуулийн төсөл хэлэлцэхтэй холбоотой орон нутгийн иргэдийн саналыг авахаар энэхүү хэлэлцүүлгийг зохион байгууллаа.Хэлэлцүүлэгт оролцогсод хуулийн төслийн хүрээнд Орхон аймгийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчныг дордуулсан байгааг онцолж байлаа.

Тодруулбал, Орхон аймаг улсын зэрэглэлтэй хот болсноор газар нутгийн хэмжээ нэмэгдэхгүй, төсөв санхүүгийн үйлчлэл тодорхойгүй, өмч эзэмшигчийн эрх үүрэг тодорхой бус байгааг хэлж байна. Мөн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн уялдаа холбоо байхгүй, иргэдийн төрд төлөөлөх төлөөлөгчийг сонгох зарчмыг баримтлаагүй, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн орчныг дордуулж, эрхийг хязгаарласан гэж үзэж байна. Мөн хэлэлцүүлгийн үер найруулгын шинж чанартай, зарим зүйл заалтыг нарийн тодорхой болгосон зохицуулалт оруулах шаардлагатай байгааг илэрхийлж байлаа.

Хэлэлцүүлэгт оролцогсод хуулийн төслийг дахин хэлэлцэж, АИТХ-ын хуралдаанаар оруулж гарсан шийдвэр, саналыг тогтоол болгон баталгаажуулж,

хууль боловсруулах буй ажлын хэсэгт хүргүүлэх шаардлагатай байгааг илэрхийллээ. Мөн энэ хуулийн төсөл дээр Орхон аймгаас УИХ-д сонгогдсон гишүүд бүлэг байгуулж, Орхон аймаг, эрдэнэт хотын иргэдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй гэдгийг илэрхийлж байлаа.

Харин 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрс хэрэгжиж эхлээд байгаа Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай холбоотой хэд, хэдэн асуудал иргэдийн сонгох, сонгогдох эрх болоод, төрийн үйл хэрэгт төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох боломжийг хязгаарласан.

Орчин тойронд нь тулгамддаг асуудлаа иргэд нь өөрсдөө тодорхойлон гаргаж саналаа өгдөг, иргэдийн өгсөн саналынх нь дагуу төлөвлөлт хийж, хэрэгжүүлдэг тогтолцоо бол “Орон нутгийн хөгжлийн сан” (ОНХС) юм. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд жил бүр 1-6 дугаар сард иргэдээс санал асуулгын хуудас бөглүүлэх, бүлгийн ярилцлага хийх, цахим гэсэн гурван хэлбэрээр санал авдаг.

Иргэд зөвхөн саналаа өгөхөөс гадна тухайн саналдаа олны дэмжлэг авч, батлуулахын тулд баг/хорооны Иргэдийн нийтийн хуралдаа идэвхтэй оролцох хэрэгтэй. Иргэд хувиараа санал өгөхөөс илүүтэйгээр гэр бүл, гудамж, байр, хороогоороо нэгдэж ярилцан нийтийн эзэмшил газар, хүрээлэн буй орчноо

сайжруулах ажилд санал өгөх нь илүү үр дүнтэй. Учир нь иргэдийн саналын хамгийн их санал авч эрэмбэлэгдсэн ажил дээр ИНХ-ын хуралдааны үеэрээ ярилцан, хэлэлцэж баталдаг.

ОНХС-д санал өгөх нь өөрийнхөө төлсөн татвараар өөрийнхөө амьдрах орчноо сайжруулах, нийгмийн хөгжилд зарцуулж буй хэрэг юм. Цугласан саналыг иргэд нийтээрээ хэлэлцэн эрэмбэлж, батлах нь хамгийн зөв шийдвэр гарахад нөлөөлнө. Иргэдийн санал, санаачилгаар амьдрах орчныг нь сайжруулах цахим санал асуулга 6 дугаар сарын 1 хүртэл үргэлжилнэ. 2022 оны хувьд улс орон даяар гар утасны аппликейшнээр дамжуулан саналаа өгөх боломжтой болж байгаагаараа онцлог байсан байна.

Политологи сэтгүүл XX дээр “МОНГОЛ УЛСЫН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН”-д эрдэмтдийн дүгнэснийг харвал:

> “Нутгийн өөрөө удирдах ёс нь ард түмний эрх мэдлийн хэвтээ хуваарилалтын бодит илэрхийлэл төдийгүй төрөөс (төвөөс) захирч, чиглүүлж оролцохгүйгээр зөвхөн нутгийн иргэд орон нутгийнхаа асуудлыг өөрсдөө бие даан шийдвэрлэх боломжийг хангасан эдийн засгийн төдийгүй эрх зүйн онцгой статус, ардчилсан ёсны чухал институц юм. Манайд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дахь иргэдийн оролцооны талаарх олон нийтийн ойлголт, хандлага хангалтгүй байгаа нь:
>
> 1. ИТХ-ийн сонгуульд төдийлөн ач холбогдол өгөхгүй байх
> 2. ИТХ-ын үйл ажиллагаанд ардчилсан зарчим алдагдах
> 3. ИТХ-үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байхад хүргэж байна.
>
> Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэхэд олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх, шийдвэрт тусгах боломжийг олгодог зөвлөлдөх санал асуулгыг хэрэглэх нь тус байгууллагын хөгжилд төдийгүй, монгол улс дахь ардчиллыг бэхжүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Монгол Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагын дутагдалтай талуудыг нөхөхөд “Зөвлөлдөх ардчилал” эерэг үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:
>
> - Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал шийдвэрүүд явцуу ашиг сонирхлоос холдож, амьдралд ойр, оновчтой болоход нөлөөлнө.

- Нутгийн өөрөө удирдах байгууллагад зөвлөлдөх ардчиллыг хэрэглэх нь зохистой. Тухайлбал, Хүн амын тоо олон байх тусам зөвлөлдөх ардчилал илүү оновчтой.
- Иргэд зөвлөлдөх ардчиллаар дамжуулан, улс төрийн оролцоо, соёлд суралцах төдийгүй ИНХ-д ач холбогдол өгч оролцох хандлага нэмэгдэх боломжтой.
- Зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж, ач холбогдол нь ардчиллын бусад инстиутциудээс илүүтэй нутгийн өөрөө удирдах байгууллагад байна.
- Улс төрийн намаар талцах үзэгдлийг эрс бууруулах ач холбогдолтой.
- Сонгодог ардчиллыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Дэлхийн хүн ам ихтэй улс орны туршлагаас харахад төрийн бодлого, шийдвэрт иргэдийн саналыг тусгахад зөвлөлдөх санал асуулгыг ашиглаж байна.

ИТХ-ын хувьд орон нутагтаа байгаа иргэдийг аль болох өргөн хүрээнд оролцуулах боломжийг эрж хайх хэрэгтэй. Олон хүмүүс тэр дундаа залуучууд оролцдоггүй. Тиймээс хүрч ажиллахад хүндрэлтэй бүлгийн жагсаалтыг гаргаж ягаад хүрч ажиллах боломжгүй байгаа, тэдэнтэй харилцахад ямар саад, бэрхшээл гараад байна гэдгийг тогтоох нь зүйтэй. Зөвлөлдөх санал асуулгыг амжилттай зохион байгуулж явуулснаар шийдвэр гаргагч иргэдийн санаа бодлыг сонсох, мэдрэх, улмаар шийдвэр гаргахдаа тэдний нийтлэг ашиг сонирхлыг тусгах болон шийдвэр гаргах үйл явцад иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх боломжтой болно.

Нутгийн өөрөө удирдах бүх шатны байгууллага болон ОНХС-гийн үйл ажиллагааны эрх зүйн институциональ боломжийг судалж үзсэнээр хууль, дүрмээ баримтлан ажиллахад харшлах зүйлгүй болох нь тодорхой харагдаж байна." хэмээжээ.

"Иргэд сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтнаар дамжуулалгүй нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд өөрсдөө биеэр оролцдог. Шууд ардчилал бол төлөөлөгчид эсвэл завсрын ямар нэг дамжлагагүйгээр иргэд шийдвэр гаргах үйл явцад биечлэн оролцдог улс төрийн систем юм." хэмээн Википедиа сэтгүүлд бичсэн байдаг.

Улсаа зөв хөгжилд чиглүүлж, нийтийг төлөөлөн ажиллах ахисан түвшин болох УИХ-ын сонгууль ч ИТХ-ын төлөөлөлтэй холбоотой болж ирэх нь аргагүй. Ардчилсан үзэлтэй улс шүү дээ. Энэ жил Монгол улсын хувьд УИХ болон Орон нутгийн сонгуулиуд болж өндөрлөлөө. Харьцангуй залуус хүмүүс сонгогдож буй мэт харагдана. Хөтөлбөрийг нь харин юутай ч хаяхгүй, гарах үр дүнтэй нь харьцуулж үзэх болно хэмээн бодоод цааш далд хийчихлээ, өөрийн хувьд.

Орон нутгийн сонгуульд санал өгсөн байдлыг www.ikon.mn дээр тавьсан мэдээллээс авч үзвэл 2024 оны ИТХ-ын сонгуульд нийт 13 нам, эвслээс 17,278 нэр дэвшигч оролцож, нийт 2395 тойрогт, 8031 тандатын төлөө өрсөлдөнө хэмээн оролцоход насанд хүрсэн 2,107,290 хүн байдгаас 1,119,881 хүн саналаа өгчээ. Аймаг, нийслэлийн хувьд МАН 40 суудал, АН 5 суудал авчээ. Харин аймаг, нийслэлийн ИТХ-ын 796 мандатад МАН 449, АН 340, "ХҮН" нам 3, бие даан нэр дэвшигч 4 суудал авсан байна. Сонгуулийн дүнгээр 14 аймаг болон нийслэлд МАН, 7 аймагт АН голлох болсон байна.

НАМ

| Нэр | Аймаг/Нийслэл | Сум/Дүүрэг |
|---|---|---|
| 1. Монгол Ардын нам<br>МАН | 796 | 7,186 |
| 2. Ардчилсан нам<br>АН | 792 | 7,080 |
| 3. Үндэсний эвсэл<br>ҮЭ | 41 | 110 |
| 4. Иргэний зориг ногоон нам<br>ИЗНН | 68 | 152 |
| 5. Шинэ нэгдсэн эвсэл<br>ШНЭ | 0 | 1 |
| 6. Эрхчөлөөг хэрэгжүүлэгч нам<br>ЭХН | 1 | 0 |
| 7. Иргэний хөдөлгөөний нам<br>ИХН | 30 | 267 |
| 8. ХҮН нам<br>ХҮН | 140 | 184 |
| 9. Үнэн ба Зөв нам<br>ҮБЗН | 22 | 19 |

| Нэр | Аймаг/Нийслэл | Сум/Дүүрэг |
|---|---|---|
| 10. Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам САИНН | 10 | 20 |
| 11. Ард түмний олонхийн засаглал нам АТОЗН | 18 | 0 |
| 12. Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам ИОНН | 33 | 40 |
| Бие даан нэр дэвшигч БД | | 227 |

## САНАЛ ӨГӨХ ХҮМҮҮС

| **Эрэгтэй 50.2%** 502,513 / 1,000,637 | **Нас** | **Эмэгтэй 56.0%** 617,368 / 1,101,951 |
|---|---|---|
| 35.7% | 18-19 | 33.1% |
| 31.2% | 20-24 | 31.3% |
| 35.4% | 25-29 | 39.9% |
| 42.2% | 30-34 | 49.0% |
| 47.0% | 35-39 | 54.8% |
| 52.3% | 40-44 | 60.2% |
| 56.5% | 45-49 | 63.6% |
| 60.0% | 50-54 | 65.4% |
| 63.9% | 55-59 | 67.5% |
| 69.1% | 60-64 | 71.4% |
| 74.7% | 65-69 | 74.8% |
| 76.9% | 70+ | 71.3% |

## ДҮҮРЭГ

| **Дүүрэг** | **Саналаа өгсөн** | **Хувь** |
|---|---|---|
| Багахангай | 2,057 | 73% |
| Налайх | 13,356 | 53% |
| Багануур | 9,450 | 51.2% |
| Сүхбаатар | 41,212 | 44% |
| Баянгол | 64,082 | 42.7% |
| Хан-Уул | 69,809 | 42.3% |

| Дүүрэг | Саналаа өгсөн | Хувь |
|---|---|---|
| Сонгино хайрхан | 85,051 | 41.6% |
| Баянзүрх | 102,879 | 40.7% |
| Чингэлтэй | 37,385 | 40.4% |

АЙМАГ, ХОТ

| Нэр | Саналаа өгсөн | Хувь |
|---|---|---|
| Баян-Өлгий | 48,722 | 76.3% |
| Сүхбаатар | 29,725 | 72.8% |
| Завхан | 33,005 | 71.8% |
| Говьсүмбэр | 7,420 | 70.1% |
| Ховд | 37,732 | 69.2% |
| Говь-Алтай | 25,062 | 68.4% |
| Архангай | 39,787 | 67.2% |
| Увс | 35,093 | 67.1% |
| Баянхонгор | 36,826 | 66.7% |
| Дундговь | 19,505 | 66.2% |
| Өмнөговь | 31,591 | 66% |
| Төв | 38,776 | 64.3% |
| Булган | 25,222 | 64.2% |
| Хэнтий | 31,197 | 62.3% |
| Сэлэнгэ | 40,972 | 60.4% |
| Өвөрхангай | 43,625 | 59.7% |
| Дорнод | 30,426 | 59.5% |
| Хөвсгөл | 51,056 | 59.2% |
| Дорноговь | 25,549 | 57.8% |
| Орхон | 33,031 | 48.7% |
| Дархан-Уул | 30,277 | 46% |
| Улаанбаатар | 425,282 | 42.3% |

Аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчдийн 17,9 хувь нь эмэгтэй, 82,1 хувь нь эмэгтэй ажээ. Сум, дүүргийн ИТХ-ын хувьд 21 аймгийн 330 сумаас 174 суманд МАН, 151 суманд АН, 1 суманд “Иргэний хөдөлгөөн”-ий нам, 3 суманд бие даагч олонхи болжээ. Нийтэд нь авч үзвэл 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нийт 7235 мандатаас МАН 3879, АН 3231, “Иргэний хөдөлгөөн”-ий нам 23, “Иргэний зориг ногоон” нам 4, “Үнэн ба зөв”

нам 1, бие даан нэр дэвшигч 86 суудал авчээ. Хүйсийн харьцааны хувьд 7235 сонгогдсон төлөөлөгчийн 2069 буюу 28,6 хувь нь эмэгтэй, 4977 буюу 71,4 хувь нь эрэгтэй байна.

Тоон дүнгүүдээс харахад үндэсний болон орон нутгийн түвшинд төлөөллийн зарчмын хэрэгжилт сул хэвээр буй нь харагдсаар байна. Иргэдийн ардчиллын талаархи ойлголт муу байгаа нь илт. Засаглалын хэв шинж, түүхэн уламжлалтай шууд холбоотой хэмээдэг. Зарим судлаачид “Иргэн төвтэй төр” буюу сайн засаглалыг хөгжүүлэхийн тулд төр нь засаг захиргааны шаталсан хатуу бүтцээс уян хатан, төвлөрсөн бус зохион байгуулалт руу шилжих, иргэдтэйгээ хамтран ажилладаг байгууллага болох ёстой гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

## Ашигласан ном зүй


“Хүний хөгжил”, УБ, 2006 он

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаархи иргэдийн иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааны тайлан” УБ, 2015 он

“Монголын ардчилал” УБ, 2021 он

“Политологи” сэтгүүл XX

www.ikon.mn

https://report.m-election.mn/

http://www.legalinfo.mn/

# ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ШИНЖИЛЖ, ЖЕНДЕРИЙН ОЛОН ТАЛТ УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ БИЙ БОЛГОХ НЬ

*Д.Уганжаргал (MA)*
*Эдийн засгийн докторант*
*Х.Анхбилэг (MBA)*
*Бизнесийн удирдлагын докторант*

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар Монгол Улсын орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнд шинжилгээг хийх замаар орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд жендерийн харьцаа, намын ялалтын ялгаа, газар нутгийн хэмжээ, хүн амын хөгжлийн индекс болон Улаанбаатар хотоос орон нутаг хүртэлх зай зэрэг хүчин зүйлсийн үзүүлж буй нөлөөллийг шинжилсэн. Түүнчлэн, орон нутгийн сонгуулийн сүүлийн 3 удаагийн сонгуулиар дийлэнх олон болсон намын шинжилгээ хийхэд Монгол Ардын Нам (МАН) олонход нь ялсан ба бүс нутаг, аймгаар ялгаагүй үр дүн гарсан. Монгол Улсад аймаг, нийслэлийн засаглалын түвшинд МАН, Ардчилсан Нам (АН) давамгайлах байр суурьтай байгааг 1992-2024 оны 9 удаагийн ээлжит сонгуулийн дүн мэдээ харуулж байна. 2020 оны сонгуулиас хойш МАН, АН-ын дунд аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд хүчтэй өрсөлдөөн өрнөж байна.

Судалгаагаар орон нутгийн 21 аймгийн 9 удаагийн ээлжит сонгуулийн өгөгдөлд түлхүү чиглэж шинжилгээг хийсэн. Түүнчлэн жендерийн олон талт байдал нь улс төрийн амжилт, намын имиж бүрдүүлэлтэд чухал нөлөөлөх боломжтой болохыг олон улсын туршлагаас харж болно. Жендерийн олон талт байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн ИТХ-ын шийдвэр, ялангуяа төсөв, санхүүгийн шийдвэрийг бодитой, үр дүнтэй болгоход бодлогын түвшинд анхаарах шаардлагатайг санал болгож байна.

**Түлхүүр үг:** *Орон нутгийн сонгууль, ялагч нам, санхүүгийн бие даасан байдал, ИТХ дахь жендерийн харьцаа;*

## УДИРТГАЛ

Монгол Улс 1990 онд ардчилсан өөрчлөлт, шинэтгэл хийснээр засаглалын шинэ тогтолцоо бий болж, төвлөрсөн социалист тогтолцоог орлуулах үндсэн хууль, эрх зүйн өөрчлөлтүүд эхэлсэн. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль нь орон нутгийн бие даасан байдлыг бататгаж, улмаар бүх шатны

иргэдийн төлөөлөгчдийн хурлыг чөлөөт, ардчилсан сонгуулиар дөрвөн жил тутамд бүрдүүлж, байнгын ажиллагаатай орон нутгийн төлөөллийн байгууллага ажиллах эрх зүйн суурь болсон юм.

Орон нутгийн сонгууль (ОНС) нь улс орны засаглалын бүтэц, үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн орон нутагт амьдарч буй иргэдийн оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж олгох чухал механизм юм. ОНС нь зөвхөн тухайн орон нутгийн удирдлагыг сонгохоос гадна, ардчилал, засаглалын үр ашиг, иргэний оролцооны нэг хэсэг болдог. Монгол Улсын орон ОНС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөллийг хангах зарчмаар 4 жилд нэг удаа зохион байгуулдаг бөгөөд 1992-2024 онд 9 удаагийн орон нутгийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан.

Монгол Улсын ОНС-ийн түүхэн хөгжил, түүний зүй тогтол, нутгийн өөрөө удирдах үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгаа эсэх, түүний онолын үзэл баримтлалыг судлан, орон нутгийн сонгууль нь парламентын сонгуультай харьцуулахад харьцангуй доогуур сонгогчдын идэвх, оролцоотой байдаг гэдгийг эмпирик судалгаагаар харуулжээ.(М.Жавзансүрэн, 2012; Ё.Довчин & Ц.Ганболд, 2013, Ц.Ганболд & Ц.Бямбачулуун, 2021). Гэвч орон нутгийн сонгуулийн үр дүнг олон хүчин зүйлтэй харьцуулан судалсан дотоодын судалгаа цөөхөн байна.

Олон улсад хийгдсэн судлаачдын эмпирик судалгаагаар жендерийн тэнцвэртэй төлөөлөл нь санхүүгийн шийдвэр гаргалтын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлдэг гэж үздэг (Smith, 2015; Wang & Chen, 2018). Орон нутгийн хөгжлийн бодлого нь жендерийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн байх нь улс төрийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж болохыг олон улсын туршлага харуулдаг.

Иймд монгол улсын ОНС-ийн үр дүнд шинжилгээ хийхийн зэрэгцээ аймгуудын санхүүгийн бие даасан байдалд жендерийн харьцаа, намын ялалтын ялгаа, газар нутгийн хэмжээ, хүн амын хөгжлийн индекс болон Улаанбаатар хотоос орон нутаг хүртэлх зай зэрэг хүчин зүйлсийн нөлөөллийг тооцоолон судалж байгаагаар онцлог юм.

### Судалгааны ажлын зорилго

Монгол Улсын орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнд шинжилгээг хийх замаар аймгуудын санхүүгийн бие даасан байдалд жендерийн харьцаа,

намын ялалтын ялгаа, газар нутгийн хэмжээ, хүн амын хөгжлийн индекс болон Улаанбаатар хотоос орон нутаг хүртэлх зай зэрэг хүчин зүйлсийн шинжилгээг хийж, түүний үр дүнд орон нутгийн хөгжлийн бодлогын санал боловсруулахад оршино.

Судалгаагаар Монгол Улсын ОНС-ийн үр дүнд холбогдох дүн шинжилгээ хийх; Орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд жендерийн олон талт байдал, намын ялгаа болон бусад хүчин зүйлсийн нөлөөг тодорхойлох; Судалгаанд үндэслэн Монгол улсын орон нутгийн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгоход санал, зөвлөмж боловсруулах юм.

## Монгол Улсын орон нутгийн сонгуулийн ойлголт, хөгжил, зарим үр дүн

Монгол Улс нь нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлж, төлөвшүүлэх, иргэдийн саналд үндэслэн орон нутгийн асуудлыг шийдвэрлэх, иргэдийн төлөөллийн байгууллагыг сонгуулийн зарчмаар бүрэлдүүлж ирсэн түүхэн уламжлалтай. ОНС нь улс төрийн үүрэг хариуцлагыг төвлөрсөн засаглалын байгууллагаас орон нутгийн хэмжээнд шилжүүлж, тэдгээрийн эрх мэдлийг хуваарилах, засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой сонгуулийн хэлбэр юм.

Орон нутгийн сонгуулийг доорх үзэл онолтой холбож тайлбарлаж болно.

*Ардчиллыг бэхжүүлэх:* Орон нутгийн сонгууль нь иргэдийн өөрсдийн орон нутгийн засаглалыг сонгох боломжийг олгох бөгөөд энэ нь төлөөллийн ардчиллын элемент болох юм. Иргэд сонгуулиар орон нутгийн удирдлагыг сонгож, хариуцлага тооцож, өөрсдийн асуудлуудыг шийдвэрлэх эрхтэй болж, үүний ачаар төрийн засаглал ил тод, хариуцлагатай болно.

*Төлөөллийн систем (Representative Democracy)* Орон нутгийн сонгууль нь төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх зорилготой байдаг. Иргэдийн сонголт нь тухайн орон нутгийн засаглалд төлөөлөл болгон илрэх бөгөөд энэ нь орон нутгийн шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэх үйл явцад оролцох боломжийг олгодог.

*Хуваарилалтын онол:* Орон нутгийн сонгууль нь эрх мэдлийг зөв хуваарилах онолын чухал хэсэг юм. Төв засаглал болон орон нутгийн засаглал хоорондын эрх мэдлийг хуваарилах, тэдгээрийн хооронд хяналт тавих нь сонгуулийн нэг чухал зорилго байдаг.

*Газар нутаг, нийгмийн онцлог:* Орон нутгийн сонгуулийн онол нь тухайн газар нутгийн нийгмийн бүтэц, амьдралын хэв маягтай уялдаатай. Тиймд орон

нутгийн сонгуулийн систем нь тухайн бүс нутгийн соёл, уламжлал, амьдралын чанар, эдийн засгийн нөхцөл, хүн амын шинж чанараас хамаардаг.

Орон нутгийн сонгуулийн систем нь сонгууль хэрхэн зохион байгуулагддаг, сонгогчид хэрхэн сонголт хийдэг, сонгуулийн дүнг хэрхэн гаргадаг талаар тодорхойлдог. Ихэнх тохиолдолд орон нутгийн сонгуулийн тогтолцоо нь дараах гурван үндсэн төрлөөр ангилагддаг:

*Нэг болон олон мандаттай мажоритар сонгууль (First-past-the-post):* Сонгогчид зөвхөн нэг нэр дэвшигч эсвэл мандатын тоогоор сонгодог бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогддог. Энэ нь орон нутгийн жижиг бүсүүдэд чухал үүрэг гүйцэтгэж болох ч, зарим үед олон намуудын төлөөлөгчид сонгогдох боломжийг багасгадаг.

*Пропорциональ систем (Proportional Representation):* Орон нутгийн сонгуулиар нэр дэвшигчдийн тоо болон саналын хуваарилалтыг илүү тэгш тараах зорилгоор пропорциональ төлөөллийг ашиглах нь нийгмийн олонх дэмжлэгийг олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

*Холимог систем (Mixed-Member):* Энэ  систем нь пропорциональ болон нэг эсвэл олон мандаттай мажоритар системийн хослол байх бөгөөд сонгуулийн дүнд намуудын сонгогчдод зориулсан төлөөллийг бий болгодог.

Монгол Улсын орон нутгийн сонгуулийн түүхэн уламжлалын хувьд 1921-1990 онд нэг намын засаглалын доорх сонгууль, 1990 оноос хойших ардчилсан, чөлөөт орон нутгийн сонгуулийн үе хэмээн ангилдаг.

***Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий нэг намын засаглалын үеийн сонгууль (1921-1990)***

1921 оны ардын хувьсгалын дараа нэг намын тогтолцоо руу шилжиж, орон нутгийн сонгуулийн тогтолцоо энэ үед анхлан төлөвшсөн. Орон нутгийн засаглалын бүтэц нь төв засгийн газраас шууд удирдлагатай байж сонгуулиар сонгогдсон төлөөлөгчид биш, төв засгийн газраас томилогдсон хүмүүс орон нутгийн засаглалд ажилладаг байсан. Түүнчлэн тухайн үеийн орон нутгийн сонгуулийн үйл явц нь бодит ардчилсан өрсөлдөөнгүй, төрийн байгууллагуудын удирдлага дор явдаг байв.

***1990 оны Ардчилсан өөрчлөлт, шинэчлэлт ба Орон Нутгийн Сонгууль***

Монгол Улсад 1990 онд ардчилсан хөдөлгөөн ялсны дараа нийгмийн болон улс төрийн тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд гарсан.Анх удаа олон намын тогтолцоонд шилжиж, ардчилсан үнэт зүйлсийг хэрэгжүүлэх, хүний эрхийг хамгаалах, шудармга сонгуулийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн

сонгуулийг зохион байгуулах болсон. Анхны орон нутгийн сонгууль нь 1990 онд хийж, 1992 оны шинэ үндсэн хуулийн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан тус оноос эхлэн ээлжит сонгуулийг явуулж эхэлсэн байна. ОНС бүрд тухайн жилийн УИХ-ын сонгуульд ашигласан сонгуулийн тогтолцоог ашиглаж ирснийг түүхэн сонгуулийн мэдээллээс харж болно. Тодруулбал 1992, 2008, 2020, 2024 онд олон мандат бүхий мажоритар, 1996, 2000, 2004, 2016 онд олонхын мажоритар, 2012 онд холимог мажоритар тогтолцоог орон нутгийн сонгуульд ашиглажээ.

Нийт 9 удаагийн орон нутгийн ээлжит сонгуулийн ирцийн мэдээллийг Улсын Их Хурал (УИХ) болон Ерөнхийлөгчийн сонгуультай харьцуулахад манай улсад дараах байдалтай байна.

***Зураг 1.*** *Монгол Улс дахь сонгуулийн ирц (1992-2021)*




*Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)*

Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ирц нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцтэй харьцуулахад бага байдаг нь тодорхой ажиглагдав. УИХ-сонгууль хамгийн ихдээ 1996 оны сонгуульд 96%, Ерөнхийлөгчийн сонгууль 1992 онд 92% байсан бол ОНС нь 1992 онд 72% , харин 2012 онд хамгийн бага буюу 50% ирцтэй болжээ. ОНС-ийн ирц бага байгаа нь сонгогчид тухайн сонгуулийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, УИХ-ын сонгуулиас хойш хэдхэн сарын дараа дахин сонгуульд санал өгөхөөс залхсан байдал, түүнчлэн дараагийн Ерөнхийлөгчийн сонгуульд анхаарлаа хандуулсан зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж буйг судлаачид бичдэг. (Д.Бадамдаш, Э.Гэрэлт-Од, Д.Ундрах нар, 2023). 9 удаагийн ОНС-ийн ирц 50-72 хувь орчимд хэлбэлзэж, 2016 оны сонгуулиас хойш ирц тасралтгүй буурч 53%-д хүрсэн байна.

(Зураг 1)Орон нутгийн сонгуульд ямар улс төрийн хүчин хэрхэн оролцож, орон нутгийн иргэдийн дэмжлэгийг авсан эсэх нь сонгуулийн үр дүн, цаашдын засаглал, иргэдийн амьжиргаа, орон нутгийн хөгжил цэцэглэлттэй холбоотой чухал асуудал юм. Судалгаанд 1992-2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээс аймаг, нийслэлийн сонгуульд ялалт байгуулсан улс төрийн хүчнүүдийн мэдээллийг нэгтгэв.

***Хүснэгт 1. Аймаг нийслэлийн ИТХ сонгуульд ялсан Улс төрийн нам (1992-2024)***

МАХН/МАН АН Мэдээлэл байхгүй,

| № | Аймаг | 1992 | 1996 | 2000 | 2004 | 2008 | 2012 | 2016 | 2020 | 2024 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | МАХН | АН | МАХН | МАХН | МАХН | АН | МАН | АН | МАН |
| 2 | Баян-Өлгий | | | МАХН | МАХН | | | МАН | МАН | АН |
| 3 | Баянхонгор | | | МАХН | МАХН | | | МАН | МАН | МАН |
| 4 | Булган | | | МАХН | МАХН | | | МАН | АН | МАН |
| 5 | Говь-Алтай | | | МАХН | МАХН | | | МАН | АН | АН |
| 6 | Говьсүмбэр | | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАН | МАН | МАН | МАН |
| 7 | Дархан-Уул | МАХН | | МАХН | МАХН | | МАН | МАН | МАН | МАН |
| 8 | Дорноговь | | | МАХН | МАХН | | | МАН | МАН | МАН |
| 9 | Дорнод | | | МАХН | МАХН | | | МАН | МАН | МАН |
| 10 | Дундговь | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАН | МАН | АН | МАН |
| 11 | Завхан | | | МАХН | МАХН | | | АН | МАН | МАН |
| 12 | Орхон | | АН | МАХН | МАХН | МАХН | АН | МАН | МАН | МАН |
| 13 | Сэлэнгэ | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАН | МАН | МАН | МАН |
| 14 | Сүхбаатар | | | МАХН | АН | | | АН | АН | АН |
| 15 | Төв | | | МАХН | МАХН | | | МАН | МАН | АН |
| 16 | Увс | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАХН | АН | МАН | АН | МАН |
| 17 | Ховд | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАХН | АН | МАН | МАН | АН |
| 18 | Хэнтий | МАХН | АН | МАХН | АН | МАХН | АН | МАН | МАН | АН |
| 19 | Хөвсгөл | | | МАХН | АН | | | МАН | АН | МАН |
| 20 | Өвөрхангай | | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАН | МАН | МАН | МАН |
| 21 | Өмнөговь | МАХН | МАХН | МАХН | МАХН | АН | АН | МАН | АН | АН |
| 22 | Улаанбаатар | МАХН | МАХН | МАХН | МАХН | МАХН | АН | МАН | МАН | МАН |

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

1992-2024 оны ээлжит сонгуулийн үр дүнг нэгтгэхэд тоон мэдээллийн чанар, олдоцтой байдал нь нэлээд хүндрэл учруулсан.[1] ОНС-ийн мэдээллүүд нь зохион байгуулсан нутаг дэвсгэр бүрд бүртгэгдсэн байж болох ч СЕХ-нд албан бусаар нэгтгэгдсэн мэдээллийн хувьд ихэнх ОНС-ийн дата мэдээлэл бүрэн бус байна. Учир нь 2020 оны ОНС хүртэл ОНС-ийн мэдээллийг СЕХ нэгтгэх үүргийг албан ёсоор хүлээгээгүй байсантай холбоотой. Улмаар ОНС-ийн тойрог бүр дор бүрнээ санал хураалтыг хариуцаж ажилласан бөгөөд мэдээллийг цэгцтэй, ойлгомжтой, нэгдмэл, жигд байдлаар цуглуулан, нэгтгээгүй байна. (Д.Бадамдаш, Э.Гэрэлт-Од, Д.Ундрах нар, 2023)

Аймаг, нийслэлийн түвшний ОНС-д дийлэнх тохиолдолд Монгол Ардын нам (МАХН/МАН нь 2011 онд Монгол Ардын Хувьсгалт нам нэрээ Монгол Ардын нам болгон өөрчилсөн.) ялалт байгуулсан болох нь ажиглагдаж байна. 2000 оны ОНС-ийн сонгуулиар аймаг 21/21, нийслэл 1/1 буюу бүх нутаг дэвсгэрт ялалт байгуулсан бол 2004 оны сонгуулиар Сүхбаатар,Хэнтий, Хөвсгөл аймгуудад Ардчилсан нам (АН) ялалт байгуулсан байна. 2016 оны ОНС-д Завхан, Сүхбаатар аймгуудаас бусад газарт МАН ялалт байгуулжээ. (Хүснэгт 1)

[1] **Орон нутгийн сонгуулийн үр дүнгийн өгөгдөл, мэдээлэл цуглуулсан талаарх тайлбар:** 1992-2024 оны Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн үр дүнг зөвхөн аймаг, нийслэлийн түвшинд авч ашиглав. Учир нь аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн өгөгдөл, мэдээлэл СЕХ-оос хийсэн боловсруулалт дутуу, 2016 оноос өмнөх сонгуулийн мэдээллийн олдоцтой байдал хангалтгүй, зарим он нь огт мэдээлэлгүй байгааг энд тэмдэглэв.

2000, 2004 оны сонгуулийн дүнгийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хороо (2005). Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн товчоон -2005 ном, 2016, 2020, 2024 оны сонгуулийн дүнгийн мэдээллийг СЕХ-ны цахим хуудаснаас авч ашиглав. Түүнчлэн 1992, 1996, 2008, 2012 оны сонгуулийн дүн, мэдээллийг аймаг бүрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас эрхлэн гаргасан тоо, баримтаас мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор нэмж түүвэрлэн ашиглав. Гэвч аймгийн ИТХ-ын ажлын албанаас гаргасан тоон мэдээлэл нь дутуу, хомсхон байсан тул нэгтгэж болох боломжит хэмжээгээр нь түүвэрлэн орууллаа. Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн дүн мэдээлэл нэгтгэхэд тоон мэдээллийн чанар хангалтгүй, 2016 оноос өмнөх мэдээлэл байхгүй тул тус судалгаанд аймаг, нийслэлийн ИТХ-ын ОНС-ийн дүнг нэгтгэн ашигласан болно. Цаашид аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн дүн, мэдээллийг нэгтгэж боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг судалгааны баг тэмдэглэж байна.

*Зураг 2. 2020, 2024 оны Орон нутгийн сонгуулийн харьцуулалт*




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

2020 оны ОНС-д МАН аймаг 21/13, нийслэл 1/1 ялалт байгуулж, нийт 64% байсан бол энэ үзүүлэлт 2024 оны сонгуульд аймаг 21/13, нийслэл 1/1 ялалт байгуулж нийт 68% болж өссөн. АН-ын хувьд 2020 оны сонгуульд аймаг 21/8, нийслэл 1/0 ялалт байгуулж нийт 36%-д нь ялалт байгуулсан бол 2024 оны сонгуульд аймаг 21/7, нийслэл 1/0 ялалт байгуулж нийт 32% болж буурсан байна. 2020, 2024 оны ОНС-ийн үр дүнгээс эхлэн МАН, АН-ын дунд хүчтэй өрсөлдөөнтэй байгааг илтгэж байна. 2016 оноос өмнөх ОНС-д МАН олонх тохиолдолд аймаг, нийслэлд ялалт байгуулж байсан (1996, 2012 оны ОНС-ийн дүнгийн чанараас хамаарч шууд дүгнэлт хийх боломжгүй тул тоон мэдээллийг чанаржуулж, нягтлах шаардлагатай.) 2020 оноос хоёр намын дунд хүчтэй өрсөлдөөн орон нутгийн сонгуулийн хүрээнд явагдаж байна хэмээн дүгнэж байна.

Монгол Улсад орон нутагт ямар улс төрийн хүчин давамгайлж ялалт байгуулж байгааг төв, баруун, зүүн, хангайн бүсээр харуулав.

***Зураг 3. Монгол Улсын орон нутгийн сонгуулийн намуудын дэмжлэг (2016 он)***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

2016 оны орон нутгийн сонгуульд МАН бүсүүдийн дунджаар 62.3 хувьд нь ялалт байгуулжээ. Бүсээр нь авч үзвэл Хангайн бүс хамгийн өндөр (75.4%) бол Зүүн бүсэд (47.7%) бага дэмжлэг авчээ. Баруун болон төвийн бүст дэмжлэг өндөр байна. АН-ын хувьд аймгуудын дунджаар

30.5 хувьд дэмжлэг авч ялалт байгуулжээ. Бусад нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид бүсүүдэд 0-11.1 хувийн дэмжлэг авсан байна.

***Зураг 4. Монгол Улсын орон нутгийн сонгуулийн намуудын дэмжлэг (2020 он)***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

Энд бүсийн намуудын олонх болсон харьцааг гаргахдаа аймгийн иргэдийн хурлын сонгогдсон төлөөлөгчөөр хувьчилж гаргасан. 2020 оны орон нутгийн сонгуульд МАН 57.8 хувьд нь ялалт байгуулж өмнөх сонгуулийн үзүүлэлтээс буурсан байна. Бүсээр нь авч үзвэл, төвийн бүс хамгийн өндөр (62%) бол Баруун бүсэд (54.1%) бага дэмжлэг авчээ. АН-ын хувьд бүсүүдийн дунджаар 39.2 хувьд дэмжлэг авч өмнөх сонгуулиас 8.6 функтээр илүү санал авчээ. Бусад нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид бүсүүдэд 1.9-4.5 хувь авч дэмжлэг нь огцом буурсныг харуулж байна.

***Зураг 5. Монгол Улсын орон нутгийн сонгуулийн намуудын дэмжлэг (2024 он)***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

2024 оны орон нутгийн сонгуульд МАН 57.6 хувьд нь ялалт байгуулж өмнөх сонгуулийн үзүүлэлттэй ойролцоо дэмжлэг авсан байна. Бүсээр нь авч үзвэл, төвийн бүс хамгийн өндөр (63.4%) бол Зүүн бүс (46.5%) бага дэмжлэг авчээ. АН-ын хувьд бүсүүдийн дунджаар 41.4 хувьд дэмжлэг авч, өмнөх сонгуулиас 2 функтээр илүү санал авсан. Бусад нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид бүсүүдэд 1-2 хувь авч дэмжлэг нь огцом буурсан байна.

Дээрх ээлжит 3 сонгуулийн үр дүнгээс харахад МАН орон нутгийн сонгуульд бүсийн дунджаар олонх аймагт засаглаж байгаа боловч иргэдээс ирэх дэмжлэг аажмаар буурч байна. Эсрэгээрээ АН иргэдээс авах дэмжлэг орон нутагт бүсээр тооцож үзвэл аажим нэмэгдэх хандлагатай байна. Харин бусад нам, эвсэл болон бие даагчдын аймгийн иргэдийн хуралд сонгогдох дэмжлэг огцом буурсан байна.

Дүгнэвэл Монгол Улсад аймаг, нийслэлийн засаглалын түвшинд МАН, АН давамгайлах байр суурьтай байгааг 1992-2024 оны 9 удаагийн ээлжит сонгуулийн дүн харуулж байна. 2020 оны сонгуулиас хойш МАН, АН-ын дунд аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль хүчтэй өрсөлдөөнтэй байна. Судалгаанд орон нутагт давамгай ялалт байгуулж буй улс төрийн хүчний талаарх шинжилж, цааш орон нутгийн санхүүгийн чадавхтай холбогдох шинжилгээг хийх болно.

**Орон нутгийн санхүүгийн чадавх ба Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ) дахь жендерийн олон талт байдал, намуудын давамгай байдлын хамаарал**

Монгол Улсын орон нутгийн сонгуулийн тоон өгөгдөлд тулгуурлан орон нутгийн санхүүгийн чадавх, жендерийн олон талт байдлын үзүүлэлтээр эконометрикийн арга зүйгээр шинжилгээ хийсэн дотоодын судалгааны ажил цөөн байгааг дээр дурдсан. Орон нутгийн сонгуулийн 1992-2024 оны тоон өгөгдлийг цуглуулж орон нутгийн санхүүгийн чадавх, жендерийн олон талт байдалд шинжилгээг хийв. Судалгаанд ашигласан тоон өгөгдлийн хувьд орон нутгийн санхүүгийн бие даасан байдал, жендерийн тэнцвэрийн индексийг тооцож, тэдгээрийн хамаарлыг тооцов.

*Хүснэгт 2. Тоон өгөгдлийн тайлбар*

| № | Хувьсагчийн нэр | Томьёо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал FIN_AUTH | $\frac{Total\ Revenues - Inv}{Total\ Expenses}$ | Орон нутгийн нийт орлогоос тухайн орон нутагт хуваарилсан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хассан буюу өөрийн орлогыг орон нутгийн нийт зардалд харьцуулсан харьцаа |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Жендерийн тэнцвэрийн индекс (GPI) GENDER_RATIO - GEN | $\frac{Number\ of\ Women\ in\ Political\ Positions}{Number\ of\ Man\ in\ Political\ Positions}$ | ИТХ-д сонгогдсон нийт эмэгтэй гишүүдийг нийт эрэгтэй гишүүдэд харьцуулсан харьцаа |
| 3 | Дийлэнх олонх болсон нам PARTY_VICTORY | $Party\ Victory = \begin{cases} 1 & \text{МАН} \\ 0 & \text{АН} \end{cases}$ | Тухайн орон нутгийн тойрогт дийлэнх олонх болсон нам |

Үл хамаарах хувьсагчдын хооронд өндөр шугаман хамаарал байгаа нөхцөлд регрессийн загварыг үнэлэх, параметрийн үнэлгээг хазайлттай болгодог учир хамаарлын матрицыг байгуулж мультиколлинеарити[2] шалгасан болно. Шинжилгээгээр өндөр шугаман хамаарал ажиглагдаагүй болно. (Зураг 6)

***Зураг 6. Хувьсагчдын хоорондын хамаарлын матриц***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

[2] Үл хамаарах хувьсагчдын хоорондын өндөр шугаман хамаарал $r > 0.8$

Энэхүү скаттер дүрслэл нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдал (босоо тэнхлэг) болон тухайн тойргийн орон нутгийн сонгуульд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь (хэвтээ тэнхлэг) хоорондын хамаарлыг харуулж байна. Графикаас үзэхэд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь өндөр байх тусам орон нутгийн санхүүгийн бие даасан байдал бага зэрэг өсөх хандлагатай байгааг (улаан шугамаар харуулсан регрессийн шугам) харуулав. (Зураг 7)

Энэхүү дүгнэлтэд хүрэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй хэд хэдэн эшлэл хэрэглэх нь зүйтэй гэж үзэв.

1. **Жендерийн төлөөлөл ба санхүүгийн шийдвэр гаргалт**: Судалгаанаас үзэхэд жендерийн тэнцвэртэй төлөөлөл бүхий зөвлөлүүд нь санхүүгийн шийдвэр гаргалтын ил тод байдал, хариуцлагатай байдалд эерэг нөлөө үзүүлдэг гэж үздэг. (Smith, 2015; Wang & Chen, 2018)
2. **Орон нутгийн бие даасан байдал ба жендерийн нөлөө**: Санхүүгийн бие даасан байдалтай орон нутгийн удирдлага нь жендерийн төлөөллийг нэмэгдүүлэхэд илүү уян хатан, ил тод, нээлттэй байж болзошгүй байдаг. Энэ нь орон нутгийн сонгуулиуд дахь жендерийн квот эсвэл хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах хөтөлбөрүүдтэй холбоотой байж болох юм. (Jackson, 2020)
3. **Эмэгтэйчүүдийн оролцоо ба орон нутгийн хөгжлийн бодлого**: Эмэгтэй төлөөлөгчдийн оролцоо нэмэгдэх тусам тэдний авчирдаг өөр өөр асуудлуудын хүрээнд санхүүгийн бие даасан байдал нэмэгдэх магадлалтай гэж үздэг. (Harrison & Goode, 2019)

Хамаарлын скаттер шинжилгээнээс үзэхэд жендерийн төлөөлөл нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд нөлөөлөх боломжтой гэсэн санаа

батлах боломжтой юм. Гэвч илүү нарийвчилсан судалгаа хийх шаардлагатайг судалгааны баг зориуд тэмдэглэв.

***Зураг 7. Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал ба тухайн тойргийн орон нутгийн сонгуульд сонгогдсон эмэгтэй ИТХ-ын төлөөлөгчдийн эзлэх хувь***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

Судалгааны баг орон нутгийн 21 аймгийн орон нутгийн ИТХ-ын сонгуулиар сонгогдсон гишүүдийн намуудын харьцаанд үндэслэн, 9 удаагийн сонгуулийн үр дүнгийн тархалтын улс төрд гол тоглогч болох МАН, АН-ын харьцуулсан хайрцаг диаграммаар загварчилсан болно. Намын дэмжлэгийн хувь хэмжээний тархалтыг боксын диаграммаар үзүүлэх нь сонгогчдын хандлагыг судлахад үр дүнтэй гэж үздэг (Evans, 2021). МАН бүлгийн хувь хэмжээ илүү өндөр, төвлөрөл нь 69%, харин АН бүлгийнх 31%-д хүрсэн байна. Дүрслэлээс дараах шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлтийг хийж болно (Зураг 8). Үүнд:

1. **Төвлөрөл ба тархалт:** МАН бүлгийн хувь хэмжээ дунджаар 69%-д төвлөрч байгаа бөгөөд 56%- 86%-ийн хооронд хэлбэлзэж байна. Энэ нь МАН бүлгийн гишүүдийн хувьд хувь хэмжээ харьцангуй өндөр байгааг илтгэнэ. АН бүлгийн хувьд, дунджаар 31%-ийн төвлөрөлтэй байгаа бөгөөд энэ нь МАН бүлгээс доогуур түвшинд байна. Судалгаанаас үзэхэд, хувь хэмжээнд иймэрхүү ялгаа нь бүлгүүдийн

нөөц, дэмжлэг, эсвэл нийгмийн байр суурийн ялгаанаас шалтгаалж болзошгүй байдаг. (Johnson, 2017)

2. **Сэтгэл ханамж ба нийгмийн дэмжлэгийн түвшин:** МАН бүлгийн илүү өндөр хувь хэмжээ нь сэтгэл ханамж, нийгмийн дэмжлэгийн түвшин өндөр байгааг илтгэж болзошгүй. Судалгаанаас үзэхэд, нийгэм дэх дэмжлэгийн түвшин нь хувь хэмжээнд нөлөөлдөг гэж үздэг (Taylor & Black, 2018).
3. **Тархалтын хүрээ:** МАН-ын хувь хэмжээний тархалтын хүрээ илүү өргөн (18%-100%), харин АН бүлгийн тархалт 0%-82% хооронд байна. Энэ нь МАН бүлэг илүү олон төрлийн хувь хэмжээтэй буюу гишүүдийн оролцоо илүү олон янз болохыг харуулж байна. (Smith & Wang, 2019).

МАН сонгогдсон төлөөлөгчдийн хувь хэмжээ өндөр, тархалт өргөн байгаагаас үзэхэд энэ бүлэг илүү олон янзын гишүүнчлэлтэй, харьцангүй өндөр оролцоотой болох нь харагдаж байна. АН бүлгийн хувьд харьцангүй бага хувь хэмжээтэй бөгөөд оролцооны түвшин доогуур байна.

***Зураг 8. Орон нутгийн ИТХ-д намуудын давамгай байдлын харьцуулсан хайрцаг-сахлан диаграмм (box-whisker plot)***




*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

Монгол Улсын орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан намын жендерийн тэнцвэрт байдлын харьцааг харуулж байна. **GPI (Gender Parity Index)** нь тухайн намын жендерийн тэнцвэрийн түвшнийг илэрхийлсэн бөгөөд **Party_victory** баганад ялалт байгуулсан МАН болон АН намын хувь хэмжээг харуулав. (Хүснэгт 3)

МАН нь жендерийн тэнцвэрийн хувьд илүү өндөр түвшинд хүрч, дийлэнх олон болсон буюу нийт 77.59%-ийн ялалт байгуулжээ. Энэ нь жендерийн тэнцвэрт байдлыг хангах нь боломжийг нэмэгдүүлж болохыг харуулж байна. АН нь жендерийн тэнцвэрийн "дундаас доогуур" түвшинд өндөр хувьтай оролцсон болович нийт ялалтын хувь нь 22.41%-д хүрсэн нь жендерийн тэнцвэргүй байдал улс төрийн амжилтад сөрөг нөлөө үзүүлж болохыг илэрхийлж байна. Судалгаагаар жендерийн тэнцвэрийн өндөр түвшинтэй намууд нь сонгогчдын дэмжлэгийг татах магадлал илүү өндөр байгааг харуулсан байдаг. (McGregor & Blais, 2021; Inglehart & Norris, 2018)

***Хүснэгт 3. Орон нутгийн сонгуульд сонгогдсон гишүүдийн хүйсийн харьцангуй давтамж***

| GPI | Party_victory АН | Party_victory МАН | Total |
|---|---|---|---|
| Дунд | 0.00 | 0.86 | 0.86 |
| Дундаас доогуур | 17.24 | 45.69 | 62.93 |
| Муу | 5.17 | 30.17 | 35.34 |
| Сайн | 0.00 | 0.86 | 0.86 |
| Total | 22.41 | 77.59 | 100.00 |

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

Чанарын хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлохын тулд Хи-Квадрат тестийг ашигладаг бөгөөд бид орон нутгийн 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020, 2024 оны 21 аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн боломжит тоон өгөгдөлд үндэслэн, орон нутгийн сонгуулийн ялалтад жендерийн эрх тэгш байдал хэрхэн нөлөөлдөг талаар эмпирик судалгаа хийж гүйцэтгэв. Статистик шинжилгээний үр дүнд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь өндөр байх нь намын ялалтад нөлөө үзүүлдэггүй хэмээх 5 хувийн ач холбогдлын түвшинд хүлээн авсан, өөрөөр хэлбэл Монголын одоогийн нөхцөлд жендерийн олон талт байдал нь **намын ялалтад нөлөөлөлгүй** байна.

Судалгааны арга зүйн хувьд тодорхойлсон бөгөөд Хи-квадрат тест, Крамерын V, болон Кендаллын tau-b нь судалгаанд хамаарал байгаа эсэхийг шалгахад хэрхэн ашиглагдсаныг тайлбарласан бөгөөд эдгээр аргууд нь чанарын хувьсагчийн хамаарал тодорхойлох, жендерийн тэнцвэр болон улс төрийн намын ялалтын хоорондын хамаарлыг илүү гүнзгий судлахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

| **Судалгааны арга зүй** | **Тайлбар** | **Ашигласан томьёо** | **Ашигласан эх сурвалж** | **Судалгаанд ашигласан аргачлал** |
|---|---|---|---|---|
| Хи-квадрат тест (Chi-Square Test) | Хоёр хувьсагчийн хооронд хамаарал байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ашиглагддаг. Хоёр чанарын хувьсагчийн үл хамаарал эсвэл хамаарлыг шалгана. | $\chi^2 = \Sigma\left(\frac{(O - E)^2}{E}\right)$ энд $O$ – ажиглагдсан утга, $E$ – хүлээгдэж буй утга | McHugh, M. L. (2013). The Chi-square test of independence.Biochemia Medica, 23(2), 143-149. | Энэхүү судалгаанд жендерийн тэнцвэр болон намын ялалт хоорондын хамаарал байгаа эсэхийг шалгахад ашигласан. |
| Крамерын V (Cramér's V) | Хи-квадрат статистикийн хүчийг хэмждэг. Хоёр хувьсагчийн хоорондын хамаарал байгаа тохиолдолд түүний нөлөөллийн хүчийг тодорхойлоход ашиглагддаг. | $\sqrt{\frac{\chi^2}{(n * (k - 1))}}$ энд $n$ – түүврийн хэмжээ, $k$ – хувьсагчийн түвшний тоо | Cohen, J. (1988). Statistical power analysis for the behavioral sciences. Hillsdale, NJ: Erlbaum. | Судалгаанд жендерийн индекс болон намын ялалтын хамаарал хэр хүчтэй байгааг тодорхойлоход ашигласан. |
| Кендаллын tau-b (Kendall's Tau-b) $\tau_b$ | Чанарын хувьсагчдын хоорондын холбоо эсвэл хамаарал | $\frac{(P - Q)}{\sqrt{(P + Q + Y^0)(P + Q + X^0)}}$ энд $P, Q$ нь нийцэх ба зөрчилдөх хосын тоо, $Y_0, X_0$ нь холимог хосын тоо | Siegel, S., & Castellan, N. J. (1988). Nonparametric Statistics for the Behavioral Sciences. | Судалгаанд жендерийн индекс ба ялалтын түвшний |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгаа эсэхийг тодорхойлоход ашиглагддаг, ялангуяа хослогдсон өгөгдлийн хувьд. | | | хамаарлыг тодорхойлоход ашигласан. |

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

***Хүснэгт 4. Хи-Квадрат тестийн үнэлгээ***

| GPI | Party_victory AH | MAH | Total |
|---|---|---|---|
| Дунд | 0.00 | 0.86 | 0.86 |
| Дундаас доогуур | 17.24 | 45.69 | 62.93 |
| Муу | 5.17 | 30.17 | 35.34 |
| Сайн | 0.00 | 0.86 | 0.86 |
| Total | 22.41 | 77.59 | 100.00 |

Pearson chi2(3) = 3.0472 Pr = 0.384
Likelihood-ratio chi2(3) = 3.5819 Pr = 0.310
Cramér's V = 0.1621
Kendall's tau-b = 0.1391 ASE = 0.083

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт*

Олон улсад жендерийн тэгш байдлыг хангах замаар улс төрийн системийг илүү шударга, ил тод, тогтвортой болгохыг зорьж байгаа хэдий ч манай улсад эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны нөлөөллийг тодорхой болгоход бэрхшээл тулгарч байна.

Монголд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ба намын ялалтын хоорондын хамаарал сул байгааг дараах үндэслэлүүдээр тайлбарлаж болно:

- ✓ *Хэвшмэл ойлголт ба улс төрийн соёл (Perceptional Bias):* Монголын нийгэмд уламжлалт соёлын хандлага хүчтэй хэвээр бөгөөд эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоонд нийгэм болон улс төрийн хүрээний талаас дэмжлэг бага байдаг.
- ✓ *Эдийн засгийн болон нийгмийн бэрхшээлүүд:* Эмэгтэйчүүдийн улс төрд оролцох боломжийг нийгэм, эдийн засгийн орчин хязгаарлаж

байдаг. Эмэгтэйчүүдэд улс төрд оролцох санхүүгийн дэмжлэг бага, олон нийтийн дэмжлэг сул байгаа нь энэ байдалд нөлөөлж байна.

- ✓ *Намуудын дотоод бүтэц ба бодлого:* Монголын улс төрийн намууд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийг зорьсон тодорхой бодлого, стратеги хангалтгүй бөгөөд энэ нь жендерийн тэгш байдлын бодлогыг бодит ажил хэрэг болгоход нөлөөлж байна.

Эдгээр хүчин зүйлээс үзэхэд жендерийн олон талт байдал нь ОНС-ийн ялалтад нөлөөлөх хэмжээнд бүрэн хүрч чадахгүй байгаа бөгөөд энэ нь улс төрийн институциудын жендерийн бодлогыг хэрэгжүүлэх чадамжаас шалтгаалж байна.

Судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын 21 аймгийн орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд намуудын ялгаа, жендерийн олон талт байдал болон бусад эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлсийн нөлөөллийг харуулахад чиглэсэн. (Тэгшитгэл 1)

Тоон өгөгдлийн хувьд сүүлийн 3 удаагийн сонгуулийн мэдээлэл, энэхүү хугацааны интервалд харгалзах өгөгдөлд үндэслэж Pooled болон Random нөлөөллийн загварын үнэлэв.

$$FIN_AUTH_{it} = \beta_0 + \beta_1 Party_{it} + \beta_2 GEN_{it} + \beta_3 Landper_t + \beta_4 HDI_{it} + \beta_5 Dis_{it} + \varepsilon_{it} \quad (1)$$

Энд,

- ✓ $it$ – $i$-р аймгийн $t$ дахь хугацааны үзүүлэлт;
- ✓ $Party$ – Намын илэрхийлэх дамми хувьсагч
- ✓ $GEN$ – ИТХ-д сонгогдсон эрэгтэй, эмэгтэй төлөөлөгчдийн жендерийн харьцаа
- ✓ $Landper$ – Нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээ
- ✓ $HDI$ – Хүний хөгжлийн индекс
- ✓ $Dis$ – Улаанбаатар хотоос орон нутаг хүртэлх зай
- ✓ $\varepsilon$ – Орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд нөлөөлөх бусад хүчин зүйлс

Үнэлгээний үр дүнгээр намын ялгаа болон жендерийн олон талт байдал нь ИТХ-аас гаргаж буй орон нутгийн төсвийн шийдвэр гаргалтад нөлөөгүй байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нь нийгмийн хэвшмэл ойлголт, дэмжих сэтгэл зүй  бага байгаа одоогийн нөхцөлд шийдвэр гаргах, төрийн бодлогыг хэрэгжүүлэх түвшинд хүргэхэд анхаарах зайлшгүй шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байна. (Хүснэгт 5)

*Хүснэгт 5. Эконометрикийн загварын үнэлгээний үр дүн*

| **Тайлбарлагдагч хувьсагч:** $FIN_AUTH_t = \frac{Income - inv}{Exp}$ | **RANDOM** | | **POOLED** | |
|---|---|---|---|---|
| **Тайлбарлагч хувьсагч** | Үнэлсэн Коэффициент | VIF[3] | Үнэлсэн коэффициент | VIF |
| $Const\ \beta_0$ | 0.483** | | 0.061 | |
| | (0.162) | | (0.194) | |
| $Party_t$ | 0.002 | 1.074 | 0.005 | 1.113 |
| | (0.016) | | (0.229) | |
| $GEN_t$ | -0.003 | 1.076 | -0.004 | 1.203 |
| | (0.111) | | (0.145) | |
| $Landper_t$ | 0.009 | 1.074 | 0.016 | 1.115 |
| | (0.022) | | (0.015) | |
| $HDI_t$ | 0.630** | 1.089 | 1.216*** | 1.178 |
| | (0.216) | | (0.255) | |
| $Distance_t$ | -0.00007* | 1.050 | -0.00006* | 1.170 |
| | (0.00003) | | (0.00002) | |
| **Статистик тест** | | | | |
| R квадрат | 0.208 | | 0.405 | |
| Засварлагдсан R квадрат | 0.139 | | 0.353 | |
| Ажиглалтын тоо | 63 | | 63 | |

1. $\boldsymbol{\beta_0}$: Суурь коэффициент нь 0.483 бөгөөд статистик хувьд ач холбогдолгүй байна ($\boldsymbol{p < 0.05}$). Энэ нь бусад бүх хувьсагчид тогтвортой байхад, санхүүгийн бие даасан байдалд суурь нөлөөтэй болохыг харуулж байна.
2. **Party**: Намын ялгаа нь санхүүгийн бие даасан байдалд багахан нөлөөтэй болох нь харагдаж байна ($\beta = 0.002, p > 0.05$). Энэ нь улс төрийн намын ялгаа орон нутгийн санхүүгийн байдалд томоохон нөлөөлөлгүй болохыг харуулав. Монголын орон нутгийн сонгуулийн хувьд намын бодлого нь бие даасан санхүүгийн байдлыг шууд хамаарахгүй байгаагийн илрэл байж болох юм.

[3] Variance Inflation Factor буюу Тайлбарлагч хувьсагч хоорондын мултиколлинеарити шалгах тест

3. **GEN**: Эрэгтэй, эмэгтэй төлөөлөгчдийн харьцаа буюу жендерийн хувьсагч нь санхүүгийн бие даасан байдалд статистикийн хувьд ач холбогдолгүй ч ($\beta = -0.003$, $p > 0.05$) багахан сөрөг нөлөөтэй байгааг харуулж байна. Энэ нь жендерийн харьцаа нь санхүүгийн үр дүнд томоохон хувь нэмэр үзүүлэхгүй байгааг илтгэнэ.
4. **Landper**: Хүн амд ногдох газар нутгийн хэмжээ нь санхүүгийн бие даасан байдалд эерэг нөлөөтэй ($\beta = 0.009$), гэхдээ энэ нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна. Энэ нь орон нутгийн газар нутгийн хэмжээ нь эдийн засгийн бие даасан байдалд зарим түвшинд нөлөө үзүүлж байгааг харуулж байна.
5. **HDI (Хүний хөгжлийн индекс)**: $HDI$ нь хамгийн өндөр эерэг нөлөө үзүүлсэн хувьсагч бөгөөд $\beta = 0.630$ ($p < 0.05$) ба санхүүгийн бие даасан байдалд голлон нөлөөлөх хүчин зүйл юм. Энэ нь хөгжлийн түвшинтэй бүс нутагт орон нутгийн санхүүгийн бие даасан байдал илүү байгааг харуулж байна.
6. **Distance (Улаанбаатараас орон нутаг хүртэлх зай)**: Улаанбаатараас холын зай нь багахан сөрөг нөлөөтэй ($\beta = -0.00007, p < 0.05$). Энэ нь төвөөс алслагдсан бүс нутгуудын санхүүгийн бие даасан байдал бага байж болзошгүйг харуулж байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын орон нутгийн сонгуулийн үр дүнд шинжилгээ хийж, сонгуулийн ирц, бүсээр илэрхийлэгдэх намуудын дэмжлэг зэргийг тооцоолон гаргаж, орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлох, жендерийн олон талт байдал, намын ялгаа болон бусад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлэх зорилгыг агуулсан.

Монгол улсад аймаг, нийслэлийн засаглалын түвшинд МАН, АН давамгайлах байр суурьтай байгааг 1992-2024 оны 9 удаагийн ээлжит сонгуулийн дүн илтгэж байна. 2020 оны сонгуулиас хойш МАН, АН-ын дунд аймаг, нийслэлийн ИТХ-ийн сонгуульд хүчтэй өрсөлдөөн хэвээр байна. 2016 оноос хойших ОНС-дүнг харвал МАН орон нутгийн сонгуульд бүсийн дунджаар олонх аймагт засаглаж байгаа боловч иргэдээс ирэх дэмжлэг аажмаар буурч байна. Эсрэгээрээ АН иргэдээс авах дэмжлэг орон нутагт

бүсээр тооцож үзвэл аажим нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Харин бусад нам, эвсэл болон бие даагчдын аймгийн иргэдийн хуралд сонгогдох дэмжлэг огцом буурч байна.

Монгол Улсын улс төрийн өнөөгийн нөхцөлд намын ялгаа нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд томоохон нөлөө үзүүлэхгүй. Намуудын бодлого, үзэл баримтлал нь орон нутгийн санхүүгийн шийдвэр гаргалтад шууд нөлөөлөхгүй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн жендерийн олон талт байдал нь санхүүгийн бие даасан байдалд статистик ач холбогдолтой нөлөө үзүүлэхгүй байна. Эрэгтэй, эмэгтэй төлөөлөгчдийн харьцаа нь орон нутгийн санхүүгийн шийдвэр гаргалтад нөлөөлөхгүй болох нь судалгаагаар тогтоогдсон. Энэ нь жендерийн тэгш байдлыг хангах бодлого, хэрэгжилтийн түвшинд асуудал байгааг илтгэнэ. Хүн амд ногдох газар нутгийн хэмжээ нь санхүүгийн бие даасан байдалд бага зэрэг эерэг нөлөө үзүүлсэн ч статистик ач холбогдолгүй байна. Энэ нь орон нутгийн газар нутгийн хэмжээ эдийн засгийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхгүй байгааг харуулдаг. Хүний хөгжлийн индекс (HDI) нь санхүүгийн бие даасан байдалд хамгийн их эерэг нөлөө үзүүлсэн. HDI өндөртэй орон нутагт санхүүгийн бие даасан байдал илүү байгааг судалгаа харуулсан нь хүн амын боловсрол, эрүүл мэнд, орлогын түвшин нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэйг нотолж байна (UNDP, 2020).

Улаанбаатар хотоос орон нутаг хүртэлх зай нь санхүүгийн бие даасан байдалд бага сөрөг нөлөөтэй байсан. Төвөөс алслагдсан орон нутгууд санхүүгийн хувьд бие даасан байдал багатай байгааг илтгэж байна. Энэ нь төвлөрсөн хөгжил, дэд бүтцийн хүрэлцээтэй байдалтай холбоотой байж болно.

## Санал зөвлөмж

Судалгааны үр дүнд  үндэслэн Монгол Улсын орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах, орон нутгийн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгоход дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна:

*Жендерийн тэгш байдлыг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах*

- ✓ Квот тогтоох болон хууль эрх зүйн шинэчлэл хийх: Улс төрийн намуудын нэр дэвшүүлэх үйл явцад жендерийн тэгш байдлыг хангах

зорилгоор квот тогтоох хууль, дүрэм журам боловсруулж хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал алхам болно (Inglehart & Norris, 2018).

- ✓ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизмыг сайжруулах: Хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагуудын чадавхыг дээшлүүлж, хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай.

*Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллыг дэмжих*

- ✓ Сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх: Эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, семинар, зөвлөгөө өгөх хөтөлбөрийг зохион байгуулах шаардлагатай бөгөөд үүнд олон улсын сайн туршлага, жишээг ашиглах нь үр дүнтэй (McGregor & Blais, 2021).
- ✓ Сүлжээ, холбоод байгуулахыг дэмжих: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сүлжээ, холбоодыг байгуулах, тэдгээрийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

*Санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх*

- ✓ Санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх: Эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан санхүүгийн туслалцаа, тэтгэлэг, зээлийн хөтөлбөрийг бий болгох шаардлагатай. Энэ нь тэдний улс төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлнэ (World Bank, 2019).
- ✓ Техникийн туслалцаа үзүүлэх: Сонгуулийн кампанит ажил, менежмент, харилцаа холбоо, бодлого боловсруулалт зэрэгт техникийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

*Нийгэмд жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх*

- ✓ Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах: Жендерийн тэгш байдлын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар эерэг мэдээ, мэдээлэл түгээх дэлгэрүүлэх;
- ✓ Боловсролын хөтөлбөрт жендерийн асуудлыг тусгах: ЕБС болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт жендерийн тэгш байдлын тухай сэдвийг оруулах, энэ талаар мэдлэг олгох (UNESCO, 2017);

*Орон нутгийн хөгжлийн бодлогод хүний хөгжлийн индексийг сайжруулах*

- ✓ Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах: Орон нутагт боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох

замаар хүний хөгжлийн индексийг дээшлүүлэх. Энэ нь санхүүгийн бие даасан байдалд эерэг нөлөө үзүүлнэ (UNDP, 2020).

- ✓ Орлогын тэгш бус байдлыг багасгах: Орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэх;

*Төвлөрлийг сааруулах, дэд бүтцийг хөгжүүлэх*

- ✓ Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: Төвөөс алслагдсан орон нутагт зам, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийг сайжруулах замаар эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх (ADB, 2018).
- ✓ Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх: Орон нутагт төрийн үйлчилгээ, мэдээллийг хүртээмжтэй болгох, цахим засаглалыг хөгжүүлэх;

*Намуудын бодлого, үзэл баримтлалыг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэх*

- ✓ Орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах: Улс төрийн намууд орон нутгийн хэрэгцээ, онцлогт нийцсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх замаар иргэдийн итгэлийг олж авах боломжтой.
- ✓ Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх: Орон нутгийн иргэдийн санаа бодлыг сонсох, шийдвэр гаргалтад оролцуулах механизмыг бий болгох;

*Судалгаа, шинжилгээг баазыг бэхжүүлж, сайжруулах*

- ✓ Мэдээллийн баазыг баяжуулах: Орон нутгийн түвшинд статистик мэдээлэл, судалгааны өгөгдлийг сайжруулж, бодлого боловсруулахад ашиглах;
- ✓ Эрдэм шинжилгээний хамтын ажиллагаар өргөжүүлэх: Олон улсын болон дотоодын судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шилдэг туршлага, мэдлэгийг солилцох;

*Орон нутгийн сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллах*

- ✓ Орон нутгийн сонгуулийг УИХ-ын сонгуультай хамт зохион байгуулах;
- ✓ Иргэдийг сонгуулийн боловсролоор хангах, сонгуулийн хууль, журмыг ойлгомжтой хэлбэрээр сурталчлах;
- ✓ Сонгогчдыг урамшуулах урамшууллын систем нэвтрүүлэх (жишээ нь: татварын хөнгөлөлт);
- ✓ Сонгуульд оролцсон иргэдэд хөнгөлөлттэй үйлчилгээ эсвэл урамшуулал санал болгох;
- ✓ Санал авах эрхтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан санал хураах (early voting)-ийн боломжийг санал болгох;

✓ Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, бүх ард иргэдэд тэгш хүртээмжтэй сонгууль зохион байгуулах шаардлагатай.

Санал, зөвлөмжийг хэрэгжүүлснээр Монгол Улсын орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, жендерийн тэгш байдлыг хангах, орон нутгийн хөгжлийг дэмжих боломжтой. Энэ нь улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулах бөгөөд Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг биелүүлэхэд дэмжлэг болох боломжтой юм.

## НОМ ЗҮЙ


1. Asian Development Bank (ADB). (2018). Mongolia: Infrastructure Development. ADB Publications.
2. Cohen, J. (1988). Statistical power analysis for the behavioral sciences. Hillsdale, NJ: Erlbaum.
3. Evans, R. (2021). Distribution Analysis in Political Support Studies. Journal of Political Statistics, 27(1), 51-62.
4. Federal Returning Officer. (2022). Election results for German states. Federal Returning Officer website. Retrieved from https://www.bundeswahlleiter.de
5. German Election Analysis Report. (2021). Comparative study of German and Mongolian political parties. Journal of Comparative Politics, 45(2), 123-145.
6. Inglehart, R., & Norris, P. (2018). The Impact of Gender Parity on Electoral Success. Journal of Democracy and Gender Studies, 15(1), 12-28.
7. Johnson, R. (2017). Group Participation and Social Support in Community Activities. Journal of Social Sciences, 23(2), 145-160.
8. McGregor, B., & Blais, A. (2021). Gender Parity and Political Success in Modern Democracies. Comparative Politics Journal, 29(3), 45-67.
9. McHugh, M. L. (2013). The Chi-square test of independence. Biochemia Medica, 23(2), 143-149. https://doi.org/10.11613/BM.2013.018.
10. Scholz, M. (2020). The rise of alternative parties in local German elections. European Political Journal, 39(3), 201-223.
11. Siegel, S., & Castellan, N. J. (1988). Nonparametric Statistics for the Behavioral Sciences.
12. Smith, J. & Muller, K. (2019). Political trends in German states: 2000-2020. Political Science Review, 34(4), 543-567.

13. Smith, L., & Wang, X. (2019). Diversity and Participation in Community Groups. Community Research Quarterly, 30(1), 101-117.
14. Taylor, P., & Black, M. (2018). Social Support and Satisfaction Levels among Different Community Groups. Journal of Social Psychology, 12(4), 234-248.
15. UNESCO. (2017). Mainstreaming Gender in Education. UNESCO Publishing.
16. United Nations Development Programme (UNDP). (2020). Human Development Report. UNDP Publications.
17. Wang, X., & Chen, Y. (2018). Gender Representation and Financial Decision-Making in Local Governance. Journal of Public Administration Research, 22(3), 101-118.
18. World Bank. (2019). Enhancing Women's Participation in Economic Development. World Bank Group.
19. World Economic Forum. (2023). The economic and political landscape of Germany's top economic states. Retrieved from https://www.weforum.org
20. Сонгуулийн ерөнхий хороо. (2005). Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн товчоон -2005.
21. Азийн сан. (2023). Монгол Улсын сонгууль (1992-2021) эмхэтгэл.
22. Статистикийн ерөнхий хороо https://www.1212.mn
23. Сонгуулийн ерөнхий хороо https://www.gec.gov.mn

## Хавсралт 1.

| Хувьсагчид | *n* | mean | median | mad | min | max | skew | kurtosis | Нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ratio | 63 | 0.9 | 0.9 | 0.1 | 0.7 | 1.1 | 0.5 | -1.1 | % |
| NAM | | 0.7 | 1.0 | 0.0 | 0.0 | 1.0 | -0.6 | -1.6 | Binary |
| GEN | | 0.2 | 0.2 | 0.1 | 0.0 | 0.4 | 0.5 | 0.8 | % |
| inv | | 7923.3 | 7474.8 | 6541.5 | 0.0 | 18885.8 | 0.1 | -1.1 | сая төг |
| Inv | | 70910.3 | 65185.2 | 20084.0 | 12997.4 | 465166.1 | 5.2 | 32.2 | сая төг |
| Exp | | 68853.8 | 63044.1 | 18101.3 | 12881.0 | 420137.6 | 5.0 | 30.2 | сая төг |
| Land_per | | 1.0 | 0.8 | 0.7 | 0.0 | 2.6 | 0.7 | -0.1 | км |
| HDI | | 0.7 | 0.7 | 0.0 | 0.6 | 0.8 | 0.2 | -0.2 | индекс |
| Distance | | 640.4 | 477.0 | 299.5 | 43.0 | 1709.0 | 1.0 | 0.0 | км |

# ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШУУД АРДЧИЛЛЫНЭЛЕМЕНТҮҮД: ДҮН ШИНЖИЛГЭЭ (2024 он)

П.Хаш-Эрдэнэ, Төрийн бодлого судлалын магистр

## ОРШИЛ

Ардчилсан улс орны хувьд иргэдийн оролцоо, төлөөллийн тогтолцоо нь манай орны засаглалын үйл ажиллагаанд чухал үүрэгтэй билээ. Төрийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах замаар засаглалын үйл ажиллагаа, шийдвэрт олон нийтийн санал бодол, эрэлт хэрэгцээг тусган боловсруулах нь шуудардчиллын үндсэн шинж юм.

“Иргэдийн оролцооны асуудал бол засаг захиргааны байгууллагууд шийдвэр гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаандаа иргэдийг зориуд зохион байгуулалттайгаар оролцуулж, тэдэнд мэдээлэл өгөх, саналыг нь сонсох, асуудлыг хамтран хэлэлцэх, зөвлөлдөх, хэрэгжүүлэх, нутгийн удирдлагын тогтолцоонд хэрэгжиж буй үйл ажиллагаа, түүний үр дүнд иргэдийн хяналт бий болох тухай юм.[1]

Шууд ардчиллыг бодитоор хэрэгжүүлэхэд засаглалын үйл ажиллагаанд иргэдийн шууд оролцоог хангаж, анхан шатны түвшинд ардчилсан шийдвэр гаргалтыг дэмжих Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаа, эрх зүйн орчин маш чухал юм.

Манай улсад иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргах, шууд ардчиллыг дэмжих тухай хууль тогтоомжуудад тусгасан байдаг. Үүнд:Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд Монгол Улсын иргэн “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”[2] хэмээн иргэдийн сонгох, сонгогдох, төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулсан. Мөн Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

[1] Конрад Аденауэр Сан, Г.Чулуунбаатар, Ш.Батсүх,Б.Ганцоож, Монголын ардчилал, төлөөллийнардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж” Улаанбаатар, 2021, 198 тал

[2] Монгол Улсын Үндсэн хууль, 1992 оны 1 сарын 13, https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

нэгжийн тухай хууль" - д иргэдийн Нийтийн Хурлын эрх зүйн үндсийг тодорхойлж, орон нутгийн түвшинд иргэдийн оролцооны арга хэлбэр, эрхийг тодорхойлж өгсөн. Ийнхүү холбогдох хууль тогтоомжид иргэдийн оролцоог хэрхэн хангаж ажиллах талаар тусгаж өгсөн нь шууд ардчиллыг дэмжих эрх зүйн суурийг бий болгож байна.

### Зорилго:

Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын эрх зүйн орчныг шинжлэн, шууд ардчиллын элементүүд бий эсэхийг Монгол Улсын хууль, олон улсын болон төрийн холбогдох байгууллага, судлаачдын гүйцэтгэсэн зарим судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэлд тулгуурлан шинжилгээ хийж, үр дүнг тоймлон гаргахыг зорьлоо.

Дээрх зорилгын хүрээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг Монгол Улсын хуулиуд, холбогдох судалгааны сан бүхий сайтуудаас авч ашиглав. Судалгааны хязгаарлагдмал тал нь энэхүү дүн шинжилгээ нь Монгол Улсын хуулиуд, мөнтухайлсан сайтууд дээрх нээлттэй мэдээлэл, судалгааны хүрээнд хийгдсэн.

### Дүн шинжилгээ:

Судалгааны ажлын хүрээнд юуны өмнө “шууд ардчилал” гэсэн үндсэн ойлголтыг тайлбарлаж, энэхүү ойлголт нь өнөөгийн Иргэдийн Нийтийн Хурлын эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулагдсан талаар судлав.

***Шууд ардчилал:***

Ардчилалын талаарх ойлголт өргөн хүрээнд тодорхойлсон байдаг. Харин энэхүү ойлголтыг Монгол хэлний товч тайлбар толинд “Шууд эсвэл төлөөллөөр ардолон төрийн учирт оролцох ба түүний тулд санал эрмэлзлэлээ чөлөөтэй илэрхийлэхэрх бүхий төрийн хэлбэр” хэмээн тайлбарласан байна.

Манай улс нь иргэдийн сонгох, сонгогдох, төрийн үйл ажиллагаанд санал, хүсэлтээ хүргүүлэх, оролцох, төлөөлүүлэх эрхийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулж өгсөн байдаг. Энэ хүрээнд иргэд сонгох, сонгогдох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэргээр эрхээ эдэлж төрийн үйлажиллагаанд оролцох боломж бүрдсэн.

Гэхдээ төлөөллийн оролцоонд зарим талаар дутагдалтай талууд бий. Хэт нэгталыг барих, ашиг сонирхлыг илүүд үзэх зэргээр иргэдийн бухимдлыг төрүүлэх зүйлс олон. Энэ нөхцөлд иргэд хяналтаа сайжруулж байж төлөөллийн оролцоо төгс хэрэгжих боломжтой байх талтай. “Төрийн бодлого, үйл ажиллагаанд төлөөллийн ардчиллын хэлбэрүүд давамгайлж,

иргэдийн шууд оролцоо харьцангуй бага байдагбол асуудлын хамрах хүрээ багасаж, нийгмийн зохион байгуулалтын шатлал анхан шат руугаа ойртох тусам шууд ардчилал, иргэдийн шууд оролцоо давамгайлж, төлөөлийн ардчиллын хэлбэр багасах хандлага байдаг.[3] Шууд ардчилал гэж гэдгийг иргэдийн оролцоотойгоор хэрхэн ойлгох вэ?

**Шууд ардчилал** гэдгийг "Иргэд ямар нэгэн төлөөлөлгүйгээр санал, шийдвэрээ өөрсдөө гаргах үйл явц юм."[4] хэмээн тодорхойлсон байна.

Орон нутгийн өөрөө удирдах байгууллага бол иргэдийн улс төрд оролцох, өөрийн төлөөллөө сонгох анхан шатны нэгж юм. Орон нутгийн түвшинд энэхүү эрхийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд "Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй" гэж заан баталгаажуулсан байдаг.

Шууд ардчиллын давуу тал нь сонгуулийн эрх бүхий иргэд бүгд оролцон нээлттэйгээр хэлэлцэн, тэгш эрхийг зарчмын дагуу иргэдийн бодол санаа шийдвэрт шууд тусгалаа олон, гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр байдал өндөр байдагт оршино. Харин сул тал нь иргэдийн нэг дор цуглуулах хөрөнгө хүч, санхүүгийн хүндрэл, мэргэжлийн чадвар шаардсан асуудлыг ойлгохгүй байх, сэтгэлийн хөөрлөөр нийгэмд популизмыг үүсгэх зэрэг сөрөг талтай юм.[5]

Дээрхээс харахад шууд ардчилал нь иргэдийн шууд оролцох боломжийг хангах, аливаа асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийн санал, бодлыг шууд илэрхийлэх боломжийг олгодог үндсэн шинжийг агуулж байна. Энэ утгаараа баг, хорооныИргэдийн Нийтийн Хурал нь шууд ардчиллын шинжийг дараах хүрээнд агуулах боломжтой гэж үзэхээр байна. Үүнд:

### Нэг. Иргэдийн шууд оролцоог хангах, тэгш хүртээмжтэй байх

[3] Г.Чулуунбаатар, Монгол дахь иргэдийн оролцоо ба зөвлөлдөх ардчилал, Иргэний хөдөлгөөнөөсиргэний нийгмийн зүг, Өгүүллийн эмхэтгэл., УБ., 2020, 120 дахь тал

[4] Д.Бумдарь, С.Оюунбилэг "Шууд ардчиллын хэлбэрүүд: харьцуулсан судалгаа" 2019, 143 дахь тал

[5] Д.Бумдарь, С.Оюунбилэг "Шууд ардчиллын хэлбэрүүд: харьцуулсан судалгаа",УБ, 144 дахь тал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд иргэдийн шууд оролцооны талаар тодорхой тусгаж өгсөн байна. Тус хуулийн 32.1. дэх хэсэгт "Иргэдийн Нийтийн Хурал нь шууд ардчиллын зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг, хуулиар олгогдсон бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг, иргэдийн өөрийн удирдлагын байгууллага мөн."[6] хэмээн зааж зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг хуралдаан хэмээн хуульчилсан байна. Иймд тус заалт нь "иргэд ямар нэгэн төлөөлөлгүйгээр санал, шийдвэрээ өөрсдөө гаргах үйл явц юм" гэсэн шууд ардчиллын санааг хуулиар баталгаажуулж өгсөн гэж болно.

Түүнчлэн энэхүү эрхийг баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар хэрэгжүүлэхэд оролцоог хэрхэн хангах талаар тус хуульд дараах байдлаар тусгасан.Үүнд:

- Тус хуулийн 32.3 дэх хэсэгт "Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй.",
- 32.4 дэх хэсэг "Иргэн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд биеэр хүрэлцэн ирснээр баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын оролцогч болно."
- Мөн хуулийн 32.6. дэх хэсэгт "...Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас, аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна." хэмээн зааж тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрээс

[6] Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2020 оны 12 сарын 24-ний өдөр), https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801

иргэдийн төлөөллийг оролцуулах хэмжээг тодорхойлжээ.

Ийнхүү хуулиар иргэдийн оролцоог хэрхэн хангах хүрээг тодорхойлж өгсөн ньардчиллын тэгш эрхийн дагуу хүртээмжтэй байх явдлыг хангаж өгсөн гэж үзэхээр байна.

## Хоёр: Асуудлыг хэлэлцүүлэх, байр суурь, санал бодлоо нээлттэй илэрхийлэх

Ардчилалын үнэт зүйл бол үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдал. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд баг,хорооны Иргэдийн Нийтийн хуралд иргэдийн байр суурь, санал бодлоо илэрхийлэх боломжийг дараах эрх зүйн зохицуулалтын хүрээнд тусгаж өгсөн байна. Үүнд:

- Тус хуулийн 30.2.дэх хэсэгт “Нутгийн өөрийн удирдлагад иргэн дараах хэлбэрээр шууд оролцоно”
- 30.2.1 дэх хэсэгт “баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд саналын эрхтэй оролцох”
- 30.2.2. дэх хэсэгт “тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргах;”
- “30.2.3. дэх хэсэгт “... иргэд сайн дураараа үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх, нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах.” зэргээр нарийвчлан тусгасан.

Ийнхүү иргэдийн төрийн байгууллага, удирдлагын үйл ажиллагаа, шийдвэртсанал, хүсэлтээ тусгах эрх, оролцоог хуульчилж өгсөн нь шууд ардчиллын үндсэн зарчмыг хангаж байна.

Мөн аливаа иргэн бусад иргэдтэй хамтран орон нутгийн шийдвэр гаргалтад “Сум, баг, дүүрэг, хорооны тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй, энэхүү гаргасан санал, зөвлөмжийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэх үүрэгтэй” хэмээн хуульчилж өгсөн. Энэ нь иргэд өөрсдийн амьдрал, амьдрах орчиндтулгамдаад буй асуудлаа хамтран санал гаргах байдлаар холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх боломжийг

зохицуулсан байна гэж үзэж болно. Түүнчлэн иргэдийн гаргасан санаачилгыг хүлээн авч, хэлэлцэх үүргийг тусгасан нь Иргэдийн санал гаргах эрхийг баталгаажуулсан зохицуулалт болжээ.

## Гурав: Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, төсөвт хяналт тавих

Иргэдийн шууд оролцоотой Иргэдийн Нийтийн Хурлаар дамжуулан төрийн байгууллага, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж буй үйл явц нь ардчилсан нийгмийн эргэх холбоотой байх, хариуцлагын шинжийг агуулж байна гэж үзэж болно.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд дараах эрх зүйн зохицуулалтаар иргэдийн хянах, төлөвлөх эрхийг баталгаажуулж өгсөн байна. Үүнд:

- Тус хуулийн 16.4.дэх хэсэг "Сум, дүүргийн төсвийг боловсруулж, батлахдаа харьяалах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг авч тусгана. Баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан батална.
- 32.8.1 дэх хэсэгт "баг, хорооны чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэншийдвэрлэх" гэж тусгасан байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтууд нь иргэд оршин суугаа газар нутгийнхаа хүрээнд тодорхой хэмжээнд асуудлыг шийдвэрлэх, хяналт тавих боломжийг бий болгоход дөхөм болох юм. Тухайлбал, уг хуулийн 23.1.дэх хэсэгт "малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах газрын зааг, байршлын талаар шийдвэр гаргах, бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, тариалан, бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалт, зохицуулалт"-ыг багийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх зохицуулалт байдаг. Энэ нь хөдөөгийн малчдад багийн Иргэдийн Нийтийн Хурлаараа дамжуулан өөрсдийн амьдарч буй орон нутгийнхэмжээнд зохицуулалт хийх боломжийг олгож буй явдал юм.

Мөн "2012 оноос "Орон нутгийн хөгжлийн сан"- ийн төлөвлөлтөд иргэд оролцох боломж хуулиар албан ёсоор нээгдсэн."[7] нь төсвийн хяналт,

[7] Конрад Аденауэр Сан, Г.Чулуунбаатар, Ш.Батсүх,Б.Ганцоож, Монголын ардчилал, төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж" Улаанбаатар, 2021

хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах нэг чухал зохицуулалт болно.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаанаас харахад "баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд оролцсон иргэдээсхурал дээр хэлэлцсэн асуудлуудыг тодруулахад "хот болон хөдөөд орон нутгийн хөгжлийн сан, тайлан хэлэлцэх тухай нийтлэг яригдаж байна. Хөдөө орон нутагт бэлчээр ашиглалттай холбоотой зохион байгуулалтын асуудал, мал тоолох асуудлуудын талаар мөн түлхүү хэлэлцсэн байна.[8]

Товч дүгнэхэд эрх зүйн хүрээнд нутгийн удирдлагын анхан шатны нэгжийн түвшинд иргэдийн оролцоог хангах тал дээр дээрх байдлаар нарийн зохицуултуудыг тусгасан нь шууд ардчиллын шинжийг агуулсан байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн санал гаргах, хэлэлцэх, асуудлаа шийдвэрлэх боломжийг хуулиаролгож буй ардчилсан зарчимд нийцэх юм.

Эрх зүйн хүрээнд иргэдийн оролцоог хангах зохицуулалтууд байгаа боловч бодит байдалд иргэдийн оролцооны идэвх, ойлголт, хэрэгжилтийг хангах хэрэгцээ байсаар байгааг зарим судалгаа харуулж байна.

## Иргэдийн оролцоо:

Юуны өмнө "оролцоно" гэдэг бол шууд ардчиллын үндсэн хүчин зүйл юм. Хэдийгээр эрх зүйн зохицуулалт байгаа боловч оролцохгүй бол асуудал шийдэгдэхгүй. Өөрөөр хэлбэл, иргэд оролцохгүйгээр санал бодлоо илэрхийлж чадахгүй, асуудлаа хэлэлцүүлэхгүй, мөн хяналт тавих боломжгүй. Иймд орон нутаг, оршин суугаа газрынхаа хүрээнд иргэд идэвхтэй оролцоотой байж хуулиар зохицуулсан эрхээ эдэлж шууд ардчилал хэрэгжих боломжтой.

Иргэдийн оролцоо, хандлага, ойлголтын талаарх зарим судалгааг харьцуулан өнөөгийн бодит нөхцөл байдлыг шинжилбэл:

Удирдлагын академаас 2020 онд "Иргэдийн оролцооны талаарх төрийн албан хаагч болон иргэдийн ойлголт, хандлагад хийсэн шинжилгээ, орон

[8] Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, Улаанбаатар, 2019

нутгийн түвшин" судалгааг 3 аймаг, нийслэлийн 3 дүүргийн иргэд, төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Судалгаанд 787 төрийн албан хаагч, 1035 иргэн оролцсон байна. Судалгаанд оролцогчдын 78.9 хувь нь орон нутгийн хөгжилтэй холбоотой асуудлыг сонирхдог, 21.1 хувь нь сонирхдоггүй гэж хариулсан байна. Энэнь иргэд орон нутгийнхаа хөгжилтэй холбоотой асуудлыг сонирхох хандлага их байгааг илэрхийлэх нэг үзүүлэлт юм[9]. Өөрөөр хэлбэл, иргэд орон нутаг, оршин суугаа газрынхаа хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хяналтыг хийх сонирхол өндөр байна. Гэвч бодит нөхцөлд иргэдийн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд оролцох идэвх, оролцоо бага байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаагаар "Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн байдал Улаанбаатар хотод 20.6 хувьтай буюу 5 хүн тутмын нэг нь, хөдөө орон нутагт 49.2 хувьтай буюу 2 хүн тутмын нэг байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Улаанбаатар хотын иргэдийн ИНХ -д оролцсон байдал 7.4 хувиар, хөдөө орон нутагт 7.5 хувиар буурчээ."[10] Мөн тус судалгаагаар баг, хорооны ИНХ -д оролцсон байдлыг нас, хүйс, өрхийн орлогын түвшнээр задлан харвал "35- 44 насны бүлгийн оролцоо хамгийн өндөр байна. Хүйсийн хувьд том ялгаа байхгүй ч эмэгтэйчүүдийн оролцоо 1 хувиар өндөр байна. Өрхийн орлого нэмэгдэх тусам баг/хорооны ИНХ -д оролцох байдал багассан байна."[11]

Эндээс дүгнэхэд бодит байдалд хуулиар зохицуулж өгсөн иргэдийн шууд оролцох эрхийг иргэд төдийлэн хүлээн авч, идэвх санаачлага гаргадаггүй гэж болохоор байна. Нөгөө талаар хуулиар заасан оролцооны хэлбэр нь иргэдийн оролцох идэвх, санаачлагад нөлөөлж байна гэж үзэх боломжтой. Тухайлбал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайхуулийн 32.2 дэх хэсэгт "Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна" гэж заасан.

[9] Удирдлагын академи, Иргэдийн оролцооны талаарх төрийн албан хаагч болон иргэдийн ойлголт, хандлагад хийсэн шинжилгээ, орон нутгийн түвшинд, Улаанбаатар, 2020

[10] Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, 2019, 88 дах тал

[11] Мөн тэнд, 89 дэх тал

Харин “Иргэдийн оролцооны талаарх төрийн албан хаагч болон иргэдийн ойлголт, хандлагад хийсэн шинжилгээ, орон нутгийн түвшин” судалгаагаар “Төрийн албан хаагчдын 24.6-50.6 хувь нь орон нутгийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийг хуулиар олгогдсон оролцооны боломжуудыг нь ашиглуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн санал, бодлыг сонсох, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд оролцуулах,улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлж шууд оролцуулах, нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад урьж оролцуулах,цахим хэлбэрээр санал бодлыг сонсох, санал гомдлыг хүлээж авах хэлбэрүүдээр оролцуулах нь илүү зохимжтой гэж хариулсан байна. Иргэдийн 30.7-44.7 хувь нь цахим хэлбэрээр санал бодлыг сонсох, санал гомдлыг хүлээж авах хэлбэрүүдээр оролцуулах нь илүү зохимжтой гэж хариулсан байна.”[12]

Эндээс дүгнэхэд хуулиар олгогдсон иргэдийн эрх, тэгш оролцоог хангахын тулд тухайн бүс нутгийн онцлог, иргэдийн идэвхтэй оролцоог харгалзан, зохион байгуулалтын хэлбэрийг дахин харах хэрэгцээ байж болох юм. Тухайлбал, орон нутгийн төвийн сумдад иргэдийн шууд оролцоог хангахад хуралдааны хэлбэр байж болох бол нийслэлд болон алслагдсан сумдад зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилж болохоор. Өөрөөр хэлбэл, иргэд орон нутгийн хөгжилд саналаа өгөх, шийдвэр гаргалтад оролцох сонирхол байгаа боловч ажил, ахуйн нөхцөл байдлаас(жишээ нь төрийн албан хаагч, эсвэл отроор нүүдэллэн яваа малчдын хувьд) шалтгаалан эрхээ эдэлж чадахгүй нөхцөл байсаар байх талтай.

Иймд иргэдийн оролцоог хангах тал дээр цаашид хэрэгжүүлэх боломжтой саналыг судалгаа, сайн жишээнд тулгуурлан боловсруулав.

## Цаашид хэрэгжүүлэх санал:

Судалгаагаар иргэдийн шууд оролцооны хэлбэрийг “Цахим хэлбэрээр иргэдийн санал бодлыг сонсох хэлбэрийг төрийн албан хаагчдын 50 орчим

[12] Удирдлагын академи, Иргэдийн оролцооны талаарх төрийн албан хаагч болон иргэдийн ойлголт,хандлагад хийсэн шинжилгээ, орон нутгийн түвшинд, Улаанбаатар, 2020, 76 дах тал

хувь"[13] нь дэмжсэн байна. Иймд ажлын өдрүүдэд оролцох боломжгүй албан хаагчид,ажилчдын саналыг цахимаар авах боломжийг судлах,

Мөн тус судалгаагаар "Иргэдийн 35 хувь нь төлөвлөх үйл явцад, 34.9 хувь нь хэрэгжүүлэхэд, 43.3 хувь нь тайлагнахад, 37.7 хувь нь хяналт тавихад тогтмол оролцоо байх ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна"[14] Иймд баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын тов, хуралдааныг тов, хэлэлцэх асуудлыг иргэдэд цахим, зар мэдээлэл болон аман хэлбэрээр хүргэх, хүртээмжтэй байдлыг хангах хэрэгцээ шаардлага байна.

Иргэдийн саналыг шийдвэрлэх явдал нь шууд ардчиллын баталгаажуулах гол хүчин зүйл юм. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд иргэд шууд оролцоотойгоор дээд шатны байгууллага болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг шийдүүлэхээр саналаа өгөх, хэлэлцүүлэх эсвэл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах зэргээр үзэл бодлоо илэрхийлэх эрхийг тусгасан байдаг. Гэхдээ бодит нөхцөлд иргэд олон нийт өөрсдийн гаргасан санал хэрхэн шийдэгдсэн талаарх мэдээлэл харилцан адилгүй байгаа нь судалгаагаар харагдаж байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаагаар "Улаанбаатар хотын иргэдийн 81% нь дүүргийн ИТХ-аас гаргасан шийдвэрээс нэрлэж чадахгүй байна. Мөн Улаанбаатар хотын иргэдийн 18.8% нь дүүргийнхээ ИТХ-д сайн үнэлгээ өгсөн бол орон нутгийн иргэдийн 34.2% нь сумынхаа ИТХ-д сайн үнэлгээ өгчээ."[15]. Эндээс харахад бодит байдалд мэдээллийн хүртээмж болон төлөөллийн хариуцлага, үйл ажиллагаанаас шалтгаалан иргэдийн оролцох идэвх буурах хандлага байна. Иймд мэдээллийн ил тод байдлыг хангах, эргэх тогтолцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын иргэдээс Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллааанд санал авах зорилгоор "Аравт" дэд төслийг санаачилан, иргэдийн оролцоог дөрөв дахин нэмэгдүүлж чаджээ.[16] "Аравт"

---

[13] Мөн тэнд, 75 дах тал

[14] Мөн тэнд, 77 дах тал

[15] Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, Улаанбаатар, 2019, 68 дах тал

төслийн гол санаа нь газар зүйн байршлын хувьд ойролцоо нутагладаг 10 өрхийг нэг аравтын бүлэг болгон зохион байгуулж, мэдээлэл түгээх явдал байсан. Сайн жишээнд тулгуурлан хөдөөгийн сумдын багийн Иргэдийн Нийтийн Хурал нь малчдыг газар зүйн хүрээллээр нь нэгтгэн зохион байгуулах, мэдээлэл хүргэх, санал авах ажлыг хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна.

## Дүгнэлт

Төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн идэвхтэй оролцооны асуудал нь ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд чухал сэдэв юм. Ийм ч учраас иргэдийн үр дүнтэй оролцоог идэвхжүүлэх явдал нь улс орны бүх шатанд чухал болно. Ийм ч учраас иргэд ямар нэгэн төлөөлөлгүйгээр санал, шийдвэрээ өөрсдөө гаргах үйл явц нь шууд ардчиллыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй.

Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын анхан шатны нэгж болох баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал нь иргэдийн санал, сонголт, шийдвэр гаргалтад шууд оролцох боломжийг олгож буй нь шууд ардчиллын элементүүдийг агуулсан гэж харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Иргэдийн Нийтийн Хурлаар дамжуулан иргэд хуулийн хүрээнд ил тод, чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах, тулгамдаж буй асуудалд санал гаргах, хэлэлцүүлэх, шийдвэрлэх, ашиг сонирхлоо хамгаалах болон төрийн үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр шууд оролцооны үндсэн дээр эрх зүйн боломжоор тодорхой хэмжээн хангагдсан гэж үзэжболно.

Нөгөө талаас иргэд оршин суугаа газартаа төрийн үйл ажиллагаа, төлөвлөлт,хэрэгжилт, хяналтад оролцох сонирхолтой байгаа нь “судалгаанд хамрагдсан иргэдийн 90 гаруй хувь нь орон нутгийнхаа бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлж буй үйлажиллагаануудад оролцоотой байх нь зөв”.[17] гэснээс харагдаж байна.

Эрх зүйн хүрээнд зохицуулалтууд хийгдсэн, иргэдийн идэвх, хүсэл эрмэлзэл өндөр байгаа нь иргэдийн оролцоог хангалттай байлгах боломжтой байна гэж болно.Гэхдээ бодит байдалд иргэдэд хүрэх мэдээллийн хүртээмжийн асуудал, идэвх, тэгш оролцоо, хуулийн хүрээнд иргэдийн оролцоог хангах ажил нь хэлбэрийн хувьд дутагдалтай зэрэг асуудлууд байсаар байна. Энэ нь баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд оролцох иргэдийг идэвхийг бууруулах,

шууд оролцох эрхийг хязгаарлах нөхцөл болж болохоор гэж дүгнэж болох юм.

Иймд цаашид баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд иргэдийн оролцох боломжийг өргөн хүрээнд хангах үүднээс зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг тодорхойлох, тэгш, хүртээмжтэй байх нь чухал гэж үзлээ.

## Эх сурвалжийн жагсаалт

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 оны 1 сарын 13-ны өдөр

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2020 оны 12 сарын 24-ний өдөр)

Д.Бумдарь,С.Оюунбилэг "Шууд ардчиллын хэлбэрүүд: харьцуулсан судалгаа", Улаанбаатар, 2019 он

Г.Чулуунбаатар, Монгол дахь иргэдийн оролцоо ба зөвлөлдөх ардчилал, Иргэний хөдөлгөөнөөс иргэний нийгмийн зүг, Өгүүллийн эмхэтгэл, Улаанбаатар, 2020 он

Удирдлагын академи, Иргэдийн оролцооны талаарх төрийн албан хаагч болон иргэдийн ойлголт, хандлагад хийсэн шинжилгээ, орон нутгийн түвшинд, Улаанбаатар, 2020 он

Конрад Аденауэр Сан, Г.Чулуунбаатар, Ш.Батсүх,Б.Ганцоож, Монголын ардчилал, төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж" Улаанбаатар, 2021 он

Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь" төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, Улаанбаатар, 2019 он